

ДӨРӨВ ДҮГЭЭР БҮЛЭГ

Трансценденталь мэдлэг

ШҮЛЭГ 1

*шри бхагаван увача
имам вивасвате йогам проктаван ахам авьяам
вивасван манаве праха манур икшвакаве `бравит*

шри бхагаван увача- Бурханы Дээд Бодгаль айлдсан, *имам*- энэ, *вивасвате*- нарны сахиулсан тэнгэрт, *йогам*- Бүхний Дээдтэй холбогдсон эрдэм ухаан, *проктаван*- сургасан, *ахам*- Би, *авьяам*- мөнхийн, *вивасван*- Вивасван (нарны сахиулсан тэнгэрийн нэр), *манаве*- хүн төрөлхтний эцэгт (Вайвасвата), *праха*- тайлбарласан, *манух*- хүн төрөлхтний эцэг, *икшвакаве*- Икшваку хаанд, *абравит*- хэлсэн.

Бурханы Дээд Бодгаль Шри Кришна айлдсан нь: Би иогийн энэхүү мөнхийн эрдэм ухааныг нарны бурхан Вивасванд айлдсан билээ. Харин Вивасван түүнийг хүн төрөлхтний эцэг Мануд, Ману цааш нь Икшвакуд номлосон.

ТАЙЛБАР: Энд, Бхагавад Гитаг анх наран гаригаас эхлээд бүх гаригуудын хаад, тэдгээрийн үр удамд хүртээн номлож ирсэн өнө удаан хугацааны түүхийг өгүүлж байна. Албат иргэдээ хамгаалах явдал нь бүх гаригуудын хаадын хувьд онцгой үүрэг байдаг учраас албат иргэдээ зохих ёсоор удирдан залах болон шунал тачаалын материаллаг хүлээснээс ангид байлгаж хамгаалах чадвартай байхын тулд Бхагавад Гитагийн эрдэм ухааныг тэд ойлгож хүртэх ёстой. Хүний амьдрал нь Бурханы Дээд Бодгалтай холбогдсон өөрийн мөнхийн харьцаа холбоог таньж мэдэхийн тулд бурханлаг мэдлэгээ хөгжүүлэхэд л зориулагдсан байдаг учир бүх гаригуудын хийгээд улс гүрнүүдийн тэргүүнүүд энэхүү мэдлэгийг боловсрол, соёлын болон шашны арга хэрэгслүүдийг ашиглан харьяат иргэддээ дэлгэрүүлэх үүрэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл аливаа улс гүрний хариуцлага бүхий удирдагчид нь Кришнагийн ухамсарын эрдэм ухааныг түгээн дэлгэрүүлэх ёстой бөгөөд ингэснээр хүмүүс энэхүү аугаа чухал эрдэм ухааны ач тусыг хүртэх болон хүний амьдралын хэлбэрт л олддог боломжийг ашиглан төгс төгөлдөрт хүрэх зам мөрөөр замнаж чадах болно.

Нарны, одоогийн энэ цаг үе дэх сахиулсан тэнгэр буюу бурханыг Вивасван гэж нэрлэдэг бөгөөд тэрээр нарны системийн бүх гаригуудын эхлэл болох нарны хаан юм. Брахма-самхитагийн (5.52)-д:

*яч-чакишур эша савита сакала-граханам
ража самаста-сура-муртир ашеша-тежах
ясьягья бхрамати самбхрита-кала-чакро
говиндам ади-пурушам там ахам бхажами*

Брахма залбиралдаа: “Би анхдагч Бодгаль болох хийгээд Түүний таалал заавраар бүх гаригуудын хаан-нар хэмжээлшгүй их хүч чадал болон илч халууныг цацруулан түгээж байдаг Бурханы Дээд Бодгаль, Говинда (Кришна)-д бишрэл хүндэтгэлээ илэрхийлье. Нар нь Бурханы мэлмийг төлөөлдөг бөгөөд Түүний таалал зарлигийн дагуу өөрийн тойрог замаар зорчиж байдаг.” гэж өгүүлсэн байдаг.

Нар нь бүх гаригуудын хаан, харин нарны сахиулсан тэнгэр (одоо цаг үед Вивасван) нь бусад бүх гаригуудыг илч дулаан болон гэрлээр хангаснаар тэдгээрийг хянах нарыг удирдан захирч байдаг. Нар нь Кришнагийн таалал зарлигаар л тойрон эргэлдэж байдаг бөгөөд Шри

Кришна анх эхлээд Вивасваныг Бхагавад Гитагийн эрдэм ухааныг ойлгож хүртэх ёстой Өөрийн анхны шавиа болгожээ. Иймээс Гита нь ач холбогдолтой бус материаллаг эрдэмтдэд зориулсан зүгээр нэг цэцэрхийллийн зохиол биш, харин өнө эртний цагаас бидэнд дамжигдан ирсэн мэдлэгийн эх сурвалж-судар юм.

Махабхаратад (Шанти-парва, 348.51-52) Гитагийн түүхийн талаар өгүүлсэн дараахь мөрүүдийг үзэж болно:

*трета-югадау ча тато вивасван манаве дадау
мануш ча лока-бхрити-артхам сутаекивакаведадау
икшвакуна ча катхито вьянья локан авастхитах*

“Бүхний Дээдтэй холбогдсон холбоо харьцааны тухай энэхүү эрдэм ухааныг Трета юга-ын эхэнд Вивасван Мануд дамжуулан хүртээсэн. Хүн төрөлхтний өвөг эцэг болох Ману түүнийг Рамачандра Бурханы илэрч тодорсон Рагхугийн удмын өвөг дээдэс хийгээд газар дэлхийн хаан болох өөрийн хүү Махаража Икшвакуд дамжуулан сургасан болой.” Иймд Бхагавад Гитаг хүн төрөлхтөн Махаража Икшвакугийн хаанчлалын цаг үеэс эхлэн хүртжээ.

Нийт 432 000 жил үргэлжлэх Кали юга эхэлснээс хойш эдүгээг хүртэл 5000 жил өнгөрөөд байна. Энэ цаг үеийн өмнө Двапара юга (800 000 жил үргэлжилсэн), мөн түүний өмнө Трета юга (1 200 000 жил үргэлжилсэн) болж өнгөрсөн Иймээс Ману нь Бхагавад Гитаг энэ гариг-дэлхийн хаан, өөрийн хүү хийгээд шавь болох Махаража Икшвакуд ойролцоогоор 2 005 000 жилийн өмнө номложээ. Одоогийн энэ Манугийн амьдралын хугацаа 305 300 000 жил үргэлжлэх бөгөөд түүнээс одоог хүртэл 120 400 000 жил нь улиран одсон билээ. Үүнээс үзэхэд, Бурхан Гитаг энэхүү Мануг төрөхөөс өмнө Өөрийн шавь-нарны сахиулсан тэнгэр Вивасванд айлдсан бол Гита нь барагцаалбал наад зах нь 120 400 000 жилийн өмнө, харин хүний нийгэмд хоёр сая жилийн өмнөө номлогджээ. Бурхан Бхагавад Гитаг 5000 жилийн өмнө Аржунад дахин айлдсан. Гитагаас өөрөөс нь болон түүнийг айлдсан Бурхан Кришнагийн айлдвараас үзэхэд Гитагийн түүхийн ерөнхий байдал ийнхүү харагдаж байна.

Нарны сахиулсан тэнгэр Вивасван нь *кшатрия* байсан хийгээд *сурья-вамша кшатрия* буюу нарны сахиулсан тэнгэрийн үр удам болцгоох бүх *кшатриянуудын* өвөг болох учир түүнд Бхагавад Гитаг айлджээ. Бхагавад Гитаг Бурханы Дээд Бодгаль айлдсан учир тэрээр Ведүүдийн нэгэн адил жинхэнэ эх сурвалж мөн болох тул түүнийг *анаурушея* буюу хүний хүч чадавхи хир хэмжээнээс хэтийдсэн илүү дээд мэдлэг хэмээдэг билээ. Ведийн сургаалыг хэн нэгэн хүний ухааны тайлбаргүйгээр, байгаа чигээр нь хүлээн авч хүртэх ёстой байдгийн адил Гитаг ч мөн материаллаг тайлбаргүйгээр хүлээн авах хэрэгтэй. Материаллаг их мэдэгч нар Гитагийн талаар өөр өөрсдийнхөөрөө цэцэрхэн байх боловч тэдгээр нь үнэн хэрэгтээ анх айлдсан төрх байдлаараа байгаа Бхагавад Гита биш юм. Иймээс Бхагавад Гитаг анх айлдсан төрх байдлаар нь буюу энд тайлбарлаж байгаачлан, Бурхан эхлээд нарны сахиулсан тэнгэрт, нарны сахиулсан тэнгэр өөрийн хүү Мануд, Ману өөрийн хүү Икшвакуд номлож сургасан шиг, өөрөөр хэлбэл багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээгээр дамжуулан хүлээн авч хүртэх ёстой.

ШҮЛЭГ 2

*эвам парампара-прамтам имам ражаршайо видух
са каленеха махата йога наштах парантапа*

эвам- ингэж, *парампара*- багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээгээр, *прамтам*- хүртдэг, *имам*- энэхүү эрдэм ухааныг, *ражаршайо*- ариун гэгээн хаад, *видух*- ойлгосон, *сах*- энэ мэдлэг, *калена*- цаг хугацааны явцад, *иха*- энэ дэлхий дээр, *махата*- аугаа, *йогах*- Бүхний Дээдтэй холбогдсон эрдэм ухаан, *наштах*- алдсан, *парантапа*- дайснаа дарагч, Аржуна минь.

Энэхүү дээдийн дээд эрдэм ухаан ийнхүү багш шавийн барилдлагааны гинжин хэлхээгээр дамжигддаг байсан бөгөөд ариун гэгээн хаад түүнийг ийм байдлаар л хүртдэг байсан. Харин цаг хугацаа улиран одох явцад энэхүү гинжин хэлхээ нь тасран эвдэрсэн учир энэ эрдэм ухаан нь алдагдсан мэт харагдмуй.

ТАЙЛБАР: Энэ шүлгээс үзэхэд Гита нь ариун гэгээн хаадад зориулагдсан гэдэг нь тодорхой. Учир нь, улс гүрнийхээ албат, иргэдийнхээ сайн сайхны төлөө Гитагийн зарчмуудыг бодит амьдралд хэрэгжүүлэх үүрэг тэдэнд ноогдсон байдаг. Бхагавад Гита нь түүний үнэ цэнийг хэнд ч ач тус болохгүйгээр бусниулан, байж болох бүхий л тайлбаруудыг өөрсдийн санаа зоргоор хийхийг оролдогч тэрсүүд үзэлтэнгүүд буюу асуруудад зориулагдаагүй гэдэг нь мэдээжийн хэрэг юм. Бүр анхны жинхэнэ утга учир нь өөрсдийн хувийн ашиг сонирхол дээрээ үндэслэн тайлбар хийгч цэцэрхэгчдийн зүгээс гуйвуулан мушгигдсан учраас багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээг дахин шинэчлэх шаардлагатай болсон. Таван мянган жилийн өмнө Бурхан Өөрөө багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээ тасарсныг тогтоон, иймээс мөн Бхагавад Гитагийн үнэн учир утга алдагдсан гэдгийг тунхагласан. Мөн эдүгээ цаг үед ч Гитагийн олон хэвлэлүүд (ялангуяа англи хэл дээр) байдаг хэдий ч эх сурвалж бүхий багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээний номлол сургаалтай нийцэх нь бараг үгүй байдаг. Материаллаг янз бүрийн эрдэмтэд, онолчид, номлогчдын хийсэн олон тооны тайлбарууд байдаг ч тэд бүгд Шри Кришнагийн айлдвараар үг хийж өөрсдөдөө ашиг хонжоо олоход ашигладаг мөртөө хэн нь ч Кришна бол Бурханы Дээд Бодьгал мөн гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй. Иймэрхүү байдал нь тэрсүүд буюу чөтгөрийн шинжтэй юм. Учир нь бурхангүй үзэлтнүүд нь Бурханд итгэдэггүй мөртөө Түүний эд баялгаас ашиглан таашаал ханамж авч байдаг. *Парампара* (багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээ)-аар уламжлагдан дамжиж ирсэнтэй таарч нийцсэн Гитагийн англи хэл дээрх хэвлэл яаралтай шаардлагатай байсан тул энэхүү асар том дутагдлыг арилгах үүднээс уг номыг хэвлэн гаргахыг чармайн оролдсон нь энэ билээ. Бхагавад Гитаг анх айлдсан төрх байдлаар нь ойлгож хүртэх нь хүн төрөлхтний хувьд маш аугаа адислал болох бөгөөд харин түүнийг зүгээр л нэг философийн цэцэрхийллийн ном хэвлэл мэтээр үзэж судлах аваас цагаа хий дэмий үрсэн хэрэг болно.

ШҮЛЭГ 3

*са эваям майа `дья йогах проктах пуратанах
бхакто `си ме сакха чети рахасьям хи этад уттамам*

сах-адил, *эва*- гарцаагүй, *аям*- үүнийг, *майа*- Надаас, *те*- чамд, *адья*- өнөөдөр, *йогах*- иогийн эрдэм ухаан, *проктах*- хэлсэн, *пуратанах*- маш эртний, *бхактах*- чин бишрэлтэн, *аси*- чи бол, *ме*- Миний, *сакха*- найз, *ча*- мөн, *ити*- иймээс, *рахасьям*- ид шид, *хи*- тодорхой, *этад*- энэхүү, *уттамам*- трансценденталь.

Чи Миний чин бишрэлтэн бөгөөд найз нөхөр минь болох учир мөн энэхүү эрдэм ухааны трансценденталь нууц ид шидийг ойлгож хүртэж чадах тул Бүхний Дээдтэй холбогдсон харьцаа холбооны тухай энэхүү өнө эртний эрдэм ухааныг Би чамд өнөөдөр нээн хүртээж байна.

ТАЙЛБАР: Чин бишрэлтэнгүүд болон тэрсүүд үзэлтэнгүүд буюу демонууд гэсэн хоёр янзын хүмүүс байдаг. Аржуна чин бишрэлтэн байсан учраас Бурхан түүнийг энэхүү аугаа чухал эрдэм ухааныг хүртэгч болгон сонгож байна. Демонуудын хувьд гэвэл энэхүү эрхэм дээд эрдэм ухааны нууцыг ойлгож хүртэнэ гэдэг боломжгүй хэрэг юм. Мэдлэгийн энэхүү аугаа номын олон хэвлэлүүд байдаг ба тэдгээрийн заримд нь чин бишрэлтэнгүүд тайлбар хийсэн байхад бусдыг нь демонууд тайлбарласан байдаг. Чин бишрэлтэнгүүдийн хийсэн тайлбар

үнэнд нийцсэн байдаг бол демонуудын хийсэн тайлбар ямар ч үнэ цэнэ, ач холбогдолгүй. Аржуна, Шри Кришна бол Бурханы Дээд Бодгаль мөн гэж хүлээн зөвшөөрч байгаа учир түүний үлгэр жишээг даган Бхагавад Гитаг тайлбарлаж байгаа хэн бүхэн нь энэхүү аугаа нандин чухал эрдэм ухаанд жинхэнэ чин бишрэл дүүрэн зүтгэж байгаа хэрэг юм. Тэгэхэд демонууд Шри Кришнаг жинхэнэ дүрх төрхөөр нь хүлээн зөвшөөрдөггүй. Харин түүний оронд тэд Кришнагийн тухай ямар нэгэн зүйл санаанаасаа зохион уншигчдыг Кришнагийн номлол сургаалын зам мөрөөс гажуудуулдаг. Энд иймэрхүү буруу замаар орж төөрөлдөхөөс сэрэмжлүүлэн анхааруулж байна. Аржунагаас эхлэлээ авсан багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээний зам мөрийг даган замнахыг хичээх хэрэгтэй. Зөвхөн тэгсэн цагт л Шримад Бхагавад Гитагийн энэхүү аугаа эрдэм ухаан бидэнд ач тусаа хайрлан хүртээх болно.

ШҮЛЭГ 4

аржуна увача

апарам бхавато жанма парам вивасватах

катхам этад вижаниям твам адау проктаван ити

аржуна увача- Аржуна айлтгасан, *апарам*- залуу, *бхаватах*- Таны, *жанма*- төрөлт, *парам*- ахмад, *вивасватах*- нарны сахиулсан тэнгэрийн, *катхам*- яаж, *этак*- үүнийг, *вижаниям*- би ойлгох ёстой, *твам*- Та, *адау*- эхэндээ, *проктаван*- номлосон, *ити*- ийм байдлаар.

Аржуна айлтгасан нь: Нарны тэнгэр Вивасван төрснөөрөө бол Танаас ахмад шүү дээ. Та энэхүү эрдэм ухааныг анх эхлээд түүнд айлдаж номлосон гэдгийг тань хэрхэн ойлгох вэ?

ТАЙЛБАР: Бурханы аугаа чин бишрэлтэн Аржуна нь Кришнагийн айлдварт хэрхэн итгэхгүй байх билээ. Үнэндээ, энэ асуултыг Аржуна өөрөө мэдэхгүйдээ буюу өөртөө хариулт авахын тулд биш, харин Бурханы Дээд Бодгальд үл итгэгчид хийгээд Кришна бол Бурханы Дээд Бодгаль мөн болохыг хүлээн зөвшөөрөхөөс татгалздаг демонуудад зориулан тавьсан хэрэг. Зөвхөн тэдний төлөө л тэр өөрөө Бурханы Дээд Бодгаль, Кришнагийн байр суурийг үл мэдэгчийн дүр эсгэсэн хэрэг. Кришна бол Бурханы Дээд Бодгаль хийгээд бүх оршнолын анхдагч эх булаг, Үнэмлэхүйн дээдийн дээд төлөв мөн болохыг Аржуна маш сайн мэддэг байсан нь арав дугаар бүлэгт тодорхой болно. Гэхдээ Кришна Девакийн хүү болон газар дэлхийд морилон бууж ирж заларсан нь үнэн билээ. Энэхүү Кришна нь мөнхийн анхдагч бодьгал, Бурханы Дээд Бодгаль мөн болохыг эгэл жирийн хүмүүсийн хувьд ойлгох нь маш хүнд. Ийм учраас энэ асуултыг Аржуна, Кришна Өөрөө жинхэнэ эх сурвалж болохын хувьд тайлбарлуулахаар Түүнд тавьж байна. Кришна бол дээдийн дээд эх сурвалж гэдгийг бүх дэлхий, ертөнц даяараа зөвхөн өнөөдөр ч биш өнө эртийн цагаас эхлэн хүлээн зөвшөөрдөг байхад зөвхөн демонууд л Түүнийг үл хүлээн зөвшөөрдөг. Иймд Кришна бүхнээр хүлээн зөвшөөрөгдсөн эх сурвалж мөн учир Аржуна энэ асуултыг, Кришнаг өөрсдийнхөө болон аялдан дагагч нарынхаа ойлголт, төсөөлөлд нийцүүлэхээр мушгин гуйвуулахыг үргэлжид оролдогч демонуудын тодорхойлолт, ойлголт төсөөлөлд няцаалт өгөхөөр Түүнд тавьснаар Тэр Өөрөө Өөрийгөө тодорхойлон айлдах болж байна. Хүн бүр өөрийн ач тусын төлөө Кришнагийн тухай эрдэм ухааныг мэдэх шаардлагатай. Иймээс Кришна Өөрийнхөө тухай айлдах нь бүхий л дэлхий ертөнцийн хувьд төгс адислал болох юм. Демонууд Кришнаг үргэлж, зөвхөн өөрсдийн байр сууринаас авч үзэж байдаг учир Кришнагийн айлдсан тайлбарууд нь тэдэнд хачирхалтай санагддаг. Харин чин бишрэлтэнгүүдийн хувьд Түүний Өөрийнхөө тухай айлдсан тайлбаруудыг машид их баяртайгаар хүлээн авдаг. Чин бишрэлтэнгүүд нь Түүний тухай улам бүр ихийг мэдэхийг үргэлжид тэмүүлэн байдаг учир Кришнагийн ийм эх сурвалж айлдваруудыг маш их бишрэлтэйгээр хүлээн авч байдаг. Кришнаг

эгэл жирийн хүн мэтээр үздэг атейстууд нь Түүний энэ айлдвараас Кришна бол хүн биш, Тэр бол *сач-чид-ананда-виграха* буюу мэдлэг хийгээд баяр цэнгэлийн мөнхийн дүр, Тэр бол трансценденталь бөгөөд материаллаг мөн чанарын гунуудын эрхшээлийн хийгээд цаг хугацаа, орон зайны нөлөөллийн чанадад оршдог гэдгийг таньж мэдэж болно. Аржуна шиг Кришнагийн чин бишрэлтэн нь Түүний трансценденталь байр суурины талаарх аливаа буруу зөрүү ойлголтуудаас ангид, дээгүүр байдаг гэдэг нь эргэлзээгүй хэрэг юм. Аржуна Кришнад энэхүү асуултыг тавьж байгаа явдал нь Түүнийг материаллаг байгалийн гунуудын эрхшээл нөлөөнд өртсөн эгэл жирийн хүн мэтээр үзэж байдаг хүмүүсийн атейст бодол, хандлагад няцаалт өгөх гэсэн чин бишрэлтэнгийн нэгээхэн оролдлого л юм.

ШҮЛЭГ 5

шири бхагаван увача

бахуни ме вьятитани жанмани тава чаржуна

тани ахам веда сарвани на твам веттха парантапа

шири бхагаван увача- Бурханы Дээд Бодгаль айлдсан , *бахуни*- олон удаа, *ме*- Миний, *вьятитани*- өнгөрсөн, *жанмани*- төрөлт, *тава*- чиний, *аржуна*- Аржуна минь, *тани*- энэ бүхэн, *ахам*- Би, *веда*- таньж мэддэг, *сарвани*- бүгд, *на*- үгүй, *твам*- чи, *веттха*- таньж мэддэг, *парантапа*- дайснаа дарагч минь.

Бурханы Дээд Бодгаль айлдсан нь: Би ч тэр, мөн чи ч тэр олон олон удаа төрөлтийг дамжин өнгөрөөсөн билээ. Тэр бүгдийн талаар Би бүгдийг нь эргэн санаж чаддаг байхад харин, ай дайснаа дарагч минь, чи чадахгүй билээ.

ТАЙЛБАР: Брахма-самхитагийн (5.33)-д Бурханы тоо томшгүй олон хувилгаан дүрүүд байдаг тухай өгүүлдэг.

адвайтам ачьютам анадим ананта-рупам

адьям пурана-пурушам нава-яуванам ча

ведешу дурлабхам адурлабхам атма-бхактау

говиндам ади-пурушам там ахам бхажами

“Би, анхдагч бодгаль, үнэмлэхүй, алдаа эндэгдэл үл гаргагч, эхлэл үгүй Бурханы Дээд Бодгаль, Говинда (Кришна)-д бишрэн мөргөнөм. Тэр хэдийгээр тоо томшгүй олон дүрд хувилдаг ч энэхүү анхдагч, хамгийн ахмад бодьгал хэвээрээ байдгийн зэрэгцээ үргэлжийн мөнх залуу харагддаг. Бурханы энэхүү мөнхийн, баяр жаргалтай хийгээд бүхнийг мэдэгч дүрүүдийг чухамдаа зөвхөн Ведийн гүн мэдлэгтэнгүүд л ойлгох боловч цэвэр, жинхэнэ чин бишрэлтэнгүүдэд Тэд үргэлж харагддаг билээ.”

Брахма-самхитагийн (5.39)-д мөн өгүүлэхдээ:

рамади муртишу кала-ниямена тишитхан

нанаватарам акарод бхуванешу кинту

кришнах сваям самабхават парамах пуман ио

говиндам ади-пурушам там ахам бхажами

“Би, Рама, Присимха зэрэг хувилгаан дүрүүд болон өөр олон хэсэгчилсэн хувилгаан дүрүүдээр Өөрийгөө үргэлж илрүүлэн тодруулахын зэрэгцээ мөн энэ дэлхийд Өөрийн анхдагч дүр болох Кришнагийн дүрээр морилон бууж ирдэг Бурханы анхдагч Бодгаль, Бүхний Дээд Бурхан Говинда (Кришна)-д бишрэн мөргөнөм.”

Үүнийг мөн Ведэд батлан өгүүлсэн байдаг: Бурхан хэдийгээр цор ганцаар боловч Тэр Өөрийгөө тоо томшгүй олон дүрүүдэд илрүүлэн тодруулдаг. Тэрээр өнгө нь өөрчлөгдөвч өөрөө тэр л хэвээрээ байдаг *вайдурья* чулуутай төстэй юм. Энэ бүх олон янзын дүрүүдийг жинхэнэ цэвэр чин бишрэлтэнгүүд л ойлгохоос биш зөвхөн Ведийг судалснаар хязгаарлах хүмүүс (*ведешу дурлабхам адурлабхам атма-бхактау*) бол үгүй. Аржуна шиг чин бишрэлтэнгүүд нь Бурханы байнгын дагуул, бараа бологсод байдаг бөгөөд Бурхан Өөрийн хувилгаан дүрээр материаллаг ертөнцөд морилон бууж ирэхэд Түүнд ямар нэгэн байдлаар үйлчлэн зүтгэхээр бараа бологчидын дүрээр хамт ирдэг. Аржуна бол эдгээр чин бишрэлтэнгүүдийн нэг бөгөөд энэ шүлгээс үзэхэд олон сая жилийн өмнө Бурхан Кришна Бхагавад Гитаг нарны сахиулсан тэнгэр Вивасванд айлдан номлох үед Аржуна мөн өөр нэгэн дүрээр Түүнтэй хамт байлцсан байна. Аржунаг бодоход Бурхан энэ үйл явдлын талаар эргэн санаж чадаж байна. Энэ бол Бүхний Дээд Бурхан болон Түүнээс гаралтай өчүүхэн жижиг хэсэг бие даасан амьд оршнол хоёрын ялгаа юм. Хэдийгээр Аржуна энд дайснаа ялан дийлж чадах, хүчирхэг баатар эр гэж нэрлэгдэж байгаа ч өөрийн өнгөрсөн үеийн янз бүрийн амьдралуудад тохиолдож, болсон үйлүүдийг эргэн дурсан санах чадваргүй байна. Иймээс амьд оршнол нь материаллаг байр сууринаас үнэлж цэгнэж үзэхэд хичнээн хүчирхэг аугаа байсан ч Бүхний Дээд Бурхантай хэзээ ч эн зэрэгцэхгүй юм. Тэр бүү хэл Бурханы байнгын бараа болгогч дагуулууд нь болох ангижирсан байх нь ямар ч эргэлзээгүй сүнснүүд хүртэл Түүнтэй адил чацуу байж чаддаггүй. Брахма-самхитад Бурханыг алдаа эндэгдэл үл гаргагч (*ачьюта*) гэж нэрлэж байгаа нь Тэр хэзээ ч, материаллаг ертөнцөд морилон бууж ирсэн байсан ч, Өөрийн байр байдлаа мартдаггүй гэсэн утгатай юм. Иймээс амьд оршнол нь Аржуна шиг ангижралыг олсон байлаа ч аль ч талаараа Бурхантай хэзээ ч эн зэрэгцэхгүй юм. Аржуна хэдийгээр Бурханы чин бишрэлтэн мөн боловч заримдаа Бурханы жинхэнэ байр суурийг мартаж байна. Гэхдээ чин бишрэлтэн нь Бурханы өршөөл нигүүлслээр мөдхөн л Бурханы алдаа эндэгдэл үл гаргагч мөн чанарыг ойлгодог байхад чин бишрэлтэн бусчууд болон демонууд нь энэхүү трансценденталь мөн чанарыг ойлгодоггүй. Иймээс Гитагийн энэхүү болон бусад адил төстэй шүлгүүдийн утгыг демонлог буюу тэрсүүд ухаан бодолтой хүмүүс ойлгох аргагүй юм. Кришна Өөрийн сая сая жилүүдийн өмнө үйлдсэн үйлүүдээ эргэн санаж байхад Аржуна хэдийгээр Түүн лугаа мөнхийн шинж чанартай ч Түүний нэгэн адил эргэн санаж чадахгүй байна. Өөрийн *сач-чид-ананда* биеийг хэзээ ч сольдоггүй учраас Бурхан бүхнийг эргэн санаж чаддаг байхад амьд оршнолууд нь өөрсдийн бие махбодийг сольдог учраас бүхнийг мартдаг нь эндээс мөн харагдаж байна. Тэр бол *адвайта* буюу Түүний бие болон Тэр хоёрын хооронд ямар ч ялгаа байдаггүй юм. Түүнтэй холбогдсон бүхэн бурханлаг байхад болзолт сүнс нь өөрийн материаллаг бие махбодиос ялгаатай байдаг. Бурхан Өөрөө болон Түүний бие нь ижил учраас Тэр материаллаг ертөнцөд морилон бууж ирсэн байсан ч Түүний байр суурь эгэл жирийн амьд оршнолынхоос үргэлж ялгаатай байдаг. Дараагийн шүлэгт Бурхан Өөрөө тайлбарлан айлдах энэхүү трансценденталь мөн чанарыг демонууд ойлгож хүлээн авах чадваргүй байдаг.

ШҮЛЭГ 6

*ажо `пи санн авьяятма бхутанам ишваро `пи сан
праkritим свам адхитхая самбхавамй атма-мая*

ажсах- төрөөгүй, *ати*- хэдий ч, *сан*- ийм болохын хувьд, *авьяя*-эвдрэл сүйрэлгүйгээр, *атма*- бие махбодь, *бхутанам*- төрсөн байх бүхэн, *ишварах*- Бүхний Дээд Бурхан, *ати*- хэдий ч, *сан*- ийм болохын хувьд, *праkritим*- трансценденталь дүрд, *свам*- Миний Өөрийн, *адхитхая*- орсоноор, *самбхавами*- Би Өөрийгөө хувилдаг, *атма-мая*- Өөрийн дотоод эрчмээрээ.

Хэдийгээр Би төрдөггүй хийгээд Миний трансценденталь бие хэзээ ч устан үгүй болдоггүй, мөн түүнчлэн хэдийгээр Би бүх амьд оршнолуудын эзэн захирагч боловч Би эрин галав бүрд Өөрийн анхдагч трансценденталь дүрээрээ морилон бууж ирдэг.

ТАЙЛБАР: Бурхан өмнөх шүлэгт Өөрийн төрөлтийн онцлог байдлын талаар өгүүлсэн: Тэр хэдийгээр эгэл жирийн хүн мэтээр илэрч тодрох боловч Өөрийн өнгөрсөн тоо томшгүй олон удаагийн “төрөлтийн” үед болсон бүхнийг эргэн санадаг байхад эгэл жирийн хүн хэдэн цагийн өмнө хийсэн зүйлээ ч эргэн санаж чаддаггүй билээ. Хэн нэгэн хүнээс өчигдөр яг энэ цаг үед юу хийснийг нь асууваас эгэл жирийн хүн түүний хувьд шууд хариулахад маш хэцүү байх болно. Тэрээр яг нэг өдрийн өмнө юу хийж байснаа эргэн санахын тулд өөрийн ой санамжаа хүчлэн шавхах нь эргэлзээгүй. Хэдийгээр ийм байдалтай байдаг боловч өөрсдийгөө бид бол Бурхан, би бол Кришна хэмээн батлахыг оролдогч хүмүүс байдаг. Тэдний өөрсдийгөө ийнхүү ямарч утгагүйгээр өргөмжлөх явдалд төөрөлдөж хууртагдаж болохгүй.

Харин дараа нь Бурхан Өөрийн *пракрити* (дүр)-ийн талаар тайлбарлаж байна. *Пракрити* гэдэг үгийг байгаль ба *сварупа* (анхдагч дүр) гэсэн хоёр янзаар орчуулж болно. Бурхан айлдахдаа: Тэрээр эгэл жирийн амьд оршнол нэг бие махбодиос нөгөө бие махбодид дамжин шилжиж байдаг шиг Өөрийн биеэ хэзээ ч сольдоггүй учир материаллаг ертөнцөд морилон бууж ирэхдээ ч Өөрийн биеэр залардаг. Болзолт сүнс нь одоогийн энэ амьдралдаа бие махбодийн тодорхой нэгэн хэлбэрт байдаг ч дараагийн амьдралдаа өөр нэгэн бие махбодийг аван төрдөг. Материаллаг ертөнцөд амьд оршнол нь тогтсон нэг бие махбодид оршдоггүй, харин нэг бие махбодиос нөгөө бие махбодид шилжин байдаг. Харин Бурхан бол тийм биш. Тэр морилох бүрдээ дотоод эрчмийнхээ хүчээр Өөрийн анхдагч биеэрээ л залардаг. Өөрөөр хэлбэл, Кришна энэ материаллаг ертөнцөд Өөрийн анхдагч мөнхийн буюу лимбэ барьсан хоёр мутартай дүрээрээ залардаг. Тэр Өөрийн жинхэнэ дүр төрхөөрөө, материаллаг ертөнцийн бузарт хэзээ ч үл өртөх мөнхийн тэр биеэрээ залардаг. Бурхан материаллаг ертөнцөд бурханлаг биеэрээ залардаг хийгээд орчлонгийн эзэн мөн хэдий ч Тэр жирийн хүн төрөх лугаа илэрч тодордог. Түүний бие нь материаллаг бие махбодь мэт өөрчлөлт хувиралтанд хэзээ ч үл өртөх боловч бага балчираас өсөх нас, өсөх наснаас идэр залуу болтлоо өсөн том болж байгаа мэт харагддаг. Харин Тэр идэр наснаас цааш хөгширч өөрчлөгддөггүй үргэлж залуугаараа үлддэг нь хамгийн гайхалтай. Курукшетрын тулалдаан болох үед Шри Кришна хэдийнээ олон ачтай болсон байсан буюу материаллаг тооцоогоор бол Тэр нилээд өндөр настай байв. Гэсэн хэдий ч Тэрээр хоринтаван настай мэт идэр залуу харагдаж байсан. Бүхий л бүтээлийн хэмжээ хүрээнд өнгөрсөн цаг үед ч, одоо цаг үед ч, мөн ирээдүйд ч Тэр хамгийн ахмад нь боловч бид нар шиг хэзээ ч өтөлж хөгширдөггүй учир Кришнагийн хөгширсөн байдалтай байх дүр зургийг бид олж хардаггүй. Түүний бие, мөн Түүний оюун ухаан нь хэзээ ч доройтон муудаж, өөрчлөгдөж хувирдаггүй. Эндээс үзэхэд, Тэр материаллаг ертөнцөд морилохдоо ч тэрхүү үл төрдөг, мэдлэг хийгээд баяр цэнгэлийн мөнхийн дүрээрээ заларч байдаг хийгээд Түүний бурханлаг бие болон Түүний бурханлаг оюун ухаан хувирч өөрчлөгддөггүй нь тодорхой. Түүний морилон ирэх болон морилон одохыг бидний өмнө тэнгэрт мандан гийж дараа нь дахин бидний хараанаас холдон жаргах нартай зүйрлэж болох юм. Нар харагдахаа больмогц бид нар жаргалаа, харин нар тэнгэрт харагдан гийж эхэлмэгц бид нар мандлаа гэж ярьцгаадаг. Гэвч үнэн хэрэгтээ нар үргэлж өөрийн тогтоогдсон байрандаа байж байхад бид өөрсдийн мэдрэхүйн төгс төгөлдөр бус байдлаасаа болж нар мандлаа, жаргалаа гэгцгээдэг. Кришна морилон ирэх хийгээд морилон одох нь эгэл жирийн амьд оршнолын төрөх болон үхэхээс үндсээрээ ялгаатай байдаг учраас Тэр Өөрийн дотоод эрчмийн эрч хүчээр үргэлжийн мөнх, мэдлэг болоод баяр цэнгэлээр бялхан дүүрэн байдаг бөгөөд материаллаг мөн чанарт хэзээ ч бузартдаггүй нь илэрхий. Ведэд, Бурханы Дээд Бодьгал нь янз бүрийн дүрээр илэрч тодрохдоо буюу залрахдаа төрж байгаа мэт харагдах боловч төрдөггүй гэдгийг мөн батлан өгүүлдэг. Мөн Ведийн нэмэлт судруудад, Бурхан төрж байгаа мэт харагдах боловч Тэр Өөрийн биеийг хэзээ ч сольдоггүй гэж батлан өгүүлсэн байдаг. Бхагаватамд, Тэр Өөрийн эхийн өмнө бүхий л зургаан гайхамшигт төгс төгөлдөр байдлаа

агуулан дөрвөн мутар бүхий Нараянагийн дүрээр хэрхэн илэрч тодорч заларсан тухай өгүүлдэг. Бурхан Өөрийн анхдагч мөнхийн дүрээрээ материаллаг ертөнцөд залрах нь амьд оршнолуудад хүртээж байгаа Түүний учир шалтгаангүй өршөөл нигүүлсэл байдаг. Үүний ач тусаар л тэд өөрсдийн ухаан бодлоо Бурханы Дээд Бодгалийг Түүний жинхэнэ дүрд нь, имперсоналистууд буюу бодгаль бусыг баримтлагчдын зүгээс Түүний дүрийн талаар буруугаар бодож олсон ухаан бодлын цэцэрхийлэл хийгээд хийсвэрлэлийн нөлөөнд оролгүйгээр төвлөрүүлж чаддаг. Вишва-коша толь бичгийн дагуу бол *майа* буюу *атма-майа* гэдэг үг нь Бурханы учир шалтгаангүй өршөөл нигүүлслийг зааж байдаг. Бурхан өнгөрсөн үеүдэд Өөрийн дүрүүдээрээ хэрхэн илэрч тодорсон болоод морилон одсон тухайгаа бүгдийг нь санаж байхад эгэл жирийн амьд оршнол дахин нэг шинэ бие махбодид төрмөгц өнгөрсөн амьдралынхаа талаарх бүхнийг мартдаг. Бурхан газар дэлхий дээр заларч байхдаа хүний хүч чадал, хир хэмжээнээс даван гарсан илүү дээд, гайхамшигтай үйлүүдийг үйлдэн байдаг учир Тэр бүх амьд оршнолуудын эзэн юм. Иймээс Бурхан үргэлж, үл өөрчлөгддөг Үнэмлэхүй Үнэн хэвээр байдаг бөгөөд Түүний дүр хийгээд Түүний Өөрийн нь хооронд буюу Түүний бие хийгээд Түүний шинж чанаруудын хооронд ялгаа байдаггүй. Бурхан энэ ертөнцөд ямар учраас морилон ирдэг хийгээд мөн морилон оддог тухай асуулт гарч болох юм. Энэ тухай дараагийн шүлэгт тайлбарлана.

ШҮЛЭГ 7

*яда яда хи дхармасьа гланир бхавати бхарата
абхьюттханам адхармасьа тадатманам срижсами ахам*

яда яда- хэзээ болон хаана ч, *хи*- зайлшгүй, *дхармасьа*- шашны, *гланих*- гажуудал, *бхавати*- бий болох, *бхарата*- Бхаратын үр удам минь, *абхьюттханам*- ноёрхол, *адхармасьа*- буруу шашны, *тада*- энэ үед, *атманам*- Өөрийгөө, *срижсами*- илрүүлж тодруулдаг, *ахам*- Би.

Шашин шүтлэг доройтон унахад болон бурхангүйн үзэлтэнгүүд ноёрхох тэр газарт, тэр цагт л, ай Бхаратын үр удам минь ээ, Би морилон бууж ирдэг билээ.

ТАЙЛБАР: Энэ шүлэгт хэрэглэгдэж байгаа *срижсами* гэдэг үг онцгой ач холбогдолтой. Өмнөх шүлэгт Бурханы бие болоод хэлбэр дүр нь мөнх тул хэзээ ч бүтээгддэггүй гэж өгүүлсэн учир энэ үгийг “бүтээл” гэсэн утгаар ойлгож болохгүй юм. Иймээс *срижсами* гэдэг үг нь Бурхан Өөрийн байгаа дүр байдлаараа морилон залардаг гэсэн утгыг илэрхийлнэ. Бурхан материаллаг ертөнцөд хэдийгээр тодорхой төлөвлөгөөний дагуу, тухайлбал Брахмын нэг өдөр нэг удаа, долоо дахь Манугийн 28 дахь юга-ын эргэлтийн Двапара юга-ын төгсгөлд морилон бууж ирдэг боловч Тэр энэхүү журам болоод хугацааг хатуу барих албагүй. Учир нь Тэр бүрэн чөлөөтэй бөгөөд үйлээ Өөрийн хүсэл тааллаараа олон янз байдлаар үйлдэж байдаг. Иймээс Тэр жинхэнэ шашин шүтлэг хавчигдан гадуурхагдаж хуурмаг шашны үзэл ноёрхох үед Өөрийн тааллаараа морилон бууж ирдэг. Шашны зарчмуудыг Ведэд тогтоож өгсөн байдаг ба ведийн журам дүрмийг зөв биелүүлэхээс гажсан аливаа гажуудал нь хүмүүсийг шашин бусын үзэл рүү хөтлөн оруулдаг. Энэхүү зарчмууд нь Бурханы хуулиуд юм гэж Бхагаватамд тайлбарладаг. Гагцхүү Бурхан л ганцаараа шашны журам тогтолцоог бүтээн бий болгодог. Мөн, Ведүүдийг анх эхлээд Бурхан айлдсан хийгээд тэдгээрийг Брахмын зүрхэнд нээн хүртээсэн гэдэг нь хүлээн зөвшөөрөгдсөн тодорхой зүйл. Иймээс, *дхарма-ын* буюу шашны зарчмууд нь Бурханы Дээд Бодгалийн шууд сургаал зааврууд юм (*дхарма ту сакшиад бхагават-пранитам*). Энэ зарчмуудын талаар Бхагавад Гитад олонтоо тодорхой заасан байдаг. Ведийн зорилго, зориулалт нь Бурханы Дээд Бодгалийн сургаал зааврын дагуу ийм зарчмуудыг тогтоох явдал байдаг бөгөөд Гитагийн төгсгөлд Бурхан, шашны дээдийн дээд зарчим бол бусад бүхнээс татгалзан огоорч ганцхан Түүнд л өөрийгөө даатгахад оршдог гэж тодорхой айлддаг. Ведийн зарчмууд нь хүнийг энэ зорилгын чиглэлд буюу Бурханд бүрнээ даатгахад

хөтлөн хүргэдэг бөгөөд энэхүү зарчмуудад демонлог хүмүүсийн зүгээс саад тотгор болох үе бүрт Бурхан морилон бууж ирдэг. Энэ дэлхий дээр материаллаг хүч түрэмгийлэн давамгайлж, материалистууд Ведийн нэр хүнд, эх сурвалжийг өөрсдийн буруу, муу дадал зуршлаа зөвтгөхөд ашиглах ая шалтаг болгох үед Кришнагийн хувилгаан дүр Будда заларсан гэдгийг Бхагаватамаас бид мэдэх билээ. Зөвхөн маш тодорхой зорилгоор үйлддэг амьтнаар өргөл өргөх тахилгад зориулсан олон тооны хязгаарлалт, цээр бүхий дүрэм журам болон үүргүүд Ведэд байдаг боловч тэр үед демонлог дур сонирхол бүхий хүмүүс Ведийн зарчмуудыг хайхралгүйгээр энэхүү өргөл тахилгуудыг үйлдэх болсон. Иймээс энэхүү учир утгагүй үйлийг эцэс болгох хийгээд ведийн хүч үл хэрэглэн энэрэн нигүүлсэхүйн үндсэн зарчмуудыг дахин сэргээхээр Бурхан Будда морилон бууж ирсэн. Өөрөөр хэлбэл, бүхий л *аватарууд* (Бурханы хувилгаанууд) нь тодорхой нэгэн үүрэг зорилготойгоор материаллаг ертөнцөд морилон бууж ирдэг бөгөөд энэ бүх *аватаруудыг* ариун гэгээн судруудад тодорхойлон өгүүлсэн байдаг. Хэрвээ сударт дурьдагдаагүй л бол хэнийг ч *аватара* гэж хүлээн зөвшөөрөх ёсгүй. Бурхан зөвхөн Энэтхэгийн газар нутагт залардаг гэж бодож болохгүй. Бурхан Өөрийн тааллын дагуу хаана ч, хэдийд ч морилж болно. Тэрээр хувилгаан дүр бүрээрээ хүмүүст, амьдралын нөхцөл байдал болон хөгжлийн түвшингээсээ хамааран ойлгож хүлээж авч чадах хэмжээнд нь тохируулан шашны тухай номлож сургадаг. Гэхдээ *аватара* бүрт нэг л үүрэг зорилго байдаг. Энэ нь хүмүүст Бурханы ухамсарыг хөгжүүлэхэд туслах болон тэднийг шашны зарчим, сургаалуудыг дуулгавартайгаар дагаж мөрдөхөд хүргэх явдал юм. Заримдаа Бурхан Өөрийн дүрээр морилон бууж ирдэг бол заримдаа Өөрийн жинхэнэ элч төлөөлөгчийг Өөрийн хүүгийн эсвэл албатын дүрээр илгээхийн зэрэгцээ мөн зарим үед Тэр Өөрөө нууцлагдмал дүрээр ч залардаг.

Аржуна нь дэлхийн бусад хэсэгт орших эгэл жирийн хүмүүсийг бодвол бурханлаг хөгжлийн хувьд илүү өндөр түвшинд хүрсэн байсан учраас Бурхан Бхагавад Гитагийн зарчмуудыг түүнд, тэгснээрээ бусад эрхэм дээд хүмүүст ч мөн нэгэн адил нээн хүртээж байна.

Хоёр дээр хоёрыг нэмэхэд дөрөв гардаг нь энгийн тооцоонд ч мөн дээд тоонд ч хүчин төгөлдөр зөв байдаг математикийн илэрхийлэл билээ. Гэхдээ л дээд болон энгийн математик нь ялгаатай. Үүний нэгэн адил Бурханы бүхий л хувилгаан дүрүүд ижил зарчмуудыг номлодог ч янз бүрийн нөхцөл байдлаас хамааран тэдний номлол дээд, доод янз бүрийн түвшинд байдаг. Нийгмийн амьдралын дөрвөн хэвшил болоод үе шат бүхий тогтолцоог хүлээн зөвшөөрч даган баримталснаар л илүү дээд шашны зарчмуудын түвшин эхэлдэг талаар хожим тайлбарлах болно. Хувилгаан дүр бүрийн цорын ганц даалгавар бол Кришнагийн ухамсарыг хаа сайгүй сэргээх явдалд оршдог. Энэ ухамсар нь тухайн нөхцөл байдлаас хамааран нийгэмд нэг үе илрэн бий болж байхад зарим үед үгүй байдаг.

ШҮЛЭГ 8

*паритраная садхунам винашая ча душкритам
дахма-самстхапанартхая самбхавами юге юге*

паритраная- авралын төлөө, *садхунам*- чин бишрэлтэнгүүдийн, *винашая*- устгалын тулд, *ча*- болон, *душкритам*- бурхангүйчүүдийн, *драхма*- шашны зарчмууд, *самстхапана-артхая*- шинэчлэхээр, *самбхавами*- Би морилдог, *юге*- цаг үеэс, *юге*- цаг үед.

Зөв шудрага үзэлтэнгүүдийг авран чөлөөлөх, гай зовлон таригч бурхангүйчүүдийг хөнөөн дарах болон шашны зарчмуудыг дахин сэргээн тогтоохоор Би нэг галваас нөгөө галавт морилон бууж ирдэг.

ТАЙЛБАР: Бхагавад Гитад тодорхойлон өгүүлсний дагуу бол *садху* буюу ариун гэгээн хүн нь Кришнагийн ухамсарт оршин байдаг. Гадна талдаа бишрэл шүтлэггүй мэт харагдаж байсан ч

Кришнагийн ухамсрын шинж чанаруудыг бүрэн хэмжээгээр агуулсан байх хүнийг *садху* гэж үзэх хэрэгтэй. *Душкритам* гэдэг үг нь Кришнагийн ухамсарт үл татагдагч хүнд хамааралтай. Иймэрхүү бурхангүйн үзэлт хүмүүс (*душкритам*)-ийг материаллаг боловсролын талдаа гаргууд сайн байсан ч тэнэг мангуу хийгээд хүн төрөлхтний хамгийн доод түвшингийн төлөөлөгчид буюу адаг шаар гэж нэрлэдэг. Харин төдийлөн сайн боловсрол эзэмшээгүй ч Кришнагийн ухамсарт зуун хувь буюу бүрнээ автсан хүнийг *садху* гэж үздэг. Бурхангүйчүүдийг даран хөнөөхийн тулд гэвэл Бүхний Дээд Бурхан нь Равана болон Камса зэрэг демонуудыг устгасан шигээр заавал Өөрөө биечлэн залрах шаардлагагүй байдаг. Демонуудыг ямар ч хүндрэл бэрхшээлгүйгээр хөнөөн дарах чадвартай олон туслагчид Бурханд байдаг. Бурхан материаллаг ертөнцөд юуны өмнө эн тэргүүнд, демонуудын зүгээс амар заяа үзүүлэхгүй байгаа Өөрийн цэвэр чин бишрэлтэнгүүддээ туслах үүднээс л морилон бууж ирдэг. Демонууд чин бишрэлтэнгүүдийг өөрсдийн нь ойр дотнын төрөл садан байсан ч ялгаагүй мөрдөн мөшгиж байдаг. Хираньякашипу бол Прахлада Махаражагийн эцэг нь байсан хэдий ч түүнийг байнгад зовоож, мөн Кришнагийн ээж Деваки нь Камсагийн охин дүү нь байсан хэдий ч зөвхөн Кришна түүний хүү болон төрөх ёстой гэсэн шалтгаар л түүнийг болон түүний нөхөр Васудева нарыг мөрдөн мөшгиж байв. Шри Кришна хэдийгээр Камсаг устгаж Девакиг аварсан буюу энэ хоёр үйлийг хоёуланг нь нэгэн зэрэг үйлдсэн ч хамгийн гол нь Камсаг устгахаасаа Девакиг аврахаар морилон бууж ирсэн. Тийм учраас энд, Бурхан чин бишрэлтэнгүүдээ авран чөлөөлөх болон бурхангүйн үзэлт демонуудыг хөнөөн дарахаар янз бүрийн хувилгаан дүрүүдээрээ залардаг гэж өгүүлж байна.

Кришнадаса Кавиража Чайтанья-чаритамрита-гийн (Мадхья, 20.263-264)-д Бурханы хувилгаан гэж хэн байдаг талаар тодорхойлсон:

*шишти-хету еи мурти прапаньче аватаре
сеи ишвара-мурти “аватара” нама дхаре
майатита паравьоме сабара авастхана
вишве аватари` дхаре “аватара” нама*

“Бурханы хувилгаан буюу аватар нь материаллаг ертөнцөд илэрч тодрохоор Бурханы орноос морилон бууж ирдэг. Бурханы Бодгалийн морилон бууж ирж буй энэ дүрийг *аватара* буюу хувилгаан дүр гэж нэрлэдэг. Эдгээр хувилгаанууд нь Бурханы орны буюу бурханлаг ертөнцийн оршин суугчид бөгөөд материаллаг ертөнцөд морилон бууж ирсэн үедээ тэд *аватара* гэж нэрлэгддэг.”

Янз бүрийн төрлийн *аватарууд* байдаг, тухайлбал *пуруша-аватара*, *гуна-аватара*, *лила-аватара*, *шактьавеша-аватара*, *манвантара-аватара* болон *юга-аватара*. Тэд бүгд тодорхой төлөвлөгөөний дагуу орчлонгийн хаа нэгтэй морилон бууж ирдэг. Харин Шри Кришна бол энэ бүх *аватаруудын* эх булаг бөгөөд анхдагч Бурхан. Вриндавана дахь Түүний юутай ч үл зүйрлүүлэм наадам, зугаа цэнгэлийг харахын хүслэн болж буй Өөрийн чин бишрэлтэнгүүдийнхээ гачаал зовлонг хөнгөлөх онцгой зорилгоор Шри Кришна материаллаг ертөнцөд морилон буун ирж залардаг. Иймээс Кришна-*аватарын* гол зорилго нь Өөрийн чин бишрэлтэнгүүдээ баярлуулан баясгах явдал байдаг. Бурхан галав бүрт залрана хэмээн айлдаж байгаа нь Тэр мөн Калийн галавт ч залардаг гэсэн үг юм. Шримад Бхагаватамд өгүүлснээр, Кали юга дахь Бурханы хувилгаан дүр нь Кришнагийн ухамсрыг бүх Энэтхэг даяар түгээн дэлгэрүүлж *санкиртана* хөдөлгөөнөөр (ариун гэгээн нэр алдруудыг хамтдаа магтан дуулах) Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэхийг номлосон Шри Чайтанья Махапрабху юм. Тэрээр энэхүү *санкиртана* хөдөлгөөн нь энэ дэлхий даяар хаа сайгүй нэг хотоос нөгөө хотод, нэг тосгоноос нөгөө тосгонд түгэн дэлгэрнэ гэж гэж урьдчилан айлдсан. Упанишад, Махабхарата болон Бхагаватам зэрэг ариун гэгээн судруудын хамгийн эрхэм нандин чухал хэсгүүдэд Шри Чайтаньяг Бурханы Дээд Бодгаль Кришнагийн хувилгаан дүр гэж шууд бус байдлаар битүү далд тодорхойлон өгүүлсэн байдаг. Шри Кришнагийн чин бишрэлтэнгүүд нь Шри Чайтаньягийн *санкиртана* хөдөлгөөнд маш ихээр татагддаг. Бурханы энэхүү *аватара* нь

бурхангүйн үзэлт хүмүүсийг хөнөөн дарахын оронд Өөрийн учир шалтгаангүй өршөөл нигүүлслээр тэднийг авардаг.

ШҮЛЭГ 9

*жанма карма ча ме дивьям эвам йо ветти таттваатах
тьяктава дехам пунах жанма найти мам эти со`ржуна*

жанма- төрөлт, *карма*- үйлүүд, *ча*- мөн, *ме*- Миний, *дивьям*- трансценденталь, *эвам*- ийм байдлаар, *ях*- тэр, *ветти*- таньж мэддэг, *таттваатах*- үнэн байдалд, *тьяктава*- орхисноор, *дехам*- энэхүү бие махбодийг, *пунах*- дахин, *жанма*- төрөлт, *на*- хэзээ ч үгүй, *эти*- хүрдэг, *мам*- Надад, *эти*- хүрдэг, *сах*- тэр, *аржуна*- Аржуна.

Миний илрэн залрахуйн хийгээд Миний үйлийн трансценденталь мөн чанарыг таньж мэдсэн хэн бүхэн бие махбодио орхисны дараагаар материаллаг ертөнцөд дахин төрдөггүй. Ай Аржуна минь ээ, тэд Миний мөнхийн оронд хүрч очдог.

ТАЙЛБАР: Бурхан Өөрийн трансценденталь орноос хэрхэн морилон бууж ирдэг талаар зургаа дугаар шүлэгт тайлбарласан билээ. Бурханы Бодгалийн залрахуйн үнэнийг ойлгож байгаа хэн бүхэн материаллаг боолчлолоос хэдийнээ ангижирсан байдаг ба иймээс одоогийн оршин байгаа бие махбодио орхисны дараагаар Бурханы оронд шууд буцаж очих болно. Гэхдээ амьд оршнолын хувьд материаллаг олзлогдлын савраас чөлөөлөгдөн ангижрана гэдэг тийм ч амар хялбар хэрэг биш. Имперсоналистууд болон иогчид нь маш их хүндрэл бэрхшээлийг туулан олон олон амьдралын дараагаар л ангижралд хүрдэг. Бурханы бодгаль бус *брахмажсьотид* уусан нэгдэж байгаа тэдний энэхүү ангижрал нь ч бүрэн төгс бус байдаг бөгөөд тэдний хувьд материаллаг ертөнцөд дахин буцан унах аюул нүүрэлсээр байх болно. Харин тэгэхэд чин бишрэлтэнгүүд нь Бурханы үйлүүд хийгээд Түүний биеийн трансценденталь мөн чанарыг ойлгож мэдсэнээр л энэхүү бие махбодио орхисны дараагаар Бурханы залран байгаа оронд дээшлэн хүрч очих бөгөөд материаллаг ертөнцөд дахин буцаж унах аюул нүүрлэхгүй. Брахма-самхитагийн (5.33)-д өгүүлсэнчлэн, Бурхан тоо томшгүй олон хэлбэр хийгээд дүрүүдэд хувилан илэрч тодордог: *адвайтам ачьютам анадим ананта-рунам*. Тоо томшгүй олон трансценденталь дүрүүд байдаг хэдий ч тэд бүгд цөм нэг л Бурханы Дээд Бодгаль байдаг билээ. Энэхүү баримт нь материаллаг эрдэмтэд хийгээд эмпирик философчдын хувьд ойлгохын аргагүй зүйл байдаг хэдий ч түүнийг итгэл үнэмшилтэй байж ойлгож ухаарах хэрэгтэй. Ведэд (Пуруша-бодхини Упанишад-д) өгүүлсэнчлэн:

*эко дево нитья-лилануракто
бхакта-вьяпи хриди антар-атма*

“Цорын ганц Бурхан, Бурханы Дээд Бодгаль нь тоо томшгүй олон трансценденталь дүрүүдээрээ Өөрийн хольцоогүй цэвэр чин бишрэлтэнгүүдтэйгээ хайраар дүүрэн солилцох мөнхийн харьцаануудаар харьцаж байдаг билээ.”

Ведийн энэхүү нотолгоог Бурхан Өөрөө Гитагийн энэ шүлэгт баталж байна. Энэхүү үнэнийг Бурханы Дээд Бодгалийн болон Ведийн эх сурвалж дээр үндэслэж тулгуурлан хүлээн зөвшөөрч, өөрийн цагаа философийн цэцэрхийлэлд хий дэмий хоосон үрэхгүй байгаа хэн бүхэн ангижралын дээдийн дээд төгс төгөлдөрт хүрнэ. Энэхүү үнэнийг итгэл бишрэлтэйгээр хүлээн зөвшөөрч байгаа хүн л ямар ч эргэлзээгүйгээр ангижралд хүрнэ. *Тат твам аси* гэсэн Ведийн цэцэн үг энд жинхэнэ биеллээ олж байна: Шри Кришна бол Дээдийн Дээд гэдгийг ойлгож ухааран Түүнд хандан “Та бол Дээдийн Дээд Брахман, Бурханы Бодгаль” хэмээн айлтгаж байгаа хэн бүхэн мөдхөн ангижралыг олох нь гарцаагүй бөгөөд ингэснээр тэр Бурханы

трансценденталь хүрээлэлд орох нь баталгаатай. Өөрөөр хэлбэл, ийм итгэл бишрэл бүхий чин бишрэлтэн төгс төгөлдөрт хүрдэг бөгөөд энэ тухай ведийн дараах шүлэгт батлан өгүүлдэг:

*там эва видитвати мритьюм эти
наньях пантха видьяте яная*

“Бурханыг, Бурханы Дээд Бодгалийг таньж мэдсэн хүн л төрөлт үхлээс ангижрахуйн төгс төгөлдөр түвшинд хүрдэг. Энэхүү төгс төгөлдөрт хүрэх өөр ямар ч арга зам байдаггүй.” (Шветашватара Упанишад, 3.8)

Үүнээс өөр зам байдаггүй гэдэг нь Кришна бол Бурханы Дээд Бодгаль гэдгийг таньж мэдээгүй хэн бүхэн харанхуй мунхгийн гунад оршдог бөгөөд иймээс ч тэр дотроо балтай савыг гаднаас нь долоохтой адилаар буюу өөрөөр хэлбэл, өөрийн материаллаг мэдлэгт тулгуурлан Бхагавад Гитагийн учир утгыг ойлгохыг оролдоод хэзээ ч ангижралд хүрэхгүй гэсэн үг юм. Иймэрхүү эмпирик философичид нь материаллаг ертөнцөд маш хүндтэй, чухал нөлөөтэй байж болох ч энэ нь тэднийг ангижралд хүрэхийн баталгаа биш болой. Иймэрхүү бардам зантай материаллаг эрдэмтдийн хувьд цорын ганц найдвар нь Бурханы чин бишрэлтэнгийн учир шалтгаангүй өршөөл нигүүлслийг л хүлээх явдал байдаг. Иймээс Кришнагийн ухамсрыг итгэл бишрэл болоод мэдлэгт тулгуурлан хөгжүүлэх ёстой бөгөөд тэгсэн цагт төгс төгөлдөрт хүрч болно.

ШҮЛЭГ 10

*вита-рага-бхая-кродха ман-майа- мам упаириатах
бахаво гьяна-тапаса нута мад-бхавам агатах*

вита- ангижирсан, *рага-* дурлан татагдахуй, *бхая-* айдас хүйдэс, *кродхах-* болон уур хилэн, *мат-майа-* Надад бүрнээ, *мам-* Надад, *упаириатах-* бүрэн автсан, *бахавох-* олон, *гьяна-* мэдлэгийн, *тапаса-* огоорохуйгаар, *нутах-* ариусдаг, *мат-бхавам-* Намайг хайрлах трансценденталь хайр, *агатах-* хүрсэн.

Дурлан татагдал, айдас хүйдэс хийгээд уур хилэнгээс ангид байж Надад бүрнээ автан, Надаас аврал ивээл, өмөг түшиг эрж хайснаар өнгөрсөн цаг үед олон олон хүмүүс Намайг таньж мэдэн ариуссан бөгөөд ингэснээр тэд бүгдээрээ Намайг хайрлах трансценденталь хайранд хүрсэн юм.

ТАЙЛБАР: Урд өмнө өгүүлсэнчлэн, материаллаг зүйлд хэт ихээр автсан хүнд дээдийн дээд Үнэмлэхүй Үнэний бодгаль шинж төлвийг ойлгох нь маш бэрхтэй байдаг. Ер нь бие махбодийн амьдралын үзэл бодолд автан байгаа хүмүүс материаллаг үзэл бодолд хэт гүн живснээр Дээдийн Дээд нь хэрхэн бодгаль байж болох талаар ойлгох чадвар бараг үгүй болдог. Иймэрхүү материалистууд нь үүрдийн жаргал цэнгэл хийгээд мэдлэгээр дүүрэн бялхах мөнхийн трансценденталь бие байдаг гэж төсөөлж ч чадахгүй. Материаллаг амьдралын үзэл бодлын дагуу бол аливаа бие махбодь нь мөнх бус бөгөөд гай зовлон хийгээд харанхуй мунхаглалаар дүүрэн байдаг. Ийм учраас хүмүүс ерөнхийдөө Бурханы бодгаль дүрийн тухай сонсохдоо өөрсдийн бие махбодьтой адил төстэй мэтээр төсөөлж дүрслэн боддог. Иймэрхүү материалист хүмүүсийн хувьд аврага том материаллаг илрэл тодролын хэлбэр л Дээдийн Дээд байдаг. Иймээс тэд Дээдийн Дээдийг бодгаль бус гэж үздэг. Мөн ухамсар нь материт хэт их автсан байдаг учир материас ангижирсаны дараагаар ч бие даан бодгаль байдлаа хадгалан үлддэг тухай бодол ойлголт тэдэнд айдас хүйдэс төрүүлдэг. Бурханлаг амьдрал нь мөн л бие даасан бөгөөд бодгаль байдалтай байдаг гэдгийг тэд мэдмэгц дахин бодгал байхаас айж эмээх тул бодгал бус хоосонд ямар нэгэн байдлаар уусахыг эрхэмд үздэг. Ерөнхийдөө тэд амьд оршнолуудыг далайн мандал дээр бий болон тогтсоноо усанд уусан дахин алга

болдог хөөстэй адилтган үздэг. Тэдний бодлоор бол энэ нь бие даасан бодгаль байдалгүйгээр хүрч болох бурханлаг амьдралын хамгийн дээд төгс төгөлдөр юм. Энэ бол бурханлаг оршихуйн талаар төгс төгөлдөр мэдлэг дутмаг байх айдас хүйдэс дүүрэн амьдралын төлөв байдал юм. Түүнээс гадна бурханлаг оршихуйн талаар юу ч ойлгох чадваргүй хүмүүс олон байдаг. Янз бүрийн философийн цэцэрхийллийн олон онол хийгээд зөрчилдөөнүүдэд төөрөлдөж будилсан тэдгээр хүмүүс цухалдан уур хилэн нь бадарч, бүхний дээд учир шалтгаан гэж байдаггүй, эцсийн эцэст бүх зүйлс хоосон гэсэн тэнэг мунхаг дүгнэлтэнд хүрдэг. Иймэрхүү хүмүүсийг өвчинд нэрвэгдсэн байна гэж үзэж болно. Хүмүүсийн нэг хэсэг нь материаллаг талдаа хэт татагдан автсанаар бурханлаг амьдралын талдаа анхаарал огтхон ч хандуулахгүй байхад зарим нь дээдийн дээд бурханлаг учир шалтгаанд уусан нэгдэхийг хүсэх бөгөөд гурав дахь хэсэг нь ямар ч тус нэмэр үл болох хуурмаг бурханлаг онолуудад ихээр цухалдсанаас болж юунд ч итгэхээ больдог. Эдгээрээс сүүлчийн бүлэг хүмүүс нь энэхүү уур цухал, хилэнтэй байдлаасаа гарахыг оролдон янз бүрийн мансууруулах бодис хэрэглэх бөгөөд зарим үед мансуурлын байдалд байхдаа хий юм үзэж харснаа бурханлаг хараа нээгдлээ гэцгээдэг. Материаллаг ертөнцөд дурлан татагдахуйн эдгээр гурван хэлбэрүүдээс буюу бурханлаг амьдралыг эс тоомсорлон үл хайхрах, бурханлаг бодьгал болохоос айж эмээх болон амьдралдаа ханамжтай бус байдлаас урган гарах “хий хоосны” ойлголтуудаас салан ангижрах хэрэгтэй. Материаллаг амьдралын үзэл бодлын эдгээр гурван түвшингээс ангижрахын тулд жинхэнэ номын багшийн сургаал зааврын доор Бурханаас өмөг түшиг, аврал ивээлийг бүрнээ эрж хайн, Бурханы чин бишрэл дүүрэн бялхах албаны зохицуулах зарчмуудыг дагаж мөрдөх хэрэгтэй. Бурханлаг амьдралын энэхүү замаар замнах хүн эцэстээ, Бурханыг хайрлах трансценденталь хайрын *бхава*- түвшинд хүрдэг.

Чин бишрэлийн албаны эрдэм ухааны шастир болох Бхакти-расамрита-синдхугийн (1.4.15-16)-д өгүүлэхдээ:

*адау шраддха татах садху-санго `тха бхажана-крिया
тато `нартха-нивриттих сьят тато нишитха ручис татах
атхасактис тато бхавас татах премабхьюданьчати
садхаканам аям премнах прадурбхаве бхавет крамах*

“Хүнд эхлээд өөрийгөө бүрэн нээж таньж мэдэх гэсэн урьдчилсан хүсэл эрмэлзэл байх хэрэгтэй. Энэ нь түүнийг бурханлаг хөгжлийн өндөр түвшинд хүрсэн хүнтэй учран харьцахыг хичээн чармайх шатанд хүргэнэ. Дараагийн үе шатанд жинхэнэ номын багшид шавь орох ба тэгснээр түүний удирдлага, сургаал, зааврын дагуу шинээр эхлэгч чин бишрэлтэн чин бишрэл дүүрэн бялхах албаны зам мөрөө эхэлдэг. Номын багшийн удирдлагын доор чин бишрэлээр дүүрэн зүтгэх үйлэнд суралцсанаар хүн бүхий л материаллаг дурлан татагдлаасаа салан ангижирч өөрийгөө бүрэн нээж танин мэдэхийн төлөө хэлбэрэлт гуйвалтгүй, байнгад хичээн чармайх бөгөөд Бурханы Үнэмлэхүй Бодгаль, Шри Кришнагийн тухай сонсох амтанд ордог. Энэхүү амт нь цаашид хөгжсөөр Кришнагийн ухамсарт дурлан татагдах түвшинд хүрдэг ба энэ нь улам боловсрон хөгжсөөр Бурханыг хайрлах трансценденталь хайрын өмнөх үе шат болох *бхава* түвшинд хүрдэг. Бурханыг жинхэнээр хайрлахыг *према* буюу амьдралын төгс төгөлдрийн дээдийн дээд түвшин гэж нэрлэдэг.”

Према түвшинд хүрсэн хүн Бурханы трансценденталь хайр дүүрэн бялхах албанд тасралтгүйгээр зүтгэж байдаг. Ийнхүү жинхэнэ номын багшийн удирдлагын доор Бурханы чин бишрэлийн албанд зүтгэх үйлэнд өөрийгөө зориулснаар хүн аажим аажмаар, материаллаг дурлан татагдахуй, бие даасан бурханлаг бодьгал болохоос айж эмээх болон хий хоосны номлолоос үүдэн гарах уур цухлаас ангижрах дээдийн дээд түвшинд хүрдэг. Тэгсэн цагт тэр эцэстээ Бүхний Дээд Бурханы оронд хүрч очно.

*е ятха мам прападьянте тамс татхайва бхажсамй ахам
мама вартманувартанте манушьях партха сарваших*

е-тэд, бүгд, *ятха*- яаж, *мам*- Надад, *прападьянте*- өөрийгөө даатгах, *тан*- тэдэнд, *татха*- ингэж, *эва*- гарцаагүй, *бхажсами*- урамшуулдаг, *ахам*- Би, *мама*- Надад, *вартма*- зам мөр, *анувартанте*- дагах, *манушьях*- бүх хүмүүс, *партха*- Притхын хүү минь, *сарваших*- бүх талаар.

Хүн хэдий хэмжээгээр өөрийгөө Надад даатган байна тэр хэмжээгээр Би түүнийг урамшуулдаг. Хүн бүр Миний зам мөрийг бүхий л талаар дагаж мөрдөх хэрэгтэй, ай Притхын хүү минь ээ.

ТАЙЛБАР: Хүн бүр Кришнаг Түүний илрэн тодрохуйн аль нэг төлөв байдалд эрж хайж байдаг. Түүний бодгаль бус *брахмажьоти* туяаг эсвэл бүгдэд, бүр атомд хүртэл залран байх бүхэнд нэвчих Дээд Сүнсийг танин мэдсэнээр хүн Бурханы Дээд Бодгаль, Кришнагийн зөвхөн зарим хэсгийг л таньж мэддэг. Кришнаг зөвхөн Түүний цэвэр чин бишрэлтэнгүүд л бүрэн төгс таньж мэдэж чадна. Иймд Кришна хүн бүрийн танин мэдэхүйн объект байдаг бөгөөд хэн бүхэн Түүнийг өөрийн хүссэн тэр төлөв байдалд таньж мэдэж болно. Мөн бурханлаг ертөнцөд Кришна Өөрийн цэвэр чин бишрэлтэнгүүдтэйгээ тэдний хүсэж байгаа тэр л трансценденталь холбоо харьцаагаар харьцдаг. Нэг чин бишрэлтэн нь Кришнаг дээдийн дээд Эзэн байдлаар харахыг хүсэж байхад өөр нэгэн нь дотнын найз нөхөр, гурав дахь нь өөрийн хүү, мөн өөр нэгэн нь амраг хайрт байдлаар Түүнтэй харьцахыг хүсэж байдаг. Кришна бүх чин бишрэлтэнгүүдээ адил байдлаар, өөрөөр хэлбэл Өөрийг нь хайрлах тэдний хайранд тохируулан урамшуулдаг. Материаллаг ертөнцөд ч мэдрэхүйн ийм солилцоо харьцаа холбоо оршин байдаг ба Бурхан, Түүнд бишрэл хүндэтгэлээ илэрхийлж байгаа бүгдийн мэдрэхүйд тэдний шүтлэг бишрэлийн хэлбэрээс хамааруулан адил зарчмаар хариулт өгч байдаг. Цэвэр чин бишрэлтэн нь энд ч, мөн бурханлаг ертөнцөд ч Бурхантай биечлэн харьцаж Түүнд өөрөө биечлэн хайр, чин бишрэлтэйгээр үйлчлэн зүтгэж байдаг ба тэр энэхүү хайр дүүрэн бялхах алба, зүтгэлээсээ трансценденталь баяр жаргалыг мэдэрч байдаг. Амьд оршнолын бие даасан оршнолоо устган хөнөөхийг буюу бурханлаг егүүтгэл үйлдэхийг хүсэж буй бодгаль бусыг баримтлагчдыг Бурхан Өөрийн туяандаа уусан нэгдэх боломж олгосноор хүссэн зорилгодоо хүрэхэд нь тэдэнд мөн тусалж байдаг. Энэхүү имперсоналистууд нь мөнхийн, баяр цэнгэлээр дүүрэн бялхах Бурханы Бодгалийг хүлээн зөвшөөрөх чадваргүй байдаг бөгөөд иймээс ч тэд өөрсдийн бие даасан байдлыг хөнөөн устгаснаар Бурханы трансценденталь албанд зүтгэхийн цэнгэл жаргалыг амтлах боломжгүй болдог. Өөрсдийн бодгаль бус оршнолдоо ч үл татагдан автах тэдний зарим нь үйл хөдлөлөө өрнүүлэх гэсэн өөрсдийн нойрмоглоон буй хүслээ хэрэгжүүлэхээр материаллаг ертөнцөд дахин буцаж ирдэг. Тэдний хувьд бурханлаг гаригуудад хүрч очих хаалга үүд хаалттай байдаг ч тэдэнд материаллаг ертөнцийн гаригууд дээр үйл хэргээ явуулах дахин нэг шинэ боломж олдоно.

Өөрсдийн ажил хөдөлмөрийн үр шимийн төлөө тэмүүлэн байгаа хүнд Бурхан *ягьяшвара* байдгийн хувьд Ведэд заасан өөрт оноогдсон үүргээ биелүүлсний нь үр шимийг хайрладаг. Мөн ид шидийн чадварыг эзэмшихийн хүслэн болж байгаа иогчдод хүссэнийг нь хүртээгч нь Бүхний Дээд Бурхан байдаг билээ. Өөрөөр хэлбэл, хэн бүхний гаргаж буй хичээл чармайлтын амжилтанд хүрэх эсэх нь дан ганц Бурханы өршөөл нигүүлслээс хамаарах бөгөөд бурханлаг арга замуудын бүхий л хэлбэрүүд нь нэг зам мөр дээрх амжилтын янз бүрийн үе шатууд болохоос өөр юу ч биш юм. Кришнагийн ухамсарын дээдийн дээд төгс төгөлдөрт хүрээгүй байсан цагт хүний бүхий л хүчин чармайлт төгс төгөлдөр бус байдгийн зэрэгцээ амжилтанд хүрдэггүй. Энэ тухай Шримад Бхагаватамын (2.3.10)-д батлан өгүүлсэн байдаг:

*акамах сарва-камо ва мокша-кама удара-дхих
тиврена бхакти-йогена яжета нурушам парам*

“Хүн, хүслээсээ ангид (чин бишрэлтэнгийн түвшин) байна уу, өөрийн ажил хөдөлмөрийн үр шимээр таашаал ханамж эдэлж цэнгэн жаргахыг хүсэж байна уу, эсвэл ангижралд хүрэхийг эрмэлзэж байна уу ялгаагүй, Кришнагийн ухамсарт л илрэлээ олдог дээдийн дээд төгс төгөлдөрт хүрэхийн тулд Бурханы Дээд Бодгальд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэхийг бүхий л хүчээрээ чармайн хичээх хэрэгтэй.”

ШҮЛЭГ 12

*канкишантах карманам сиддхим яжанта иха деватах
кишипрам хи мануше локе сиддхир бхавати карма-жа*

канкишантах- хүссэнээр, *карманам*- кармын үйлийн, *сиддхим*- төгс төгөлдөр байдал, *яжанте*- тэд өргөлөөр бишрэн шүтдэг, *иха*- материаллаг ертөнцөд, *деватах*- сахиулсан тэнгэрүүдийг, *кишипрам*- маш хурдан, *хи*- тодорхой, *мануше*- хүний нийгэмд, *локе*- энэ дэлхийд, *сиддхих*- амжилт, *бхавати*- ирдэг, *карма-жа*- кармын үйлээр.

Энэ дэлхийн хүмүүс үр дагавар дагуулах үйлдээ амжилт гаргахын тулд сахиулсан тэнгэрүүдийг шүтэн биширч байдаг бөгөөд мэдээж хэрэг тэд өөрсдийн үйлийн үр шимийг маш түргэн хүртдэг.

ТАЙЛБАР: Материаллаг ертөнцийн сахиулсан тэнгэрүүдийн байр суурийг хүмүүс үргэлж буруу ойлгож байдаг: Номч мэргэд хэмээн хүндлэгддэг хэдий ч тийм ч оюунлаг бус байдаг хүмүүс эдгээр сахиулсан тэнгэрүүдийг Бүхний Дээд Бурханы янз бүрийн дүрүүд гэж үздэг. Үнэн хэрэгтээ сахиулсан тэнгэрүүд нь Бурханы янз бүрийн дүрүүд биш харин Түүний янз бүрийн хэсгүүд л юм. Бурхан бол нэг, харин Түүний хэсгүүд бол олон. Ведэд өгүүлсэнчлэн: *нитьо нитьянам*- Бурхан бол ганц. *Ишварах парамах кришнах*. Зөвхөн ганц Бүхний Дээд Бурхан Кришна л байдаг бөгөөд Тэрээр материаллаг ертөнцийг захиран залахад шаардлагатай хүч чадлыг сахиулсан тэнгэрүүдэд хүртээдэг. Эдгээр сахиулсан тэнгэрүүд нь бүгд, янз бүрийн зэрэг, түвшний материаллаг эрх мэдэл бүхий амьд оршнолууд (*нитьянам*) юм. Тэд Бүхний Дээд Бурхан-Нараяна, Вишну буюу Кришнатай эн зэрэгцэхгүй. Сахиулсан тэнгэрүүдийг Бурхантай нэг адил түвшинд байдаг гэж итгэдэг хүнийг атейст (*нашанди*) гэж нэрлэдэг. Брахма болон Шива зэрэг хамгийн хүчирхэг сахиулсан тэнгэрүүдийг ч Бүхний Дээд Бурхантай харьцуулахын аргагүй. Харин ч Брахма болон Шива зэрэг сахиулсан тэнгэрүүд нь өөрсдөө Бурханыг шүтэн биширч байдаг (*шива-вишинчнутама*). Хэдийгээр ийм байдаг боловч хачирхалтай нь антропоморфизм болон зооморфизмын хорт буруу үзэл санаанд төөрөлдөн тэнэг мунхаг хүмүүсээр өөрсдийгөө тахин шүтүүлж байдаг удирдагчид хүмүүсийн дунд олноороо байдаг.

Иха деватах гэдэг үг нь материаллаг ертөнцийн хүчирхэг хүн эсвэл сахиулсан тэнгэрийг заадаг. Харин Бурханы Дээд Бодгаль-Нараяна, Вишну буюу Кришна бол энэ ертөнцөд хамаарагддаггүй. Тэрээр түүнээс дээш, материаллаг бүтээлийн хүрээ хязгаарын чанадад, түүнд трансценденталь байр суурьтай залран байдаг. Тэр бүү хэл, имперсоналист философийг номлогч Шрипада Шанкарачарья хүртэл Нараяна буюу Кришна нь энэхүү материаллаг ертөнцийн хүрээ хязгаарын чанадад залран байдаг гэсэн үзлийг баримталж байсан. Тэгсэн хэдий ч мунхаг хүмүүс (*хрита-гьяна*) үр дүнд хурдан хүрэхийн тулд сахиулсан тэнгэрүүдийг шүтэн, тэдгээрт бишрэл хүндэтгэлээ илэрхийлж байдаг. Тэд хэдийгээр үр дүнд хүрэх боловч ийнхүү хүрсэн үр дүн нь түр зуурын хийгээд зөвхөн оюунлаг бус хүмүүст л зориулагдсан байдаг гэдгийг мэддэггүй. Оюунлаг хүмүүс нь Кришнагийн ухамсарын зам мөрөөр замнах бөгөөд ямар нэгэн даруйхан олдох түр зуурын үр дүнгийн төлөө өрөвдөм сахиулсан тэнгэрүүдийг шүтэн бишрэх шаардлагагүй байдаг. Материаллаг ертөнцийн сахиулсан тэнгэрүүд нь материаллаг ертөнцийн сүйрлийн үед өөрсдийг нь шүтэн

бишрэгчдийнхээ хамтаар устдаг. Сахиулсан тэнгэрүүдийн түгээн хүртээх өршөөл адислал нь ийнхүү материаллаг хийгээд түр зуурын байдаг. Материаллаг ертөнц болон түүний сахиулсан тэнгэрүүд хийгээд тэдгээрийг шүтэн бишрэгчдийг оролцуулсан бүхий л оршин суугчид нь сансрын далайн мандал дээрх хөөснөөс өөрцгүй юм. Гэвч хүний нийгэм нь түр зуурын зүйл болох эд баялаг, хөрөнгө, газар орон, гэр бүл болон бусад тав тухтай байдлын хойноос л галзуурсан мэт хөөцөлдөж байдаг. Иймэрхүү түр зуурын зүйлийг хүртэхийн тулд тэд сахиулсан тэнгэрүүд эсвэл хүний нийгэм дэх эрх мэдэл бүхий хүчирхэг хүмүүсийг шүтэн биширч байдаг. Улс төрийн хэн нэгэн удирдагчид бялдуучлан зүтгэснээрээ засгийн газрын сайдын албан тушаалд томилогдсон хүн өөрийгөө маш аугаа адислал, хишиг хүртлээ дээ гэж бодож итгэж явдаг. Иймээс цаг зуурын ашиг хонжоо олж, эрх дарх эдлэхийн тулд тэд “дээд амьтан” буюу удирдагч гэгдэгчийнхээ өмнө бүгд бялдуучлах бөгөөд тэд үнэхээрч өөрсдийн хүссэн иймэрхүү зүйлээ авдаг. Иймэрхүү тэнэг мангуу хүмүүс нь материаллаг оршихуйн бүхий л хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх Кришнагийн ухамсрын талаар огтхон ч сонирхдоггүй. Тэд бүгд л мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн хойноос тэмүүлцгээх бөгөөд ийнхүү мэдрэхүйн ханамж таашаалаа хангах өчүүхэн төдий үл ялих боломжийн төлөө ч сахиулсан тэнгэрүүд мэт тодорхой эрх мэдэл бүхий амьд оршнолуудыг шүтэн бишрэх дур сонирхолтой байдаг. Кришнагийн ухамсрыг сонирхдог хүмүүс маш ховор байдаг тухай энэ шүлэгт өгүүлж байна. Хүмүүс ихэнхдээ материаллаг таашаал ханамж эдлэх сонирхолтой байдаг учир ямар нэгэн хүчирхэг амьд оршнолыг шүтэн биширч байдаг.

ШҮЛЭГ 13

*чатур-варньяма майа сриштам гуна-карма-вибхагашах
тасья картарам апи мам виддхи акартарам авьяам*

чатур-варньяма- хүний нийгмийн дөрвөн хуваагдал, *майа*- Надаар, *сриштам*- бүтээгдсэн, *гуна*- шинж чанарын, *карма*- ажил, *вибхагашах*- хуваагдалтай холбогдсон, *тасья*- түүний, *картарам*- эцэг, *апи*- хэдий ч, *мам*- Намайг, *виддхи*- чи мэдэх ёстой, *акартарам*- үйл үл үйлдэгч байдлаар, *авьяам*- үл хувирч өөрчлөгдөгч.

Материаллаг гурван гуна болон тэдгээртэй холбогдсон үйлүүдэд харгалзуулан Би хүний нийгмийг дөрвөн ангид хуваан бүтээсэн билээ. Би хэдийгээр энэ системийг бүтээгч мөн хэдий ч үл хувирч өөрчлөгдөгч болохын хувьд Би Өөрөө үйл үйлдэгч биш гэдгийг чи мэдэх ёстой.

ТАЙЛБАР: Бурхан бол бүхнийг бүтээгч. Бүх зүйлс Түүнээс үүсэн гардаг, Тэр бүгдийг тэтгэж, тогтоон барьж байдаг, мөн устаж сүйрсний дараа ч бүгд Түүний дотоодод амирлангуйг олдог. Ийм учраас Тэр нийгмийн тогтолцооны дөрвөн ангийг бүтээгч мөн бөгөөд энэ тогтолцооны эхний ангид *брахмана* гэж нэрлэгдэх хамгийн оюунлаг хүмүүс хамаарагддаг. Тэд цэвэр ариуны гунад оршдог. Дараагийн ангид удирдан захирагч хэсэг болох *кшатрия* нар хамаарагддаг бөгөөд тэд хүсэл тачаалын гунын нөлөөнд оршиж байдаг. *Вайшья* буюу худалдаа үйлдвэрлэл эрхлэгчид нь гурав дахь ангид хамаарагддаг ба тэд хүсэл тачаалын болон харанхуй мунхгийн гунуудын холимог нөлөөн доор оршиж байдаг. Харин дөрөв дэх ангид хамаарагддагчид болох *шудра* буюу ажилчид нь харанхуй мунхгийн гунын нөлөөлөл доор оршиж байдаг. Шри Кришна хүний нийгмийн дөрвөн ангийг бүтээн бий болгосон ч Тэр Өөрөө болзолт сүнс биш учраас эдгээр ангиудад үл хамаарагддаг. Болзолт сүнснүүдийн зөвхөн нэгээхэн хэсгийг л бүрдүүлдэг хүний нийгэм нь бусад амьтан адгуусны аймгаас бараг үл ялгагддаг. Гэхдээ хүмүүсийг амьтан адгуусны түвшингээс дээшлүүлэн, тэдэнд Кришнагийн ухамсрыг системтэйгээр хөгжүүлэх боломж олгохын тулд Бурхан дээр дурьдсан ангиудыг буюу нийгмийн тогтолцоог бүтээсэн. Тодорхой нэгэн ажил үйлэнд дурлан татагдах хүний дур сонирхол нь тэдэнд үйлчлэл нөлөөллөө үзүүлж байгаа материаллаг байгалийн гунаар

болзолдож нөхцөлдсөн байдаг. Материаллаг байгалийн гунуудын эдгээр нөлөөлөл хүмүүсийн амьдралд яаж илэрдэг талаар энэ номын арваннайм дугаар бүлэгт тодорхой өгүүлнэ. Кришнагийн ухамсарт байгаа хүн *брахманаас ч* илүү дээгүүр түвшинд оршдог. *Брахманууд* нь дээдийн дээд Үнэмлэхүй Үнэн, Брахманы тухай мэдлэгийг хүртэн агуулсан байх ёстой байдаг ч тэдгээрийн ихэнх нь Шри Кришнагийн зөвхөн бодьгал бус Брахманы илрэлийг л ойлгож ухаарсан байдаг. *Брахмануудын* хязгаарлагдмал ойлголт мэдлэгийн хүрээний чанадад гарч Бурханы Дээд Бодгаль, Шри Кришнагийн тухай мэдлэгийг хүртсэн хүн л Кришнагийн ухамсрын түвшинд хүрдэг буюу *вайшнава* болдог. Кришнагийн ухамсар нь Рама, Нрисимха, Враха зэрэг олон Кришнагийн бусад бүх бүрэн хувилгаан дүрүүдийн талаарх мэдлэгийг өөртөө агуулж байдаг. Шри Кришна хүний нийгмийн дөрвөн ангит дээрх тогтолцоонд трансценденталь байр суурьтай залран байдгийн адил Кришнаг ухамсарласан хүн ч нийгмийн бүлэг, үндэс угсаа, арьс өнгө гэх мэтийн хүний нийгмийн бүхий л ангилалын хүрээ хязгаарын чанадад тэдгээрт мөн трансценденталь байр сууринд оршдог.

ШҮЛЭГ 14

*на мам кармани лимпанти на ме карма-пхале сприха
ити мам йо `бхижанати кармабхир на са бадхьяте*

на- хэзээ ч үгүй, *мам-* Намайг, *кармани-* ажлын бүхий л төрлүүд, *лимпанти-* нөлөөлөх, *на-* үгүй, *ме-* Миний, *карма-пхале-* кармын үйлд, *сприха-* эрмэлзэл тэмүүлэл, *ити-* ийм байдлаар, *мам-* Намайг, *ях-* тэр, *абхижанати-* таньж мэддэг, *кармабхих-* ийм ажлын үр дагавраар, *на-* үгүй, *сах-* тэр, *бадхьяте-* орооцолддог.

Надад нөлөөлөл үзүүлэх ямар ч ажил үйл гэж байдаггүй. Мөн Би үйлийн үр дүнд тэмүүлдэггүй. Миний тухай энэхүү үнэнийг таньж мэдсэн хэн бүхэн өөрийн үйлийн үр дагаварт мөн үл орооцолддог билээ.

ТАЙЛБАР: Хаан хүн алдаа эндэгдэл үл гаргадаг хийгээд тэр төрийн хуулинд захирагддаггүй гэсэн хуулиуд материаллаг ертөнцөд байдгийн адил Бурхан хэдийгээр энэ материаллаг ертөнцийн бүтээгч мөн ч Тэр түүний нөлөөлөлд үл өртөнө. Тэр бүтээдэг ч, бүтээснээсээ ангид тусдаа, тэдгээрт үл шүргэж хавьтана. Харин тэгэхэд амьд оршнолууд нь материаллаг баялгийг эзэмшин захирах гэсэн дур сонирхол, эрмэлзлээсээ болж өөрсдийн материаллаг үйлийн үр дагаварт орооцолддог. Аливаа нэгэн үйлдвэр аж ахуйн газартажиллаж байгаа албан хаагч нь өөрийн ажил үйлийнхээ хариуцлагыг өөрөө хүлээдэг болохоос биш тухайн газрын эзэн хүлээдэггүй. Мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн хүсэл шунал нь л амьд оршнолыг материаллаг үйлэнд татан оруулдаг болохоос биш Бүхний Дээд Бурхан эдгээр үйлүүдийг үйлдэхийг түүнд даалгадаггүй. Мэдрэхүйн таашаал ханамж эдлэх илүү боломж олохын тулд амьд оршнолууд энэ дэлхийн ажил үйлтэй зууралдан байдаг бөгөөд үхсэний дараагаар тэнгэрийн гаригуудад хүрч аз жаргалтай учран золгохыг чармайцгааж байдаг. Бурхан Өөрөө Өөртөө дүүрэн ханамжтай, төгс төгөлдөр байдаг учраас тэнгэрийн аз жаргал гэгдэгч зүйлд огтхон ч татагддаггүй. Тэнгэрийн гаригуудын сахиулсан тэнгэрүүд нь ердөө л Түүний томилсон албатууд билээ. Эзэн хүн өөрийн доод ажилчдын тэмүүлэн байгаа тийм доод түвшний аз жаргалыг хүсэж, түүнийг амсаж эдлэхийг эрмэлздэггүй. Материаллаг үйлдэл хийгээд үр дагаварт Бурхан хэзээ ч үл хавьтана. Жишээлбэл, бороогүйгээр газар дэлхий дээр янз бүрийн ургамал ногоо ургадаггүй ч тэдгээрийг ургаагүйн төлөө бороо хариуцлага хүлээдэггүй. Энэ тухай ведийн *смрити-д* дараах байдлаар батлан өгүүлсэн байдаг:

*нимитта-матрам эвасау срижсьянам сарга-кармани
прадхана-карани-бхута ято вай срижсья-шактаях*

“Бурхан бол материаллаг бүтээлүүдийн хувьд тэдгээрийн зөвхөн дээдийн дээд учир шалтгаан. Харин тэдгээрийн шууд учир шалтгаан нь сансар огторгуйн илрэл тодролуудыг илрүүлж тодруулан ил харагдуулагч материаллаг мөн чанар болно.” Сахиулсан тэнгэрүүд, хүмүүс болон доод амьтан адгуус зэрэг олон янз төрөл хэлбэртэй бүтээгдсэн оршнолууд байдаг бөгөөд тэд бүгд өөрсдийн өнгөрсөн үеийн сайн болоод муу үйлүүдийн үр дагаварт баригдсан байдаг. Бурхан тэдэнд эдгээр үйлүүдийг үйлдэх зөвхөн зохистой боломжууд болон материаллаг мөн чанарын гунуудын дагуу харгалзах удирдамжуудыг өгдөг боловч Тэрээр тэдний өнгөрсөн болоод одоогийн үйлүүдийнх нь төлөө хэзээ ч хариуцлага хүлээдэггүй. Энэ тухай Веданта судрын (2.1.34)-д батлан өгүүлсэн байдаг: *вайшамья-найргхринье на сапекишатват* буюу Бурхан ямар ч амьд оршнолд хэзээ ч тал тохой татан алагчилж үздэггүй. Амьд оршнол үйлдсэн үйлийнхээ төлөө өөрөө хариуцлага хүлээдэг. Бурхан гадаад эрчим буюу материаллаг мөн чанарын тусламжтайгаар түүнд зөвхөн үйл үйлдэх боломжийг л өгдөг. Үр дагавар дагуулагч үйлийн буюу кармын хуулийн энэ бүх төвөгтэй нарийн уялдаа холбоонуудыг нарийн сайн ойлгож мэдсэн хүн өөрийн үйлийн үр дагаврын нөлөөлөлд өртдөггүй. Өөрөөр хэлбэл Бурханы трансценденталь мөн чанарыг ухаарсан хүн Кришнагийн ухамсарт маш сайн дадлагажиж туршлагажсан байдаг учир кармын хуулинд хэзээ ч эрсдэн орж захирагддаггүй. Бурханы трансценденталь мөн чанарыг таньж мэдээгүй хүн Түүний үйлүүд нь эгэл жирийн амьд оршнолуудын үйлийн нэгэн адил материаллаг үр дүнд хүрэхэд чиглэгдсэн гэж бодож итгэж байдаг тул тэрээр өөрийн үйлийн үр дагаврын торонд гарцаагүй орооцолддог. Харин дээдийн дээд Үнэнийг таньж мэдсэн хэн бүхэн ангижралд хүрсэн хийгээд Кришнагийн ухамсарт гүн бат автсан сүнс байдаг.

ШҮЛЭГ 15

*эвам гьятва критам карма пурвайр апи мумукиубхих
куру кармаива тасмат твам пурвайх пурватарам критам*

эвам- ийм байдлаар, *гьятва*- сайн мэдсэнээр, *критам*- үйлдэгдсэн, *карма*- үйл, *пурвайх*- өнгөрсөн үеийн эх сурвалжуудаар, *апи*- үнэхээр, *мумукиубхих*- ангижралд хүрсэн, *куру*- гүйцэтгэ, *карма*- оноогдсон үүрэг, *эва*- тодорхой, *тасмат*- иймээс, *твам*- чи, *пурвайх*- өмнөх үеийнхнээр, *пурва-тарам*- өнгөрсөн цаг үе дэх, *критам*- яаж үйлддэг.

Эрт дээр цагийн ангижирсан сүнснүүд нь бүгд Миний трансценденталь мөн чанарын тухай ойлгоц дээрээ тулгуурлан үйлээ үйлдэж байсан. Иймээс чи тэдний үлгэр жишээг даган өөрт оноогдсон үүргээ биелүүлэх хэрэгтэй.

ТАЙЛБАР: Хүмүүс хоёр янз байдаг: нэг хэсгийнх нь зүрх материаллаг бузраар дүүрэн байхад нөгөө хэсгийнх нь зүрх түүнээс ангид чөлөөтэй байдаг. Тэдгээрийн хэн хэнд нь Кришнагийн ухамсар адислалаа адилхан хайрладаг. Бузраар дүүрэн хүн чин бишрэлийн алба үйлийн зохицуулах зарчмуудыг дагаж мөрдсөнөөр өөрийгөө аажим аажмаар ариусгахын тулд Кришнагийн ухамсарт хандаж болно. Бүхий л бузраасаа хэдийнээ ариуссан хүн Кришнагийн ухамсарт өөрийн үйлээ цаашид үргэлжлүүлэх хэрэгтэй бөгөөд тэгснээр бусад хүмүүс түүний үлгэр жишээг даган ач тусыг олох болно. Тэнэг мунхаг хүмүүс болон Кришнагийн ухамсарт шинээр эхэлж байгаа тэр талаар мэдлэг хомс хүмүүс ихэнхдээ бүхий л үйлээс холдон хөндийрөхийг хүсдэг. Тулалдааны талбараас зайлсхийн холдон одох гэсэн Аржунагийн хүсэлтийг Бурхан сайшаан дэмжээгүй. Хүн үйлийг хэрхэн яаж үйлдэх ёстойг л мэдэх хэрэгтэй. Кришнагийн ухамсарын үйлээс холдон, өөрийгөө Кришнагийн ухамсарын өндөр түвшинд хүрсэн хэмээн дүр эсгэн хаа нэгтэй буйдхан газар Кришнагийн ухамсар гэгчийн талаар үзүүлбэр хийн суух нь Кришнагийн таалалд жинхэнэ нийцсэн үйл үйлдэх шиг ач тустай байдаггүй. Урьд өмнө яригдаж байсан нарны сахиулсан тэнгэр Вивасван шиг Бурханы өмнөх үеийн шавь нарын үлгэр дууриал, зам мөрийг даган Кришнагийн ухамсарт үйлээ үйлдэхийг

Аржунад зөвлөж байна. Бүхний Дээд Бурхан зөвхөн Өөрийн урьдын үйлүүдээ төдийгүй, өнгөрсөн цаг үед Кришнагийн ухамсарт үйл хэргээ явуулж байсан бодгалиудын бүх үйлүүдийг мөн мэддэг. Ийм учраас л Бурхан энд, олон сая жилийн тэртээ Өөрөөс нь Кришнагийн ухамсарын үйлэнд зүтгэх урлагийг сурч хүртсэн нарны бурхны үлгэр дууриалыг дагахыг Аржунад зөвлөж байна. Шри Кришнагийн эдгээр бүх шавь нарыг өнгөрсөн цаг үед ангижралыг олсон сүнсүүд гэж нэрлэж байна. Учир нь тэд бүгд Кришнагаас өөрсдөд нь даалгаж хүлээлгэсэн үүргүүдийг ягштал биелүүлж байсан билээ.

ШҮЛЭГ 16

*ким карма ким акармети кавайо `ни атра мохитах
тат те карма правакшьями яж гьятва мокшьясе `шубхат*

ким- юу, карма- үйл, ким- юу, акарма- үйл биш, ити- ингэж, каваях- оюунлаг хүмүүс, апи- мөн, атра- энэ хэрэгт, мохитах- төөрөлдсөн, тат- энэ, те- чамд, карма- үйл, правакшьями- Би тайлбарлана, ят- түүнийг, гьятва- мэдсэнээр, мокшьясе- чи ангижрах болно, ашубхат- гай тотгороос.

Тэр ч бүү хэл оюунлаг хүмүүс ч үйл ба үйл бус гэж юу болохыг тодорхойлж чадахгүй будилж төөрөлддөг. Би одоо чамд үйл гэж юу болохыг тайлбарлая. Үүнийг мэдсэнээр чи бүхий л гай тотгороос ангижрах болно.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсар дахь үйл нь өнгөрсөн цаг үеийн аугаа чин бишрэлтэнгүүдийн үлгэр жишээтэй нийцсэн байх ёстой. Энэ талаар арвантав дугаар шүлэгт өгүүлсэн. Ийм үйл нь яагаад үл хамаарсан байдалтай байж болохгүй тухай дараагийн шүлэгт тайлбарлана.

Энэ бүлгийн эхэнд тайлбарласанчлан, Кришнагийн ухамсарт үйл үйлдэхийн тулд багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээнд хамаарагдах эх сурвалж бодьгалын удирдлаганд итгэх хэрэгтэй. Кришнагийн ухамсарын эрдэм ухааныг эхлээд нарны бурханд хүртээсэн, нарны сахиулсан тэнгэр түүнийг өөрийн хүү Мануд, Ману цааш нь өөрийн хүү Икшвакуд сургаж номлосон ба ийнхүү энэхүү эрдэм ухаан өнө эртийн тэр цаг үеэс манай газар дэлхий дээр түгэн дэлгэрч эхэлсэн. Ийм учраас л багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээн дэх өмнөх үеийн эх сурвалж бодьгалуудын зам мөрөөр замнах хэрэгтэй байдаг. Эс тэгэх аваас хамгийн оюунлаг хүмүүс ч Кришнагийн ухамсар дахь үйлийн хэмжүүр гэж юу болохыг ойлгож мэдэхгүй. Энэ учир шалтгааны улмаас Бурхан Өөрөө Аржунад Кришнагийн ухамсарын эрдэм ухааныг номлон айлдахаар шийдвэрлэсэн бөгөөд Аржуна ийнхүү энэ мэдлэгийг Бурханаас Өөрөөс нь шууд хүртсэн учир түүний зам мөрийг даган замнах хэн бүхэн бүхий л төөрөгдлөөс ангид байна гэдэг нь эргэлзээгүй хэрэг.

Судруудад өгүүлсэнчлэн, хүн төгс төгөлдөр бус, туршлагын дүнд бий болсон мэдлэгийн тусламжтайгаар шашин гэж юу болохын учрыг олж чадахгүй. Үнэн хэрэгтээ, шашны үндсэн зарчмуудыг зөвхөн Бурхан л тогтоодог: *дхармам ту сакшад бхагават-пранитам* (Шримад Бхагаватам, 6.3.19). Хэн ч төгс төгөлдөр бус цэцэрхийллээрээ шашин номын үндсэн зарчмыг тогтоон бий болгож чадахгүй. Брахма, Шива, Нарада, Ману, Кумарууд, Капила, Прахлада, Бхишма, Шукадева Госвами, Ямаража, Жанака болон Бали Махаража нар шиг аугаа эх сурвалжуудын үлгэр жишээг дагах хэрэгтэй. Ухаан бодлын цэцэрхийллээр шашин болон өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүй гэж юу болохыг хэн ч мэдэж чадахгүй. Ийм учраас Бурхан чин бишрэлтэнгүүдээ үзүүлдэг Өөрийн учир шалтгаангүй өршөөл нигүүлслийн улмаас л Аржунад үйл болон үйл бус гэж юу болох талаар шууд тайлбарлан айлдаж байна. Зөвхөн Кришнагийн ухамсар дахь үйл л хүнийг материаллаг оршихуйн орооцолдооноос ангижруулж чадна.

ШҮЛЭГ 17

*кармано хй апи боддхавьям боддхавьям ча викарманах
акарманах ча боддхавьям гахана кармано гатих*

карманах- үйлийн, хи- тодорхой, апи- мөн, боддхавьям- ойлгогдох ёстой, боддхавьям- ойлгогдох ёстой, ча- мөн, викарманах- хориотой үйлийн, акарманах- үйл бус үйлийн, ча- мөн, боддхавьям- ойлгогдох ёстой, гахана-маш хүнд, карманах- үйлийн, гатих- гарц.

Үйлийн нарийн төвөгтэй байдлыг ойлгоход маш төвөгтэй. Ийм учраас үйл ба хориглосон үйл мөн үйл бус гэж юу болохыг нарийн сайн мэдэх хэрэгтэй.

ТАЙЛБАР: Материаллаг боолчлолын савраас ангижрахыг үнэхээрийн хүсэн байгаа хүн үйл, эх сурвалж бус үйл болоод үйл бусын хоорондын ялгааг ойлгох хэрэгтэй. Тэрээр үйл болон түүний үр дагавар, мөн түүнчлэн хорио цээр бүхий үйлийн мөн чанарыг дэлгэрэнгүй тодорхой судалж үзэх хэрэгтэй. Энэ бол маш нарийн төвөгтэй сэдэв. Кришнагийн ухамсар болон материаллаг байгалийн гунуудад харгалзсан үйлүүдийг хооронд нь ялгаж салгаж чаддаг болохын тулд Бүхний Дээдтэй холбогдсон холбоо харьцаагаа ойлгож сурах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл төгс төгөлдөр мэдлэгийг хүртсэн хүн л амьд оршнол бүр нь Бурханы мөнхийн албат мөн болох учир үйлээ Кришнагийн ухамсарт үйлдэх ёстой гэдгийг ойлгож мэддэг. Бхагавад Гитагийн бүхий л агуулга биднийг энэ дүгнэлтэнд хөтлөн хүргэдэг. Энэхүү ухамсар болон түүнтэй холбогдсон үйлүүдтэй зөрчилдөх бүхий л дүгнэлтүүд нь *викарма* (хориглосон үйл)-ийн ангилалд хамаарагддаг. Энэ бүх зүйлсийг ойлгож мэдэхийн тулд Кришнагийн ухамсрын эх сурвалжуудад хандах хэрэгтэй бөгөөд тэднээс л энэхүү эрхэм нандин нууц мэдлэгийг Бурханаас шууд Өөрөөс нь хүртэхийн нэгэн адил хүртэж болно. Харин энэ зарчмыг үл дагах хэн ч, хамгийн оюунлаг нэгэн байсан ч ялгаагүй зөвхөн мухардал төөрөгдөлд л орох болно.

ШҮЛЭГ 18

*карманй акарма ях пашьед акармани ча карма ях
са буддхиман манушьешу са юктах критсна-карма-крит*

кармани- үйл дэх, акарма- үйл бус, ях- тэр, пашьет- хардаг, акармани- үйл бус дахь, ча- мөн, карма- үр дагавар дагуулагч үйл, ях- тэр, сах- тэр, буддхиман- оюунлаг, манушьешу- хүний нийгэмд, сах- тэр, юктах- трансценденталь байр сууринд байдаг, критсна-карма-крит- байж болох бүхий л үйлүүдийг хийж байдаг ч.

Үйл дэхь үйл бусыг болон үйл бус дахь үйлийг харж байгаа хүн бол хүмүүсийн дундаас хамгийн оюунлаг нь байдаг бөгөөд тэр хэдийгээр үйлдэж болох бүхий л үйлүүдийг үйлдэж байдаг боловч трансценденталь түвшинд оршдог.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсарт үйл үйлдэж байгаа хүн кармын хүлээснээс өөрөө аяндаа салан ангижирдаг. Тэр бүхий л үйлээ Кришнад зориулан үйлдэж байдаг учраас үйлийнхээ үр дагаврыг амсан таашаал ханамж эдлэх болон зовон шаналахаар тулгагдан шахагддаггүй. Иймээс тэр — Кришнад зориулан — янз бүрийн үйл үйлдэж байдаг ч хүний нийгмийн хамгийн оюунлаг хэсэгт хамаарагддаг. *Акарма* гэдэг нь “үр дагавар үл дагуулах үйл” гэсэн утгатай үг. Имперсоналист буюу бодгаль бусыг баримтлагч нь гарах үр дагавар нь өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн зам мөрт саад тотгор болно хэмээн эмээдэг учраас үр дагавар дагуулах үйл үйлдэхээс татгалздаг. Харин персоналист буюу бодгальг баримтлагч нь Бурханы Дээд Бодгалийн мөнхийн албат мөн байдаг гэдэг байр сууриа машид сайн мэдэх учраас өөрийгөө

Кришнагийн ухамсрын үйлэнд зориулж байдаг. Тэр бүхнээ Кришнад зориулан үйлдэж байдаг тул энэхүү алба үйлэндээ зүтгэн байх явцдаа зөвхөн трансценденталь аз жаргалыг амсаж эдэлж байдаг. Үйлээ ийнхүү үйлдэх хүнд өөрийн мэдрэхүйд таашаал ханамж эдлүүлэх гэсэн хүсэл байдаггүй. Кришнагийн мөнхийн албат байх гэсэн ухамсар нь хүнийг материаллаг үр дагаврын бүхий л хэлбэрээс хамгаалан сэргийлж, халдашгүй болгодог.

ШҮЛЭГ 19

*ясья сарве самарамбхах кама-санкална-варжитах
гьянагни-дагдха-карманам там ахух пандитам будхах*

ясья- түүний, *сарве*- бүхий л төрлийн, *самарамбхах*- хичээл чармайлт, *кама*- мэдрэхүйн таашаал ханамж эдлэх хүсэлд үндэслэгдсэн, *санкална*- шийдвэртэй байдал, *варжитах*- юу ч үгүй, *гьяна*- төгс төгөлдөр мэдлэгийн, *агни*- галаар, *дагдха*- шатаадаг, *карманам*- түүний үйлүүд, *там*- түүнийг, *ахух*- нэрлэх, *пандитам*- мэргэд, *будхах*- мэдлэг бүхий.

Үйлдэж буй үйл бүр нь мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн хүсэл эрмэлзлээс ангид байх хэн бүхнийг төгс төгөлдөр мэдлэгийг хүртсэн гэж үздэг. Үйлээ ийнхүү үйлдэх хүний тухай цэцэд мэргэд: төгс төгөлдөр мэдлэгийн гал түүний үйлийн бүхий л үр дагаврыг шатаасан гэж ярьцгаадаг.

ТАЙЛБАР: Төгс төгөлдөр мэдлэгийг хүртсэн хүн л Кришнагийн ухамсарт оршин байгаа хүний үйлийг ойлгоно. Кришнаг ухамсарласан хүн мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн аливаа дур сонирхлоос ангид байдаг явдал нь Бурханы Дээд Бодгалийн мөнхийн албат зарц мөн болох түүний жинхэнэ байр суурийн талаарх төгс төгөлдөр мэдлэгийн галд үйлдсэн үйлийнх нь бүхий л үр дагавар шатаж байдаг гэдгийг харуулж байна. Мэдлэгийн энэхүү төгс төгөлдөрт хүрсэн хүн л үнэхээрийн гүн мэдлэгтэй байдаг. Кришнагийн мөнхийн зарц албат байдаг тухай энэ мэдлэгээ хөгжүүлэхийг нэг л асан дүрэлзсэн бол бүхий л үйлийн үр дагаврыг шатааж чадах галтай зүйрлэдэг.

ШҮЛЭГ 20

*тьяктва карма-пхаласангам нитья-трипто нирашраях
карманй абхиправритто `ни найва кинчит кароти сах*

тьяктва- орхисноор, *карма-пхала-асангам*- үр дагаварт дурлан татагдахуй, *нитья*- үргэлж, *трипта*- ханамжтай, *нирашраях*- ямар нэгэн аврал өмгөөлөлгүйгээр, *кармани*- үйлтэй, *абхиправрита*- бүрнээ зүтгэх, *апи*- гэлээ ч, *на*- үгүй, *эва*- гарцаагүй, *кинчит*- ямар нэгэн зүйл, *кароти*- хийдэг, *сах*- тэр.

Тэр өөрийн үйлүүдийн үр дагаварт дурлан татагдахаас ангид чөлөөтэй байдаг ба үргэлж ханамжтай, үл хамаарсан байдалтай байдаг ба хэдийгээр тэрээр гар хумхилгүй олон төрлийн ажил үйл эрхэлж байдаг ч өчүүхэн төдий үр дагавар дагуулах үйлийг үйлддэггүй.

ТАЙЛБАР: Үйлийн уяа хүлээснээс ийнхүү ангид чөлөөтэй байх нь зөвхөн бүхнийг Кришнад зориулан үйлдэх Кришнагийн ухамсарт л боломжтой байдаг. Кришнаг ухамсарласан хүн Бурханы Дээд Бодгалийг хайрлах чин ариун хайрын улмаас л үйлээ үйлдэж байдаг учраас үйлийн үр дагаварт дурлан татагдах явдлыг өчүүхэн төдий ч мэдэрдэггүй. Тэрээр бүхнээ Кришнад даатгадаг учир өөрийн бие махбодио хэрхэн тогтоон барьж, тэжээн тэтгэж авч явах талдаа ч санаа зовдоггүй. Мөн тэр аливаа зүйлийг эзэмших эсвэл өөрт байгаа зүйлээ алдаж

осолдохоос айж болгоомжлон хамгаалахыг ч эрмэлздэггүй. Тэр өөрийн үүргээ биелүүлэхийн тулд бүхий л хүч чадлаа дайчлан чармайдаг бөгөөд өөрийгөө гагцхүү дан ганц Кришнагаас л хамааралтай байлгадаг. Материаллаг дурлан татагдлаас огоорч ангижирсан ийм хүн сайн болоод муу үр дагавраас ямар ч үйл үйлдээгүй юм шиг үргэлжид ангид байдаг. Энэ бол *акарма* буюу материаллаг үр дагавар үл дагуулах үйлийн шинж байдал. Кришнагийн ухамсарт үйлдээгүй бусад бүх үйлүүд нь материаллаг боолчлолын уяа хүлээнд байхын учир шалтгаан болдог бөгөөд чухамдаа энэ нь л урьд өмнө тайлбарласан *викармын* учир утга билээ.

ШҮЛЭГ 21

нирашир ята-читтатма тьяга-сарва-париграхах
шарирам кевалам карма курван напноти килбишам

нираших- үр дагварын хойноос шавдалгүйгээр, *ята-* эзэмдэн захирдаг, *читта-атма-* ухаан болон оюун ухаан, *тьякта-* орхисноор, *сарва-* бүгд, *париграхах-* өмчлөх санаархал, *шарирам-* бие махбодь болон сүнсээ хамтат нь байлгахаар, *кевалам-* зөвхөн, *карма-* ажил, *курван-* хийснээр, *на-* үгүй, *апноти-* өөртөө хураадаггүй, *килбишам-* нүгэлт үр дагавруудыг.

Ийм хүн төгс хянасан ухаан болон оюун ухаанаар үйлээ үйлддэг бөгөөд өмч хөрөнгө, эд баялаг эзэмших талаарх бүхий л эрмэлзэл санаархлаа орхидог бөгөөд зөвхөн амьдралд нэн зайлшгүй шаардлагатай зүйлийн төлөө л үйл үйлддэг. Ийм байдлаар үйл хэргээ явуулснаар тэр нүгэлт үр дагавартай хэзээ ч холилдон хутгалддаггүй.

ТАЙЛБАР: Кришнаг ухамсарласан хүн өөрийн үйлээсээ сайн болоод муу ямар ч үр дүнг хүсэн хүлээдэггүй. Тэр ухаан болоод оюун ухаанаа бүрэн эзэмдэн захирсан байдаг. Тэрээр өөрийгөө Дээдийн Дээдийн өчүүхэн жижиг хэсэг мөн бөгөөд ийм учраас Бүрэн Бүтэний нэгэн хэсэг байдлаар л үйл үйлддэг бөгөөд бие даан үл хамааралгүйгээр үйл үйлдэж чаддаггүй, харин Дээдийн Дээдийн тодорхойлсноор зөвхөн Түүний зохицуулалтаар үйлддэг гэдгээ л мэддэг. Хэрвээ гар хөдлөх аваас тэр өөрийн хүсэлтээр биш харин бүхий л бие махбодийн хүсэлтийн дагуу хөдөлж байдаг. Кришнаг ухамсарласан хүн өөрөө мэдрэхүйн таашаал ханамж эдлэх хүсэл эрмэлзэлгүй байдаг учир тэрээр үргэлж дээдийн дээд таалалд нийцсэн үйл үйлдэж байдаг. Тэр яг, машины нэгэн хэсэг хэрхэн яаж хөдөлж байдагтай нэгэн адил үйл хөдлөлөө хийж байдаг. Машиныг хэвийн сайн ажиллагаатай байлгахын тулд түүний эд анги, хэсгүүдийг тосолж цэвэрлэж байдаг шиг Кришнаг ухамсарласан хүн зөвхөн Бурханы трансценденталь хайр дүүрэн бялхах албанд зүтгэх чадвартай байхын төлөө л өөрийн материаллаг амьдралын амин чухал хэрэгцээгээ хангахын тулд ажилладаг. Иймээс тэр өөрийн үйлдэж буй бүх үйлүүдийн үр дагавраас ангид байдаг. Амьтан адил, бие махбодио ч эзэмшин захирах ч санаархал түүнд байдаггүй. Эзнийхээ эрхшээл, мэдэлд байгаа амьтан ямар ч үл хамаарсан байдалгүй байдаг ба харгис зэрлэг эзэн нь түүнийг алж нядлахаар зэхэж байхад ч ямар ч эсэргүүцэл үзүүлдэггүй билээ.

Гагцхүү өөрийгөө бүрэн нээж танин мэдэх үйлэнд зүтгэж байгаа Кришнаг ухамсарласан хүнд ямар нэгэн материаллаг эд зүйлс эзэмших гэсэн хий хуурмаг эрмэлзэлд зориулах цаг зав байдаггүй. Бие махбодь болон сүнсээ хамтад нь тогтоон барьж байхын тулд цэвэр бус аргаар мөнгө олох хэрэг түүнд байдаггүй. Иймээс тэр иймэрхүү материаллаг нүглээр бузартдаггүй. Тэр өөрийн үйлдсэн үйлүүдийнхээ бүхий л үр дагавраас ангид байдаг.

ШҮЛЭГ 22

ядричча-лабха-сантушто двандватито виматсарах
самах сиддхав асиддхау ча критвати на нибадхьяте

ядриччха- өөрөө, лабха- ашиг орлоготой, сантуштах- ханамжтай, двандва- хоёрдмол байдал, атитах- ялан дийлэх, виматсарах- атаархалаас ангид, самах- үл ажирсан, сиддхау- амжилтанд, асиддхау- ялагдалд, ча- мөн, критва- үйлдсэнээр, апи- хэдий ч, на- хэзээ ч үгүй, нибадхьяте- нөлөөлөгддөг.

Өөрөө орж ирж буй олз ашигт хангалуун хийгээд энэ ертөнцийн хоёрдмол байдлаас ангид байхын зэрэгцээ атаархаж жөтөөрхөхийг үл мэдэн амжилт ялалт болоод алдаа дутагдалд үл ажирсан нэг л байдлаар тайван хандах хүн үйл үйлдэж байдаг ч үйлийнхээ үр дагаварт хэзээ ч орооцолдон баригддаггүй.

ТАЙЛБАР: Кришнаг ухамсарласан хүн өөрийн бие махбодийн хэрэгцээг хангахын төлөө хүч чадлаа ихээр шавхаад байдаггүй. Тэр өөрөө орж ирж буй олз ашигт хангалуун байдаг. Тэр гуйлга гуйж, өр зээл тавьдаггүй, харин өөрийн хүч чадалд тохирсон ажлыг шудрагаар хийдэг ба энэхүү шудрага хөдөлмөрийнхөө үр шимд ханамжтай байдаг. Тиймээс тэр өөрийн амьдралаа залгуулахын хувьд хэнээс ч хамааралгүй, хараат бус байдаг. Кришнагийн ухамсар дахь үйлэнд нь өөр хэн нэгэнд үйлчлэн зүтгэх явдал саад тотгор болохыг тэр үл зөвшөөрнө. Гэхдээ Бурханд үйлчлэн зүтгэхийн тулд тэр ямар ч төрлийн үйлийг үйлдэхэд бэлэн байдаг бөгөөд энэ явцад нь түүнд халуун хүйтэн, эсвэл баяр хөөр уйтгар гуниг зэрэг материаллаг ертөнцийн хоёрдмол байдлууд огтхон ч саад тотгор болдоггүй. Кришнаг ухамсарласан хүн Кришнагийн таалалд нийцүүлэн Түүнийг цэнгүүлэх үйлэнд зүтгэхээс ямар ч нөхцөл байдал байсан хойш үл суух учир энэхүү хоёрдмол байдлаас дээш оршиж байдаг. Иймээс тэр амжилт ололттой эсвэл алдаа дутагдалтай байсан ч аль алинд нь үл ажирсан нэг янзаар тайван ханддаг. Энэхүү шинжүүд нь трансценденталь мэдлэгт бүрнээ автсан байх хүнд л илэрдэг болой.

ШҮЛЭГ 23

*гата-сангасья муктасья гьянавастхита-четасах
ягьяя чаратах карма самаграм правиляте*

гата-сангасья- материаллаг байгалийн гунуудад үл дурлан татагдагчийн, муктасья- ангижирагчийн, гьяна-авастхита- трансценденталь түвшинд оршигчийн, четасах- цэцэн мэрэгэн байдал нь, ягьяя- Ягья (Кришна)-ын төлөө, ачаратах- үйлдсэнээр, карма- үйл, самаграм- бүхэлдээ, правиляте- бүрэн уусан ордог.

Материаллаг байгалийн гунуудын нөлөөллөөс ангижирсан хийгээд трансценденталь мэдлэгт бүрнээ автсан хүний үйлүүд нь Үнэмлэхүйд бүрэн уусан ордог.

ТАЙЛБАР: Кришнаг бүрэн ухамсарласан хэн бүхэн бүхий л хоёрдмол байдлуудаас ангижирсан байх тул материаллаг гунуудын бузраас ангид байдаг. Кришнаатай холбогдсон өөрийн жам ёсны байр сууриа мэдсэн байх түүний хувьд ангижралд хүрэх хаалга үүд нээлттэй байдаг. Иймээс түүний ухаан Кришнагийн ухамсраас холдон сарнихгүй бөгөөд хийж үйлдэж буй бүхнээ анхдагч Вишну, Кришнад зориулдаг. Иймд түүний бүхий л үйлүүд нь чухамдаа өргөлүүд байдаг. Учир нь, “өргөл” гэдэг нь Бүхний Дээд Бодгаль, Вишну, Кришнаг цэнгүүлэх гэсэн утгатай юм. Ийм үйлүүдийн бүхий л үр дүн нь Үнэмлэхүйд уусан ордог нь тодорхой бөгөөд ямар ч материаллаг үйлчлэл нөлөө үзүүлэхгүй.

ШҮЛЭГ 24

*брахмарпанам брахма хавир брахмагнау брахмана хутам
брахмайва тена гантавьям брахма-карма-самадхина*

брахма- мөн чанарын хувьд бурханлаг, *арпанам*- өргөл, *брахма*- Бүхний Дээд, *хавих*- тос, *брахма*- бурханлаг, *агнау*- тахилгын галд, *брахмана*- бурханлаг сүнсээр, *хутам*- өргөсөн, *брахма*- бурханлаг орон, *эва*- гарцаагүй, *тена*- түүгээр, *гантавьям*- хүргэгддэг, *брахма*- бурханлаг, *карма*- үйлд, *самадхина*- бүрэн автсанаар.

Кришнагийн ухамсарт бүрнээ автсан хүн бурханлаг оронд хүрч очих нь эргэлзээгүй. Учир нь тэр өөрийгөө бурханлаг үйлэнд бүрнээ зориулж байдаг ба энэ үйлүүдийг үйлдэх үйл явц нь үнэмлэхүй ба өргөл болгон өргөж буй зүйл нь ч мөн л нэг адил бурханлаг мөн чанартай байдаг билээ.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсарт үйлдэж буй үйл нь эцэстээ хүнийг бурханлаг төгс төгөлдөрт хэрхэн хүргэдэг талаар энд өгүүлж байна. Кришнагийн ухамсарт олон янз хэлбэртэй үйлүүд байдаг ба тэд бүгдийн талаар дараагийн шүлгүүдэд өгүүлнэ. Харин энд эхлээд зөвхөн Кришнагийн ухамсрын зарчмыг тайлбарлаж байна. Материаллаг бузарт нэрвэгдсэн болзолт сүнс нь үйлээ материаллаг нөлөөллийн доор үйлдэж байдаг нь эргэлзээгүй хэрэг бөгөөд энэ нөлөөллөөс өөрийгөө чөлөөлөн ангижруулах хэрэгтэй. Болзолт сүнсний материаллаг нөлөөллөөс салан ангижирч чадах арга зам бол Кришнагийн ухамсар юм. Жишээлбэл, сүүн бүтээгдэхүүн хэт их хэрэглэснээс болж гэдэс дотор нь хямарч эвгүйрхсэн өвчтөнийг сүүн бүтээгдэхүүний өөр нөгөн төрлөөр, тухайлбал таргаар анагааж болдог. Гитад энд тайлбарлаж байгаачлан, материаллаг ухамсарт живэн байх болзолт сүнсийг Кришнагийн ухамсрын арга замаар анагааж болно. Энэ үйл явцыг ерөнхийд нь *ягья* (өргөл) гэж нэрлэдэг бөгөөд энэ нь бүхэлдээ Вишну буюу Кришнаг цэнгүүлэхэд зориулан үйлдэж буй үйлүүд юм. Материаллаг ертөнцийн үйлүүдийг Кришнагийн ухамсарт өөрөөр хэлбэл, Вишнуг цэнгүүлэхэд зориулан хэдийчинээн их үйлдэнэ үүний ач тусаар энэ дэлхийн байдал төдийчинээн бурханлаг болно. *Брахма* (Брахман) гэдэг үг нь бурханлаг гэсэн утгатай. Бурхан мөн чанарын хувьд бурханлаг байдаг учраас Түүний трансценденталь биеэс цацрах туяаг *брахмажьоти* буюу Түүний бурханлаг туяа гэж нэрлэдэг. Оршин байгаа бүх зүйлс энэхүү туяанд оршдог, харин энэ *жьоти* нь хий хуурмаг (*майа*) буюу мэдрэхүйн таашаал ханамж эдлэх дур хүслээр бүрхэгдэн хучигдсан үед түүнийг материаллаг гэж нэрлэдэг. Кришнагийн ухамсарын зориулалтаар өргөж буй өргөл, энэ өргөлийг таалан болгоогч, таалж болгоох үйл явц, өргөл өргөгч болон үр дүн-энэ бүгд нь цогцоороо Брахман, Үнэмлэхүй Үнэн болох учир энэхүү материаллаг гивлүүр, бүрхүүлийг Кришнагийн ухамсрын арга замаар хоромхон зуурт холдуулан алга болгож болно. *Майа*-гаар бүрхэгдсэн Үнэмлэхүй Үнэнийг матери гэж нэрлэдэг. Гэхдээ материйг Үнэмлэхүй Үнэний алба үйлэнд зориулан ашиглаж оролцуулах аваас түүний бурханлаг шинж чанар дахин сэргэх болно. Кришнагийн ухамсар бол хий хуурмагаар хучигдан бүрхэгдсэн ухамсарыг Брахманы буюу Дээдийн Дээдийн ухамсарт хувиргагч арга үйл юм. Кришнагийн ухамсарт бүрнээ автан байгаа ухааныг *самадхи* (транс)-д байна гэж ярьдаг. Ийм трансценденталь ухамсарт үйлдэж буй хүний үйл бүхэн *ягья*, буюу Бүхний Дээдэд зориулсан өргөл болдог. Бурханлаг ухамсрын энэ төлөвт өргөл өргөгч, өргөж буй өргөл, өргөлийг таалан болгоохуй, тахилгач буюу өргөл тахилгыг шууд удирдан гүйцэтгэгч болон үр дүн нь бүгд Үнэмлэхүй буюу Дээдийн Дээд Брахмантай нэг ижил болдог. Энэ бол Кришнагийн ухамсрын арга зам.

ШҮЛЭГ 25

дайвам эвапаре ягьям иогинах парьюпасате
брахмагнав апаре ягьям ягьенайвопажухвати

дайвам- сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэхэд, *эва*- ийм байдлаар, *апаре*- бусад, *ягьям*- өргөл, *иогинах*- ид шидэт-иогч, *парьюпасате*- төгс төгөлдөр байдлаар бишрэн шүтдэг,

брахма- Үнэмлэхүй Үнэний, *агнау*- галд, *апаре*- бусад, *ягьям*- өргөл, *ягьена*- өргөлөөр, *эвайим* байдлаар, *унажухвати*- өргөдөг.

Зарим иогчид сахиулсан тэнгэрүүдэд янз бүрийн өргөл өргөн тэднийг хичээнгүйлэн шүтэн биширч байхад бусад нь Бүхний Дээд Брахманы галд өргөл өргөдөг.

ТАЙЛБАР: Дээр өгүүлсэнчлэн, Кришнагийн ухамсарт өөрийн үүргээ биелүүлж байгаа хүнийг мөн төгс төгөлдөр иогч гэж нэрлэдэг. Гэсэн ч мөн үүнтэй төстэй байдлаар өргөл өргөн байх өөр иогчид ч байдаг: тэдний зарим нэгэн нь сахиулсан тэнгэрүүдийг, өөр бусад нь Бүхний Дээд Бурханы бодьгал бус төлөв болох Дээдийн Дээд Брахманыг шүтэн биширч байдаг. Янз бүрийн хүмүүсийн ийнхүү үйлдэн байгаа өөр өөр төрлийн өргөлүүд байдаг боловч тэдгээр нь зөвхөн гадна өнгөн талдаа л ялгаатай харагддаг. Үнэн хэрэгтээ, бүхий л өргөлүүд нь эцсийн дүндээ, мөн *ягья* гэж нэрлэгддэг Бүхний Дээд Бурхан, Вишнуд л зориулагддаг. Энэ бүх, янз бүрийн хэлбэрийн өргөлүүдийг материаллаг баялгийн болон трансценденталь мэдлэг хүртэх зориулалт бүхий өргөл гэсэн хоёр ерөнхий ангилалд хуваадаг. Кришнагийн ухамсарт орших чин бишрэлтэнгүүд нь өөрсдийн бүхий л материаллаг зүйлсээ Бүхний Дээд Бурханыг цэнгүүлэхийн тулд зориулан өргөл болгож байхад түр зуурын материаллаг аз жаргалын төлөө тэмүүлэх зарим хүмүүс нь нарны бурхан болон Индра зэрэг сахиулсан тэнгэрүүдэд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэхийн тулд тэдэнд материаллаг эд баялгаа өргөж байдаг. Мөн өөр нэг хэсэг нь болох имперсоналистууд нь бодьгал бус Брахманд уусаж нэгдэн орсноор өөрсдийн бие даасан байдлаа өргөл болгож байдаг. Сахиулсан тэнгэрүүд нь орчлон даяар илч дулаан, ус, гэрэл болон бусад зүйлсийг түгээн хангаж, харж хянаж байх бүхий л материаллаг үүргүүдийг гүйцэтгэх даалгаврыг Бүхний Дээд Бурханаас авсан хүчирхэг амьд оршнолууд юм. Материаллаг ашиг хонжоо, эрх дарх хүсэгчид нь сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэж тэдэнд зориулан, Ведэд заасны дагуу өргөл тахилгуудыг үйлдэж байдаг. Иймэрхүү хүмүүсийг *бахв-шивара-вади* буюу олон бурхдад итгэгчид гэдэг. Сахиулсан тэнгэрүүдийг түр зуурын хэмээн үзэж Үнэмлэхүй Үнэний бодгаль бус төлвийг бишрэн шүтэх өөр бусад хүмүүс нь өөрсдийн бие даасан байдлаа Үнэмлэхүйн галд өргөл болгон Дээдийн Дээдийн оршнолд уусан орж нэгдсэнээр өөрсдийн бие даасан оршихуйгаа эцэс болгодог. Бодгал бусын талыг баримтлагч иймэрхүү хүмүүс нь Дээдийн Дээдийн мөн чанарыг ойлгохын тулд өөрсдийн цагаа философийн цэцэрхийлэлд зориулан өргөл болгон үрж байдаг. Өөрөөр хэлбэл, үйлийнхээ үр дагаврын төлөө ажиллагсад нь материаллаг таашаал ханамж эдлэхийн төлөө өөрсдийн материаллаг эд хөрөнгө, баялгаа өргөж байхад бодьгал бусыг баримтлагчид буюу имперсоналистууд нь Бүхний Дээдийн оршнолд уусан нэгдэх зорилгоор өөрсдийн материаллаг адилтгалаа буюу бодьгал байдлаа өргөл болгодог. Имперсоналистуудын хувьд өргөл тахилгын галын шүтээн нь Дээдийн Дээд Брахман, харин өргөл нь бол Брахманы галд шатан үгүй болох тэдний бие даасан байдал байдаг. Харин Аржуна шиг Кришнаг ухамсарласан хүн Кришнаг цэнгүүлэхэд л бүхнээ зориулан өргөж байдаг ба ингэснээр түүний бүхий л материаллаг зүйлс болон мөн тэр өөрөө- бүгд Кришнад өргөл болдог. Ингэснээрээ тэр төгс төгөлдөр иогч болдог ч өөрийн бие даасан байдлаа хэзээ ч алддаггүй.

ШҮЛЭГ 26

шротрадининдрияни анье самьямагнишу жухвати
шабдадин вишаян анья индриягнишу жухвати

шротра-адини- жишээлбэл сонсох үйл явц шиг, *индрияни*- мэдрэхүй, *анье*- бусад, *самьяма*- хойш татахуйн, *агнишу*- галд, *жухвати*- өргөх, *шабда-адин*- дуу авиа гэх мэт, *вишаян*- мэдрэхүйн таашаал ханамжийн объектууд, *анье*- бусад, *индрия*- мэдрэхүйн эрхтэнгүүд, *агнишу*- галд, *жухвати*- тэднийг өргөдөг.

Нэг хэсэг (жинхэнэ брахмачарья нар) нь сонсох үйл явц хийгээд мэдрэхүйгээ ухаанаа эзэмдэн захирахын галд өргөж байхад өөр нэг хэсэг (зохицуулах журмын дагуу гэр бүлийн амьдралаар амьдрагсад) нь мэдрэхүйн галд мэдрэхүйн объектуудаар тахилга өргөл өргөж байдаг.

ТАЙЛБАР: Хүний амьдралын дөрвөн хэвшлийн гишүүд болох *брахмачари, грихастхи, ванапрастха* болон *санньяси* нар нь бүгд төгс төгөлдөр иогчид, төгс төгөлдөр трансценденталистууд болох ёстой. Хүний амьдрал нь амьтан адгуус мэт мэдрэхүйн таашаал ханамж эдлэхэд зориулагдаагүй учир хүний амьдралын дөрвөн үе шат нь хүн бурханлаг амьдралын төгс төгөлдөрт хүрч чадахаар тэгж зохион байгуулагдсан байдаг. *Брахмачари* буюу жинхэнэ номын багшийн асрамж хяналтанд байх шавь нь мэдрэхүйн таашаал ханамж эдлэхээс хол хөндий байснаар ухаанаа эзэмдэн захирахад суралцдаг. Тэр зөвхөн Кришнагийн ухамсарт холбоотой үгүүдийг л сонсож байдаг. Сонсох нь ойлгохын үндэс байдаг учраас жинхэнэ цэвэр ариун *брахмачари* нь үргэлж *харер наманукиртанам* буюу Бурханы гайхамшигт сайхнаас сонсох болон давтан хэлэх, өгүүлэх үйлэнд автан байдаг. Тэр материаллаг дуу авиаг сонсоход хэзээ ч анхаарал хандуулдаггүй, харин Харе Кришна Харе Кришна-ын трансценденталь дуу авианд л төвлөрч байдаг. Тодорхой хэмжээгээр мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийг зөвшөөрсөн байдаг гэр бүлтэй хүмүүс нь энэ үйлүүдээ мөн нэгэн адил маш их хязгаарлалттайгаар үйлдэж байдаг. Бэлгийн дур хүслээ хангах, мансууруулах зүйлс хэрэглэх болон хоол хүнсэндээ мах хэрэглэх зэрэг нь хүний нийгмийн нийтлэг чиг хандлага байдаг ч амьдралаа тодорхой журам дүрмийн дагуу зохицуулан авч яваа гэр бүлийн амьдралын хэвшилд амьдрах хүн нь ямар ч жолоодлогогүй бэлгийн амьдрал болон мэдрэхүйн бусад таашаал ханамж эдлэхээр өөрийгөө дур зоргоор нь тавьдаггүй. Шашин номын амьдралын үндсэн зарчмуудад нийцэж зохицсон гэр бүл нь бэлгийн амьдралыг хязгаарлах арга зам болдог учраас соёл иргэншил бүхий аль ч нийгэмд байдаг нийтээр заншсан ердийн зүйл юм. *Грихастха* нь бэлгийн таашаал ханамж эдлэх гэсэн өөрийн дур сонирхлыг илүү дээд, бурханлаг амьдралын төлөө өргөл болгон өргөж байдаг учир энэхүү жолоодлого, хязгаарлалт бүхий бэлгийн амьдрал нь *ягья-ийн* нэгэн төрөл болж байдаг.

ШҮЛЭГ 27

*сарваиндрия-кармани прана-кармани чапаре
атма-самьяма-йогагнау жухвати гьяна-дипите*

сарвани- бүхий л, *индрия-* мэдрэхүй, *кармани-* үүргүүд, *прана-кармани-* амьдралын амьсгалын үүргүүд, *ча-* мөн, *апаре-* бусад, *атма-самьяма-* ухаанаа эзэмдэн захирахуйн, *йога-* холбох үйл явц, *агнау-* галд, *жухвати-* өргөх, *гьяна-дипите-* өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйд хүрэх хүсэл эрмэлзлийн үндсэн дээр.

Ухаан болон мэдрэхүйгээ эзэмдэн захирснаар өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйд хүрэхээр чармайн байгаа бусад хэсэг нь өөрсдийн мэдрэхүйн болоод амьдралын амьсгалын бүхий л үүргүүдээ эзэмдэн захирагдсан ухааны галд өргөл болгодог.

ТАЙЛБАР: Энд Патанжалийн үндэслэсэн иогийн системийн тухай өгүүлж байна. Патанжалийн иогийн сударт сүнсийг *пратьяг-атма, параг-атма* гэж нэрлэсэн байдаг. Мэдрэхүйн таашаал ханамж эдлэхэд татагдан байгаа сүнсийг *параг-атма*, харин иймэрхүү мэдрэхүйн таашаал ханамж эдлэх явдалд үл татагдан түүнээс ангид байх сүнсийг *пратьяг-атма* гэж нэрлэдэг. Сүнс нь бие махбодийн дотоодод урсан үйлчлэл нөлөөллөө үзүүлж байдаг агаарын арван урсгалын эрхшээл, нөлөөнд баригдан байдаг бөгөөд үүнийг амьсгалаа удирдаж сурснаар мэдэрч болно. Патанжалийн иогийн систем нь бие махбодийн хийн урсгалыг механик иогийн системийн аргын тусламжтайгаар хэрхэн хянан захирах, тэгснээр эцэстээ

дотоод хийн нөлөөллийн бүхий л шинжүүдийг ашиглан сүнсийг материаллаг байдалд дурлан татагдахаас ариусгахад сургадаг. Иогийн энэ системийн дагуу бол *прагья-атма* нь дээдийн дээд зорилго. *Прагья-атма* гэдэг нь материаллаг үйлээс хөндийрэхийг хэлдэг. Мэдрэхүй нь мэдрэхүйн объектуудтай буюу чихэнд сонсох, нүдэнд харах, хамарт үнэрлэх, хэлэнд амтлах, гарт хүртэх зэрэг мэдрэмж өгөх харилцан үйлчлэлд байдаг тул бүх мэдрэхүй нь үйлийг сүнснээс гадуур үйлдэж байдаг. Эдгээрийг *прана-ваю-ын* үүргүүд гэдэг. *Апана-ваю* нь доош, *вьяна-ваю* нь агшаах тэлэх, *самана-ваю* нь тэнцвэртэй байдлыг хадгалах, *удана-ваю* нь дээш чиглэгдсэн урсгалтай байдаг. Мэдлэг ухааныг хүртэн гэгээрсэн хүн л хийн эдгээр урсгалуудыг өөрийгөө бүрэн нээн танин мэдэхэд гаргаж байгаа хичээл чармайлтандаа ашигладаг.

ШҮЛЭГ 28

*дравья-ягьяс тапо-ягья йога-ягьяс татхапаре
свадхья-гьяна-ягьяш ча ятаях-самшита-вратах*

дравья-ягьях- өөрийн эд хөрөнгөө өргөснөөр, *тапо-ягьях*-огоорохуй дахь өргөл, *йога-ягьях*-найман шатлалт мистик иог дахь өргөл, *татха*- ингэж, *апаре*- бусад, *свадхья*- Ведийг судлахуй дахь өргөл, *гьяна-ягьях*- трансценденталь мэдлэгийг хөгжүүлэхүй дэх өргөл, *ча*- мөн, *ятаях*- гэгээрсэн хүмүүс, *самшита-вратах*- хатуу чанга сахил өөртөө авсанаар.

Хатуу чанга ам өчиг өгч сахил хүртсэн зарим нь өөрсдийн эд баялаг хөрөнгөө өргөл болгон өргөснөөр, зарим нь хатуу чанга тэвчил наминчлал үйлдсэнээр, зарим хэсэг нь найман шатлалт йогоор хичээллэсэнээр, эсвэл зарим нь трансцендент мэдлэгтээ ахиц дэвшил гаргахын тулд Ведүүдийг судласнаар тахилга өргөж өргөж байдаг.

ТАЙЛБАР: Эдгээр өргөлүүдийг хэд хэдэн бүлэгт хувааж болно. Хөрөнгөө янз бүрийн хандив өглөгт зориулан өргөл болгодог хүмүүс байдаг. Энэтхэгт баян худалдаачид болон сурвалжит язгууртай хүмүүс *дхарма-шала*, *анна-киштра*, *атитхи-шала*, *анатхалая*, *видья-питха* болон өөр бусад хандивын байгууллагуудыг нээн ажиллуудаг. Бусад орнуудад ч мөн олон эмнэлэг, ахмад настай хүмүүсийг асрах байр болон ядуучуудад хоол, боловсрол, эмнэлгийн тусламж үнэгүй олгох, үзүүлэх зэрэг өглөг хандивын бусад байгууллага, сангууд байдаг. Энэ бүх хандив буяны үйлүүдийг *дравья-майа-ягья* гэж нэрлэдэг. Мөн амьдралын илүү өндөр түвшинд эсвэл дараагийн амьдралдаа орчлонгийн дээд гаригуудад хүрч очихын тулд *чандраяна* болон *чатурмасья* зэрэг тэвчил огоорлын янз бүрийн хэлбэрүүдийг өөртөө сайн дураараа оногдуулж эдэлдэг хүмүүс ч байдаг. Эдгээр үйл явцууд нь хүнийг тодорхой нарийн дэглэм журам баримтлан амьдрахыг шаарддаг. Тухайлбал, *чатурмасья-ын* тэвчил үйлдэж байгаа хүн жилийн дөрвөн сарын хугацаанд (7-11 дүгээр саруудын хооронд) үс сахлаа авахгүй байх, тодорхой төрлийн хоол хүнсийг үл хэрэглэх болон өдөрт зөвхөн нэг удаа хооллох, мөн гэр орноосоо огтхон ч гарч болдоггүй ёстой байдаг. Ийнхүү өөрийн амьдралын тав тухтай байдлыг өргөл болгохыг *тапомайа-ягья* гэдэг. Бусад зарим хүмүүс нь Патанжалийн систем (Үнэмлэхүйд уусан орохын тулд) эсвэл *хатха-йога* юмуу *аштанга-йога* (төгс төгөлдөрийн тодорхой нэгэн хэлбэрт хүрэхийн тулд) зэрэг ид шидийн иогийн янз бүрийн төрлүүдээр оролдон хичээллэж байхад өөр нэг хэсэг нь мөргөлийн ариун дагшин газруудаар аялан явж байдаг. Иймэрхүү хэлбэрийн бүх үйлүүдийг *йога-ягья* буюу материаллаг ертөнц дэх төгс төгөлдөрийн тодорхой нэгэн хэлбэрт хүрэхийн төлөөх өргөл гэж нэрлэдэг. Мөн цаашилбал ведийн янз бүрийн судруудыг, ялангуяа Упанишад, Веданта судар эсвэл *санхья*-философийг судлахад өөрсдийгөө зориулан судлах, суралцах үйлээ өргөл болгодог хүмүүс ч байдаг. Эдгээр үйл явцыг *свадхья-ягья* буюу ариун гэгээн судруудыг судлахуйн өргөл гэж нэрлэдэг. Энэ бүх иогчид нь бүрэн итгэл бишрэлтэйгээр эдгээр олон төрлийн өргөлүүдийг өргөн амьдралын илүү өндөр дээд түвшинд хүрэхийг эрмэлзэж байдаг. Гэхдээ Кришнагийн

ухамсар нь Бүхний Дээд Бурханд шууд үйлчлэн зүтгэх алба үйл учраас эдгээр олон өргөлүүдээс ялгаатай. Дээр дурьдсан олон өргөлүүдийн алиныг нь ч өргөсөн Кришнагийн ухамсарт хүрч чадахгүй. Харин түүнд зөвхөн Бурханы болон Түүний жинхэнэ чин бишрэлтэнгийн өршөөл нигүүлслээр л хүрч болно. Ийм учраас Кришнагийн ухамсар нь трансценденталь юм.

ШҮЛЭГ 29

*апане жухвати пранам пране `панам татханаре
пранана-гати- руддхва пранаяма-параянах
анаре ниятахарах пранам пранешу жухвати*

апане- доош чиглэн урсаж байгаа хийд, *жухвати-* өргөх, *пранам-* гадагш чиглэн урсаж байгаа хий, *пране-* гадагш чиглэн урсаж байгаа хийд, *апанам-* доош чиглэн урсаж байгаа хий, *татха-* мөн тэрчлэн, *анаре-* бусад, *прана-* гадагш чиглэн урсаж байгаа хийн, *апана-* болон доош чиглэн урсаж байгаа хийн, *гати-* хөдөлгөөн, *руддхва-* зогсоосноор, *пранаяма-* амьсгалаа зогсоосноор хүрдэг транс, *параянах-* үүнд дур сонирхолтой, *анаре-* бусад, *нията-* эзэмдэн захирсанаар, *ахарах-* хоол, *пранан-* гадагш чиглэн урсах хий, *пранешу-* гадагш чиглэн урсах хийд, *жухвати-* өргөх.

Трансын байдалд байхын тулд амьсгалаа хянан удирдах үйлд татагдан байх өөр нэг хэсэг хүмүүс нь гадагш гаргаж буй амьсгалаа дотогш татаж буй амьсгалдаа, дотогш татаж буй амьсгалаа гадагш гаргаж буй амьсгалдаа өргөл болгодог. Ингэснээр тэд эцэстээ бүх амьсгалаа зогсоосноор трансын байдалд ордог. Хоолоо хязгаарлан байгаа бусад нь гаргаж буй амьсгалаа өөртөө өргөл болгож байдаг.

ТАЙЛБАР: Амьсгалын үйл явцыг хянан удирдах иогийн энэхүү системийг *пранаяма* гэж нэрлэдэг бөгөөд *хатха-йогын* системийн эхлэл үед суудлын янз бүрийн байрлалд хийдэг. Энэ бүх аргуудыг мэдрэхүйгээ эзэмдэн захирч сурах болон бурханлаг танин мэдэхүйдээ цаашдын хөгжил дэвшил гаргахын тулд хэрэглэхийг зөвлөдөг. Бие махбодийн доторх хийн урсгалыг хянан удирдсанаар, жишээлбэл тэдний хөдөлгөөний чиглэлийг эсрэгээр өөрчлөх чадвартай болох явдал энэ арга техникт хамаардаг. *Апана* хий нь дээш, *прана* хий нь доош чиглэсэн хөдөлгөөнтэй байдаг. *Пранаяма*-иогчид нь хийн хоёр урсгалууд бие биенээ саармагжуулан *пурака* буюу тэнцвэртэй байдалд орох хүртэл амьсгалаа эсрэг чиглэлээр үйлдэхэд суралцаж байдаг. Гадагш гаргаж буй амьсгалаа дотогш татаж буй амьсгалдаа өргөхийг *речака* гэдэг бөгөөд хийн энэ хоёр урсгалын хөдөлгөөнийг бүрэн зогсоохыг *кумбхака-йога* гэж нэрлэдэг. Бурханлаг хөгжлийн төгс төгөлдөрт хүрэхийн тулд хүн *кумбхака-йога-д* суралцан дадлагажсанаар амьдралынхаа үргэлжлэх хугацааг уртасгаж болно. *Кумбхака-йога-ыг* хийснээр иогчид амьдралаа олон олон жилээр уртасгаж чадах учир ухаалаг иогчид нь төгс төгөлдөрт дараагийн амьдралдаа хүрнэ гэж хойш тавилгүйгээр энэ амьдралдаа л хүрэхээр чармайдаг. Харин Кришнаг ухамсарласан хүн Бурханы трансценденталь хайр дүүрэн бялхах алба үйлэнд байнгад автан байдаг учир мэдрэхүйгээ аяндаа эзэмдэн захирч тэдгээрийн эзэн нь болдог. Түүний мэдрэхүй нь Кришнад үйлчлэн зүтгэх үйлүүдэд байнгад автан байх учир өөр ямар нэгэн зүйлд үл татагдана. Ийнхүү тэрээр амьдралынхаа эцэст Шри Кришнагийн трансценденталь түвшинд аяндаа дээшлэн хүрч очих учир амьдралынхаа үргэлжлэх хугацааг уртасгахыг чармайдаггүй. Бхагавад Гитагийн (14.26)-д батлан өгүүлсэнчлэн, тэрээр ангижралын түвшинд шууд дээшлэн хүрдэг:

*мам ча йо `вьябхичарена бхакти-йогена севате
са гунам саматитьяйтан брахма-бхуяя калпате*

“Бурханы булингаргүй чин бишрэл дүүрэн албанд зүтгэн байгаа хүн материаллаг байгалийн гуууудыг ялан дийлж даван гарах бөгөөд бурханлаг түвшинд шууд дээшлэн хүрнэ.” Кришнаг ухамсарласан хэн бүхэн бүр эхнээсээ л трансценденталь түвшинд оршин байх бөгөөд тэрээр энэхүү ухамсраа байнгад хадгалж байдаг. Тийм учраас тэрээр уналтанд үл өртөх бөгөөд эцэстээ Бурханы оронд шууд хүрч очно. Энэ шүлэгт хоол ундаа хязгаарлах буюу хоолны дэглэм барих арга замын талаар мөн дурьдаж байгаа бөгөөд хүн, эхлээд Бурханд өргөсөн зоог буюу зөвхөн *Кришна-прасадам* хүртэж байх аваас энэ асуудал аяндаа зохицуулагдаж шийдэгдэнэ. Мэдрэхүйгээ эзэмдэн захирахын тулд хоол ундаа хязгаарлан дэглэм барих нь маш тустай. Мэдрэхүйгээ эзэмдэн захирахгүйгээр материаллаг хүлээснээс ангижрана гэдэг боломжгүй хэрэг билээ.

ШҮЛЭГ 30

*сарве`ти эте ягья-видо ягья-кшапита-калмашах
ягья-шишита-амрита-бхужо янти брахма санатанам*

сарве- бүгд, *апи*- хэдийгээр ялгаатай харагдавч, *эте*- эдгээр, *ягья-видах*- тахилга өргөл өргөхийн зорилгыг сайн мэдэх, *ягья-кшапита*- иймэрхүү өргөлийн үр дүнд ариуссан байгаа, *калмашах*- нүгэлт үр дагавруудаас, *ягья-шишита*- иймэрхүү ягья-үйлдэхийн үр дүнгүүдийн, *амрита-бхужах*- ийм рашааныг амталсан байх тэд, *янти*- ойртдог, *брахма*- дээдийн дээд, *санатанам*- мөнхийн орны.

Тахилга өргөл нь нүгэлт үйлийн үр дагавраас ангижруулдаг гэдгийг мэдэх энэ бүх тахилга өргөл үйлдэгчид нь тахилга өргөлийн үр шим болсон рашааныг амтлах бөгөөд дээд мөнхийн ахуй өөд өгсөн дээшилмүй.

ТАЙЛБАР: Өргөлийн янз бүрийн хэлбэрүүдийн (тухайлбал: өөрийн хувийн эд баялгийг өргөх, Ведийг судлах, философийн номлол эсвэл иогоор хичээллэх) тухай өгүүлсэн дээрх тайлбараас үзэхэд энэ бүх өргөлүүд нь зөвхөн мэдрэхүйгээ хяналт захиргаандаа оруулах гэсэн нэг л зорилготой гэдэг нь харагдаж байна. Мэдрэхүйн таашаал ханамж эдлэх нь материаллаг оршихуйн үндсэн гол шалтгаан байдаг. Иймээс мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн хүсэл бүхий түвшингээс ангижран дээш гараагүй цагт хүн төгс төгөлдөр мэдлэг, төгс төгөлдөр цэнгэл жаргал болон төгс төгөлдөр амьдралын мөнхийн түвшинд дээшлэн хүрч очих боломжгүй байдаг. Энэхүү түвшин нь мөнхрөлийн буюу Брахманы хүрээнд оршин байдаг. Дээр дурьдсан бүхий л өргөлүүд нь хүнийг материаллаг оршихуйн нүгэлт үр дагавруудаас ариусахад нь тус дэм болдог. Энэхүү бурханлаг хөгжил дэвшлийн ач тусаар хүн зөвхөн энэ амьдралдаа аз жаргалтай, чинээлэг хангалуун байгаад зогсохгүй эцэс хожмоо мөн, нэг бол бодьгал бус Брахманд уусан нэгдэх, үгүй бол Бурханы Дээд Бодгаль Кришнагийн хүрээлэлд орсноор Бурханы мөнхийн оронд хүрч очно.

ШҮЛЭГ 31

наям лока`сти аягьясья кутто`ньях куру-саттама

на- үгүй, *аям*- энэ, *локах*- гариг, *астти*- байдаг, *аягьясья*- өргөл үл өргөх хэний ч хувьд, *кутах*- хаана, *аньях*- бусад, *куру-сат-тама*- Куругийнхны хамгийн шилдэг минь.

Ай Куру удмынхны хамгийн шилдэг нь минь ээ, өргөл өргөлгүйгээр энэхүү гариг дээр, энэ амьдралдаа хүн аз жаргалтай байж чадахгүй билээ. Тиймээс дараагийн амьдралын талаар юу ч ярих билээ дээ?

ТАЙЛБАР: Амьд бодгаль нь материаллаг оршихуйн ямар ч хэлбэрт оршин байсан өөрийн жинхэнэ байр суурийн талаар юу ч үл мэдэх харанхуй мунхаг байдалд байдаг. Өөрөөр хэлбэл, материаллаг ертөнцөд оршнож, амьдрахын учир шалтгаан нь бидний нүгэлт амьдралын тоо томшгүй олон үр дагаварт байдаг. Харанхуй мунхаг байдал нь нүгэлт амьдралын учир шалтгаан, харин нүгэлт амьдрал нь бидний материаллаг оршихуйд цаашид үргэлжлэн байхын учир шалтгаан болдог. Хүний амьдралын хэлбэр нь энэхүү урхи занганаас гарах цорын ганц нүх сүв буюу боломж гарц байдаг. Иймээс Вед нь шашны, эдийн засгийн хөгжил цэцэглэлтийн болон материаллаг таашаал ханамж эдлэхүйн зам мөрийг мөн эцэст нь энэхүү гай зовлонгоор дүүрэн байх нөхцөл байдлаас хэрхэн бүрмөсөн гарахыг зааж өгснөөр бидэнд ангижралд хүрэх боломжийг олгодог. Шашин номын зам мөр буюу дээр зөвлөмж болгосон өргөлийн янз бүрийн хэлбэрүүд нь бидний эдийн засгийн бүхий л асуудлуудыг аяндаа шийдвэрлэдэг. Хэрвээ бид *ягья* үйлдэж байх аваас “хүн ам хэт их өссөн” гэх нөхцөлд ч хангалттай хэмжээний хүнсний бүтээгдэхүүн, сүү болон бусад зүйлтэй байх болно. Бие махбодь нь шаардлагатай бүх зүйлээр хангагдсан үед хүн жам ёсоороо мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн хойноос тэмүүлж эхэлдэг. Иймээс, мэдрэхүйн таашаал ханамж эдлэх явдлыг зохицуулахын тулд ариун гэгээн гэр бүл болохын чухлыг Ведед заасан байдаг. Ийм байдлаар л хүн материаллаг уяа хүлээснээс ангижрах түвшинд аажим аажмаар дээшлэн хүрч очих бөгөөд энэхүү ангижирсан амьдралын дээдийн дээд төгс төгөлдөр нь Бүхний Дээд Бурхантай хамт байж болоход л оршдог. Төгс төгөлдөрт хүн, дээр өгүүлсэнчлэн, өргөл (*ягья*) өргөснөөр л хүрнэ. Ведэд заасны дагуу *ягья* үйлдэхэд бэлэн биш байгаа хүн дараагийн амьдралдаа өөр гариг дээр бүү хэл энэхүү амьдралдаа хэрхэн аз жаргалтай байж чадах билээ? Тэнгэрийн янз бүрийн гаригууд дээр материаллаг тав тух, аятай таатай байдлын янз бүрийн түвшингүүд байдаг бөгөөд ийм *ягья-уудыг* үйлдсэн хүн бүрийг ямар ч тохиолдолд хэмжээлшгүй их аз жаргал хүлээж байдаг. Гэхдээ хүний хүрч болох хамгийн дээд аз жаргал бол Кришнагийн ухамсрыг жинхэнэ байдлаар хэрэгжүүлснээр бурханлаг гаригуудад хүрч очих явдал байдаг. Иймээс Кришнагийн ухамсар дахь амьдрал бол материаллаг оршихуйн бүх асуудлуудыг шийдвэрлэх түлхүүр юм.

ШҮЛЭГ 32

*эвам баху-видха ягья витата брахmano мукхе
карма-жан виддхи тан сарван эвам гьятва вимокиьясе*

эвам- ингэж, *баху-видах-* янз бүрийн төрлийн, *ягьях-* өргөлүүд, *витатах-* тархагддаг, *брахманах-* Вед, *мукхе-* амаар, *карма-жан-* ажил үйлээс төрөх, *виддхи-* чи мэдэх ёстой, *тан-* тэд, *сарван-* бүгд, *эвам-* ингэж, *гьятва-* таньж мэдсэнээр, *вимокиьясе-* чи ангижрах болно.

Энэхүү янз бүрийн өргөлүүд нь бүгд Ведэд сайшаан зөвшөөрөгдсөн байдаг бөгөөд тэд бүгд янз бүрийн төрлийн үйлүүдээс тогтдог. Энэ тухай мэдсэнээр чи ангижралд хүрэх болно.

ТАЙЛБАР: Өмнөх шүлгүүдэд өгүүлсэнчлэн, янз бүрийн төрлийн хүмүүст зохицсон өргөлийн янз бүрийн хэлбэрүүдийн талаар Ведэд дурьдсан байдаг. Хүмүүс бие махбодийн амьдралын үзэл бодолд гүн гүнзгий живсэн байдаг учир эдгээр өргөлүүдийг тэд нэг бол бие махбодиороо, эсвэл ухаанаараа үгүй бол оюун ухаанаараа үйлдэх буюу өргөж байхаар зохицуулагдсан байдаг. Гэхдээ эцсийн дүндээ, амьд оршнолыг материаллаг бие махбодийн тор, хүлээснээсээ салан ангижрахад тус болох үүднээс л энэ бүх өргөлүүдийг үйлдэхийг зөвлөсөн байдаг. Энэ тухай Бурхан Өөрөө энд батлан айлдаж байна.

ШҮЛЭГ 33

*шреян дравья-маяд ягьяж гьяна-ягьях парантапа
сарвам кармакхилам партха гьяне парисаманьяте*

шреян- илүү дээр, *дравья-маят-* материаллаг эд баялгийн, *ягьят-* өргөлөөс, *гьяна-ягьях-* мэдлэг дэх өргөл, *парантапа-* дайснаа дарагч минь, *сарвам-* бүгд, *карма-* үйлүүд, *акхилам-* цогц байдалдаа, *партха-* Притхын хүү минь, *гьяне-* мэдлэг дэх, *парисаманьяте-* дуусдаг.

Ай дайснаа дарагч минь ээ, мэдлэгт тулгуурласан өргөл өргөх нь ердөө материаллаг эд баялгаар өргөл өргөхөөс илүү дээр. Ай Притхын хүү минь ээ, эцсийн эцэст бүх өргөлийн дээдийн дээд зорилго нь трансценденталь мэдлэг хүртэх явдал байдаг юм.

ТАЙЛБАР: Бүхий л өргөлүүдийн зорилго нь хүнийг бүрэн төгс төгөлдөр мэдлэгийн түвшинд хүргэх явдал байдаг бөгөөд тэгснээр материаллаг оршихуйн зовлон бэрхшээлээс ангижруулах болон эцэст нь Бүхний Дээд Бурханы (Кришнагийн ухамсар) трансценденталь алба үйлэнд хандуулахад оршдог. Гэхдээ энэ бүх олон янзын өргөлүүдэд нэг л нууц байдаг ба энэхүү нууцыг таньж мэдэх хэрэгтэй. Өргөл бүр нь тухайн өргөлийг өргөгчийн итгэл бишрэлээс хамааран янз бүр байдаг. Итгэл бишрэл нь трансценденталь мэдлэгийн түвшинд хүрсэн хүнийг энэхүү мэдлэгийг хүртээгүй зүгээр л өөрийн материаллаг эд баялгийг өргөн байгаа хүнээс илүү хөгжил дэвшилд хүрсэн гэж үзэх ёстой. Учир нь, ийм мэдлэгт үндэслэж тулгуурлаагүй өргөл нь материаллаг түвшинд л байх бөгөөд ямар ч бурханлаг ач тус болохгүй. Жинхэнэ мэдлэгийн оргил нь трансценденталь мэдлэгийн дээдийн дээд түвшин, Кришнагийн ухамсарт илрэлээ олдог. Ийм илүү дээд мэдлэгт үндэслэж тулгуурлалгүйгээр өргөсөн өргөл нь зүгээр л нэг материаллаг үйлээс өөрцгүй. Харин ийм үйлүүдийг трансценденталь мэдлэгт тулгуурлан үйлдэх аваас тэд бүгд бурханлаг түвшинд үйлдэгдсэн өргөлүүд болно. Өргөл өргөж буй хүмүүсийн ухамсарын түвшингийн ялгаатай байдлаас хамааран өргөл өргөж буй тэдний үйлүүд нэг бол *карма-канда* (үр дагавар дагуулах үйл) үгүй бол *гьяна-канда* (үнэний хойноос эрэл хайгуул хийхтэй холбогдсон үйл)-ийн ангилалд хамаарагддаг. Зорилго нь мэдлэг байх аваас илүү сайн.

ШҮЛЭГ 34

*тад виддхи пранипатена парипрашнена севая
упадекшьянти те гьянам гьянинас таттва-даршинах*

тат- янз бүрийн мэдлэгийн тухай энэхүү мэдлэг, *виддхи-* ойлгохыг оролд, *пранипатена-* номын багшид хандсанаар, *парипрашнена-* хүлцэнгүй байдалтай асуулт тавьснаар, *севая-* зүтгэснээр, *упадекшьянти-* тэд гэгээрүүлэх болно, *те-* чамайг, *гьянам-* мэдлэгт, *гьянинах-* өөрийгөө бүрэн нээж танин мэдсэн, *таттва-* үнэнийг, *даршинах-* харагч.

Үнэнийг таньж мэдэхийн тулд номын багшид хандан өөрийгөө даатга. Түүнд үйлчлэн зүтгэж хүлцэнгүйгээр асуу. Өөрийгөө бүрнээ нээж таньж мэдсэн сүнснүүд нь үнэнийг харсан байдаг учир тэд л чамд мэдлэг хүртээж чадна.

ТАЙЛБАР: Бурханлаг танин мэдэхүйн зам мөр нь тийм ч амар хялбар бус байдаг гэдэг нь мэдээжийн хэрэг билээ. Тиймээс Бурхан бидэнд, Түүнээс Өөрөөс нь эхэлсэн багш шавийн барилдлагааны гинжин хэлхээ сүлжээнд хамрагдах жинхэнэ номын багшид хандахыг зөвлөж байна. Энэхүү хэлхээ сүлжээний үндсэн зарчмыг баримтлахгүй байгаа бол тэрээр хэн ч байсан жинхэнэ номын багш байж чадахгүй. Бурхан Өөрөө номын анхдагч багш бөгөөд багш шавийн барилдлагааны гинжин хэлхээ сүлжээнд хамаарагддаг багш л Бурханы айлдварыг анх айлдсан тэр байдлаар нь өөрийн шавьдаа дамжуулж чадах билээ. Өнөө цаг үед тэнэг мунхаг, хоёр

нүүртэнгүүдэд маяг, моод болсонтой адил өөрийн гэсэн зам мөрийг сэдэж олон түүгээрээ замнах хэн ч бурханлаг танин мэдэхүйд хүрч чадахгүй. Бхагаватамын (6.3.19)-д өгүүлэхдээ: *дхармам ту сакиад бхагават-пранитам* буюу “Шашны зам мөрийг Бурхан Өөрөө шууд тогтоож өгдөг.” Тийм учраас ухаан бодлын цэцэрхийлэл болон хуурай хоосон баримтууд нь хүнийг зөв зам мөртөө ороход нь тусалж чадахгүй. Мөн түүнчлэн, мэдлэгийн номуудыг бие даан судлаад ч бурханлаг амьдралдаа хөгжил дэвшил гаргах боломжгүй юм. Мэдлэг хүртэхийн тулд жинхэнэ номын багшид л хандан түүнд өөрийгөө бүрэн даатгаж, хуурамч ихэрхэг бардам зангаа орхин хамгийн дорд зарц лугаа үйлчлэн зүтгэх хэрэгтэй. Өөрийгөө бүрнээ нээж танин мэдсэн номын багшийн ханамжтай байх явдал нь бурханлаг амьдралын хөгжил дэвшлийн нууц билээ. Дуулгавартай хандах хийгээд асууж лавлах нь бурханлаг ойлгоцод хүрэх хамгийн зохистой хослол юм. Номын багшдаа дуулгавартай биш хийгээд үйлчлэн зүтгэхэд бэлэн бус байдалтайгаар бидний тавьсан аливаа асуулт ямар ч үйлчлэл нөлөө үзүүлдэггүй. Шавь нь номын багшийнхаа туршилт шалгалтыг тэнцэн давах чадвартай байх хэрэгтэй бөгөөд тэрээр шавьдаа үнэхээрийн чин хүсэл эрмэлзэл байхыг харваас түүнд жинхэнэ бурханлаг мэдлэгээр адислалаа нээн хүртээдэг. Энэ шүлэгт, багшийг сохроор даган бишрэх болон утгагүй асуулт тавихыг буруушааж байна. Номын багшийг зөвхөн дуулгавартайгаар сонсох биш мөн түүнд асуулт тавин хүлцэнгүйгээр үйлчлэн зүтгэж байж л түүнээс цэвэр бурханлаг мэдлэгийг хүртэхийг чармайх хэрэгтэй. Жинхэнэ номын багш нь мөн чанарын хувьд өөрийн шавьдаа үргэлж маш ээлдэг ялдам дотно байдаг. Иймээс шавь нь номын багшдаа дуулгавартай хүлцэнгүйгээр хандан түүнд үйлчлэн зүтгэхэд хэзээд бэлэн байдгаа харуулж чадах аваас тэр багшаасаа бүхий л асуултуудынхаа хариултыг авч төгс төгөлдөр мэдлэгийг хүртэх болно.

ШҮЛЭГ 35

*ях гьятва на пунар мохам эвам ясьяси пандава
ена бхутани ашешани дракшьяси атмани атхо майи*

ят- үүнийг, *гьятва*- мэдсэнээр, *на*- хэзээ ч үгүй, *пунах*- дахин, *мохам*- хий хуурмагт, *эвам*- ийм байдлаар, *ясьяси*- чи унах болно, *пандава*- Пандугийн хүү минь, *ена*- түүгээр, *бхутани*- амьд оршнол, *ашешани*- бүгд, *дракшьяси*- чи харах болно, *атмани*- Дээд Сүнсэнд, *атха*- өөр үгээр хэлбэл, *майи*- Надад.

Өөрийгөө бүрэн нээж танин мэдсэн сүнснээс жинхэнэ мэдлэгийг ийм байдлаар хүртсэнээр чи хэзээ ч иймэрхүү хий хуурмагт эрсдэхгүй. Учир нь энэ мэдлэгийг хүртсэнээр бүх амьд оршнолууд нь Бүхний Дээдийн хэсгүүд болохоос өөр юу ч биш буюу өөрөөр хэлбэл тэд бүгд Минийх гэдгийг харж мэддэг.

ТАЙЛБАР: Өөрийгөө бүрэн нээж таньж мэдсэн сүнснээс буюу юмс зүйлсийг жинхэнэ байгаа байдлаар нь таньж мэдэх хүнээс мэдлэг хүртсэнээр хүн, бүх амьд оршнолууд нь Бүхний Дээд Бурханы Бодгаль Кришнагийн хэсгүүд юм гэдгийг таньж мэддэг. Аливаа зүйл нь Кришнагаас тусдаа оршдог гэдэг ойлголт төсөөллийг *майа* (*ма*- биш, *йа*- энэ) гэж нэрлэдэг. Зарим хүмүүс, бид бол Кришнатай ямар ч холбоогүй, Тэр бол зүгээр л нэг түүхэн бодгаль, Үнэмлэхүй гэдэг бол бодьгал бус Брахман гэж бодоцгоодог. Харин, үнэн хэрэгтээ энэхүү бодьгал бус Брахман нь Бхагавад Гитад батлан өгүүлсэнчлэн, Кришнагаас цацрах туяа билээ. Бурханы Дээд Бодгаль мөн болохын хувьд Кришна нь бүхний учир шалтгаан. Брахма-самхитад, Кришна бол Бурханы Дээд Бодгаль, бүх учир шалтгааны эх учир шалтгаан гэж тов тодорхой өгүүлсэн байдаг. Бурханы сая сая хувилгаан дүрүүд нь бүгд Түүний илрэл тодролууд байдгийн адил амьд оршнолууд ч гэсэн зөвхөн Түүний илрэл тодролууд л билээ. *Майавадийн* философичид нь Кришна энэхүү олон дүрд хувилан илэрч тодорсоноороо Өөрийн бие даасан оршнолоо алддаг хэмээн буруугаар бодож итгэж байдаг. Энэ бол жинхэнэ материаллаг шинж чанартай

бодол юм. Материаллаг ертөнцийн ямар нэгэн зүйл олон хэсэгт хуваагдсанаар өөрийн анхны төрх байдлаа алддаг гэдгийг бид өөрсдийн туршлагаараа мэднэ. Харин *майавадийн* философичид нь Үнэмлэхүй гэж юу болохыг, үнэмлэхүй түвшинд нэг дээр нэмэх нь нэг тэнцүү нэг хийгээд нэгээс хасах нь нэг тэнцүү нэг байдаг гэдгийг ойлгож мэддэггүй.

Үнэмлэхүйн тухай эрдэм ухааны мэдлэг хомсоос болж бид хий хуурмагт бүрхэгдэн, өөрсдийгөө Кришнагаас хамааралгүй, ангид тусдаа байдаг гэж бодож итгэцгээдэг. Хэдийгээр бид Түүний салангид хэсгүүд мөн боловч Түүнээс ялгаагүй. Амьд оршнолуудын хоорондын бие махбодийн ялгаатай байдал нь *майа* буюу тэрээр үнэн хэрэгтээ оршин байдаггүй юм. Бид бүхэн Кришнагад л цэнгүүлэх үүрэгтэй. Зөвхөн *майа-гийн* нөлөөллөөс болж Аржуна, төрөл төрөгсөдтэйгөө холбогдсон цаг зуурын бие махбодийн хэлхээ холбоо нь Кришнагад холбогдсон мөнхийн бурханлаг харилцаанаас илүү чухал гэж бодож байсан. Бүхий л Гитагийн зорилго нь, Кришнагийн мөнхийн албат болох амьд оршнол нь хэзээ ч Түүнээс ангид тусдаа байж чадахгүй бөгөөд иймээс Бурханаас хамааралгүй байдаг гэсэн түүний ойлголт төсөөлөл нь *майа* юм гэдгийг бидэнд номлож сургахад оршдог. Амьд оршнолууд нь Бүхний Дээдийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд өөрийн гэсэн үүрэгтэй байдаг. Гэвч энэхүү үүргээ мартаж умартсан учраас тэд өнө эртийн цагаас л нэг бие махбодиос нөгөө бие махбодид шилжин хүн, амьтан сахиулсан тэнгэр... гэх мэт болж байдаг. Амьд оршнолууд Бурханы трансценденталь албыг мартсанаас болж л бие махбодийн энэхүү ялгаатай байдлууд нь бий болдог. Харин Кришнагийн ухамсартайгаар трансценденталь албанд зүтгэх аваас аваас мөдхөн энэхүү хий хуурмагаас салан ангижрана. Ийм цэвэр ариун мэдлэгийг зөвхөн жинхэнэ номын багшаас л хүртэж болох бөгөөд ингэснээр амьд оршнол нь Кришнагад эн тэнцүү байдаг хэмээн алдаа гаргахаас зайлсхийж чадна. Төгс төгөлдөр мэдлэг нь Дээд Сүнс, Кришна бол бүх амьд оршнолуудын хувьд хамгийн дээд аврал ивээл хайрлагч мөн болох ба энэхүү аврал хайрлагчаа умартсанаар тэд материаллаг эрчимд мэхлэгдэж төөрөлдөн өөрсдийгөө Кришнагаас салангид тусдаа оршдог хэмээн бие тоон сайрхдаг гэдэг тухай мэдлэг юм. Ийнхүү тэд өөрсдийгөө материаллаг янз бүрийн хэлбэр дүртэй адилтган үзэж, Кришнагад мартдаг. Гэхдээ ийнхүү төөрөлдсөн амьд оршнолууд нь өөрсдөдөө Кришнагийн ухамсрыг хөгжүүлэх аваас тэднийг ангижралд хүрэх зам мөрт орсон байна гэж үзэж ойлгох хэрэгтэй. Энэ талаар Бхагаватамын (2.10.6)-д батлан өгүүлсэн байдаг: *муктир хитваньятха-рупам сварупена вьявастхитих*. Кришнагийн мөнхийн албат байх өөрийн жам ёсны байр сууриндаа (өөрөөр хэлбэл Кришнагийн ухамсарт) татагдан, автан байхыг ангижралд хүрэх гэдэг.

ШҮЛЭГ 36

*апи чед аси папехьях сарвебхьях папа-крит-тамах
сарвам гьяна-плавенайва врижинам сантаришьяси*

апи- хэдий ч, *чет*- хэрвээ, *аси*- чи бол, *папехьях*- нүгэлтнүүдээс, *сарвебхьях*- бүхий л, *папа-крит-тамах*- хамгийн их нүгэлтэн, *сарвам*- энэ бүх нүгэлт үр дагаврууд, *гьяна-плавена*- трансценденталь мэдлэгийн хөлөг дээр, *эва*- зайлшгүй, *врижинам*- зовлонгийн далайг, *сантаришьяси*- чи бүрэн төгс гатлах болно.

Чи нүгэлтнүүдийн дундаас хамгийн илүү нүгэлтэн нь ч байж болно. Гэхдээ чи трансценденталь мэдлэгийн хөлөг дээр суух аваас зовлонгийн далайг гатлан туулах чадвартай болно.

ТАЙЛБАР: Кришнагад холбогдсон өөрийн жинхэнэ байр суурийг зөв ойлгох нь мунхгийн харанхуй далайн дундах оршихуйн төлөөх тэмцлээс аврагдах тийм ач тусыг хүнд хайрлаж хүртээдэг. Энэхүү материаллаг ертөнцийг зарим үед нэг бол мунхгийн харанхуй далайтай үгүй бол дүрэлзэн шатаж буй ойтой зүйрлэдэг. Далайн усны голд, хүн хичнээн сайн сэлж чаддаг байсан ч амьд гарахын тулд хамаг хүч чадлаа шавхах хэрэгтэй болно. Живж байгаа үед

нь түүнд хэн нэгэн туслан уснаас татан гаргах аваас тэр бол хамгийн аугаа аврагч болох билээ. Үүний нэгэн адил Бурханы Дээд Бодгалиас хүртэн байгаа төгс төгөлдөр мэдлэг нь ангижралд хүргэх зам мөр болдог. Кришнагийн ухамсрын хөлөг нь маш энгийн хялбарын зэрэгцээ хамгийн ариун дээд эрхэм байдаг.

ШҮЛЭГ 37

*ятхайдхамси самиддхо `гнир бхасма-сат куруте `ржуна
гьянагних сарва-кармани бхасма-сат куруте татха*

ятха- шиг, *эдхамси*- түлээ, *самиддхах*- дүрэлзэн байгаа, *агних*- гал, *бхасма-сат*- үнс, *куруте*- хувиргадаг, *аржуна*- Аржуна минь, *гьяна-агних*- мэдлэгийн гал, *сарва-кармани*- материаллаг үйлийн бүхий л үр дагаврыг, *бхасма-сат*- үнс, *куруте*- хувиргадаг, *татха*- адил төсөөтэй байдлаар.

Дүрэлзэн асах гал нь модыг үнс болгон хувиргадгийн адил, ай Аржуна минь ээ, мэдлэгийн гал нь материаллаг үйлийн бүхий л үр дагаврыг мөн үнс нурам болтол шатаадаг.

ТАЙЛБАР: Сүнс, Дээд Сүнсний тухай болон тэдгээрийн хоорондын харилцаа холбооны тухай төгс төгөлдөр мэдлэгийг энд галтай зүйрлэж байна. Энэхүү гал нь зөвхөн нүгэлт муу үйлүүдийн үр дагаврыг шатаагаад зогсохгүй буянт сайн үйлүүдийн үр дагаврыг ч мөн бүгдийг нь үнс нурам болгон хувиргадаг. Үйлийн үр дагаврууд нь янз бүрийн буюу одоо дөнгөж боловсорч эхэлж бий болж буй үр дагаврууд, бүрэн боловсроод одоо үр жимсээ өгч эхэлж буй үр дагаврууд, үйлчлэл нөлөөлөл нь өнгөрч буй үр дагаврууд, ирээдүйд боловсрох үр дагаврууд гэсэн үе шатуудаар илэрч байдаг. Гэвч амьд оршнолын жинхэнэ жам ёсны байр суурийн тухай мэдлэг нь энэ бүхнийг үнс нурам болтол шатаан үгүй болгодог. Хүн бүрэн төгс мэдлэгийг хүртсэн тэр цагт л түүний үйлүүдийн илэрсэн болон илрээгүй үр дагаврууд бүгд устан үгүй болно. Ведэд (Брихад-араньяка-упанишад, 4.4.22) *убхе ухаиваиша эте таратий амритах садхв-асадхуни* буюу “Хүн нүгэлт муу болоод буянт сайн үйлүүдийнхээ үр дагавраас ангижирдаг.” гэж өгүүлсэн байдаг.

ШҮЛЭГ 38

*на хи гьянена садришам навитрам иха видьяте
тат сваям йога-самсиддхах каленатмани виндати*

на- юу ч үгүй, *хи*- тодорхой, *гьянена*- мэдлэгтэй, *садришам*- харьцуулахад, *навитрам*- ариуссан, *иха*- энэ ертөнцөд, *видьяте*- байдаг, *тат*- үүнийг, *сваям*- өөрөө, *йога*- чин бишрэлийн зүтгэлд, *самсиддхах*- боловсорсон тэр, *калена*- цаг хугацааны явцад, *атмани*- өөрөө өөртөө, *виндати*- таашаадаг.

Энэ ертөнцөд трансценденталь мэдлэг шиг тийм эрхэм дээд болоод ариун зүйл гэж үгүй билээ. Энэхүү мэдлэг нь бүхий л ид шидийн бүрнээ боловсорсон үр жимс бөлгөө. Чин бишрэлийн алба зүтгэлийн зам мөрдөө хөгжил дэвшилд хүрсэн хэн бүхэнд энэхүү мэдлэг цагаа болохоор нээгдэх ба энэ мэдлэгээр цэнгэн баясмуй.

ТАЙЛБАР: Трансценденталь мэдлэгийн доор бид амьд оршнолын бурханлаг мөн чанараа ухаарахыг ойлгодог. Иймээс трансценденталь мэдлэг шиг ариун болоод эрхэм дээд зүйл гэж үгүй билээ. Мунхгийн харанхуй нь бидний материаллаг боолчлогдлын учир шалтгаан байдаг бол мэдлэг нь ангижралын учир шалтгаан болдог. Энэхүү мэдлэг нь чин бишрэлийн албаны

боловсорч гүйцсэн үр жимс бөгөөд энэхүү мэдлэгийг хүртсэнээр хүн өөрөө өөртөө амар амгаланг таашаан эдлэх учир түүнийг өөр хаанаас ч эрэх хэрэггүй болдог. Өөрөөр хэлбэл, мэдлэг болоод амар амгаланд хүрэхээр тэмүүлэх хүний тэмүүллийн оргил нь Кришнагийн ухамсар байдаг билээ. Энэ бол Бхагавад Гитагийн дүгнэлт болой.

ШҮЛЭГ 39

*шраддхавал лабхате гьянам тат-парах самьятендриях
гьянам лабдхва парам шантим ачиренадхигаччхати*

шраддха-ван- итгэл бишрэлтэй хүн, *лабхате-* хүрдэг, *гьянам-* мэдлэг, *тат-парах-* түүнд маш их дурлан татагддаг, *самьята-* эзэмдэн захирсан, *индриях-* мэдрэхүй, *гьянам-* мэдлэг, *лабдхва-* хүрсэнээр *парам-* трансценденталь, *шантим-* амар амгалан, *ачирена-* маш хурдан, *адхигаччхати-* хүрдэг.

Трансценденталь мэдлэг хүртэхийн төлөө өөрийгөө зориулан байгаа хийгээд мэдрэхүйгээ эзэмдэн захирч чадсан итгэл бишрэл бүхий хүн л энэ мэдлэгийг хүртэж чадах болно. Ийнхүү үүнийг хүртээд тэрээр дээдийн дээд бурханлаг амар амгаланд маш хурдан хүрдэг.

ТАЙЛБАР: Кришнад бат итгэл бишрэлтэй хүн л Кришнагийн ухамсрын мэдлэгийг хүртэж чадна. Зөвхөн Кришнагийн ухамсарт үйл ажиллагаагаа явуулснаар л дээдийн дээд төгс төгөлдөрт хүрч болно гэж боддог хүнийг итгэл бишрэлтэй гэж нэрлэдэг. Аливаа материаллаг бузраас хүний зүрхийг ариусгагч Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе/Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе Харе мантраг давтан хэлэх болон чин бишрэлийн албанд зүтгэснээр л энэхүү итгэл бишрэлтэй болдог. Үүнээс гадна мэдрэхүйгээ эзэмдэн захирч хяналтандаа байлгах хэрэгтэй. Кришнад итгэдэг хийгээд мэдрэхүйгээ эзэмдэн захирч чадаж байгаа хүн Кришнагийн ухамсрын эрдэм ухааны төгс төгөлдөрт ямар ч хүндрэл бэрхшээлгүй бөгөөд удаж төдөлгүй хүрэх болно.

ШҮЛЭГ 40

*агьяши чашраддадханаши ча самшаятма винашьяти
наям лока `сти на паро на сукхам самшаятманах*

агьях- шийдвэрлэгч судруудад агуулагдах мэдлэгийг үл мэдэх тэнэг, *ча-* болон, *ашраддадханах-* ариун гэгээн судруудад итгэддэггүй, *ча-* мөн, *самшая-* эргэлзээ, *атма-* хүн, *винашьяти-* унадаг, *на-* хэзээ ч үгүй, *аям-* энэ, *локах-* дэлхийд, *асти-* байдаг, *на-* үгүй, *парах-* дараагийн амьдралд, *на-* үгүй, *сукхам-* аз жаргал, *самшая-* эргэлзэж байгаа, *атманах-* хүний.

Ариун гэгээн судруудад эргэлзэх, харанхуй мунхаг хийгээд итгэл бишрэлгүй хүмүүс нь Бурханы ухамсарт хүрэхгүй бөгөөд доош унана. Эргэлзэгч сүнснүүдийн хувьд энэ дэлхийд ч тэр, мөн дараа нь өөр хаа нэгтэй ч тэр аз жаргал ирдэггүй.

ТАЙЛБАР: Нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хийгээд эх сурвалж болох ариун гэгээн судруудаас Бхагавад Гита бол хамгийн эрхэм дээд нь билээ. Адгуус амьтан мэт хүмүүс нь олонд хүлээн зөвшөөрөгдсөн ариун гэгээн судруудад итгэдэг ч үгүй бөгөөд тэдний талаар мэддэг ч үгүй. Тэдний тухай мэддэг хийгээд тэдгээрээс иш татан ярьдаг хүмүүс байсан ч үнэн хэрэгтээ тэд ярьж буй энэ үгнүүддээ ч итгэдэггүй. Мөн Бхагавад Гита зэрэг судруудад итгэдэг ийм хүмүүс байх боловч тэд нар нь Бурханы Бодьгал, Шри Кришнагийн оршин байдагт итгэдэггүй, Түүнд

бишрэл хүндэтгэлээ илэрхийлдэгчгүй. Иймэрхүү хүмүүс нь Кришнагийн ухамсарт байж чаддаггүй тул удалгүй уналт доройтолд ордог. Дээр дурьдсан хүмүүсээс итгэл бишрэлгүй хийгээд байнгад эргэлзэх хүмүүс нь ямар ч хөгжил дэвшилд хүрдэггүй. Бурханд болон Түүний ариун гэгээн айлдваруудад үл итгэх хүнийг энэ амьдралд нь ч тэр мөн дараагийн амьдралд нь ч тэр ямар ч сайн зүйл угтан хүлээдэггүй. Түүнд өчүүхэн төдий ч аз жаргал заяадаггүй. Иймээс хүмүүс ариун гэгээн судруудад заасан зарчмуудыг итгэл бишрэлтэйгээр дагаж мөрдөх ёстой бөгөөд тэгснээр л жинхэнэ мэдлэгийн түвшинд дээшлэн хүрнэ. Зөвхөн энэхүү мэдлэг л бурханлаг ойлголтын трансценденталь түвшинд хүрэхэд тусалж чадна. Өөрөөр хэлбэл, эргэлзэн байгаа хүнд бурханлаг ангижралд хүрэх өчүүхэн төдий ч боломж, горьдлого байдаггүй. Иймээс багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээнд хамаарагдах аугаа их *ачарья* нарын үлгэр дууриалыг дагах хэрэгтэй бөгөөд ингэж байж л амжилтанд хүрэх болно.

ШҮЛЭГ 41

*йога-санньяста-карманам гьяна-санчхинна-самшаям
атмавантам на кармани нибадхнанти дхананьжася*

йога- карма-йога дахь чин бишрэлийн албаар, *санньяста-* огоорогч, *карманам-* өөрийн үйлийн үр дүнг, *гьяна-* мэдлэгээр, *санчхинна-* огтолж хэрчдэг, *самшаям-* эргэлзээ, *атмавантам-* өөрөө өөрийгөө таньж мэдсэн байдаг, *на-* хэзээ ч үгүй, *кармани-* үйлүүд, *нибадхнанти-* уяж хүлдэг, *дхананьжася-* баялгийг эзлэгч минь.

Өөрийн үйлийн үр дүнг огоорон Бурханы чин бишрэлийн албанд зүтгэж байгаа хийгээд трансценденталь мэдлэгийн ачаар эргэлзээнээсээ салж ангижирсан хүн өөрийгөө үнэхээр таньж мэдсэн байдаг. Иймээс, ай баялгийг байлдан эзлэгч минь ээ, тэр өөрийн үйлийн үр дагаварт уягдаж орооцолддоггүй.

ТАЙЛБАР: Бурханы Дээд Бодьгалын Өөрийнх нь анх айлдсан тэр төрх байдлаараа байгаа Бхагавад Гита-гийн сургаалыг дагасан хэн бүхэн трансценденталь мэдлэгийн өршөөл нигүүлслээр бүхий л эргэлзээнээсээ салан ангижирдаг. Ингээд Бурханы салшгүй өчүүхэн жижиг хэсэг мөн болохын хувьд тэр Кришнаг бүрнээ ухамсарлах ба өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн түвшинд хэдийнээ хүрсэн байдаг. Иймээс тэр өөрийн үйлийн үйлдэл болоод үр дагаварт уягдаж орооцолдолгүй тэдгээрээс ангид дээгүүр оршдог гэдэг нь эргэлзээгүй билээ.

ШҮЛЭГ 42

*тасмад агьяна-самбхутам хрит-стхам гьянасинатманах
чхиттвайнам самшаям йогам атиитхоттиитха бхарата*

тасмат- иймээс, *агьяна-самбхутам-* мунхаглалаас үүсэн бий болсон, *хрит-стхам-* зүрхэнд орших, *гьяна-* мэдлэгийн, *асина-* зэвсгээр, *атманах-* өөрийн, *чхиттва-* огтолсноор, *энам-* энэхүү, *самшаям-* эргэлзээг, *йогам-* йогад, *атиитха-* бай, *уттиитха-* тулалдахаар дээшээ бос, *бхарата-* Бхаратын үр удам минь.

Иймээс, мунхгийн харанхуйн улмаас чиний зүрхэнд үүсэн бий болсон эргэлзээг мэдлэгийн зэвсгээр бут цохих хэрэгтэй. Иогоор зэвсгэл. Ай Бхарата минь ээ, дээшээ босож тэмцэл тулаандаа ор.

ТАЙЛБАР: Энэ бүлэгт тайлбарлан өгүүлсэн иогийн системийг *санатана-йога* буюу амьд оршнолын мөнхийн үйл гэж нэрлэдэг. Энэ иог нь тахилга өргөлийн хоёр хэлбэрт хуваагддаг. Нэг нь материаллаг эд зүйлсийн өргөл өргөх, нөгөө нь жинхэнэ цэвэр бурханлаг үйл болох

буюу өөрийн “би”-гийн тухай мэдлэгийг хөгжүүлэх явдал юм. Материаллаг эд баялгийг өргөл болгон өргөж байгаа хүн өөрийн бурханлаг мөн чанарыг таньж мэдэхийг эрмэлзэхгүй байгаа л бол түүний өргөл нь материаллаг чанартай хэвээр байх болно. Харин энэхүү өргөлийг бурханлаг зорилготойгоор буюу Бурханы чин бишрэлийн албанд өргөх аваас жинхэнэ төгс төгөлдөр өргөл болно. Бурханлаг үйлүүдийг авч үзвээс мөн тэдгээр нь өөрийн жинхэнэ “би”-гийн (буюу сүнсний жинхэнэ байр суурийн) тухай мэдлэгт болон Бурханы Дээд Бодьгалтай холбоотой үнэнд хүрэх гэсэн хоёр бүлэгт хуваагддаг болох нь харагдаж байна. Анх айлдсан төрх байдлаараа байгаа Бхагавад Гитад заасан зам мөрийг даган мөрдөж байгаа хүн бурханлаг мэдлэгийн энэхүү хоёр чухал дэд бүлгүүдийг маш хялбархан ойлгоно. Түүний хувьд өөрийн “би”-гийн талаарх төгс төгөлдөр мэдлэгийг хүртэх болон өөрийн “би” бол Бурханы өчүүхэн жижиг хэсэг мөн гэдгийг ойлгох нь хүнд хэцүү биш. Энэхүү ойлголт ухаарал нь цаашдаа Бурханы трансценденталь үйлүүдийг хялбархан ойлгоход түүнд тус болдог. Энэ бүлгийн эхэнд Бүхний Дээд Бурхан Өөрийн үйлүүдийн трансценденталь мөн чанарын тухай тайлбарласан. Гитагийн номлол сургаалыг үл ойлгогч нь итгэл бишрэлгүй байдаг бөгөөд Бурханаас түүнд хайрласан өчүүхэн төдий бие даасан байдлаа буруу ашиглаж байгаа нь илэрхий. Энэхүү номлол сургаал байсаар байтал Шри Кришнагийн жинхэнэ үнэн мөн чанарыг мөнхийн, жаргал цэнгэл дүүрэн, бүхнийг мэдэгч Бурханы Бодьгал гэж үл ойлгох хэн бүхэн бол хамгийн тэнэг мунхаг хүн юм. Кришнагийн ухамсрын зарчмуудыг аажим аажмаар хүлээн авснаар харанхуй мунхгийг арилган зайлуулж болно. Сахиулсан тэнгэрүүдэд өргөл өргөх, Брахманд өргөл өргөх, гэр бүл бололгүй ариун журамт байдлыг хадгалах, зохицуулалт хязгаарлалт бүхий гэр бүлийн амьдралаар амьдрах, мэдрэхүйгээ эзэмдэн захирах, ид шидит иогоор хичээллэх, тэвчил үйлдэх, материаллаг баялгаас огоорох, Ведийг судлах болон *варнашрама-дхармын* нийгмийн байгуулал дахь өөрт оноогдсон үүргээ биелүүлэх гэх зэрэг янз бүрийн өргөл өргөснөөр Кришнагийн ухамсрыг дахин сэргээж болно. Энэ бүхэн нь өргөлийн янз бүрийн хэлбэрүүд бөгөөд тэд бүгд судруудад заасан тодорхой журам зарчмууд дээр үндэслэгдсэн байдаг. Гэхдээ энэ бүх үйлүүдийн хувьд өөрийгөө бүрэн нээж танин мэдэх явдал нь хамгийн чухал зорилго, хүчин зүйл байдаг. Энэхүү зорилгод тэмүүлж байгаа хэн бүхэн Бхагавад Гитагийн жинхэнэ шавь юм. Харин Кришнагийн эх сурвалж гэдэгт эргэлзэж байдаг хэн бүхэн уналт доройтолд ордог. Иймээс Бхагавад Гита болон бусад судруудыг жинхэнэ номын багшид хүлцэнгүйгээр үйлчлэн зүтгэж түүний удирдлагын доор үзэж судлахыг зөвлөдөг. Жинхэнэ номын багш нь өнө эртийн цагаас эхэлсэн *парамтарын* хэлхээ сүлжээнд хамрагддаг бөгөөд тэр Бүхний Дээд Бурханаас сая сая жилийн өмнө нарны сахиулсан тэнгэрт айлдсан хийгээд түүнээс газар дэлхийд уламжлагдан дамжиж ирсэн сургаал заавраас хэзээ ч гаждаггүй. Иймээс Бхагавад Гитагийн зам мөрийг, Гитад өөрт нь тодорхойлон бичсэн дагуу дагаж мөрдөх ёстой бөгөөд зөвхөн өөрийгөө алдаршуулахын төлөөнөө бусдыг зөв зам мөрөөс нь гажуудуулах хар амиа бодсон хүмүүсээс сэрэмжлэх хэрэгтэй. Бурхан бол Дээдийн Дээд Бодьгал гэдэг нь ямар ч эргэлзээгүй бөгөөд Түүний үйлүүд нь трансценденталь. Үүнийг ойлгосон хэн бүхэн Бхагавад Гитаг судалж эхлэх мөчөөсөө л ангижралыг олсон сүнс байдаг бөлгөө.

Шримад Бхагавад Гитагийн “Трансценденталь мэдлэг” гэсэн нэртэй дөрөв дүгээр бүлэгт Бхактиведантын хийсэн тайлбар ийнхүү өндөрлөлөө.

ТАВ ДУГААР БҮЛЭГ

Карма йога-Кришнагийн ухамсар дахь үйл

ШҮЛЭГ 1

*аржуна увача
саннясам карманам кришна пунар йогам ча шамсаси
яч чхрея этайор экам тан ме брухи су-нишчитам*

аржунах увача- *Аржуна айлтгасан нь, санньясам- огоорохуй, карманам- бүхий л үйлүүдийн, кришна- Кришна минь ээ, пунах- дахин, йогам- чин бишрэл дүүрэн бялхах алба, ча- мөн, шамсаси- Та магтаж сайшааж байна, ят- тэр, шреяx- илүү төгс ач, этайох- энэ хоёрын, экам- нэг, тат- түүнийг, ме- надад, брухи- айлдаж хайрлаач, су-нишчитам- тодорхой.*

Аржуна айлтгасан нь: Ай Кришна минь ээ, Та эхлээд, намайг бүх үйлээсээ огоорохыг шаардсан, харин дараа нь үйлээ чин бишрэлтэйгээр үйлдэхийг зөвлөж байна. Энэ хоёрын чухам аль нь илүү ач тустай болохыг тодорхой айлдана уу.

ТАЙЛБАР: Бхагавад Гитагийн энэхүү тав дугаар бүлэгт Бурхан, чин бишрэлийн албанд зүтгэх нь ухаан бодлын хуурай цэцэрхийллээс илүү байдаг тухай айлдаж байна. Чин бишрэлийн алба нь трансценденталь мөн чанартай тул материаллаг үр дагавраас ангид байдаг учраас ухаан бодлын цэцэрхийллээс илүү амар хялбар. Хоёр дугаар бүлэгт, сүнс болоод түүний материаллаг бие махбодид хэрхэн уягдан хүлэгдэж байдаг тухай анхан шатны энгийн мэдлэгийг тайлбарласан. Үүнтэй холбогдуулан, *буддхи-йогын* тусламжтайгаар, өөрөөр хэлбэл чин бишрэлийн алба үйлэнд зүтгэснээр материаллаг олзны хорионоос хэрхэн ангижирч болох талаар мөн тодорхойлон өгүүлсэн. Бурхан, жинхэнэ мэдлэгийг хүртсэн хүнд цаашид биелүүлэх ёстой ямар ч үүрэг байдаггүй тухай гурав дугаар бүлэгт, өргөлийн бүхий л хэлбэр нь эцсийн эцэст мэдлэг, танин мэдэхүйд хүргэдэг тухай дөрөв дүгээр бүлэгт тус тус тайлбарласан. Гэхдээ дөрөв дүгээр бүлгийн төгсгөлд Бурхан Аржунад хандан, энэхүү төгс төгөлдөр мэдлэгийг хүртсэн болохоор сэрж, тулалдаанд орохыг зөвлөдөг. Кришна, чин бишрэлтэйгээр үйл үйлдэх болон хүртсэн мэдлэгтээ тулгуурлан үйл үл үйлдэхийн чухлыг нэгэн зэрэг онцолсон учир Аржуна төөрөлдөн самуурч улмаар түүний шийдэмгий занг мухардалд оруулж байна. Мэдлэгт тулгуурласан огоорохуй гэдэг нь мэдрэхүйн үйл байдлаар үйлдэгдэж байгаа ажлын бүхий л хэлбэрийг зогсоон, болих явдал гэж Аржуна ойлгож байдаг. Гэхдээ чин бишрэлийн албанд зүтгэн байгаа хүн ажил үйлээ хэрхэн зогсоож, орхиж чадах билээ дээ? Өөрөөр хэлбэл, түүний хувьд үйл, огоорол хоёр нь нийцэшгүй мэт бодогдох тул, тэрээр *санняса* буюу мэдлэгт үндэслэж тулгуурласан огоорохуй нь ямар ч үйлээс бүрэн ангид байх ёстой гэж ойлгож байна. Жинхэнэ мэдлэгт үндэслэж тулгуурласан үйл нь ямар ч үр дагавар дагуулдаггүй учир үйл үл үлдэхтэй адил гэдгийг тэр ойлгоогүй мэт харагдаж байна. Иймээс л тэр, үйл үйлдэхээ бүрмөсөн зогсоох, эсвэл төгс төгөлдөр мэдлэгт тулгуурлан үйл үйлдэхийн аль илүү болох тухай асууж байна.

ШҮЛЭГ 2

шри бхагаван увача

саннясах карма-йогаш ча нихшреяса-карав убхау

тайос ту карма-саннясат карма-його вишишьяте

шири бхагаван увача- Бурханы Дээд Бодьгал айлдсан нь, санньясах- ажил үйлээс

огоорохуй, карма-йогах- Бурханд үйлчлэн зүтгэх, ча- мөн, тэрчлэн, нихшреяса-карау-

ангижралд хүргэх, убхау- хоёул, тайох- энэ хоёроос, ту- гэвч, карма-санньясат- үр

дагавар дагуулах үйлээс огоорохуйтой харьцуулахад, карма-йогах- чин бишрэлийн

үйл, вишишьяте- илүү дээр.

Бурханы Дээд Бодьгал айлдсан нь: Үйлээс огоорох болон үйлээ чин бишрэлтэйгээр үйлдэхийн аль аль нь ангижралд хүргэнэ. Гэхдээ энэ хоёроос, чин бишрэлийн албанд зүтгэх нь бүхий л үйлээсээ огоорохоос илүү төгс юм.

ТАЙЛБАР: Үр дагавар дагуулах үйл (мэдрэхүйн таашаал ханамж эдлэх зорилготой) нь материаллаг боолчлолд баригдан байхын учир шалтгаан болдог. Бие махбодийнхоо тав тухтай оршнох нөхцөл байдлыг сайжруулах зорилго бүхий үйлийн хойноос хөөцөлдөж байсан цагт хүн нэг хэлбэрийн бие махбодиос нөгөө хэлбэрийн бие махбодид шилжин материаллаг боолчлолын уяанд тасралтгүйгээр хүлэгдэн баригдсаар байх болно. Энэ тухай Шримад Бхагаватамын (5.5.4-6)-д дараах байдлаар батлан өгүүлсэн байдаг:

*нунам праматтах куруте викарма
яд-индрия-притая априности
на садху манье ята атмано `ям
асни апи клешада аса дехах*

*парабхавас тавад абодха-жато
яван на жигьясата атма-таттваам
яват крияс тавад идам mano вай
карматмакам ена шарира-бандхах*

*эвам манах карма вашам праюнкте
авидьяятманйупадхиямане
притир на яван майи васудеве
на мучьяте деха-йогена тават*

“Хүмүүс нь мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн хойноос улайран хөөцөлдөж байдаг бөгөөд гаслан зовлонгоор дүүрэн одоогийн энэ бие махбодь нь өнгөрсөн цаг үедээ үйлдсэн үр дагавар дагуулах үйлүүдийн нь үр дүн мөн гэдгийг мэддэггүй. Хэдийгээр бие махбодь нь түр зуурын ч гэсэн олон талын хүндрэл бэрхшээлүүдийг учруулж байдаг. Иймээс мэдрэхүйн ханамж таашаал эдлэхийн төлөө үйл үйлдэх нь сайн зүйл биш юм. Хүн өөрийгөө жинхэнэдээ хэн болохын учрыг олохыг оролдохгүй байгаа бол амьдралаа шал дэмий хий хоосон өнгөрөөж байна гэсэн үг. Өөрийн жинхэнэ мөн чанарыг ойлгоогүй цагт хүн мэдрэхүйн ханамж таашаал эдлэх гэсэн хүслээ хангахаар үр дагавар дагуулах үйлийн хойноос хөөцөлдөн байхаар тулгагдсан байдаг. Ийнхүү мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн ухамсарт автан байгаа хүн нэг бие махбодиос нөгөөд шилжин орших хэрэгтэй болдог. Ухаан нь үр дагавар дагуулах үйлийн хойноос тэмүүлэн, харанхуй мунхагийн нөлөөнд автсан байсан ч хүн Васудевад чин бишрэлээр зүтгэх хайрыг өөртөө хөгжүүлэхийг чармайх хэрэгтэй. Зөвхөн тэгсэн цагт л түүнд материаллаг оршихуйн хүлээснээс мултран гарах боломж олдоно.”

Иймээс *гьяна* (хүн бол бие махбодь биш харин бурханлаг сүнс юм гэсэн мэдлэг) нь ангижралыг олоход хангалттай биш. Бурханлаг сүнс байдлаар үйл ажиллагаагаа явуулахгүй бол материаллаг боолчлолын гав гинжнээс салж, чөлөөлөгдөх боломжгүй. Кришнагийн ухамсарт үйлдэгдсэн үйл нь үр дагавар дагуулдаггүй. Төгс төгөлдөр мэдлэгт тулгуурлан үйлдсэн үйл нь хүний бурханлаг танин мэдэхүйдээ хүрсэн хөгжил дэвшлийг батжуулан бэхжүүлдэг. Кришнаг ухамсарлалгүйгээр, үр дагавар дагуулах үйлээс зүгээр л татгалзаж огоорох нь болзолт сүнсний зүрхийг материаллаг бузраас үндсэндээ ариусгадаггүй. Зүрх ариусаагүй байсан цагт хүн кармын үйлтэй зууралдсаар байх болдог. Харин Кришнагийн ухамсарт үйлээ үйлдсэнээр хүн аяндаа өөрөө кармын үр дагавраас ангижран салах тул түүний хувьд дахин доройтон унаж материаллаг түвшний үйлтэй зууралдах шаардлага гарахгүй. Иймээс Кришнагийн ухамсарт үйл үйлдэх нь уналтанд өртөх аюул байнга учруулж байдаг үйл үйлдэхээс зүгээр л татгалзан огоорохоос ямар ч нөхцөлд хавьгүй илүү. Кришнагийн ухамсаргүй огоорохуй нь төгс төгөлдөр бус гэдгийг Шрила Рупа Госвами Бхакти-расамрита-синдхугийн (1.2.258)-д дараах байдлаар батлан өгүүлсэн:

*прапанчикатая буддхья хари-самбандхи-вастунах
мумукшубхих паритьяго вайрагьям пхалгу катьяте*

“Ангиралд хүрэхийг тэмүүлж байгаа хүн, үнэн хэрэгтээ Бүхний Дээд Бурханы Бодьгалтай холбоотой зүйлүүдээс, эдгээр нь материаллаг зүйлс юм хэмээн татгалзаж байх аваас түүний энэ огоорол нь төгс төгөлдөр бус юм.” Оршин байгаа бүхий л зүйлс бүгд Бурханд харьяалагддаг учраас хэн ч ямар ч зүйлийг өмчлөн эзэмшихийг санаархах ёсгүй гэдгийг ухаарч ойлгосон хүний огоорол л бүрэн төгс огоорол юм. Үнэн хэрэгтээ, хэнд ч юу ч харьяалагддаггүй гэдгийг хүн бүр ойлгож ухаарах ёстой. Өөрт нь огт харьяалагдаж, хамаарагддаггүй зүйлээс огоорох гэж юуг хэлнэ вэ? Бүх зүйлс Кришнагийн өмч гэдгийг ухаарч мэдсэн хүн л төгс төгөлдөр огоорол гэж юу болохыг харуулж байдаг. Бүгд Кришнад харьяалагдах учир тэд бүгдийг Кришнагийн албанд үйлчлэн зүтгэхэд л ашиглаж хэрэглэх ёстой билээ. Кришнагийн ухамсар дахь энэхүү үйлийн төгс төгөлдөр хэлбэр нь *майвадийн* номлолын *санньясуудын* зохиомол огоорлоос аль ч талаараа хавьгүй илүү төгс юм.

ШҮЛЭГ 3

*гьеях са нитья-санньяси йо на двешти на канкшати
нирвандво хи маха-бахо сукхам бандхат прамучьяте*

гьеях- таньж мэдэгдэх ёстой, сах- тэр, нитья- үргэлж, санньяси- огоорогч, ях- тэр, на- хэзээ ч үгүй, двешти- үзэн яддаг, на- үгүй, канкшати- хүсдэг, нирдвандвах- бүхий л хоёрдмол байдлаас ангид, хи- тодорхой, маха-бахо- хүчит гарт минь, сукхам- аз жаргалтай, бандхат- уяа хүлээснээс, прамучьяте- бүрэн ангижирдаг.

Өөрийн үйлийн үрийг үл жигшин үзэхийн зэрэгцээ түүнд үл шунах хүн л огоорохуйн түвшинд байнгад амьдарч байдаг. Бүхий л хоёрдмол байдлаас ангид байх ийм хүн л материаллаг боолчлолын гав гинжийг амархан тайлж хаян ангижралд бүрэн хүрдэг юм шүү, ай хүчит гарт Аржуна минь ээ.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсарт гүн бат автан байгаа хүн өөрийн үйлийн үрийг үл жигшихийн зэрэгцээ түүнд үл татагдан шунах тул бүрнээ огоорсон байдаг. Бурханы трансценденталь хайр дүүрэн бялхах албанд зүтгэхэд өөрийгөө зориулж ийнхүү бүрнээ огоорсон хүн л Кришнаатай холбогдсон жинхэнэ байр сууриа таньж мэдсэн байдаг тул төгс төгөлдөр мэдлэгийг хүртсэн байдаг. Кришна бол Бүрэн Бүтэн, харин өөрөө Түүний өчүүхэн жижиг хэсэг гэдгээ тэр сайн мэддэг. Энэхүү мэдлэг нь, Бүхний Дээдтэй холбогдсон түүний тооны болоод чанарын харьцааг үнэн зөв илэрхийлэх учир төгс төгөлдөр юм. Бүрэн бүтэн зүйлийн нэгээхэн хэсэг нь түүнтэй хэзээ ч адил тэнцүү байдаггүй учир амьд оршнол нь Кришнаатай нэг адил юм гэж итгэх нь үнэнд нийцэхгүй. Бүхний Дээдтэй чанарын хувьд ижил, харин хэмжээний хувьд ялгаатай гэдгээ таньж мэдсэн хүн жинхэнэ трансценденталь мэдлэгийг хүртсэн байдаг бөгөөд энэхүү мэдлэг нь түүнийг дотоод ханамжтай болоход хүргэдэг ба тэгснээр түүний хувьд санаа зовох болон хойноос нь тэмүүлэх зүйл гэж үгүй болдог. Тэр хийж үйлдэж буй бүхнээ Кришнад зориулах учир түүний ухаанд хоёрдмол байдал гэж байхаа болино. Ийнхүү хоёрдмол байдлаасаа салсан хүн л материаллаг ертөнцөд оршин байх үедээ ч ангижралын түвшинд хүрсэн байдаг.

ШҮЛЭГ 4

*санкхья-йогау притхаг балах праваданти на пандитах
экам апй астхитах самьяе убхайор виндате пхалам*

санкхья- материаллаг ертөнцийг задлан шинжлэхүй, йогау- чин бишрэлийн албаны үйл, притхак- ялгаатай, балах- ухаалаг бусчууд, праваданти- хэлдэг, на- хэзээ ч үгүй, пандитах- номч мэргэд, экам- нэгэнд, апи- хэдий ч, астхитах- оршин байгаа, самьяк- бүрэн төгс, убхайох- хоёулангийн нь, виндате- таашаадаг, пхалам- үр дүн.

Зөвхөн харанхуй мунхаг хүмүүс л, чин бишрэлийн алба зүтгэл (карма-йога) нь материаллаг ертөнцийг задлан шинжлэх замаар судлах (санкхья)-аас өөр хэмээн ярьдаг. Харин эдгээр зам мөрүүдийн аль нэгэнд өөрийгөө бүрнээ зориулсан хүн хоёулангийнх нь үр дүнд хүрдэг хэмээн жинхэнэ номч мэргэд өгүүлдэг.

ТАЙЛБАР: Материаллаг ертөнцийг задлан шинжлэх аргаар судлахын зорилго нь бүх оршнолын сүнсийг олж нээх явдал байдаг. Материаллаг ертөнцийн сүнс нь Вишну буюу Параматма (Дээд Сүнс). Бурханд чин бишрэл дүүрэн зүтгэж байгаа хүн мөн Параматмад зүтгэн байгаа хэрэг. Нэг арга зам нь модны үндсийг олох, нөгөө нь үндсийг нь услахад оршдог. *Санкхья*-философийг жинхэнэ байдлаар нь судалж байгаа хүн материаллаг ертөнцийн үндэс Вишнуг олдог бөгөөд дараа нь тэр төгс төгөлдөр мэдлэгт тулгуурлан Бурханы албанд зүтгэдэг. Иймд, энэ хоёр замын аль алины нь зорилго Вишну учир тэдгээрийг хооронд онцгой ялгаа байхгүй. Дээдийн дээд зорилгоо таньж мэдээгүй хүн л *санкхья* болон *карма-йогын* арга замуудын зорилгууд нь ялгаатай юм гэж ярьдаг байхад, гүн гүнзгий мэдлэгийг хүртсэн хүн энэ хоёр арга зам нь нэг зорилгод хүргэдэг гэдгийг мэддэг.

ШҮЛЭГ 5

*ят санкхьяйх прапьяте стханам тад йогайр апи гамьяте
экам санкхьям ча йогам ча ях пашьяти са пашьяти*

*ят- тэр, санкхьяйх- санкхья философийн тусламжтайгаар, прапьяте- хүрдэг,
стханам- байр суурь, тат- түүнийг, йогайх- чин бишрэлийн албаар, апи- мөн, гамьяте-
хүрдэг, экам- нэг, санкхьям- задлан шинжлэхүйн судалгаа, ча- болон, йогам- чин
бишрэлийн алба дахь үйл, ча- болон, ях- тэр, пашьяти- хардаг, сах- тэр, пашьяти-
жинхэнэ хардаг.*

Задлан шинжилж судлах арга замаар хүрсэн зорилгод чин бишрэлээр зүтгэснээр мөн хүрч болохыг мэддэг болон иймээс задлан шинжилж судлах болоод чин бишрэлээр зүтгэх хоёр нь нэг ижил түвшинд байдгийг мэдэх хүн бүх зүйлийг жинхэнэ байгаа байдлаар нь хардаг.

ТАЙЛБАР: Философийн судалгааны жинхэнэ зорилго нь амьдралын дээдийн дээд зорилгыг олж илрүүлэхэд оршиж байдаг. Амьдралын дээдийн дээд зорилго нь өөрийгөө бүрэн нээж танин мэдэх явдал байдаг учир дээр дурьдсан хоёр аргын хүрэх дүгнэлт нь өөр хоорондоо ялгаагүй юм. *Санкхья* философийн судлалаар бол амьд оршнол нь материаллаг ертөнцийн бүрэлдхүүн хэсэг биш, харин дээдийн дээд бурханлаг Бүрэн Бүтэний салшгүй хэсэг юм гэсэн дүгнэлтэнд хүрдэг. Иймээс, бурханлаг сүнс нь материаллаг ертөнцтэй ямар ч холбогдолгүй; түүний үйл нь Бүхний Дээдтэй ямар нэгэн байдлаар холбоотой байх хэрэгтэй. Кришнагийн ухамсарт үйлээ явуулж эхлэсэн цагтаа л тэр өөрийн жинхэнэ байр сууриа эзэлдэг. Эхний арга зам буюу *санкхья* философийн зам мөрийг дагаснаар хүн материас салж холддог бол чин бишрэлийн зүтгэлийн *йогын* зам мөрөөр замнаснаар Кришнагийн ухамсарын үйлүүдэд татагддаг. Өнгөцхөн харахад нэг нь салж холдоход, нөгөө нь дурлан татагдахад хүргэж байгаа мэт боловч энэ хоёр арга зам нь үндсэндээ ялгаагүй. Материас салан холдох ангижрах болон Кришнад дурлан татагдах хоёр нь нэг ижил юм. Үүнийг ойлгож чадсан хүн л юмыг жинхэнэ байгаа байдлаар нь хардаг.

ШҮЛЭГ 6

*саннясас ту маха-бахо духхам аптум айогатах
йога-юкто мунир брахма на чиренадхигачхати*

*саннясах- огоорохуйн амьдралын түвшин, ту- гэвч, маха-бахо- хүчит гарт минь,
духхам- аз жаргалгүй байдал, аптум- автдаг, айогатах- чин бишрэлийн албагүйгээр,
йога-юктах- чин бишрэл дүүрэн бялхах албанд зүтгээгч, муних- сэтгээгч, брахма-
Бүхний Дээдэд, на чирена- тэр даруй, адхигачхати- хүрдэг.*

Бурханд чин бишрэлээр зүтгэх үйлэнд өөрийгөө зориулалгүйгээр зөвхөн аливаа үйлээс татгалзсанаар хүн аз жаргалтай байж чадахгүй. Харин чин бишрэлийн албанд зүтгэн байгаа гүн гүнзгий мэдлэг бүхий хүн л Бүхний Дээдэд мөдхөнөө хүрнэ.

ТАЙЛБАР: Огоорохуйн амьдралын түвшинд оршин байгаа хүмүүс буюу *саннясуудыг* хоёр ангилдаг. *Вайшнава-саннясууд* нь Веданта судрын үнэн зөв тайлбарыг өгдөг *Бхагаватам*-философийг судлаж байхад, *майвади-*

санньясууд нь санкхья-философийг үзэж байдаг. *Майавади-санньясууд* нь мөн *Веданта* судрыг судладаг боловч Шанкарачарьягийн бичсэн *Шарирака-бхашья* гэж нэрлэгдэх өөрсдийн номлолын тайлбарыг ашигладаг. *Бхагавата*-номлолыг баримтлагчид нь *панчаратрики* зарчмын дагуу Бурханы чин бишрэл дүүрэн бялхах албанд өөрсдийгөө зориулж байдаг тул *вайшнава-санньясуудын* хувьд энэхүү трансценденталь албанд зүтгэх олон янзын үйл байнгад байдаг. *Вайшнава-санньясууд* нь материаллаг үйлтэй огтхон ч холбогдолгүй байдаг ч Бурханы чин бишрэл дүүрэн бялхах албанд зүтгэн байхдаа хамгийн олон талт, янз бүрийн үйлүүдийг үйлддэг. Тэгэхэд *майавади-санньясууд нь санкхья, Веданта* философийг судлах болон цэцэрхийллээр хөөцөлдөн байх учир Бурханд чин бишрэлээр зүтгэхийн жаргал цэнгэлийг амталж мэдэрч чаддаггүй. Тэдний энэхүү судлах үйл нь цаг хугацааны явцад маш уйтгартай болоод амтгүй болох учир тэд Брахманы тухай цэцэрхэхээс алжаан ядрах тул үнэн зөвөөр ойлгохгүй ч аврал ивээл эрэн *Бхагаватамд* ханддаг. Иймээс Шримад Бхагаватамыг судлах нь тэдний хувьд маш хэцүү бэрх байдаг. Зохиомол аргаар хуурай хоосон цэцэрхийлэх болон бодьгал бус байдлаар тайлбарлах явдал нь *майавади-санньясуудад* цаашид ямар ч тус нэмэр болохгүй. Тэгэхэд чин бишрэлийн албанд зүтгэн байгаа *вайшнава-санньясууд* нь өөрт оноогдсон үүргээ биелүүлэх явцдаа трансценденталь аз жаргалыг мэдрэхийн зэрэгцээ эцэстээ Бурханы оронд хүрч очих баталгаатай болж байдаг. *Майавади-санньясууд* нь заримдаа өөрийгөө танин мэдэхүйн зам мөрөөсөө гажуудан гарч унан, материаллаг үйл болох энэрэн нигүүлсэхүйн болон бодь сэтгэлийн шинж чанартай үйлүүдэд дахин автдаг. Эндээс үзэхэд, Кришнагийн ухамсрын үйлэнд зүтгэн байгаа хүмүүс нь, хэдийгээр олон амьдралын дараагаар Кришнагийн ухамсарт мөн ирэх боловч одоогоор зөвхөн, Брахман гэж юу болох, Брахман биш гэж юу болох талаар цэцэрхийлэн байгаа *майавади-уудаас* илүү дээд байр сууринд оршдог гэсэн дүгнэлтэнд хүрч болно.

ШҮЛЭГ 7

*йога-юкто вишуддхатма вижитатма житендриях
сарва-бхутатма-бхутатма курванн апи на липьяте*

Йога-юктах- чин бишрэлийн албанд зүтгэн байгаа, вишуддха-атма- ариуссан сүнс,

вижита-атма- эзэмдэн захирдаг, жита-индриях- мэдрэхүйгээ ялан дийлснээр, сарва-

бхута- бүх амьд оршнолуудад, атма-бхута-атма- энэрэл өрөвдлөөр дүүрэн, курван апи-

хэдийгээр үйл үйлдэн байгаа ч, на- хэзээ ч үгүй, липьяте- орооцолддог.

Хэн Бурханд чин бишрэлтэйгээр зүтгэж байна, хэн цэвэр ариун сүнс байна, хэн ухаан хийгээд мэдрэхүйгээ эзэмдэн захирч байна, тэр бүгдэд эрхэм байх бөгөөд бүгд түүнд эрхэм. Тэр хэдийгээр үргэлж идэвхитэй байж үйл хөдлөл хийж байдаг ч тэдгээрийн үр дагаварт хэзээ ч орооцолдон, уягдаж хүлэгддэггүй.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсарт үйл хэргээ явуулснаар ангижралд хүрэх зам мөрөөр замнаж байгаа хүн амьд оршнол бүрт маш эрхэм байдгийн зэрэгцээ амьд оршнол бүр түүнд эрхэм. Энэ бол Кришнагийн ухамсрын ач тус билээ. Ийм хүн нь навч мөчрийг модноос тусад нь салган авч үзэж болдоггүйн нэгэн адил амьд оршнолыг Кришнагаас ангид тусад нь салган үздэггүй. Тэрээр ходоодонд орсон хоол хүнс бүх бие махбодийг шаардлагатай эрч хүчээр хангаж байдаг эсвэл модны үндсийг усласнаар түүний навч мөчрийг мөн услаж чийгээр хангадаг гэдгийг сайн мэддэг. Үүний нэгэн адил, Кришнагийн ухамсарт үйл хэргээ явуулж буй хүн амьд оршнол бүрт үйлчлэн зүтгэж байдаг учир тэрээр амьд оршнол бүрт маш эрхэм байдаг. Амьд оршнол бүр түүний үйлдэж буй үйл бүрт ханамжтай байдаг учир түүний ухамсар нь цэвэр ариун байдаг нь ойлгомжтой. Түүний ухамсар нь цэвэр ариун учраас ухаанаа бүрэн эзэмдэн захирсан байдаг. Тэр ухаанаа бүрэн эзэмдэн захирсан байдаг учраас түүний мэдрэхүйнүүд нь мөн бүрэн эзэмдэн захирагдсан байдаг. Түүний ухаан нь Кришнад байнгад төвлөрөн байх учир тэр түүнээс холдон хөндийрэх буюу түүний мэдрэхүйнүүд нь Кришнад зүтгэхээс өөр ямар нэгэн үйлд татагдах явдал гарах боломжгүй юм. Тэр Кришнад хамааралгүй сэдвийн талаар сонсохыг болон Кришнад өргөөгүй л бол юу ч байсан идэхийг хүсдэггүй. Мөн Кришнад үйлчлэн зүтгэхтэй холбогдолгүй л бол тэр хаашаа ч явдаггүй. Иймээс түүний мэдрэхүйнүүд нь бүрэн хяналтанд орж захирагдсан байдаг. Мэдрэхүйгээ эзэмдэн захирч, хянан удирдаж чадаж байгаа хүн хэнд ч хор хөнөөл учруулдаггүй. Тэгвэл яагаад Аржуна тулалдаанд орж бусдыг хөнөөсөн юм бэ? Тэр Кришнагийн ухамсаргүй байсан гэж үү? гэсэн асуулт хэн нэгэнд төрж болох юм. Өнгөцхөн харахад, Аржуна эдгээр хүмүүст хүч хэрэглэж байгаа мэт санагдаж болох юм. Хоёр дугаар бүлэгт тайлбарласанчлан, сүнс бол хэзээ ч усташгүй учир тулалдааны талбарт амь эрсэдсэн бүх хүмүүс цаашид бие даасан сүнс байдлаа мөн хадгалан амьдарсан хэрэг. Бурханлаг талаас нь авч үзвэл Курукшетрын тулалдааны талбарт нэг ч амьд оршнол устгагдаагүй хэрэг. Тэнд цугларагсад зөвхөн гадуур өмсгөлөө л сольсон бөгөөд энэ нь тэнд Өөрөө биечлэн заларч байсан Кришнагийн таалал, айлдварт нийцсэн хэрэг юм. Иймээс Аржуна нь Курукшетрын тулалдааны талбарт үнэн хэрэгтээ огтхон ч тулалдаагүй, тэр Кришнагийн бүрэн ухамсарт л Кришнагийн айлдварыг гүйцэтгэсэн хэрэг. Ийн байдлаар үйл үйлдэх хүн өөрийн үйлдсэн үйлийн үр дагаварт хэзээ ч орооцолдон уягдаж хүлэгддэггүй.

ШҮЛЭГ 8-9

найва кинчит каромити

*юкто маньета таттва-вит
пашьянь шринван спришань жиэхранн
ашнан гаччхан свапан швасан*

*пралапан вишрижан грихнанн
унмишан нимишанн апи
индрияниндрияртхешу
вартанта ити дхараян*

на- хэзээ ч үгүй, эва- гарцаагүй, кинчит- ямар нэгэн зүйл, кароми- би хийдэг, ити- ингэж, юктах- Бурханы ухамсарт зүтгэдэг, маньета- боддог, таттва-вит- үнэнийг таньж мэдэж байгаа, пашьян- харсанаар, шринван- сонссоноор, спришан- хүрсэнээр, жигхран- үнэрлэсэнээр, ашнан- идсэнээр, гаччхан- явсанаар, свапан- унтсанаар, швасан- амьсгалснаар, пралапан- ярьснаар, вишрижан- орхисноор, грихнан- авснаар, унмишан- нээсэнээр, нимишан- хааснаар, апи- хэдий ч, индрияни- мэдрэхүй, индрия-артхешу- мэдрэхүйн таашаал ханамж эдлэхтэй холбогдсон үйлд, вартанте- автаж байсан байг, ити- ийм байдлаар, дхараян- эрэгцүүлэн бодсоноор.

Бурханлаг ухамсарт орших хүн хэдийгээр харж, сонсож, хүрч, үнэрлэж, идэж, хөдөлж, унтаж, амарч байх боловч үнэн хэрэгтээ тэр ямар ч үйл үйлддэггүй гэдгээ өөрийн дотооддоо үргэлж мэдэж байдаг. Учир нь ярьж хэлэлцэж, ходоодоо суллаж дүүргэж, нүдээ нээж аньж байхдаа ч зөвхөн материаллаг мэдрэхүйнүүд нь л өөрсдийн объектуудтайгаа харилцан холбогдож байна, харин өөрөө бол түүнээс дээш оршин байдаг гэдгийг тэр үргэлж мэдэж байдаг.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсарт оршин байгаа хүн оршихуйн цэвэр ариун түвшинд оршин байдаг учир тэрээр үйл үйлдэгч, уг үйл, гадаад нөхцөл байдал, хүчин чармайлт болон хувь тавилан зэрэг шууд болон шууд бус таван учир шалтгаанаас хамаарах үйл ажиллагаатай ямар ч холбоогүй байдаг. Энэ нь тэр Кришнагийн трансценденталь хайр дүүрэн бялах албанд зүтгэж байгаад оршдог. Гаднаас нь өнгөцхөн харахад тэр бие махбодь, мэдрэхүйнхээ тусламжтайгаар үйл үйлдэж байгаа мэт боловч үнэн хэрэгтээ тэр бурханлаг үйл үйлдэх өөрийн жинхэнэ байр сууриа ухаарсан байдаг. Материаллаг ухамсартай хүмүүсийн мэдрэхүй нь мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийг л сонирхон түүний хойноос хөөцөлдөж байдаг бол Кришнагийн ухамсарт оршин буй хүмүүсийн мэдрэхүй нь Кришнагийн мэдрэхүйг цэнгүүлэх үйлэнд зүтгэж байдаг. Ийм учраас Кришнагийн ухамсарт оршин буй хүн мэдрэхүйн объектуудтай холбогдсон үйл үйлдэн байгаа мэт харагдах боловч түүнээс үргэлж ангид байдаг. Харах, сонсох зэрэг үйлүүд нь мэдлэг хүртэх, танин мэдэх мэдрэхүйн үүргүүд байхад хөдлөх, ярих, ходоод гэдсээ суллах гэх зэрэг үйлүүд нь ажлын мэдрэхүйн үүргүүд байдаг. Кришнаг ухамсарласан хүн мэдрэхүйн үйлүүдийн нөлөөнд хэзээ ч ордоггүй. Тэр өөрийгөө Бурханы мөнхийн зарц үйлчлэгч гэдгээ мэдэх учир Бурханы албанд үйлчлэн зүтгэхээс өөр ямар ч үйлийг үйлддэггүй.

ШҮЛЭГ 10

*брахмани адхая кармани сангам тьяктва кароти ях
липьяте на са палена падма-патрам ивамбхаса*

брахмани- Бурханы Дээд Бодьгалд, адхая- зориулснаар, кармани- бүхий л үйлээ, сангам- дурлан татагдахуй, тьяктва- орхисноор, кароти- биелүүлдэг, ях- тэр, липьяте- нөлөөнд ордог, на- хэзээ ч үгүй, сах- тэр, палена- нүглээр, падма-патрам- бадамлянхуа цэцгийн навч, ива- шиг, амбхаса- усаар.

Өөрт оноогдсон үүргээ ямар ч дурлан татагдалгүйгээр биелүүлэн, үр дүнгийг нь Бүхний Дээд Бурханд чин бишрэлтэйгээр зориулах хүн бадамлянхуа цэцгийн навч усанд нордоггүйн адил нүгэлт үйлүүдийнхээ үр дагаврын нөлөөнд нэрвэгддэггүй.

ТАЙЛБАР: Энд брахмани гэдэг үг нь “Кришнагийн ухамсарт” гэсэн утгыг агуулна. Материаллаг ертөнц нь материаллаг байгалийн гурван гунуудын цогц илрэл бөгөөд прадхана гэж нэрлэгддэг. Ведийн дууллуудад өгүүлэхдээ: сарвам хй этад брахма (Мандукья-упанишад, 2), тасмад этад брахма нама рупам аннам ча жайате (Мундака-упаниша, 1.2.10). Мөн Бхагавад Гитагийн (14.3)-д мама йонир махад брахма гэж өгүүлсэн байдаг. Эдгээр

шүлгүүд нь материаллаг ертөнцөд оршин байгаа бүх зүйлс нь Брахманы илрэл тодрол гэж зааж байна. Хэдийгээр үйлчлэл, үр дагавар нь янз бүрийн хэлбэрээр илрэх боловч тэд бүгд учир шалтгаанаасаа ялгаагүй юм. Ишопанишадад, бүх зүйл Дээд Брахман, Кришнаатай холбоотой байдаг ба иймээс тэд бүгд ганцхан Түүнд л харьяалагддаг гэж өгүүлсэн байдаг. Бүх зүйл Кришнад харьяалагдаж, Тэр оршин байгаа бүхний эзэн мөн учраас бүгдийг Түүний албанд зүтгэхэд ашиглаж болно гэдгийг бүрэн төгс ойлгосон хүн өөрийн үйлийн үр дагавар нь буянтай сайн ч байна уу, нүгэлтэй муу ч байна уу ялгаагүй түүнтэй орооцолддоггүй. Тодорхой хэлбэрийн үйл үйлдэхэд нь зориулан Бурханы хайрлаж хүртээсэн материаллаг бие махбодийг ч Кришнагийн ухамсарт хандуулан ашиглаж болно. Тэгссэн цагт тэр, усны мандал дээр байх боловч хэзээ ч нордоггүй бадамлянхуа цэцгийн навч адил нүгэлт үр дагаврын бузраас ангид байдаг. Бурхан мөн Гитагийн (3.30)-д: *майи сарвани кармани санньясьяа* буюу “Өөрийн бүхий л үйлээ Надад чин бишрэлтэйгээр зориул.” гэж айлдсан билээ. Эдгээрээс дүгнэж үзэхэд: Кришнагийн ухамсаргүй хүн бие махбодийн болон мэдрэхүйн түвшинд үйл, хөдлөл хийж байдаг бол Кришнаг ухамсарласан хүн бие махбодь нь Кришнад харьяалагддаг, Түүний өмч болох тул Түүний албанд зүтгэх ёстой гэсэн мэдлэгт тулгуурлан үйлчлэн зүтгэж байдаг.

ШҮЛЭГ 11

*каена манаса буддхья кевалайр индрияйр апи
йогинах карма курванти сангам тьяктватма-шуддхае*

каена- бие махбодиор, *манаса*- ухаанаар, *буддхья*- оюун ухаанаар, *кевалайх*- ариуссан, *индрияйх*- мэдрэхүйгээр, *апи*- тэр ч бүү хэл, *йогинах*- Кришнаг ухамсарласан хүмүүс, *карма*- үйлүүд, *курванти*- тэд гүйцэтгэдэг, *сангам*- дурлан татагдахуй, *тьяктва*- орхисноор, *атма*- өөрийн, *шуддхае*- ариусгахын төлөө.

Аливаа зүйлд дурлан татагдахаа больсон иогч бие махбодь, ухаан, оюун ухаан, бүр мэдрэхүйгээ хүртэл зөвхөн ариусах зорилгоор л ашигладаг.

ТАЙЛБАР: Кришнагийн мэдрэхүйг хангахын төлөө, Кришнагийн ухамсарт бие махбодь, ухаан, оюун ухаан тэр бүү хэл мэдрэхүйгээр гүйцэтгэж байгаа аливаа үйл нь материаллаг бузраас ариуссан байдаг. Кришнаг ухамсарласан хүний үйлдэж байгаа үйлийг материаллаг үр дагавар дагалддаггүй. Ийнхүү ариуссан үйл (*сад-ачара*)-г үйлдэхийн тулд Кришнагийн ухамсарт оршин байх л хангалттай. Шри Рупа Госвами Бхакти-расамрита-синдхугийн (1.2.187)-д үүнийг дараах байдлаар тодорхойлсон байдаг:

*иха ясья харер дасье кармана манаса гира
никхиласе апи авастхасу живан-муктах са учьяте*

“Кришнагийн ухамсарт бие махбодь, ухаан, оюун ухаан болон үг хэлээрээ үйл ажиллагаа явуулж байгаа буюу өөрөөр хэлбэл Кришнагийн албанд зүтгэж байгаа хүн хэдийгээр материаллаг үйлийн хойноос хөөцөлдөн байгаа мэт харагдах боловч материаллаг ертөнцөд оршин байхдаа л хэдийнээ ангижралд хүрсэн байдаг.” Тэр өөрийгөө материаллаг бие махбодьтойгоо адилтган үздэггүй буюу өөрийгөө энэ бие махбодийн эзэн гэж тооцдоггүй учир түүнд хуурамч эго байдаггүй. Тэр бол бие махбодь биш гэдгээ болон бие махбодь нь түүнд мөн хамаарагддаггүйг мэддэг. Тэр өөрөө Кришнад харьяалагдан, Түүний соёрхолд байдаг бөгөөд түүний бие махбодь ч мөн адил Кришнад харьяалагддаг. Бие махбодь, ухаан, оюун ухаан, үг яриа, амьдрал, эд баялгаа болон өөрт байгаа бүхнээ Кришнагийн албанд үйлчлэн зүтгэхэд зориулан ашиглах аваас тэр удаж төдөлгүй Түүнтэй холбогдох болно. Тэр Кришнаатай ижил бөгөөд, хэн нэгний би бол бие махбодь... гэх зэргээр боддогчлонтой адил хуурамч эгогоос ангид байдаг. Энэ үе шат бол Кришнагийн ухамсрын төгс төгөлдөр үе шат юм.

ШҮЛЭГ 12

*юктах карма-пхалам тьяктва шантим апноти найштхиким
аюктах кама-карена пхале сакто нибадхьяте*

юктах- чин бишрэлийн албанд зүтгэн байгаа, *карма-пхалам*- бүхий л үйлийнхээ үр дүнг, *тьяктва*- огоорсноор, *шантим*- төгс төгөлдөр амар амгалан, *апноти*- хүрдэг, *найштхиким*- гуйвалтгүй, *аюктах*- Кришнагийн ухамсаргүй хүн, *кама-карена*- өөрийн үйлийн үр дүнгээр таашаал ханамж эдлэхээр, *пхале*- үр дашаварт, *сактах*- дурлан татагдсан, *нибадхьяте*- орооцолддог.

Чин бишрэлээр гуйвалтгүй зүтгэх сүнс нь өөрийн бүхий л үйлийн үр дүнг Надад өргөж байдаг учир жинхэнэ амар амгаланд хүрдэг. Харин Бурхантай үл холбогдон, өөрийн үйлийн үрийн хойноос хомхойрон тэмүүлж байдаг хүн материаллаг боолчлолын уяа хүлээсэнд орооцолддог.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсартай болон бие махбодийн ухамсартай хүмүүсийн хоорондын ялгаа нь эхнийх нь Кришнад, харин нөгөө нь өөрийн үйлийн үр дүнд татагдан байдаг оршино. Кришнад татагдан, зөвхөн Түүний төлөө л үйлээ зориулан байгаа хүн ангижралын түвшинд хүрсэн байдаг ба үйл ажиллагааныхаа үр дүнг хүсэн шаарддаггүй. Хүн үйлийнхээ үр дүнд санаа зовох шалтгаан нь тэр үйлээ хоёрдмол байдлын үзэл бодлын нөлөөн доор буюу Үнэмлэхүй Үнэний тухай мэдлэггүйгээр үйлддэгт оршдог гэж Бхагаватамд тайлбарласан байдаг. Кришна бол дээдийн дээд Үнэмлэхүй Үнэн, Бурханы Бодьгал билээ. Оршин байгаа бүх зүйлс Кришнагийн эрчмийн бүтээгдэхүүн байдаг бөгөөд Кришна бүх талаараа төгс төгөлдөр учир Кришнагийн ухамсарт хоёрдмол байдал гэж байдаггүй. Иймээс Кришнагийн ухамсар дахь үйл нь үнэмлэхүй түвшинд үйлдэгдэж байдаг; ийм үйл нь трансценденталь байх бөгөөд материаллаг үр дагавар дагуулдаггүй. Үүнээс үзэхэд, Кришнагийн ухамсарт орших

хүн амар амгалангаар дүүрэн байдаг. Мэдрэхүйн таашаал ханамж эдлэх зорилгоор өөрийн орлого ашгын тооцоотой зууралдан байгаа хүн энэхүү амар амгаланг олохгүй. Кришнагийн ухамсарын нууц нь Кришнагаас гадуур тусдаа орших зүйл гэж огт байдаггүй гэдгийг танин мэдэхэд оршдог бөгөөд ийнхүү танин мэдэх нь амар амгаланг олох хийгээд айдас хүйдэсгүй байхын үндэс байдаг.

ШҮЛЭГ 13

*сарва-кармани манаса санньясьясте сукхам ваши
нава-дваре пуре дехи найва курван на караян*

сарва- бүгд, *кармани*- үйлүүд, *манаса*- ухаанаар, *санньясья*- огоорсноор, *асте*- үлддэг, *сукхам*- аз жаргалд, *ваши*- өөрийгөө эзэмдэн захирагч, *нава-дваре*- есөн хаалгат, *пуре*- хотод, *дехи*- бие махбодид төрсөн сүнс, *на*- хэзээ ч үгүй, *эва*- гарцаагүй, *курван*- ямар нэгэн зүйл хийснээр, *на*- үгүй, *караян*- хийх шалтгаан болсноор.

Бие махбодид орших амьд оршнол нь өөрийн мөн чанараа хянан захирч, ухааны түвшиндээ бүхий л үйлээс огоорсноор есөн хаалгатай хот (материаллаг биемахбодь)-доо аз жаргалтай амьдрах болно. Тэрээр аливаа үйлийг үйлдэгч ч биш, мөн аливаа үйлийг үйлдэх учир шалтгаан ч биш билээ.

ТАЙЛБАР: Бие махбодийг аван төрсөн сүнс нь есөн хаалгатай хотод оршдог болой. Бие махбодийн буюу үлгэрлэж хэлснээр хотын үйл нь түүнд нөлөөлөн үйлчилж буй материаллаг мөн чанарын гунуудаар өөрөө аяндаа үйлдэгддэг. Хэдийгээр сүнс нь бие махбодийн нөхцөл байдлын эрхшээлд байдагч хэрвээ тэр хүсэх аваас энэ нөхцөл байдлыг даван гарч чадна. Тэрээр зөвхөн өөрийн дээд мөн чанарын талаар мартсаны уршгаар өөрийгөө материаллаг бие махбодтой адилтган үздэг тул ийнхүү зовж шаналж байгаа хэрэг. Кришнагийн ухамсарын тусламжтайгаар тэр өөрийн жинхэнэ байр сууриа дахин эзлэх боломжтой бөгөөд ингэснээр материаллаг бие махбодийн олзноос салан гарч чадна. Өөрөөр хэлбэл, Кришнагийн ухамсарт хандсанаар хүн бие махбодийн бүхий л үйлээс мөдхөн салан ангижрах болно. Бодол санааныхаа чиглэлийг өөрчлөн, амьдралаа ийнхүү хянан захирч зохион явуулж байгаа хүн есөн хаалгатай хотдоо аз жаргалтай амьдарч чадна. Эдгээр есөн хаалгыг дараах байдлаар тодорхойлсон байдаг:

*нава-дваре пуре дехи хамсо лелаяте бахих
ваши сарвасья локасья стхаварасья чарасья ча*

“Амьд оршнолын бие махбодид залран байх Бурхан, Бурханы Дээд Бодьгал нь орчлонгийн бүхий л амьд оршнолуудын эзэн, захирагч мөн билээ. Бие махбодь нь хоёр нүд, хамрын хоёр нүх, хоёр чих, ам, анус болон гениталь гэсэн есөн хаалгатай байдаг. Болзолдож нөхцөлдсөн байдалд байгаа амьд оршнол нь өөрийгөө бие махбодьтойгоо адилтган үзэж байдаг, харин тэр өөрийгөө дотооддоо залрах Бурхантай адилтган үзэх аваас бие махбодид оршин байгаа ч Түүн лугаа ангижирсан байдалтай болно.” (Шветашватара-упанишад, 3.18)

Ийм учраас, Кришнаг ухамсарласан хүн нь материаллаг бие махбодийн гадаад болон дотоод үйлээс ангид байдаг.

ШҮЛЭГ 14

*на картритвам на кармани локасья срижати прабхух
на карма-пхала-самьогам свабхаваас ту правартате*

на- хэзээ ч үгүй, *картритвам*- өмч хөрөнгө, *на*- үгүй, *кармани*- үйлүүд, *локасья*- хүмүүсийн, *срижати*- бүтээдэг, *прабхух*- бие махбодийн хотын эзэн, *на*- үгүй, *карма-пхала*- үйлүүдийн үр дүнтэй, *самьогам*- холбоо, *свабхава*- материаллаг байгалийн гунууд, *ту*- харин, *правартате*- үйлдэх.

Хотын эзэн буюу бие махбодид орших бурханлаг сүнс нь үйл үйлддэггүй ба бусдыг үйл үйлдүүлэхээр өдөөдөггүй. Мөн өөрийн үйлийн үр дагаврыг ч бий болгодоггүй. Энэ бүгдийг материаллаг байгалийн гунууд үйлдэж байдаг.

ТАЙЛБАР: Амьд оршнол нь Бүхний Дээд Бурханы нэгэн мөн чанар буюу эрчим мөн болох хийгээд энэ мөн чанар нь Бурханы өөр нэгэн буюу доод мөн чанар болох материас ялгаатай байдаг тухай долоо дугаар бүлэгт тайлбарлах болно. Дээд мөн чанар буюу амьд оршнол нь өнө эртийн цагт ямар нэгэн байдлаар материаллаг мөн чанартай холбогдсон хэрэг. Амьд оршнолын оршин байх энэхүү түр зуурын бие махбодь нь олон янзын үйл хийгээд түүнээс урган гарах үр дагаврын учир шалтгаан байдаг. Ийн болзолдож нөхцөлдсөн байдалд амьдарч байгаа хүн харанхуй мунхагийн улмаас өөрийгөө бие махбодьтойгоо адилтгаснаар бие махбодийн үйлийн үр дагаварт зовж, шаналж байдаг. Түүний бие махбодийн зовлон зүдгүүрийн учир шалтгаан нь өнө эртийн цагаас түүнийг эрхшээлдээ бүрэн оруулсан харанхуй мунхаг байдал нь байдаг. Амьд оршнол нь бие махбодийн үйлээс холдон хөндийрмөгц л үр дагавруудаас нь мөн ангижрах болно. Тэр энэхүү бие махбодийн хотод оршин байхдаа өөрийгөө түүний эзэн, захирагч мэтээр үзэх боловч үнэн хэрэгтээ тэр түүний захирагч ч биш, мөн түүний үйлүүд хийгээд тэдгээрийн үр дагаврыг удирдагч эзэн ч биш байдаг. Тэр зүгээр л материаллаг ертөнцийн далайн гол дунд оршин амьдрал оршнолынхоо төлөө тэмцэж байдаг. Далайн давалгаа түүнийг ийш тийш нь шидлэн чулуудах бөгөөд тэрээр тэдгээрийг захирах ямар ч чадваргүй байдаг. Энэхүү далайн уснаас гарах хамгийн зөв шийдвэр бол Кришнагийн ухамсарт хандах явдал. Зөвхөн энэ л түүнийг бүх гай зовлонгоос аварч чадна.

ШҮЛЭГ 15

*надатте касьячит папам на чайва сукритам вибхух
агьяненавритам гьянам тена мухьянти жантавах*

на- үгүй, адатте- авдаг, касьячит- хэн нэгний, папам- нүглийг, на- үгүй, ча- мөн, эва- гарцаагүй, су-критам- зөв шудрага үйлүүд, вибхух- Бүхний Дээд Бурхан, агьянена- мунхагаар, авритам- хучигддаг, гьянам- мэдлэг, тена- түүгээр, мухьянти- төөрөлдсөн, жантавах- амьд оршнолууд.

Мөн Бүхний Дээд Бурхан хэний ч нүгэлт болоод шудрага зөв сайн үйлийн хариуцлагыг Өөртөө авч хүлээдэггүй. Бие махбодид орших амьд оршнолын тэнэг мунхаг байдал нь жинхэнэ, үнэн мэдлэгийг нь бүрхэгдүүлэх тул тэрээр бүрмөсөн төөрч будилдаг.

ТАЙЛБАР: *Вибху* гэдэг санскрит үг нь хязгааргүй их мэдлэг, хэмжээлшгүй их баялаг, хэмжээлшгүй их хүч, хэмжээлшгүй их алдар, зүйрлэшгүй гоо сайхан болон хязгааргүй огоорлыг төгс төгөлдөр байдлаар агуулах Бүхний Дээд Бурхан гэсэн утгатай. Тэр Өөртөө бүрэн ханамжтай байдаг бөгөөд нүгэлт хийгээд зөв шудрага үйлийн аль нь ч Түүний амгалан тайванг алдагдуулахгүй. Тэр хэнд ч зориулан тусгай онцгой байдлыг бий болгодоггүй, харин амьдралын тодорхой нөхцлөөр хангагдахыг хүсэгч нь харанхуй мунхагт төөрөлдсөн амьд оршнол өөрөө байдаг бөгөөд ингэснээр түүний үйлдэл болон үр дагаврын гинжин хэлхээ эхэлдэг билээ. Амьд оршнол нь дээд мөн чанартай учир мэдлэгээр дүүрэн байдаг. Гэсэн ч хязгаарлагдмал, мөхөс хүчин чадлынхаа улмаас тэр мунхагийн харанхуйн эрхшээл, нөлөөлөлд автамтгай байдаг. Бурхан бол бүхнээс хүчирхэг байдаг бол харин амьд оршнол нь тийм биш юм. Бурхан бол *вибху* буюу бүхнийг мэдэгч, харин амьд оршнол нь *ану* буюу өчүүхэн жижиг. Амьд оршнол нь амьд сүнс учраас чөлөөтэйгөөр хүсэх чадвартай байдаг ч түүний бүх хүслийг бүхнээс хүчирхэг Бурхан л биелүүлдэг. Амьд оршнол төөрөгдөж самуурсан хүсэлтэй байсан ч түүнд энэ хүслээ биелүүлэх зөвшөөрлийг өгдөг нь мөн л Бурхан. Гэхдээ Бурхан амьд оршнолын хүслээр үйлдэгдэж буй аливаа үйл болоод түүний үр дагаврын төлөө хэзээ ч хариуцлага хүлээдэггүй. Бие махбодийг аван төрсөн сүнс нь төөрөгдөлд орсон байдаг учраас өөрийгөө болзолдож нөхцөлдсөн материаллаг бие махбодтойгоо адилтган үздэг ба ингэснээр амьдралын түр зуурын зовлон, жаргалын эрхшээл нөлөөлөлд ордог. Бурхан, Параматма буюу Дээд Сүнс хэлбэрээр амьд оршнолыг ямагт дагалдан байдаг тул, хүн өөрийн ойр байгаа цэцгийг үнэрээр нь мэдэрдэгийн адилаар бие даан орших сүнсийн хүсэлтийг мэдэж байдаг. Хүсэл бол амьд оршнолын уяа хүлээсний нарийн хэлбэр юм. Бурхан, амьд оршнолын хүслийг хүртэх ёстой гавьяаных нь хэмжээнд тохируулж тааруулан биелүүлдэг. Иймээс “хүн бодож сэтгэж, Бурхан залж байдаг” гэж ярьдаг. Иймд бие даасан сүнс нь өөрт төрөх хүслээ өөрөө биелүүлэх тийм төгс хүч чадалтай байдаггүй. Харин Бурхан бүгдийн хүссэн бүрийг биелүүлж чадах билээ. Гэхдээ Бурхан бүгдэд ялгаваргүйгээр ханддаг учир Тэрээр өчүүхэн жижиг, бие даасан амьд оршнолын хүсэлд хутгалдан оролцдоггүй. Харин хэн нэгэн нь Кришнаг хүсэх аваас Түүн рүү тэмүүлж байгаа түүнд Тэр Өөрөө онцгой анхаарал тавьж, түүнийг Өөрт нь ойртох хийгээд мөнхийн аз жаргалдаа хүрэх гэсэн хүслээ биелүүлэхэд нь зоригжуулдаг. Иймээс Ведийн дуулалд: *эша у хи эва садху карма караяти там ям ебхьо локебхья уннинишате; эша у эвасадху карма караяти ям адхо нинишате*- буюу “Бурхан амьд оршнолд зөв шудрага үйл үйлдэн дэвшин дээшлэх боломж өгдөг; Бурхан түүнд нүгэл үйлдэн тамд унах боломж өгдөг” (Каушитаки-упанишад, 3.8).

*агьо жантур анишо `ям атманах сукха-дужхайох
ишвара-прерито гаччхет сваргам ваше абхрам эва ча*

“Амьд оршнолын жаргал, зовлон нь Бүхний Дээд Бурханаас бүрэн хамааралтай байдаг. Дээдийн Дээдийн тааллаар тэр, салхинд туугдах үүл мэт диваажинд ч, эсвэл тамд ч очиж болно.”

Тэгэхлээр бие махбодид орших сүнсийн төөрөгдөлд орсон шалтгаан нь Кришнагийн ухамсраас зайлсхийх гэсэн өнө эрт цагийн хүсэл эрмэлзэлдээ хөтлөгдсөн өөрөө байдаг байна. Сүнс нь мөн чанарын хувьд мөнх, жаргал цэнгэл болон мэдлэгээр дүүрэн байдаг хэдий ч тэрээр өчүүхэн жижиг болохоор Бурханы албат, зарц байдаг өөрийн жам ёсны байр сууриа мартан харанхуй мунхагийн урхинд орж олзлогддог. Мунхгийн харанхуйн эрхшээлд орсноор амьд оршнол нь өөрийн болзолт оршихуйн хариуцлагыг Бурханд тохоон хүлээлгэж байдаг. Харин Веданта судрын (2.1.34)-д : *вайшамья-найрехринье на сапекшатват татха хи даршаяти*- буюу “Бурхан үзэн ядаж, хайрлаж байдаг мэт харагдах боловч Тэр хэнийг ч хайрлаж, хэнийг ч үзэн яддаггүй.” гэж өгүүлсэн байдаг.

ШҮЛЭГ 16

*гьянена ту тад агьянам ешам нашитам атманах
тешам адитья-важ гьянам пракашаяти тат парам*

гьянена- мэдлэгээр, *ту*- гэхдээ, *тат*- энэхүү, *агьянам*- мунхаглал, *ешам*- хэний, *нашитам*- устгагддаг, *атманах*- амьд оршнолын, *тешам*- тэдний, *адитья-ват*- мандаж байгаа нар мэт, *гьянам*- мэдлэг, *пракашаяти*- гийгүүлдэг, *тат парам*- Кришнагийн ухамсар.

Гэхдээ, хүн мунхгийн харанхуйг үлдэн хөөх эрдэм мэдлэгийг хүртэн гэгээрснээр, өдрийн цагт нар бүхнийг гийгүүлэн гэрэлтүүлдэгтэй адил бүх зүйл түүнд нээгдэнэ.

ТАЙЛБАР: Кришнаг мартсан хэн бүхэн төөрөгдөлд ордог нь эргэлзээгүй хэрэг. Харин Кришнагийн ухамсарт орших хүн өчүүхэн төдий ч будилж самуурдаггүй. Бхагавад Гитад: *сарвам гьяна-плавена, гьянгних сарва-кармани* болон *на хи гьянена садришам* гэж өгүүлсэн байдаг. Мэдлэг бол үнэлж баршгүй юм хэмээн үргэлж эрхэмлэн дээдлэгддэг.

Мэдлэг гэж энд чухам юуг хэлнэ вэ? Долоо дугаар бүлгийн арванес дүгээр шүлэгт тайлбарласанчлан, амьд оршнол нь Кришнад өөрийгөө даатгасан цагт л төгс төгөлдөр мэдлэгийг хүртэх болно: *бахунам жанманам анте гьянаван мам прападьате*. Олон олон төрөлтийн дараагаар хүн төгс төгөлдөр мэдлэгт үндэслэж тулгуурлан Кришнад өөрийгөө даатгахад буюу Кришнагийн ухамсарт хүрэхэд, нар өдрийн цагт бүхнийг гийгүүлэн гэрэлтүүлдгийн нэгэн адил түүнд бүх зүйл тайлагдан нээгдэнэ. Амьд оршнол олон янз хэлбэрээр самуурал төөрөгдөлд ордог. Жишээлбэл, тэр өөрийгөө Бурхан хэмээн ямар ч нэрэлхэж зовох юмгүйгээр өргөмжлөн зарлаж байх аваас мунхагийн харанхуйн сүүлчийн урхинд орж байгаа хэрэг. Амьд оршнол нь Бурхан юм бол тэр яагаад мунхагийн харанхуйд төөрөлдөн будилж байгаа юм бэ? Бурхан харанхуй мунхагаас болж төөрөлдөнө гэж үү? Хэрвээ тийм гэж үзвэл, харанхуй мунхаг буюу четгөр шулам нь Бурханаас дээш, илүү байдаг гэсэн үг болно. Жинхэнэ мэдлэгийг зөвхөн Кришнагийн төгс төгөлдөр ухамсарт байгаа хүнээс л хүртэж болно. Кришнагийн ухамсар нь шөнийн түнэр харанхуйг сарниулан гийгүүлэгч нар лугаа мунхагийн харанхуйг үлдэн хөөж арилгадаг нь эргэлзээгүй учир ийм жинхэнэ номын багшийг олж түүний удирдлагын доор Кришнагийн ухамсар гэж юу болохыг ойлгож сурах хэрэгтэй. Хүн өөрөө энэ бие махбодь биш, харин түүнд трансценденталь байр суурьтай байдаг гэдгээ бүрнээ таньж мэддэг болсон байсан ч энэ нь тэр сүнсийг Дээд Сүнснээс ялгаж чадна гэсэн үг биш. Гэхдээ тэр Кришнаг ухамсарласан, төгс төгөлдөр жинхэнэ номын багшаас өмөг түшиг, аврал ивээл эрэхийг чармайх аваас бүхнийг зөв ойлгож мэдэж чадна. Бурханыг болон Түүнтэй холбогдсон өөрийн холбоо харьцааг хүн зөвхөн Түүний элч төлөөлөгчидтэй учирч байж л таньж мэдэх болно. Бурханы элч нь өөрийгөө Бурхан хэмээн хэзээ ч хэлдэггүй. Гэхдээ тэр Бурханы тухай мэдлэгийг агуулсан байх тул түүнд Бурханд үзүүлж байгаатай адил хүндэтгэл бишрэл үзүүлж байх хэрэгтэй. Бурхан болон амьд оршнол хоёрын хоорондын ялгаа чухам юунд оршдогийг ойлгож сурах хэрэгтэй. Бхагавад Гитагийн хоёр дугаар бүлэгт (2.12) Шри Кришнагийн айлдсанчлан, амьд оршнол бүр бие даасан байдалтай байдаг ба мөн Бурхан ч Өөрөө бие даасан байдаг. Бүх амьд оршнолууд нь өнгөрсөн цаг үед ч, одоо үед ч энэ байдлаа хадгалж байдаг бөгөөд ирээдүйд ч энэхүү бие даасан байдлаа мөн хадгалсаар байх болно. Тэр ч бүү хэл ангижралыг олсоны дараа ч бие даасан байдлаа үргэлжлүүлэн хадгалсаар байх болно. Шөнийн харанхуйд бүх зүйлс нэг л юм шиг харагдах боловч өдөр, нарны гэрэлд бүгд өөр, өөрийн жинхэнэ байдлаараа харагддаг. Амьд оршнол, бурханлаг оршнолдоо бие даасан байдлаа хадгалан байна гэдгээ ойлгох нь жинхэнэ үнэн мэдлэг болой.

ШҮЛЭГ 17

*тад-буддхаяс тад-атманас тан-ништхас тат-параянах
гаччхантй апунар-авриттим гьяна-нирдхута-калмашах*

тад-буддхаях- оюун ухаанаа үргэлж Бүхний Дээдэд төвлөрүүлэгч, *тад-атманах*- ухаан нь үргэлж Бүхний Дээдэд төвлөрөгч, *тан-ништхах*- итгэл нь зөвхөн Бүхний Дээдэд чиглэгдэгч, *тат-параянах*- Түүнээс бүрнээ аврал ивээл эрсэн, *гаччхантй*- явах, *апунах-авриттим*- ангижралд, *гьяна*- мэдлэгээр, *нирдхута*- ариуссан, *калмашах*- гай зовлон таригч зүйлс.

Оюун ухаан, ухаан, итгэл бишрэл болон аврал ивээл эрэх зэргээ бүгдийг нь Бүхний Дээдэд төвлөрүүлсэн цагт хүн төгс төгөлдөр мэдлэгийн ач тусаар гай зовлон таригч бүхнээс ариусах бөгөөд ингэж байж л тэр ангижралд хүрэх зам мөрөөр гуйвалтгүй урагшилна.

ТАЙЛБАР: Дээдийн дээд трансценденталь үнэн бол Шри Кришна. Шри Кришна бол Бурханы Дээд Бодьгал мөн юм гэдгийг батлан тайлбарлахад л Бхагавад Гита бүхэлдээ чиглэсэн. Ведийн бүхий л судруудын утга санаа үүнтэй мөн нэг ижил байдаг. *Пара-маттва* гэдэг нь Дээдийн Дээд бол Бхагаван, Параматма болон Брахман юм гэдгийг ойлгож ухаарсан хүний хүртсэн байх тэр “дээдийн дээд үнэн, бодит байдал” юм. Бхагаван буюу Бурханы Дээд Бодьгал нь Үнэмлэхүйн дээдийн дээд төлөв юм. Үүнээс дээш зүйл гэж байдаггүй. Бурханы айлдсанчлан: *маттах паратарам наньят кинчит асти дхананьяя*. Бодьгал бус Брахман нь мөн Кришнагаас хамааралтай байдаг: *брахmano хи пратиштхахам*. Иймээс Кришна бүхий л талаараа дээдийн дээд үнэн, бодит байдал юм. Ухаан, оюун ухаан, итгэл бишрэл болон авралын найдвар нь Кришнад байнгад чиглэн байх буюу өөрөөр хэлбэл Кришнаг бүрнээ ухамсарласан хүн бүхий л гай зовлонгоосоо ариусан ангижирсан нь эргэлзээгүй бөгөөд Үнэмлэхүйн талаарх бүрэн төгс төгөлдөр мэдлэгийг хүртсэн байдаг. Кришнаг ухамсарласан хүн Кришнад хоёрдмол байдал байдаг гэдгийг (нэгэн зэрэг адил байдал болон бие даасан байдалтай байх явдал) сайн ойлгодог ба энэхүү трансценденталь мэдлэгийг хүртсэнээр тэр ангижралд хүрэх замаар итгэл төгс гуйвалтгүй урагшилдаг болно.

ШҮЛЭГ 18

*видья-виная-сампанне брахмане гави хастини
шуни чайва шва-паке ча пандитах сама-даршинах*

видья-мэдлэгтэй, *виная*- болон ховор мөн чанар, *сампанне*- бүрэн хангагдсан, *брахмане*- брахманад, *гави*- үнээнд, *хастини*- заанд, *шуни*- нохойнд, *ча*- болон, *шва*- гарцаагүй, *шва-паке*- нохойгоор хооллогчдод (ангид үл харьяалагдагчид), *ча*- мөн, *пандитах*- мэргэд, *сама-даршинах*- адил байдлаар харах.

Хүлцэнгүй мэргэд нь жинхэнэ мэдлэгийг хүртсэний ач тусаар гүн гүнзгий мэдлэгтэй ба сайн шинж чанар бүхий брахман болон үнээ, заан, нохой мөн нохойгоор хооллогч (ямар нэг анги давхаргад үл багтагч)-г нэг л ижил байдлаар хардаг.

ТАЙЛБАР: Кришнаг ухамсарласан хүн амьдралын хэлбэрүүдийн хооронд болон кастуудын хооронд ямар ч ялгаа хийдэггүй. Брахман болон кастад үл хамаарагч хавьтаж шүргэхийн аргагүйчүүдийг нийгмийн байдлын нь хувьд авч үзвэл ялгаатай, мөн нохой, үхэр эсвэл заан зэрэг нь амьдралын өөр өөр хэлбэрт хамаарагддаг. Гэвч

трансценденталь гүн гүнзгий мэдлэгийг хүртсэн хүний нүдэнд иймэрхүү бие махбодийн ялгаа нь ямар ч ач холбогдол төрүүлдэггүй. Бурхан Өөрийн бүрэн хувилгаан дүр болох Параматма хэлбэрээр бүгдийн зүрхэнд залран байдаг учраас тэрээр бүгдийг Дээдийн Дээдтэй холбоотойгоор ийнхүү харж байдаг. Дээдийн Дээдийн тухай ийм ойлголт нь жинхэнэ мэдлэг болой. Бурхан амьд оршнол бүрийг ямар каст болон амьдралын ямар хэлбэрт байгаагаас үл хамааран найз нөхөр мэт үздэг тул бүгдэд адилхан эелдэг ялдам ханддаг. Амьд оршнолууд янз бүрийн нөхцөл байдалд оршиж байх боловч Бурхан Өөрийн байр сууриа тэр бүгдийн дотоодод залрах Параматма дүрээр үргэлж хадгалж байдаг. *Брахмана* болон кастад үл хамаарагчийн бие махбодиуд нь хэдийгээр өөр хоорондоо ялгаатай боловч Бурхан Параматма дүрээрээ *брахманы* ч, мөн кастад үл хамаарагчийн ч тэр, аль алины нь бие махбодид заларч байдаг. Бие махбодь нь материаллаг мөн чанарын янз бүрийн гунуудын материаллаг бүтээгдэхүүн байдаг ч бие махбодид оршин байх сүнс болон Дээд Сүнс, Параматма нь нэг ижил, бурханлаг шинж чанартай. Сүнс болон Параматма хоёр нь чанарын хувьд нэг ижил байдаг нь тэд хэмжээний хувьд мөн нэг адил байна гэсэн үг биш. Учир нь, сүнс зөвхөн тухайн нэг бие махбодид оршин байдаг бол Параматма нь бүхий л бие махбодиудад залран байдаг. Кришнаг ухамсарласан хүн энэ бүхнийг бүрэн ухаарсан байх тул тэр үнэнхүү гүн гүнзгий мэдлэгтэй байдаг бөгөөд бүгдийг нэг ижил байдлаар хардаг. Сүнс болон Дээд Сүнс хоёрын адил төстэй шинж тэмдэг нь бол хоёулаа ухамсартай, мөнхийн бөгөөд жаргал цэнгэлээр дүүрэн байдаг оршдог. Гэхдээ тэдний хоорондын ялгаа нь, бие даан орших сүнс нь зөвхөн өөрийн бие махбодиор хязгаарлагдмал хүрээнд ухамсарлаж байхад, Параматма бүхий бие махбодиудын хэмжээнд ухамсарлаж байдаг оршдог. Дээд Сүнс нь ямар ч ялгаварлалгүйгээр бүхий л бие махбодиудад залран байдаг.

ШҮЛЭГ 19

*йхайва тайр житах сарго ешам самье стхитам манах
нирдошам хи самам брахма тасмад брахмани те стхитах*

иха- энэ амьдралд, *эва*- гарцаагүй, *тайх*- тэднээр, *житах*- ялан дийлсэн, *саргах*- төрөлт болон үхэл, *ешам*- түүний, *самье*- тэнцвэртэй байдалд, *стхитам*- оршин байгаа, *манах*- ухаан, *нирдошам*- гэм нүгэлгүй, *хи*- тодорхой, *самам*- тогтвортой дөлгөөн байдал, *брахма*- Бүхний Дээд лугаа, *тасмат*- иймээс, *брахмани*- Бүхний Дээдэд, *те*- тэд, *стхитах*- орших.

Ухаан нь нэг л янзаар, тэнцвэрт байдлаар батажсан хүмүүс нь төрөлт үхлээр болзолдож нөхцөлдсөн байдлыг хэдийнээ ялан дийлсэн хэрэг. Тэд Брахман мэт гэм нүгэлгүй, өө сэвгүй тул хэдийнээ Түүнд оршдог.

ТАЙЛБАР: Ухааны тэнцвэр тогтвортой байдал нь, дээр өгүүлсэнчлэн, өөрийгөө бүрэн нээж танин мэдсэний шинж тэмдэг юм. Энэ түвшинд үнэхээрийн хүрсэн хүнийг бүхий л материаллаг болзолдож нөхцөлдсөн байдлыг, ялангуяа төрөлт болон үхлийг ялан дийлсэн сүнс гэж үзэх хэрэгтэй. Өөрийгөө бие махбодтойгоо адилтган үзэж байгаа цагт хүнийг болзолт сүнс гэж үзэх боловч өөрийн жинхэнэ оршнолыг таньж мэдэн тогтвор тэнцвэртэй байх түвшинд дээшлэн хүрснээр тэр болзолт амьдралаасаа ангижрах болно. Өөрөөр хэлбэл, энэ түвшинд хүрснээр тэр материаллаг ертөнцөд дахин төрөхгүй болдог бөгөөд үхлийн дараагаар бурханлаг тэнгэрт хүрч очих болно. Бурхан дурлан татагдах болон үзэн ядахаас ангид байх тул гэм нүгэлгүй байдаг. Амьд оршнол нь мөн дурлан татагдах болон үзэн ядахаас ангижрах аваас гэм нүгэлгүй болж улмаар бурханлаг тэнгэрт очих эрхтэй болно. Ийм хүмүүсийг хэдийнээ ангижирсан сүнснүүд гэж үзэх хэрэгтэй бөгөөд тэдний шинж чанарын талаар доор тодорхойлон өгүүлэх болно.

ШҮЛЭГ 20

*на прахришьет прям прапья подвижет прапья чапрям
стхира-буддхир асаммудхо брахма-вид брахмани стхитах*

на- үгүй, *прахришьет*- баярлаж хөөрдөг, *прям*- таатай зүйл, *прапья*- хүрсэнээр, *на*- үгүй, *удвижет*- өдөөгддөг, *прапья*- хүрсэнээр, *ча*- мөн, *апрям*- таагүй зүйл, *стхира-буддхир*- оюун ухаан нь өөртөө автан байх оюун ухаан, *асаммудха*- төөрөлддөггүй, *брахмавит*- Бүхний Дээдийг төгс төгөлдөр байдлаар таньж мэдэж байгаа, *брахмани*- трансценденталь түвшинд, *стхитах*- автдаг.

Таатай сайн зүйл тохиолдсон ч баярлаж хөөрдөггүй, таагүй муу зүйл тохиолдсон ч гуниж гутардаггүй, оюун ухаан нь сүнсэндээ автан байх, төөрөлдөж самуурдаггүй, Бурханы тухай эрдэм ухаанд нэвтэрхий болсон хүн аль хэдийнээ трансценденталь түвшинд оршин байдаг.

ТАЙЛБАР: Өөрийгөө бүрэн нээж, таньж мэдсэн хүний шинж тэмдгийн талаар энд тодорхойлон өгүүлж байна. Эхний шинж тэмдэг нь хүн өөрийн жинхэнэ “Би”-г бие махбодтойгоо андуу ташаагаар адилтган үзэх хий хуурмагт автдаггүй гэдэгт оршино. Тэр өөрөө бие махбодь биш, харин Бурханы Дээд Бодьгалын салшгүй, өчүүхэн жижиг хэсэг мөн гэдгээ сайн мэддэг. Тиймээс л тэр бие махбодтой нь холбоотой ямар нэгэн зүйл орж ирэхэд баярлаж хөөрдөггүй хийгээд алдагдан, гарз хохирол учирсан ч гуньж гутардаггүй. Ухааны энэхүү тогтвор тэнцвэртэй, үл ажирсан байдлыг *стхира-буддхи* буюу өөрийн оршнолоо ойлгож ухаарч танин мэдсэн оюун ухаан гэж нэрлэдэг. Ийм шинж чанартай хүн нь өөрийн бүдүүн бие махбодийг сүнс хэмээн үзэж самуурч төөрөлддөггүй. Учир нь тэр бие махбодио түр зуурын гэж үздэгтэйгээ адил сүнсний оршнолыг анхаарлаасаа гадуур орхидоггүй. Энэхүү мэдлэг нь түүнийг Үнэмлэхүй Үнэний тухайлбал, Брахманы, Параматмын болон Бхагаваны тухай эрдэм ухааныг бүрэн ойлгох түвшинд хүргэдэг. Тийм учраас тэр өөрийн жинхэнэ байр суурийг маш тодорхой ойлгож ухаардаг бөгөөд Дээдийн Дээдтэй бүхий л талаараа нэг адил ижил байх гэж андуу ташаагаар чармайн оролддоггүй. Үүнийг Брахманыг

таньж мэдэх буюу өөрийгөө бүрэн нээж танин мэдэх гэдэг. Ийм тогтвортой ухамсрыг Кришнагийн ухамсар гэж нэрлэдэг.

ШҮЛЭГ 21

*бахья-спаршешв асактатма виндатй атмани ят сукхам
са брахма-йога-юктатма сукхам акшаям ашнута*

бахья-спаршешу- мэдрэхүйн гадаад баяр хөөр, *асактатма*- үл дурлан татагдсан хүн, *виндати*- таашаал ханамж эдэлдэг, *атмани*- өөртөө, *ят*- тэр, *сукхам*- аз жаргал, *сах*- тэр, *брахма-йога*- Брахманд төвлөрүүлснээр, *юкта-атма*- өөртэйгөө холбогдсон, *сукхам*- аз жаргал, *акшаям*- хязгааргүй, *ашнута*- таашаадаг.

Ангиралыг олсон ийм хүн материаллаг мэдрэхүйн баяр хөөр, таашаал ханамжинд дурлан татагдалгүй, харин байнгад трансад умбан дотооддоо баяр цэнгэлийг эдэлж байдаг. Өөрийгөө бүрэн нээж танин мэдсэн хүн Бүхний Дээдэд төвлөрөн байх учир тэр ийнхүү хязгааргүй их аз жаргалаар бялхан байдаг.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсар дахь аугаа их чин бишрэлтэн Шри Ямуначарья хэлэхдээ:

*яд-авадхи мама четах кришна-падаравинде
нава-нава-раса-дхаманй удьятам рантум асит
тад-авадхи бата нари-сангаме смарьямане
бхавати мукха-викарах суштху ништхиванам ча*

“Кришнагийн трансценденталь хайраар дүүрэн бялхах алба үйлэнд үйлчлэн зүтгэж эхэлсэн цагаасаа эхлэн би Түүнээс баяр цэнгэлийг үргэлж шинээр амталж мэдэрч байна. Бэлгийн таашаалын тухай бодол орж ирэх бүрд би энэ бодлыг нулиман хаядаг бөгөөд ийнхүү жигшин зэвүүцсэний улмаас миний уруул хүртэл мурчийн татвалздаг билээ.”

Брахма-йогын зам мөрөөр замнах буюу өөрөөр хэлбэл, Кришнагийн ухамсарт оршин байгаа хүн Кришнад чин хайраар зүтгэх үйлд гүнээ автсан байдаг учраас түүний материаллаг мэдрэхүйн таашаал ханамжийг амтлах аливаа хүсэл нь үгүй болдог. Материаллаг таашаал ханамжуудаас хамгийн дээд нь бэлгийн таашаал байдаг. Бүхий л дэлхий ертөнц түүний ид шидийн хүчийн доор эргэлдэж байдаг бөгөөд ямар ч материалист хүн энэхүү учир шалтгаангүйгээр үл хөдлөнө, үл ажиллана. Харин Кришнагийн ухамсарт оршин байгаа чин бишрэлтэн бэлгийн дур хүсэлдээ хөтлөгдөлгүйгээр, харин ч эсрэгээр түүнээс бүрмөсөн холдон хөндийрч бүр илүү их эрчтэйгээр ажиллаж чаддаг. Бурханлаг танин мэдэхүй болон бэлгийн таашаал ханамж хоёр нь хоорондоо үл нийцэж зохицох учраас энэ нь өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн шалгуур болдог. Кришнаг ухамсарласан хүн нь ангиралд хүрсэн сүнс мөн болох тул тэрээр мэдрэхүйн таашаал ханамжийн ямар ч төрөлд дурлан татагддаггүй.

ШҮЛЭГ 22

*е хи самспарша-жа бхога духкха-йоная зва те
адй-антавантах каунтея на тешу рамате будхах*

е- тэр, *хи*- тодорхой, *самспарша-жа*- материаллаг мэдрэхүйтэй хүрэлцсэнээр, *бхогах*- таашаал ханамж, *духкха*- зовлон гуниг, *йонаях*- эх булгаас, *зва*- гарцаагүй, *те*- тэд бол, *ади*- эхлэл, *анта*- төгсгөл, *вантах*- эрхшээлд орсон, *каунтея*- Кунтийн хүү минь, *на*- хэзээ ч үгүй, *тешу*- эдгээрт, *рамате*- баяр хөөрийг олох, *будхах*- ухаалаг хүн.

Оюунлаг хүн нь материаллаг мэдрэхүйтэй холбогдсоноос үүсэн гарах зовлон зүдгүүрийн үүсвэр-эх булгаас хутган авдаггүй. Ай Кунтийн хүү минь ээ, иймэрхүү баяр цэнгэл нь эхлэл, төгсгөлтэй байдаг учир мэргэд нь тэдгээрт хууртан уруу татагдан баярлаж баясдаггүй.

ТАЙЛБАР: Материаллаг мэдрэхүйн баяр цэнгэл нь цаг зуурын материаллаг мэдрэхүйтэй холбогдсоноос бий болдог. Бие махбодь нь өөрөө түр зуурын байдаг учир мэдрэхүй нь мөн л түр зуурын юм. Ангиралд хүрсэн сүнс нь цаг зуурын байх ямар ч зүйлд дурлан татагддаггүй. Трансценденталь баяр цэнгэлийн аз жаргалтай байдлыг амсаж мэдсэн ангиралд хүрсэн сүнс нь хуурамч баяр цэнгэлд юу боллоо гэж татагдах билээ дээ. Падма Пуранад өгүүлэхдээ:

*раманте йогино `нанте сатьянанде чид-атмани
ити рама-паденасау парам брахмабхидхияте*

“Иогчид нь Үнэмлэхүй Үнэнээс хэмжээлшгүй их трансценденталь баяр цэнгэлийг утган авч байдаг тул дээдийн дээд Үнэмлэхүй Үнэн, Бурханы Бодьгал нь мөн Рама хэмээн алдаршсан.”

Мөн Шримад Бхагаватамын (5.5.1)-д өгүүлэхдээ:

*наям дехо деха-бхажам нри-локе
каштан каман архате вид-бхужам е
тапо дивьям путрака ена саттвам
шуддхьед ясмад брахма-саукхьям тв анантам*

“Миний хайрт хүүхдүүд минь ээ, энэхүү хүний амьдралын хэлбэрт мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн төлөө нөр их хүч гарган ажиллах ямар ч учир байхгүй билээ. Иймэрхүү таашаал ханамж, баяр цэнгэл нь ялгадас идэгч (гахай)-д л байж болохуйц зүйл. Түүний оронд *тапаса*-тэвчил хатамжлалын амьдралаар амьдран өөрийн оршихуйг ариусгах хэрэгтэй бөгөөд үүнийхээ үр дүнд л та нар хэмжээлшгүй их трансценденталь жаргал цэнгэлийг эдлэх болно.”

Иймээс, жинхэнэ иогчид болон гүн гүнзгий мэдлэгтэй трансценденталистууд нь материаллаг оршихуйн үргэлжлэн байхын учир шалтгаан болох мэдрэхүйн таашаал ханамжинд огтхон ч дурлан татагддаггүй билээ. Материаллаг таашаал ханамж, баяр цэнгэлд хэдийчинээн ихээр дурлан татагдана, материаллаг зовлон зүдгүүрт төдийчинээн ихээр орооцолдох болно.

ШҮЛЭГ 23

*шакнотихайва ях содхум прак шарира-вимокшанат
кама-кродходбхавам вегам са юктах са сукхи нарах*

шакноти- чадвартай, *иха эва*- энэ бие махбодид, *ях*- тэр, *содхум*- тэсвэрлэх, *прак*- өмнө, *шарира*- бие махбодийг, *вимокшанат*- орхисноор, *кама*- шунал тачаал, *кродха*- уур хилэн, *удбхавам*- үүссэн, *вегам*- шахалт даралт, *сах*- тэр, *юктах*- трансд, *сах*- тэр, *сукхи*- аз жаргалтай, *нарах*- хүн.

Хэрвээ хүн энэхүү бие махбодио орхихоос өмнө материаллаг мэдрэхүйн шавдалт шаардлагыг сөрөн зогсож, өөрийн шунал тачаал хийгээд уур хилэнг барьж сурах аваас илүү баталгаатай байр суурийг эзлэн, энэхүү материаллаг ертөнцөд аз жаргалтайгаар амьдрах болно.

ТАЙЛБАР: Өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн замаар итгэлтэй урагшлахыг хүсэж байгаа хүн материаллаг мэдрэхүйн шавдалт, шахалтыг эзэмдэн захирахыг хичээх хэрэгтэй. Үг ярианы, уур хилэнгийн, ухааны, ходоодны, бэлгийн, хэлний шавдалт, шахалт гэж байдаг. Энэ бүх мэдрэхүйн шавдалт, шахалтыг хийгээд мөн ухаанаа эзэмдэн захирах чадвартай хүнийг *госвами* эсвэл *свами* гэж нэрлэдэг. Ийм *госвами* нь мэдрэхүйн шавдалт шаардлагыг замаасаа бүрэн зайлуулж, маш нарийн хатуу чанд дэг журам, зохицуулалт бүхий амьдралаар амьдардаг. Материаллаг хүсэл хангагдаж биелэгдээгүйн улмаас уур хилэн бадардаг учраас ухаан, нүд, цээж нь өдөөгдөн оволздог. Иймээс энэхүү бие махбодио орхихоос өмнө мэдрэхүйгээ эзэмдэн захирч сурах хэрэгтэй. Энэхүү чадварыг эзэмшсэн байх хэн бүхнийг өөрийгөө бүрэн нээж танин мэдсэн гэж үзэх хэрэгтэй бөгөөд тэрээр өөрийгөө таньж мэдсэн энэхүү төлөв байдалдаа аз жаргалтай байдаг. Шунал тачаал болон уур хилэнгээ эзэмдэн захирахын төлөө бүх хүч чадлаараа чармайх нь трансценденталь хүний үүрэг байдаг.

ШҮЛЭГ 24

*йо `нтах-сукхо `нтар-арамас татхантар-жьотир эва ях
са йоги брахма-нирванам брахма-бхута `дхигагчхати*

ях- тэр, *антах-сукхах*- дотооддоо аз жаргалтай, *антах-арамах*- дотооддоо идэвхтэй таашаан байгаа, *татха*- мөн тэрчлэн, *антах-жьотих*- дотооддоо чиглэгдсэн, *эва*- гарцаагүй, *ях*- тэр, *сах*- тэр, *йоги*- трансценденталист, *брахма-нирванам*- Бүхний Дээдэд ангижрахуй, *брахма-бхутах*- өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн түвшинд, *адхигагчхати*- хүрдэг.

Аз жаргал, ажил үйл, баяр хөөрөө өөрийн дотоодоосоо олохын зэрэгцээ зорилго нь мөн өөрийн нь дотоодод байх хэн бүхэн жинхэнэ төгс төгөлдөр иогч. Тэр Дээдийн Дээдэд ангижралыг олох бөгөөд эцэстээ Дээдийн Дээдэд хүрэх болно.

ТАЙЛБАР: Өөрийн дотоод дахь аз жаргал, цэнгэлээ амталж мэдээгүй байгаа цагт хүн өнгөцхөн аз жаргал, цэнгэлийг хайх гадагш чиглэсэн материаллаг үйлээсээ хэрхэн татгалзаж чадах билээ. Ангижралд хүрсэн хүн аз жаргалыг үнэхээрийн бодитойгоор эдэлж байдаг. Тэр хаа дуртай газраа тайван суугаад өөрийн дотоод дахь амьдралын үйлээрээ цэнгэн жаргаж чаддаг. Ангижралд хүрсэн ийм хүн гадаад, материаллаг аз жаргалын хойноос огтхон ч хүсэж тэмүүлдэггүй. Энэхүү төлөв байдлыг *брахма-бхута* гэдэг бөгөөд энэ түвшинд хүрсэн хүн Бурханы зүг, буцаад гэр лүүгээ хүрч очих нь баталгаатай болсон байдаг.

ШҮЛЭГ 25

*лабханте брахма-нирванам ришаях кишина-калмашах
чхинна-двайдха ятатманах сарва-бхута-хите ратах*

лабханте- хүрэх, *брахма-нирванам*- Бүхний Дээдэд ангижрахуй, *ришаях*- дотооддоо идэвхтэй байгаа, *кишина-калмашах*- бүхий л нүглээс ангид байх, *чхинна*- тасалсанаар, *двайдхах*- хоёрдмол байдал, *ята-атманах*- өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйд зүтгэдэг, *сарва-бхута*- бүхий л амьд оршнолуудын төлөө, *хите*- ач тус болох үйлд, *ратах*- ажилладаг.

Эргэлзээ тээнгэлзээнээс үүдэн бий болох хоёрдмол байдлын чанадад оршин, ухаанаа өөрийн дотоод үйлэндээ чиглүүлэн, бүхий л амьд оршнолуудын сайн сайхан, ач тусын төлөө үйл үйлдэх хийгээд аливаа нүглээс ангид байх хүн л Дээдийн Дээдэд ангижралыг олдог.

ТАЙЛБАР: Кришнаг бүрэн ухамсарласан хүнийг л бүх амьд оршнолуудын тусын тулд үйл ажиллагаагаа явуулж байдаг гэж хэлж болно. Кришна бол бүхний анхдагч эх булаг гэж үнэхээрийн ойлгож ухаарсан хийгээд ийм ухамсартайгаар үйлээ үйлдэж байгаа хүн л бүгдийн төлөө үйл ажиллагаагаа явуулдаг. Кришна бол дээдийн дээд таашаан цэнгэгч, дээдийн дээд эзэмшигч, дээдийн дээд найз нөхөр гэдгийг мартсанаас болж хүн төрөлхтөн зовж шаналж байдаг. Тийм учраас энэхүү ухамсарыг нийт хүн төрөлхтөний дунд дахин сэргээхийн тулд үйлдэж буй үйл нь дээдийн дээд ач тустай үйл юм. Дээдийн Дээдэд ангижралыг олоогүй хүн ийм тэргүүн зэргийн ач тустай үйл ажиллагаагаа явуулж чадахгүй. Кришнаг ухамсарласан хүн Түүний дээд байр сууринд огтхон ч эргэлздэггүй. Ийм хүн бүхий л нүглээс бүрэн ангид байх тул тэр талаар бат итгэлтэй байдаг. Энэ бол бурханлаг хайрын түвшин.

Хүн төрөлхтөний зөвхөн бие махбодийн эрүүл энх, сайн сайхны төлөө чармайн зүтгэж байгаа хүн нь үнэн хэрэгтээ хэнд ч тус болж чадахгүй. Гадаад бие махбодь болон ухааны зовлон шаналалыг түр зуур хөнгөлөн амсхийлгэх нь хангалттай биш юм. Амьдрал оршнолын төлөөх хатуу ширүүн тэмцлийн явцад учрах хүндрэл бэрхшээлүүдийн жинхэнэ учир шалтгаан нь хүмүүс Бүхний Дээд Бурхантай холбогдсон өөрсдийн холбоо харьцаагаа мартсанд л оршдог. Кришнаатай холбогдсон өөрийн холбоо харьцааг бүрэн ухаарсан хүн материаллаг бие махбодид оршин байгаа ч үнэн хэрэгтээ ангижралыг олсон сүнс байдаг билээ.

ШҮЛЭГ 26

*кама-кродха-вимуктанам ятинам ята-четасам
абхито брахма-нирванам вартате видитатманам*

кама- шунал тачаалаас, *кродха-* болон уур хилэн, *вимуктанам-* ангижирсан байгаа, *ятинам-* ариун гэгээн хүмүүсийн, *ята-четасам-* ухаанаа бүрэн хяналтандаа авсан, *абхитах-* ойрын ирээдүйд, *брахма-нирванам-* Бүхний Дээдэд ангижрахуй, *вартате-* байдаг, *видита-атманам-* өөрийгөө бүрэн нээж танин мэдэгсэдээс.

Уур хилэн болон бүхий л материаллаг хүслээсээ салж, өөрийгөө бүрэн нээн танин мэдэж, эзэмдэж чадсан бөгөөд төгс төгөлдөрт хүрэхийн тулд байнга чармайж байгаа хүн мөдхөн Дээдийн Дээдэд ангижралыг олох болно.

ТАЙЛБАР: Ангижралд хүрэхийн тулд хэлбэрэлт гуйвалтгүй чармайн байгаа ариун гэгээн хүмүүсийн дундаас Кришнагийн ухамсарт оршин байгаа нь хамгийн эрхэм, шилдэг нь бөлгөө.

Үүнийг Шримад Бхагаватамын (4.22.39)-д дараах байдлаар батлан өгүүлсэн байдаг:

*ят-пада-панкажа-палаша-виласа-бхактья
кармашаям гратхитам удератхаянти сантах
тадван на рикта-матайо ятайо `пи рудхха-
срото-ганас там аранам бхажа васудевам*

“Бурханы Дээд Бодьгал Васудевад чин бишрэлээр үйлчлэн зүтгэснээр өөрийн бишрэл хүндэтгэлээ илэрхийлэхийг л чармай. Аугаа их мэргэд хүртэл, Бурханы бадамлянхуа өлмийд үйлчлэн зүтгэж, кармын үйлийн хойноос тэмүүлэх гүн гүнзгий суусан үндсийг таслан трансценденталь жаргал цэнгэлд умбан байгаа хүмүүсийн адил өөрсдийн мэдрэхүйн шавдалт захалтыг эзэмдэн захирах чадваргүй байдаг.”

Үйлийнхээ үр дагавраар таашаал ханамж эдлэх гэсэн хүсэл нь болзолт сүнсэнд маш гүн бат үндэс мэт суусан байдаг тул аугаа их мэргэд хүртэл үлэмж их хүчин чармайлт гаргадаг ч энэхүү хүслээ эзэмдэн захирахад маш хүнд байдаг. Харин Кришнагийн ухамсарт байнга зүтгэх бөгөөд өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн төгс төгөлдөр түвшинд хүрсэн байх чин бишрэлтэнгүүд нь маш хурднаар Дээдийн Дээдэд ангижралыг олдог. Тэрээр өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн талаарх төгс төгөлдөр мэдлэгийг хүртсэн байдаг учир трансд байнгад автан умбаж байдаг. Үүнтэй холбогдсон нэг сайхан жишээ сударт байдаг:

*даршана-дхьяна-сампаршайр матсья-курма-вихангамах
сванй апатьяни пушнанти татхахам апи падма-жа*

“Загас, яст мэлхий болон шувуу нь зөвхөн дан ганц харах, бодох (бясалгах) болон дарах (хүрэх) байдлаар л өөрсдийн үр удмаа халамжилж, санаа тавин өсгөж байдаг. Ай Падмажа минь дээ, би ч гэсэн мөн үүний нэг адил шүү дээ.”

Загас үр удмаа зөвхөн харж л өсгөдөг, харин яст мэлхий тэдний тухай зөвхөн бодож бясалган байж өсгөдөг. Яст мэлхий өндөгнүүдээ хуурай газарт булчихаад өөрөө усандаа буцаж ирэн, тэндээс, зайнаас тэднийхээ тухай бодож бясалгаж байдаг. Үүний нэгэн адил Кришнагийн ухамсарт орших чин бишрэлтэн нь Бурханы залран байх орноос алсын алсад байх боловч Түүний тухай байнгад бясалган бодсоор буюу Кришнагийн ухамсарт зүтгэн байснаар тийшээ хүрч очих болно. Тэр материаллаг амьдралын зовлон шаналалыг анзаарч мэдрэхээ больдог. Амьдралын энэ түвшинг *брахма-нирвана* буюу Дээдийн Дээдийг байнгад бясалгаснаар материаллаг зовлон шаналалаас хагацахуй гэж нэрлэдэг.

ШҮЛЭГ 27-28

спаршан критва бахир бахьями чакшуш чайвантаре бхрувох

ятендрия –мано-буддхир мунир мокша-параянах
вигатеччха-бхая-кродхо ях сада мукта эва сах

спаршан- дуу авиа зэрэг мэдрэхүйн объектууд, *критва*- барьснаар, *бахих*- гадаад, *бахьян*- хэрэггүй дэмий, *чакшух*- нүднүүд, *ча*- мөн, *эва*- гарцаагүй, *антаре*- хооронд, *бхрувох*- хөмсөг, *прана-апанау*- дээш болон доош урсах хий, *самау*- тогтвортой, *критва*- барьснаар, *наса-абхьянтара*- хамрын нүхэнд, *чаринау*- үлээн, *ята*- эзэмдэн захирдаг, *индрия*- мэдрэхүй, *манах*- ухаан, *буддхих*- оюун ухаан, *муних*- трансценденталист, *мокша*- ангижралын төлөө, *параянах*- зориулагддаг, *вигата*- орхиж татгалзсанаар, *иччха*- хүсэл шунал, *бхая*- айдас хүйдэс, *кродхах*- уур хилэн, *ях*- тэр, *сада*- үргэлж, *муктах*- ангижирдаг, *эва*- гарцаагүй, *сах*- тэр бол.

Мэдрэхүйн бүх гадаад объектоос холдон хөндийрч, харцаа хоёр хөмсөгний хооронд төвлөрүүлж, орох гарах амьсгалаа хамрын нүхэндээ тогтоон барьж, мэдрэхүй, ухаан, оюун ухаанаа эзэмдэн захирсанаар трансценденталист нь ангижралд хүрэхээр тэмүүлэх явцдаа хүсэл шунал, айдас хүйдэс, уур хилэнгийн эрхшээлээс гардаг. Ийм байдалд байнгад оршин байх хэн бүхэн ангижралд хүрсэн нь ойлгомжтой.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсрын зам мөрөөр замнах хэн бүхэн мөдхөн, өөрийн жинхэнэ бурханлаг мөн чанараа ойлгох бөгөөд дараа нь чин бишрэлийн алба, үйлэнд зүтгэснээр Бүхний Дээд Бурханыг мөн ойлгож ухаарах болно. Чин бишрэлээр зүтгэх үйлэнд улам бүр татагдан автсанаар тэр Бурханы оршин байгааг өөрийн бүхий л үйлдээ мэдрэх трансценденталь түвшинд хүрдэг. Ийм түвшинд хүрэхийг Дээдийн Дээдэд ангижралыг олох гэж нэрлэдэг.

Дээдийн Дээдэд ангижралыг олох дээр дурьдсан зарчмуудыг тайлбарласны дараагаар Бурхан Аржунад, энэ түвшинд *аштанга-йога* гэж нэрлэгдэх ид шидэт иогийн тусламжтайгаар хэрхэн хүрч болох тухай сургаал хайрлаж байна. Энэ иог нь *яма*, *нияма*, *асана*, *пранаяма*, *пратьяхара*, *дхарана*, *дхьяна* болон *самадхи* гэсэн нэр бүхий найман үе шатаас бүрддэг. Зургаа дугаар бүлэгт энэ иогийн талаар дэлгэрэнгүй тодорхой өгүүлэх болно. Харин энд, тав дугаар бүлгийн төгсгөлд энэ талаар зөвхөн урьдчилсан байдлаар л товчхон тайлбарыг өгч байна. *Пратьяхара-йогын* үйл явцад дуу авиа, хүртэхүй, хэлбэр, амт болон үнэр зэрэг мэдрэхүйн объектуудаас салан хөндийрэх хэрэгтэй бөгөөд харцаа хөмсөгний хооронд чиглүүлэн нүдээ хагас анин хамрын үзүүрт төвлөрүүлдэг. Нүдээ бүр аниснаар хүн унтачихаж магадгүй тул ингэх нь ач тусгүй юм. Мөн нүдээ бүрмөсөн нээснээр анхаарал мэдрэхүйн объектуудад татагдах аюул учирч болзошгүй. Бие махбодь дахь өгсөж-уруудаж буй хийн урсгалыг саармагжуулснаар хамрын нүхэн дотроо амьсгалаа тогтоон барьж байх хэрэгтэй. Энэ иогийн арга замын тусламжтайгаар хүн мэдрэхүйгээ эзэмдэж захиран, мэдрэхүйн гадаад объектуудаас холдон хөндийрэх чадвартай болж улмаар өөрийгөө Дээдийн Дээдэд ангижрахад бэлтгэдэг.

Иогийн энэ үйл явц нь хүнийг айдас хүйдэс хийгээд уур хилэнгийн бүхий л хэлбэрүүдээс салж ангижрахад туслах бөгөөд тэгснээр тэр Параматмаг оршин байгааг трансценденталь түвшинд мэдрэх болно. Өөрөөр хэлбэл Кришнагийн ухамсар нь иогийн зарчмуудыг гүйцэтгэн хэрэгжүүлэхэд хамгийн хялбар арга болох юм. Энэ тухай дараагийн бүлэгт тодорхой тайлбарлах болно. Кришнаг ухамсарласан хүн чин бишрэлийн үйлэнд байнгад зүтгэж байдаг учраас түүний хувьд, мэдрэхүйнүүд нь ямар нэгэн өөр үйлд татагдан хөтлөгдөх аюул учирдаггүй. Тийм учраас мэдрэхүйгээ удирдан залахад энэ арга нь *аштанга-йогоос* илүү сайн юм.

ШҮЛЭГ 29

бхоктарам ягья-тапасам сарва-лока-махешварам
сукридам сарва-бхутанам гьятва мам шантим риччхати

бхоктарам- таашаан цэнгэгч, *ягья*- тахилга өргөлийн, *тапасам*- тэвчил наманчлал, *сарва-лока*- бүхий л гаригууд болон тэдгээр дээрх сахиулсан тэнгэрүүд, *маха-ишварам*- Бүхний Дээд Бурхан, *су-хридам*- сайныг хийгч, *сарва*- бүгдийн, *бхутанам*- амьд оршнол, *гьятва*- ийм байдлаар таньж мэдсэнээр, *мам*- Намайг, *шантим*- бүхий л материаллаг зовлон зүдгүүрийн хөнгөлөл, *риччхати*- хүрдэг.

Намайг бүрнээ ухааран, Би бол бүх өргөл болон тэвчлийн дээдийн дээд таашаагч, Би бол бүх гаригууд, сахиулсан тэнгэрүүдийн дээдийн дээд эзэн бөгөөд бүх амьд оршнолуудын сайн санаат найз нөхөр хийгээд ивээгч нь гэдгийг мэдэх хүн л материаллаг зовлон зүдгүүрээс ангижирч бүрэн амар амгаланд хүрдэг.

ТАЙЛБАР: Хий хуурмагийн эрчмийн олзонд орсон болзолт сүнснүүд нь материаллаг ертөнцөд тайван амгаланг олохыг чармайх боловч Бхагавад Гитагийн энэ хэсэгт тайлбарласан байх түүний томъёолол, жорыг нь мэддэггүй. Тайван амгалангийн тухай хамгийн сайн томъёолол бол: Шри Кришна нь бүх амьд оршнолуудын бүх үйлийн үр дүнг таашаагч юм. Бурхан бүх гаригууд хийгээд эдгээр гаригууд дээр оршин байх бүх сахиулсан тэнгэрүүдийн эзэн захирагч мөн тул өөрт байгаа бүхнийг Түүний трансценденталь албанд зориулан өргөх хэрэгтэй. Түүнээс аугаа хэн ч байдаггүй. Тэр хамгийн аугаа сахиулсан тэнгэрүүд болох Брахма, Шива нараас ч илүү аугаа. Ведэд (Шветашватара-упанишад 6.7) Бүхний Дээд Бурханыг *там ишваранам парамам махешварам* хэмээн тодорхойлон өгүүлсэн байдаг. Хий хуурмагийн нөлөөнд автсан амьд оршнол нь өөрийн хараанд өртсөн бүхнийг ноёлон захирч эзэн нь болохыг чармайх боловч үнэн хэрэгтээ, харин тэр өөрөө Бурханы материаллаг эрчмийн эрхшээл захиргаан доор байдаг. Бурхан бол материаллаг мөн чанарын эзэн бөгөөд болзолт сүнснүүд нь түүний хатуу чанга хуулиудад захирагдаж байдаг. Энэхүү энгийн хялбар байдлуудыг ойлголгүйгээр энэ ертөнцөд хувь хүний хувьд ч тэр, нийгмийн хувьд ч тэр тайван амгаланг олно гэдэг боломжгүй хэрэг юм. Кришнагийн ухамсрын гол утга санаа нь: Шри Кришна бол дээдийн дээд эзэн, харин амьд оршнолууд, түүний дотор аугаа их сахиулсан тэнгэрүүд хүртэл бүгд

Түүний албатууд, захирагдагсад юм. Төгс төгөлдөр амар амгаланг зөвхөн Кришнагийн төгс төгөлдөр ухамсарт л хүрч болно.

Тав дугаар бүлэг нь *карма-йога* гэж нэрлэгдсэн Кришнагийн ухамсрын практик талын тайлбаруудаас бүрдэж байна. Энд *карма-йога* нь ангижралд хэрхэн хүргэдэг талаар ухаан бодлын цэцэрхийллээр хөөцөлдөгчдийн зүгээс тавьж байдаг асуултанд хариулт өгч байна. Кришнагийн ухамсарт үйл үйлдэнэ гэж, Бурхан бол бүхний дээдийн дээд захирагч мөн болох тухай төгс төгөлдөр мэдлэг дээр үндэслэж тулгуурлан үйл үйлдэхийг хэлдэг. Ийм үйл нь трансценденталь мэдлэгээс огт өөрцгүй юм. *Бхакти-йога* нь Кришнагийн шууд ухамсар болох бөгөөд, харин *гьяна-йога* нь *бхакти-йогад* хүргэх зам мөр юм. Кришнагийн ухамсар гэдэг нь дээдийн дээд Үнэмлэхүйтэй холбогдсон өөрийн холбоог бүрэн ухамсарласны үндсэн дээр үйлдэх үйлийг хэлэх бөгөөд энэхүү ухамсарын төгс төгөлдөр нь Бурханы Дээд Бодьгал Кришнагийн тухай бүрэн төгс мэдлэгийг хүртэхэд оршдог. Цэвэр ариун сүнс нь Бурханы салшгүй жижиг хэсэг байдлаар Түүнд мөнхөд үйлчлэн зүтгэж байдаг. Харин тэр хий хуурмаг буюу *майа-э* эрхшээлдээ оруулан захирах гэсэн хүсэлдээ хөтлөгдөн хий хуурмагтай хутгалдан зууралдах аваас энэ нь түүнтэй учрах зовлонгийн учир шалтгаан болдог. Сүнс нь материтай холбоотой байгаа цагт тэр өөрийн материаллаг хэрэгцээг хангахын хойноос хөөцөлдөх хэрэгтэй байдаг. Кришнагийн ухамсар нь материаллаг ертөнцөд бурханлаг оршихуйг практик үйлээр дахин сэргээдэг учир амьд оршнолыг материйн хяналт эрхшээлд байсан ч бурханлаг амьдралын түвшинд дээшлүүлэн хүргэдэг. Хүн Кришнагийн ухамсарт ахиц дэвшил гаргахын хирээр материаллаг хүлээс, гинж тушаанаасаа төдий чинээн салж чөлөөлөгдөж байдаг. Бурхан хэн бүхэнд алагчлалгүй ханддаг. Өөрийн үүргээ Кришнагийн ухамсарт хэрхэн бодитойгоор биелүүлж байгаагаас бүх зүйл хамаардаг учраас Кришнагийн ухамсрын арга зам нь хүнд мэдрэхүйгээ бүхий л талаар эзэмдэн захирах болон шунал тачаал, уур хилэнгээ ялан дийлэхэд тусалдаг. Кришнагийн ухамсарт ийнхүү батжин бэхжсэн хийгээд дээр дурьдсан хүсэл тачаалаа эзэмдэн захирсан байх хүн трансценденталь буюу *брахма-нирваны* түвшинд үнэхээрийн оршиж байдаг. Кришнагийн ухамсарт орших хүн найман шатлалт мистик иогийн зам мөрийн эцсийн зорилгод шууд хүрсэн байдаг тул энэхүү иог нь Кришнагийн ухамсарт давхар агуулагдаж, багтсан байдаг. *Яма, нияма, асана, пранаяма, пратьяхара, дхарана, дхьяна* болон *самадхи* гэсэн найман шатыг дамжсанаар хүн аажим аажмаар ахиц дэвшил гаргах боловч энэ нь чин бишрэл дүүрэн бялхах алба, үйлэнд зүтгэснээр хүрдэг төгс төгөлдөр түвшингийн зөвхөн өмнөх үе шатууд байдаг юм. Зөвхөн чин бишрэлийн алба л хүнийг амар амгаланд хүргэнэ. Энэ бол амьдралын дээдийн дээд төгс төгөлдөр бөлгөө.

Шримад Бхагавад Гитагийн "Карма-йога – Кришнагийн ухамсар дахь үйл" нэртэй тав дугаар бүлэгт Бхактиведантын хийсэн тайлбар ийнхүү өндөрлөлөө.

ЗУРГАА ДУГААР БҮЛЭГ

Дхьяна-йога

ШҮЛЭГ 1

шри бхагаван увача

анашритах карма-пхалам карьям карма кароти ях

са санньяси ча йоги ча на нирагнир на чакриях

шри бхагаван увача- *Бурханы Дээд Бодьгал айлдсан нь, анашритах- аврал өмгөөлөл эрэлгүйгээр, карма-пхалам- ажил үйлийн үр дүнгийн, карьям- үүрэг байдлаар, карма- үйл, кароти- биелүүлдэг, ях- тэр, сах- тэр, санньяси- огоорохуйн амьдралын түвшинд амьдрагч, ча- мөн, йоги- ид шидтэн, ча- мөн, на- үгүй, них- -гүй, агних- гал, на- үгүй, ча- мөн, акриях- өөрийн үүргийг үл биелүүлэгч.*

Бурханы Дээд Бодьгал айлдсан нь: Үйлдэж байгаа үйлээ үр дүнд нь татагдалгүй, өөрт оноогдсон үүрэг байдлаар биелүүлж байгаа хүн нь огоорохуйн түвшинд амьдарч байдаг. Тэр бол жинхэнэ шидтэн ба гэрэл ба гал биш мөн үүргээ үл биелүүлэгч нэгэн биш.

ТАЙЛБАР: Бурхан энэ бүлэгт найман шатлалт *йогын* систем нь ухаан хийгээд мэдрэхүйгээ эзэмдэн захирахад зориулагдсан арга хэрэгсэл гэдгийг тайлбарлана. Гэхдээ энэхүү арга замыг дагаж мөрдөх нь ихэнхи хүмүүсийн хувьд, ялангуяа Калийн энэ цаг үед маш хүнд. Хэдийгээр энэ бүлэгт Бурхан найман шатлалт *йогын* талаар танилцуулж байгаа ч *карма-йогын* арга буюу Кришнагийн ухамсар дахь үйл нь түүнээс илүү дээр гэдгийг онцлон тэмдэглэж байна. Энэ дэлхий дээрх хүн бүр өөрийн гэр бүл болон түүнд хамаарагдах бүхнийг энх мэнд, элбэг дэлбэг байлгахын төлөө ажиллаж байдаг. Өөрийнх нь эсвэл ойрын хүрээллийнхнийх нь сонирхол, таашаал ханамжинд нь шууд эсвэл шууд биш байдлаар үл нийцэж байвал хэн ч ажилладаггүй. Үйлийнхээ үр дүнгээр таашаал ханамж эдлэх гэсэн хүслээс ангид, Кришнагийн ухамсарт үйл үйлдэж байх нь төгс төгөлдөрийн шалгуур болж байдаг. Амьд оршнолууд нь мөн чанарын хувьд Бүхний Дээдийн салшгүй өчүүхэн жижиг хэсгүүд учир Кришнагийн ухамсарт үйл ажиллагаагаа явуулж байх нь тэдний үүрэг байдаг. Бие махбодийн эрхтэн хэсгүүд нь цогц бие махбодийнхоо тусын тулд ажиллаж байдаг. Тэд зөвхөн өөр өөрсдийн хувийн таашаал ханамжийн төлөө бус харин бүхэл бүтэн цогц бие махбодидоо таашаал ханамж эдлүүлэхийн тулд хамтран ажилладаг. Үүний нэгэн адил, өөрийн таашаал ханамжийн төлөө бус, дээдийн дээд Бүрэн Бүтэнийг цэнгүүлэхийн тулд үйл ажиллагаагаа явуулж байгаа хүнийг төгс төгөлдөр *санньяси*, төгс төгөлдөр иогч гэж үздэг.

Зарим *санньясууд* нь өөрсдийгөө бүхий л материаллаг үүргээсээ чөлөөлөгдсөн гэж зохиомлоор андуу ташаа бодсоноор *агнихотра-ягья* буюу галан тахилга өргөлөө үйлдэхээ больдог. Гэвч үнэн хэрэгтээ энэ нь тэдний бодьгал бус Брахманд уусан нэгдэх зорилгоос үүдэн гарах хувийн сонирхолтой нь холбоотой юм. Иймэрхүү хүсэл нь аливаа материаллаг хүслээс илүү дээр байх боловч хувийн сонирхлоос ангид бус байдаг. Үүний нэгэн адил бүхий л материаллаг үйлээ зогсоон, нүдээ хагас анин иогийн системийг хэрэгжүүлж байгаа ид шидэт-иогчид нь ямар нэгэн байдлаар өөрөө таашаал ханамж эдлэхийг л хүсэж байгаа хэрэг. Харин Кришнагийн ухамсарт оршин, үйлээ үйлдэх хүн өөрийн хувийн сонирхлыг үл хайхран Бүрэн Бүтэний таалалд нийцүүлэн тааруулахаар ажиллаж байдаг. Кришнаг ухамсарласан хүн өөрөө ханамж таашаал эдлэх гэсэн аливаа хүсэл эрмэлзэлээс ангид байдаг. Үйлдэж буй үйлийг нь Кришна хир зэрэг таалж болгоон, цэнгэж байгааг амжилтынхаа шалгуур болгож байдаг учир тэрээр төгс төгөлдөр *санньяси* буюу төгс төгөлдөр иогч юм. Төгс төгөлдөр огоорохуйн дээдийн дээд үлгэр дууриал бологч Шри Чайтанья, Кришнад хандан дараахь байдлаар залбирч байсан:

*на дханам на жанам на сундарим
кавитам ва жагад-иша камае
мама жанмани жанманишваре
бхаватад бхактир ахайтуки твайи*

“Ай бүхнээс хүчирхэг Бурхан минь ээ, Надад эд баялагт ч тэр, гоо сайхан эмэгтэйд ч тэр тэмүүлэх хүсэл алга. Мөн олон дагуул, бараа бологчидтой ч болохыг хүсэхгүй байна. Миний цорын ганц хүсэл бол: амьдралаас амьдралдаа Таны чин бишрэлээр үйлчэн зүтгэх албаны учир шалтгаангүй өршөөл нигүүлсллийг хүртэж байх явдал болой.”

ШҮЛЭГ 2

*ям санньясам ити прахур йогам там виддхи пандава
на хй асанньяста-санкалпо йоги бхавати кашчана*

ям-тэр, санньясам- огоорохуй, ити- ингэж, прахух- тэд нэрлэдэг, йогам- Бүхний Дээдтэй холбогдох, там- түүнийг, виддхи- чи мэдэх хэрэгтэй, пандава- Пандугийн хүү минь, на- хэзээ ч үгүй, хи- тодорхой, асанньяста- орхилгүйгээр, санкалтах- өөртөө таашаал ханамж эдлэх хүслийг, йоги- ид шидэт трансценденталист, бхавати- болдог, кашчана- аливаа.

Огоорол гэж нэрлэгдэх зүйл нь иог буюу Бүхний Дээдтэй холбогдох үйл явцтай адил юм гэдгийг чи мэдэх хэрэгтэй. Учир нь, ай Пандугийн хүү минь ээ, мэдрэхүйн таашаал ханамж эдлэх хүсэл эрмэлзлээсээ огоороогүй л бол хэн ч иог ч болж чаддаггүй.

ТАЙЛБАР: *Санньяса-йога* буюу *бхактийн* жинхэнэ утга нь хүн өөрийн буюу амьд оршнолын жинхэнэ байр суурийг таньж мэдэн, тэр дагуу үйл ажиллагаагаа явуулахад оршдог. Амьд оршнол нь салангид, хамааралгүй байдаггүй. Тэр бол Бүхний Дээдийн хязгаарын эрчим. Амьд оршнол нь материаллаг эрчмийн урхинд унаснаар болзолдож нөхцөлдсөн байдалд ордог боловч Кришнаг ухамсарласнаар буюу өөрөөр хэлбэл бурханлаг эрчмийг ойлгож ухаарснаар тэр жинхэнэ бөгөөд жам ёсны байр сууриа эзлэх болно. Иймээс, бүрэн төгс мэдлэг хүртсэнээр хүн материаллаг таашаал ханамжийн бүхий л хэлбэрээс холдон хөндийрөх буюу мэдрэхүйн таашаал ханамж эдлэхтэй холбоотой бүхий л үйлээс огоордог. Иогчид нь мэдрэхүйгээ материаллаг объектод дурлан татагдахаас хөндийрүүлэн холдуулснаар энэ зорилгод хүрэхийг чармайж байдаг. Харин Кришнаг ухамсарласан хүний мэдрэхүйд Кришнад зориулагдаагүй л бол өөр ямар ч зүйлээр оролдон зууралдах хэрэг огт байдаггүй. Иймээс Кришнаг ухамсарласан хүн нэгэн зэрэг *санньяси* болоод иогч юм. Кришнагийн ухамсарт оршин байгаа хүн, *гьяна* болон *йога-ын* системийн зорилго болох мэдлэг хийгээд өөрийгөө эзэмдэн захирах чадварт аяндаа хүрдэг. Аливаа хүн өөрийн хувийн сонирхол, аминчхан мөн чанараа ялан дийлэх чадваргүй л бол *гьяна* болон *йога* нь ямар ч ашиг тус болохгүй. Амьд оршнолын хувьд түүний жинхэнэ зорилго нь мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн аминчхан хүсэл бүрээсээ татгалзан, орхиж Дээдийн Дээдийг цэнгүүлэхэд бэлэн байх явдал байдаг. Кришнагийн ухамсарт оршин байгаа хүн хувийн таашаал ханамж эдлэх гэсэн ямар ч хүсэл эрмэлзлийг агуулдаггүй, харин тэр Дээдийн Дээдийг цэнгүүлэхийг үргэлжид хичээн чармайж байдаг. Аливаа хүн үйл хөдлөл үл хийн, идэвхгүй байж үл чадах учраас, Дээдийн Дээдийн талаарх мэдлэг хүртээгүй л бол тэр зөвхөн өөрийн хувийн сонирхлыг хангах үйлтэй зууралдах нь зайлшгүй хэрэг болдог. Кришнагийн ухамсрын зам мөрөөр замнаснаар л бусад бүхий л арга замуудын зорилгод бүрэн төгс хэмжээгээр хүрэх болно.

ШҮЛЭГ 3

*арурукишор мунер йогам карма каранам учьяте
йогарудхасья тасьяйва шамах каранам учьяте*

арурукишох- иогийн зам мөрөөр шинээр эхлэн орогч, *мунех*- мэргэдийн, *йогам*- найман шатлалт иогийн систем, *карма*- ажил, *каранам*- зам, *учьяте*- гэж хэлдэг, *йога*- найман шатлалт иог, *арудхасья*- хүрсэн хүний, *тасья*- түүний, *эва*- гарцаагүй, *шамах*- бүхий л материаллаг үйлүүдийн эцэс төгсгөл, *каранам*- зам, *учьяте*- гэж хэлдэг.

Найман шатлалт иогийн зам мөрд шинээр эхлэн орогсдын хувьд зорилгодоо хүрэх арга хэрэгсэл нь үйл ажил байдаг бол өндөр түвшинд хэдийнээ хүрэгсдийн хувьд энэхүү арга хэрэгсэл нь бүхий л материаллаг үйлээ орхин зогсоох явдал байдаг.

ТАЙЛБАР: Дээдийн Дээдтэй холбогдох үйл явцыг *йога* (иог) гэж нэрлэдэг. Иогийг бурханлаг танин мэдэхүйн оргилд хүргэх шаттай зүйрлэж болно. Энэ шат нь хамгийн доод материаллаг амьдралын түвшингээс эхлэх бөгөөд амьд оршнолыг цэвэр ариун бурханлаг амьдрал дахь өөрийгөө бүрэн нээн танин мэдэхүйн төгс төгөлдөрт хүргэдэг. Энэ шатны гишгүүрүүд нь бурханлаг хөгжил дэвшилд хүрсэн хэмжээ, зэргээс хамааран тодорхой нэрүүдтэй байдаг. Шатыг нийтэд нь иог гэж нэрлэх бөгөөд тэрээр *гьяна-йога*, *дхьяна-йога* болон *бхакти-йога* гэсэн гурван хэсэгт хуваагддаг. Шатны доод хэсэг буюу суурийг *йогарурукишу*, оройг *йогарудха* гэж нэрлэдэг.

Найман шатлалт иогийн системийн хувьд, хүн бясалгалд автан умбахын тулд эхлээд зохицуулах зарчмуудыг дагаж мөрдөхийн зэрэгцээ янз бүрийн байрлалуудаар суухад (эдгээр нь их бага ямар нэгэн хэмжээгээр биеийн тамирын дасгалууд байдаг) суралцах хэрэгтэй байдаг бөгөөд энэхүү эхний үе шат нь үр дагавар дагуулагч үйлд буюу кармын үйлд хамаарагддаг. Энэ бүх үйл нь эцэс хожим нь хүнийг ухаанаа бүрэн төгс тэнцвэртэй байдалд оруулахад хүргэх бөгөөд ингэснээр тэр мэдрэхүйгээ эзэмдэн захирч чадах болно. Бясалгалын арга үйлийг төгс сайн эзэмшсэн хүн ухааны саад учруулах нөлөөллийг эцэс болгон тайван амгалан байдалд хүрдэг.

Харин Кришнаг ухамсарласан хүн Кришнагийн тухай байнгад бодож байдаг тул бүр эхнээсээ л бясалгалын түвшинд хүрсэн байдаг. Мөн тэрээр Кришнагийн алба үйлэнд байнгад зүтгэж байдаг тул бүхий л материаллаг үйлээс салан ангижирсан нь эргэлзээгүй хэрэг.

ШҮЛЭГ 4

яда хи нендриартхешу на кармасв анушажжате

сарва-санкална-санньяси йогарудхас тадочьяте

яда- хэрвээ, хи- тодорхой, на- үгүй, индрия-артхешу- мэдрэхүйн таашаал ханамжид, на- хэзээ ч үгүй, кармасу- үр дагавар дагуулагч үйлтэй, анушажжате- чухалчлан зүтгэдэг, сарва-санкална- бүхий л материаллаг хүслүүд, санньяси- огоорогч, йога-арудхах- иогд ахиц дэвшилд хүрсэн, тада- тэгсэн цагт, учьяте- гэж хэлдэг.

Бүх материаллаг хүслээ орхисон хийгээд мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн тулд болон ашиг хонжоо олохын төлөө ажил үйл үл үйлдэх хүнийг иогийн өндөр түвшинд хүрсэн гэж үздэг.

ТАЙЛБАР: Бурханы трансценденталь хайрын албанд бүрнээ зүтгэж байгаа хүн өөрөө өөртөө буюу дотооддоо ханамжтай байдаг тул тэрээр ямар нэгэн кармын буюу мэдрэхүйн таашаал ханамж эдлэхтэй холбогдсон үйлийн хойноос хөөцөлдөхөө больдог. Хэн ч ямар нэгэн үйл, хөдлөл хийлгүйгээр байж чаддаггүй учир дээрх түвшинд хүрээгүй л бол мэдрэхүйн таашаал ханамж эдлэх үйлтэй хугалдан зууралдахаас өөр аргагүй байдаг. Кришнаг ухамсарлаагүй хүн үргэлжид нэг бол өөрийнхөө эсвэл ойр дотны хүмүүсийнхээ ашиг сонирхлын төлөө амиа бодсон үйл ажиллагаа явуулж байдаг. Харин Кришнаг ухамсарласан хүн өөрийн бүхий л үйлээ Кришнаг цэнгүүлэхийн төлөө үйлдэж байдаг тул мэдрэхүйн ханамж таашаал эдлэх гэсэн хүсэл эрмэлзлээс бүрэн төгс ангижирсан байдаг. Өөрийгөө танин мэдэхүйн энэ түвшинд хүрээгүй

хүн шатны хамгийн дээд гишгүүр хүртлээ материаллаг хүслээсээ механик байдлаар салах гэж оролдож байдаг.

ШҮЛЭГ 5

*уддхаред атманатманам натманам авасадает
атмайва хй атмано бандхур атмайва рипур атманах*

уддхарет- ангижрах хэрэгтэй, *атмана*- ухаанаар, *атманам*- болзолт сүнс, *на*- хэзээ ч үгүй, *атманам*- болзолт сүнс, *авасадает*- доройтдог, *атма*- ухаан, *эва*- гарцаагүй, *хи*- үнэндээ, *атманах*- болзолт сүнс, *бандхух*- найз, *атма*- ухаан, *эва*- гарцаагүй, *рипух*- дайсан, *атманах*- болзолт сүнсний.

Хүн өөрийн ухааныг унаж доройтолд орохын тулд биш харин ангижралд хүрэхийн төлөө ашиглах ёстой. Ухаан бол болзолт сүнсний хувьд найз нөхөр нь байдаг. Мөн тэр түүний дайсан нь ч болдог.

ТАЙЛБАР: *Атма* үэдэг үг нь тухайн нөхцөл байдлаасаа хамааран бие махбодь, ухаан, эсвэл сүнс гэсэн утгыг зааж байдаг. Иогийн системд ухаан болон болзолт сүнс нь онцгой байр суурийг эзэлдэг. Иогийг хэрэгжүүлэхийн гол төв нь ухаан байдаг тул энэ шүлэгт *атма* гэдэг үг нь ухааныг зааж байна. Иогийн зорилго нь ухаанаа эзэмдэн захирах, мөн түүнийг мэдрэхүйн объектуудад дурлан татагдахаас холдуулан хөндийрүүлэхэд оршдог. Ухааныг, болзолт сүнсийг харанхуй мунхагийн намгаас суга татан гаргаж чадахаар болтол хэмжээнд сургаж дадлагажуулах хэрэгтэй гэж энд онцлон тэмдэглэсэн байна. Материаллаг оршихуйд орших хүн ухаан болон мэдрэхүйнхээ нөлөөлөлд автан хөтлөгдсөн байдаг. Үнэн хэрэгтээ, ухаан нь материаллаг мөн чанарыг ноёлон захирах гэсэн хүсэл эрмэлзэл бүхий хуурамч эгоны нөлөөлөлд орсноос л болж цэвэр ариун сүнс нь материаллаг ертөнцийн урхинд орж зовж зүдэрдэг болно. Тийм учраас, ухаан нь материаллаг ертөнцийн гял цал байдалд татагдахааргүй болтол сургагдах аваас болзолт сүнс аврагдах болно. Хүн мэдрэхүйн объектод татагдахын хирээр материаллаг оршихуйд улам бүр орооцолдон уягдаж хүлэгддэг учраас ийнхүү мэдрэхүйн объектын өдөөлтөнд татагдан өөрийгөө уналт доройтолд оруулах ёсгүй. Энэхүү уяа хүлээснээс ангижран салах хамгийн шилдэг сайн арга бол ухаанаа Кришнагийн ухамсрын үйлэнд байнгад хандуулан оролцуулах явдал юм. Үйлээ ийм байдлаар л үйлдэх ёстой гэдгийг улам онцгойлохын тулд энд *хи* гэдэг үгийг ашигласан байна. Мөн өөр нэгэн газар дараахь шүлгийг өгүүлсэн байдаг:

*мана эва манушьянам каранам бандха-мокшайох
бандхая вишаясанго муктьяй нирвишаям манах*

“Хүний ухаан нь түүний боолчлогдон байх болон ангижралд хүрэх хоёрын хоёулангийн нь шалтгаан болж байдаг. Мэдрэхүйн объектуудад гүнээ татагдан автсан ухаан нь боолчлогдохын учир шалтгаан болж байдаг бол эдгээр объектуудаас салж холдсон ухаан нь ангижралд хүрэх шалтгаан болдог.” (Амрита-бинду Упанишад, 2) Иймээс Кришнагийн ухамсарт байнга орших ухаан нь дээдийн дээд ангижралын учир шалтгаан юм.

ШҮЛЭГ 6

*бандхур атматманас тасья енатмайватмана житах
анатманас ту шатрутве вартетатмайва шатру-ват*

бандхух- найз, *атма*- ухаан, *атманах*- амьд оршнолын, *тасья*- түүний, *йена*- түүгээр, *атма*- ухаан, *эва*- гарцаагүй, *атмана*- амьд оршнолоор, *житах*- дийлсэн, *анатманах*-ухаанаа эзэмдэн захирч чадаагүй хүний, *ту*- гэвч, *шаирутве*- дайсагналаас, *вартета*- үлддэг, *атма эва*- тэр л ухаан, *шатру-ват*- дайсан байдлаар.

Ухаанаа ялан дийлсэн хүний хувьд ухаан нь түүний сайн нөхөр, харин тэгж чадаагүй хүний хувьд тэр түүний хамгийн аюултай дайсан нь хэвээр үлддэг.

ТАЙЛБАР: Найман шатлалт иогийн зорилго нь ухаанаа эзэмдэн захирах явдал байдаг. Тэгснээр ухаан нь хүний сайн найз нөхөр болж амьдралын жинхэнэ зорилгодоо хүрэхэд нь түүнд тус болох ёстой. Ухаанаа хянан захиралгүйгээр иогоор хичээллэх нь (шоу байдлаар) хүний нүд хуурч, цагаа хий дэмий хоосон үрсэн үзүүлбэр болно. Ухаанаа эзэмдэн, хянан захирч чадахгүй байгаа хүн өөрийн хамгийн аюулт заналт дайсантайгаа байнгад хамт байгаа хэрэг тул тэр өөрийн амьдралыг болон амьдралынхаа үүрэг зорилгыг сүйтгэн үгүйрүүлж байгаа явдал юм. Амьд оршнолын жам ёсны бөгөөд жинхэнэ байр суурь нь дээрээс соёрхсон тушаал зарлигыг л биелүүлэхэд оршдог. Ухаан нь дийлдэшгүй дайсан хэвээр байсан цагт хүн хүсэл тачаал, уур хилэн, хорон муу санаа, хомхой сувдаг зан, хий хуурмагийн гэх мэтчилэн олон зүйлийн дарангуйлалд орж тэдгээрийн шахалт шаардлагыг дагах болно. Харин ухаанаа ялан дийлмэгц хүн өөрийн зүрхэндээ Параматма дүрээр залран байх Бурханы Дээд Бодьгалын сургаал зааврыг сайн дураараа дагадаг. Жинхэнэ иог нь хүнд өөрийн зүрхэнд залран байх Параматматай холбоо тогтоохоос илүү гарч улмаар Түүний таалал сургаалыг даган биелүүлэх боломжийг олгодог. Харин Кришнагийн ухамсарт шууд хандан байгаа хүн Бурханы сургаал зааврыг аяндаа өөрөө жинхэнэ, төгс төгөлдөр байдлаар даган биелүүлдэг.

ШҮЛЭГ 7

житатманах прашиантасья параматма самахитах
шиштошна-сукха-духкхешу татха манаманайох

жита-атманах- ухаанаа ялан дийлэгчийн, *прашиантасья*- ухаанаа ийнхүү ялан дийлсэнээр тогтвор тэнцвэртэй байдалд хүрсэн, *параматма*- Дээд Сүнс, *самахитах*- бүрэн хүрсэн, *шита*- хүйтэн, *ушна*- халуунд, *сукха*- аз жаргалд, *духкхешу*- зовлон шаналалд, *татха*- мөн, *мана*- хүндэтгэл, *аманайох*- болон гутамшиг.

Өөрийн ухаанаа ялан дийлсэн хүн тэнцвэртэй дөлгөөн байдалтай болсон байдаг учир Параматмад хэдийнээ хүрсэн хэрэг. Ийм хүний хувьд баяр хөөр уйтгар гуниг, аагим халуун тэсгим хүйтэн, хүндэтгэл доромжлол цөм адил байдаг.

ТАЙЛБАР: Чухамдаа амьд оршнол бүр өөрийн зүрхэндээ Параматма дүрээр залран байх Бүхний Дээд Бурханы сургаал зааврыг даган биелүүлж байх ёстой байдаг. Гадаад, хий хуурмагийн эрчимд ухаан нь төөрөлдөж самуурснаас болж л хүн материаллаг үйлтэй орооцолдон зууралддаг. Иймээс иогийн аль нэгэн системийн тусламжтайгаар ухаанаа эзэмдэн, хянан захирч чадсан хүнийг өөрийн зорилгодоо хэдийнээ хүрч чадсан гэж хэлж болох юм. Хүн ямар ч нөхцөлд байсан илүү дээд сургаал заавруудыг дагах хэрэгтэй. Ухаан илүү дээд мөн чанарт гүн бат төвлөрсөн цагт түүний хувьд Бүхний Дээдийн тааллыг дагах аас өөр ямар ч сонголт, боломж байдаггүй. Ухаан нь аль нэгэн илүү дээд сургаалыг эрхэмлэн түүнийг даган биелүүлэх хэрэгтэй байдаг. Ухаанаа нэгэнт эзэмдэн захирсан л бол хүн өөрөө аяндаа Дээд Сүнс, Параматмын сургаал зааврыг дагаж мөрддөг. Кришнагийн ухамсарын зам мөрөөр замнаснаар хүн энэхүү трансценденталь түвшинд шууд хүрдэг учир, Бурханы чин бишрэлтэн нь материаллаг оршнолын баяр хөөр уйтгар гуниг, халуун хүйтэн гэх зэргийн хоёрдмол

байдлын нөлөөлөлд автан ордоггүй. Ингэснээр тэр *самадхи* төлөв байдалд бодитойгоор байгаа буюу Бүхний Дээдийн тухай бодолд бүрнээ автан умбаж байгаа хэрэг.

ШҮЛЭГ 8

*гьяна-вигьяна-трипатма кута-стхо вижитендриях
юкта итй учьяте йоги сама-лоштрашма-канчанах*

гьяна- хүртсэн мэдлэгээр, *вигьяна*- болон таньж мэдсэн мэдлэгээр, *трипта*- ханамжтай, *атма*- амьд оршнол, *кута-стхах*- бурханлаг байр сууринд байдаг, *вижита-индриях*- эзэмдэн захирсан мэдрэхүйтэй, *юктах*- өөрийн бүрэн нээж танин мэдсэн, *ити*- ингэж, *учьяте*- гэж нэрлэгддэг, *йоги*- ид шидтэн, *сама*- адилаар хардаг, *лоштра*- хайрга, *ашма*- чулуу, *канчанах*- алт.

Хүртсэн хийгээд таньж мэдсэн мэдлэгийнхээ хүчээр бүрэн ханамжтай байгаа хүнийг өөрийгөө бүрэн нээж танин мэдсэн хүн буюу иогч (мистик) гэж үздэг. Ийм хүн Үнэмлэхүйд автсан хийгээд өөрийгөө бүрэн эзэмдэн захирсан байдаг. Тэрээр хайрга, чулуу эсвэл алт ч бай ялгаагүй бүгдийг нэг л адил байдлаар харж байдаг.

ТАЙЛБАР: Дээдийн Дээд Үнэнийг бүрэн таньж мэдэлгүйгээр эзэмшсэн номын мэдлэг ямар ч ач тусгүй байдаг. Энэ тухай дараах шүлэгт батлан өгүүлдэг:

*атах шри- кришна-намади на бхавед грахьям индрияйх
севонмукхе хи жихвадау сваям эва спхуратй адах*

“Хэн ч өөрийн материаллаг ойлгоцоор бузартсан мэдрэхүйгээр Шри Кришнагийн нэр алдар, дүр төрх, шинж чанар болон зугаа наадмын трансценденталь мөн чанарыг ойлгож чадахгүй. Зөвхөн Бурханы трансценденталь албанд зүтгэснээр бурханлаг мөн чанар нь бялхан байгаа хүнд л Бурханы трансценденталь нэр алдар, трансценденталь дүр төрх, трансценденталь шинж чанар болон трансценденталь зугаа наадам тайлагдан нээгддэг.” (Бхакти-расамрита-синдху, 1.2.234)

Бхагавад Гита бол Кришнагийн ухамсрын эрдэм ухаан. Дан ганц материаллаг шинжлэх ухааны гүн гүнзгий мэдлэг эзэмшсэнээр хүн Кришнаг ухамсарлахгүй. Энэ нь зөвхөн цэвэр ариун ухамсар бүхий бодьгалтай харилцаж холбоо тогтоосон зол зовшаантай хүний хувьд л бүтэх хэрэг. Кришнаг ухамсарласан хүн гагцхүү Бурханы цэвэр чин бишрэлийн алба зүтгэлдээ ханамжтай байдаг учраас Шри Кришнагийн өршөөл соёрхлоор жинхэнэ таньж мэдсэн мэдлэгийг агуулж байдаг. Энэхүү трансценденталь мэдлэгийн ач тусаар тэр төгс төгөлдөрт хүрч, өөрийн үзэлдээ бат итгэл үнэмшилтэй болж байхад жирийн академик боловсрол эзэмшсэн хүн санаа бодлын зөрөлдөөнд амархан хууртагдан мэхлэгдэж улмаар төөрөлдөн самуурдаг. Өөрийгөө бүрэн нээж танин мэдсэн хүн л Кришнад даатгасан байдаг учир өөрийгөө үнэхээр эзэмдэн захирч чаддаг. Тэрээр материаллаг сургаал номлолтой ямар ч холбоогүй байдаг учир трансценденталь. Материаллаг шинжлэх ухаан болон ухаан бодлын цэцэрхийлэл нь бусдад алт мэт чухал байх боловч түүний хувьд энэ нь хайрга, чулуунаас өөрцгүй үнэ цэнэ багатай зүйл байдаг.

ШҮЛЭГ 9

*сухрин-митрарй-удасина-мадхьястха-двешья-бандхушу
садхушв апи ча папешу сама-буддхир вишишьяте*

сукрит- бусдад сайныг хүсэгч мөн чанараар, *митра*-дотно ачлалтай, *ари*- дайснууд, *удасина*- эсрэг талуудын дунд үл оролцох, *мадхьястха*- сөргөлдөгч талуудыг эвлэрүүлэн зохицуулагч, *двешья*- атаач, *бандхушу*- найз нөхөд эсвэл төрөл төрөгсөд, *садхушу*- зөв шудрага үйлтэн, *апи*- мөн тэрчлэн, *ча*- болон, *папешу*- нүгэлтэн, *сама-буддхих*- адил оюун ухаантай, *вишишьяте*- өндөр ахиц дэвшилд хүрсэн.

Зөв шударгаар сайныг хүсэгч, дотнын ачлалт, хөндлөнгийн ажиглагч, эвлэрүүлэн зохицуулагч болон атаач жөтөөч, найз нөхөр болоод атаат дайсан, зөв шудрага үйлтэн болоод нүгэл үйлдэгч эд бүгдийг эн тэнцүү нэг ижил байдлаар авч үздэг ухаан бүхий хүнийг бурханлаг хөгжлийн бүр илүү өндөр түвшинд хүрсэн гэж үздэг.

ШҮЛЭГ 10

*йоги юнжита сататам атманам рахаси стхитах
экаки ята-читтатама нирашир апариграхах*

йоги- трансценденталист, *юнжита*- Кришнагийн ухамсарт төвлөрөх хэрэгтэй, *сататам*- байнгад, *атманам*- өөрөө (бие махбодь, ухаан болон сүнсээрээ), *рахаси*- аглаг зэлүүд хүнгүй газар, *стхитах*- байснаар, *экаки*- ганцаар, *ята-читта-атма*- ухаандаа үргэлж анхааралтай, *нираших*- өөр бусад ямар нэгэн зүйлд татагдалгүйгээр, *апариграхах*- өмчилж эзэмших мэдрэмжээс ангид.

Трансценденталист нь Бүхний Дээдтэй холбоотой үйлэнд өөрийн сүнс, бие махбодь болон ухаанаараа үргэлж зүтгэж байх ёстой. Тэрээр аглаг зэлүүд газар ганцаар амьдран, өөрийн ухааныг үргэлжид, хичээнгүйлэн эзэмдэн захирч байх ёстой. Мөн эд баялаг өмчилж, эзэмших гэсэн шуналын мэдрэмж, хүслээс ангид байх ёстой.

ТАЙЛБАР: Кришнаг Брахман, Параматма болон Бурханы Дээд Бодьгаль төлөв байдлаар янз бүрийн түвшинд таньж мэдэж болдог. Кришнагийн ухамсар гэж юу болохыг товчоор хэлбэл, Бурханы трансценденталь хайрын албанд үргэлжид зүтгэн байх явдал юм. Бодьгал бус Брахман нь Кришнагийн бурханлаг туяа, Параматма нь Кришнагийн бүхэнд нэвтрэх хэсэгчилсэн хувилгаан дүр болох тул бодьгал бус Брахман эсвэл амьд оршнолын зүрхнээ залрах Параматмад татагдан байгаа хүн Кришнаг бүрэн бус байдлаар л ухаарч байгаа хэрэг юм. Иймээс имперсоналистууд, мөн бясалгагч нар нь Кришнаг шууд бус байдлаар ухамсарлаж байдаг. Харин Кришнагийн ухамсрыг шууд хөгжүүлэн байгаа чин бишрэлтэн нь Брахманыг ч, мөн Параматмаг ч танин мэдсэн байдаг тул хамгийн дээд трансценденталист юм. Үнэмлэхүй Үнэний талаарх түүний хүртсэн мэдлэг төгс төгөлдөр байдаг бол бодьгал бусыг баримтлагчид болон бясалгалын иогийн зам мөрөөр замнагчид нь Кришнаг зөвхөн бүрэн төгс бус байдлаар л ухамсарладаг.

Тэглээ ч гэсэн, ийм хүмүүст эрт орой хэзээ нэгэн цагт дээдийн дээд төгс төгөлдөрт хүрэхийн тулд өөр өөрсдийн баримтлах зам мөрийг цөхрөлтгүй даган байхыг энд зөвлөж байна. Трансценденталистын хамгийн эн тэргүүний үйл нь өөрийн ухааныг Кришнад байнгад төвлөрүүлж байх явдал юм. Кришнаг агшин зуурч марталгүйгээр, Түүний тухай тасралтгүйгээр бодож байх ёстой. Бүхний Дээдэд ухаанаа төвлөрүүлэхийг *самадхи* буюу транс гэж нэрлэдэг. Ухаанаа төвлөрүүлэхийн тулд хүн эзгүй аглаг зэлүүд газар суурьшин, гаднын зүйлүүдийн учруулах саад тотгороос зайлсхийх ёстой. Трансценденталист, өөрийгөө бүрэн нээж танин мэдэх үйлд нь таатай, тохиромжтойгоор нөлөөлөх нөхцөл байдлыг хүлээн авч, тааламжтай бусаас нь татгалзан зайлсхийх ёстой. Мөн тэрээр, эд баялаг өмчлөх, эзэмших гэсэн шунал хомхойрлыг төрүүлэх аливаа шаардлагатай бус материаллаг зүйлсийн хойноос тэмүүлэх явдлыг шийдвэртэйгээр таслан зогсоож, орхих ёстой. Кришнагийн шууд ухамсар нь материаллаг эд баялаг эзэмших шунал хомхойрол төрөх боломж үгүй байдаг өөрөө

огоорохуй учраас Кришнагийн ухамсарын үйлэнд шууд зүтгэхэд энэ бүх урьдчилсан нөхцөл байдлууд болон урьдчилсан сэргийлэх арга хэмжээнүүд бүрэн төгс төгөлдөр хэмжээгээр биелэгдсэн байдаг. Шрила Рупа Госвами Кришнагийн ухамсарыг дараахь байдлаар тодорхойлсон байдаг:

*анасактасья вишаян ятхархам упанюнжатах
нирбандхах кришна-самбандхе юктам вайрагьям учьяте
прапанчикатая буддхья хари-самбандхи-вастунах
мумукиубхих паритьяго вайрагьям пхалгу катхьяте*

“Хүн юунд ч дурлан татагдалгүй байхын зэрэгцээ бүхнийг Кришнаатай холбоотойгоор хүлээн авч байх аваас тэрээр эд баялаг, өмч хөрөнгө эзэмших гэсэн бүхий л хүсэл шуналаасаа зөв байдлаар ангид хол байгаа хэрэг. Нөгөө талаас, эдгээр юмсыг Кришнаатай холбоотой гэдгийг таньж мэдэлгүйгээр бүгдээс татгалзаж байгаа хүний огоорохуй нь төгс төгөлдөр бус байдаг.” (Бхакти-расамрита-синдху, 2.255-256)

Кришнаг ухамсарласан хүн бүх зүйлс Кришнад харьяалагдаж Түүний соёрхолд байдаг гэдгийг тун сайн мэдэх учраас тэрээр ямар нэгэн зүйл хувьдаа өмчлөх гэсэн мэдрэмж, хүслээс байнгад ангид байдаг. Иймээс тэр өөрийн хувийн зорилгын үүднээс ямар ч зүйлийг хүсдэггүй. Кришнагийн ухамсарт ашигтай тустай зүйлийг хүлээн авахаа болон Кришнагийн ухамсарт хортой, муу зүйлээс зайлсхийхээ тэр мэддэг. Трансценденталь түвшинд байнга орших тэрээр материаллаг зүйлсээс дээш, тэдний чанадад байх бөгөөд Кришнаг ухамсарлаагүй хүмүүсийн сонирхолтой адил зүйл буюу тэдэнтэй холбоотой юу ч байдаггүй учир үргэлж ганцаар байдаг. Ийм учраас Кришнагийн ухамсарт оршин байгаа хүн бол төгс төгөлдөр иогч.

ШҮЛЭГ 11-12

*шучау деше пратиштхалья стхирам асанам атманах
натй-уччхритам нати-ничам чайлажсина-нушоттарам*

*татрайкаграм манах критва ята-читтендрия-крях
упавишьясане юнжъяд йогам атма-вишуддхае*

шучау- цэвэр ариун, *деше-* газарт, *пратиштхалья-* байрлуулснаар, *стхирам-* хатуу, *асанам-* суудал, *атманах-* өөрийн, *на-* үгүй, *ати-* хэт, *уччхритам-* өндөр, *на-* үгүй, *ати-* хэт, *ничам-* доор, *чайла-ажина-* зөөлөн алчуур болон бугын арьсаар, *куша-* куша өвс, *уттарам-* хучсанаар, *татра-* түүн дээр, *экаграм-* төвлөрсөн анхааралтайгаар, *манах-* ухаан, *критва-* хийснээр, *ята-читта-* ухаанаа эзэмдэн захирсанаар, *индрия-* мэдрэхүй, *крях-* болон үйлүүд, *упавишья-* сууснаар, *асане-* суудал дээрээ, *юнжъят-* гүйцэтгэх ёстой, *йогам-* иогийн үйл явцыг, *атма-* зүрх, *вишуддхаве-* ариусгахаар.

Иогоор хичээллэн, хэрэгжүүлэхийн тулд аглаг зэлүүд газар очих ёстой ба куша өвсийг газар зулж дэвсэн түүнийгээ бугын арьс болон зөөлөн даавуугаар бүтээнэ. Суудал хэтэрхий өндөр ч биш, мөн нам ч биш байх ёстой бөгөөд түүнийг ариун дагшин газар засаж бэлтгэх хэрэгтэй. Иогч нь бат тогтвортой суугаад, өөрийн ухаан, мэдрэхүй, үйлээ хянан захирснаар зүрхээ ариусгах ба ухаанаа нэг л зүйлд дээр төвлөрүүлэн бясалгамой.

ТАЙЛБАР: Ариун дагшин гэж өргөл, мөргөл үйлддэг газрыг хэлдэг. Энэтхэгт иогчид, трансценденталистууд болон чин бишрэлтэнгүүд гэр орноо орхин, Ямуна болон Ганга зэрэг ариун дагшин гол мөрнүүдийн эрэгт, аглаг зэлүүд газарт иогийн үйлээ хэрэгжүүлэхээр Праяга, Матхура, Вриндавана, Хришикеша, Хардвар зэрэг газруудад суурьшдаг. Гэхдээ ингэх нь хүн бүрт боломжтой байдаггүй, ялангуяа барууны хүмүүст бүр ч хүндрэлтэй. Том хотуудад байдаг

иогийн нийгэмлэг гэгдэх байгууллагууд нь үүсгэн байгуулагчиддаа материаллаг ашиг тус авчирч болох ч иогийг жинхэнээр нь хэрэгжүүлэхэд хэрэг болохуйц зүйл огтхон ч биш. Өөрийгөө хянан захирч чадаагүй, ухаан нь тайван бус байх хүн хэзээ ч бясалгал үйлдэж чадахгүй. Иймээс, Брихан-Нарадия Пурана-д өгүүлснээр, хүмүүсийн амьдралын үргэлжлэх хугацаа богино, бурханлаг талын хөгжил удаантай, байнгад янз бүрийн түгшүүр зовиуртай байдаг Кали югад (одоо үргэлжилж байгаа юга буюу цаг үе) бурханлаг танин мэдэхүйд тустай хамгийн сайн арга бол Бурханы ариун гэгээн нэр алдрыг магтан дуулах явдал юм.

*харер нама харер нама харер намайва кевалам
калау настй эва настй эва настй эва гатир аньятха*

“Хэрүүл тэмцэл болон бялангач үзэл ноёрхон байх энэ цаг үед ангижралд хүрэх цорын ганц арга хэрэгсэл бол Бурханы ариун гэгээн нэр алдрыг давтан хэлэх явдал. Үүнээс өөр ямар ч арга зам байхгүй. Үүнээс өөр ямар ч арга зам байхгүй. Үүнээс өөр ямар ч арга зам байхгүй.”

ШҮЛЭГ 13-14

*самам кая-широ дхараянн ачалам стхирах
сампрекшья насикаграм свам дишааш чанавалокаян*

*прашантатма вигата-бхир брахмачари-врате стхитах
манах самьямья мач-читто юкта асита мат-парах*

самам- шулуун, *кая-* бие махбодь, *ширах-* толгой, *гривам-* болон хүзүү, *дхараян-* байлгаснаар, *ачалам-* хөдлөлгүй, *стхирах-* тайван, *сампрекшья-* харснаар, *насика-* хамрын, *аграм-* үзүүр дээр, *свам-* өөрийн, *дишах-* бүх талууд, *ча-* мөн, *анавалокаян-* харалгүйгээр, *прашанта-* өдөөгдөлгүй, *атма-* ухаан, *вигата-бхих-* айдас хүйдэснээс ангид, *брахмачари-врате-* ариун журамт байдлын сахилд, *стхитах-* автдаг, *манах-* ухаан, *самьямья-* бүрэн ялснаар, *мат-* Надад (Кришна), *читтах-* ухааныг төвлөрүүлснээр, *юктах-* жинхэнэ иогч, *асита-* суух ёстой, *мат-* Намайг, *парах-* дээдийн дээд зорилго.

Цээжин бие, хүзүү, толгойгоо цэх шулуун босоо нэг шугаманд байлгаж, харцаа хамрын үзүүрт байнгад чиглүүлнэ. Ийм байдлаар ухаанаа хянан, айдас хүйдэсгүй, бэлгийн амьдралаас бүрмөсөн ангид байж өөрийн зүрхнээ залрах Намайг бясалган, амьдралынхаа дээдийн дээд зорилгоо Намайг болгох ёстой.

ТАЙЛБАР: Амьдралын зорилго нь амьд оршнол бүрийн зүрхнээ дөрвөн мутар бүхий Вишнугийн дүрээр залран байдаг Кришнаг таньж мэдэх явдал байдаг. Иогийн үйл явц нь энэхүү, зүрхнээ залрах Вишну дүрийг нээх болон харахад л зориулагдсан болохоос биш өөр ямар нэгэн зүйлд биш. Амьд оршнол бүрийн зүрхнээ залрах Вишну-мурти нь Кришнагийн бүрэн төлөөлөл юм. Вишну-муртиг танин мэдэх зорилго өмнөө тавилгүйгээр иогоор ямар ч утгагүйгээр, дууриан хичээллэх нь цагаа хий дэмий үрсэн хэрэг. Амьдралын дээдийн дээд зорилго бол Кришна, харин иогийн зам мөрөөр замнан хэрэгжүүлэхийн зорилго бол өөрийн зүрхнээ залран байх Вишну-мурти. Энэ зорилгодоо хүрэхийн тулд бэлгийн харьцаанаас бүрмөсөн ангид байх шаардлагатай байдаг учраас гэр орноо орхин аглаг зэлүүд газарт ганцаар амьдран дээр өгүүлсэн нэг л байрлалаар суух хэрэгтэй байдаг. Өдөр бүр гэр орондоо болон өөр хаа нэгтэй газар бэлгийн таашаал эдлэнгээ иогийн курс, хичээл гэгдэх цуглаанд сууснаар жинхэнэ иогч болохгүй. Ухаанаа эзэмдэн зархирахын зэрэгцээ ялангуяа бэлгийн таашаал хамгийн нэг дүгээрт тавигддаг мэдрэхүйн ханамж таашаал эдлэх бүхий л хэлбэрүүдээс зайлсхийх ёстой. Аугаа их мэргэдийн нэг Ягьявалькьягийн бичиж үлдээсэн, цэвэр ариун байдлаа хадгалан гэр бүлгүй амьдрах амьдралын дүрэм журамд өгүүлэхдээ:

*кармана манаса вача сарваастхасу сарвада
сарватра майтхуна-тьяго брахмачарьям праचाкиште*

“Брахмачария сахил нь бодол, үйл, үгээрээ хаана ч, хэзээ ч, ямар ч нөхцөл байдалд байсан бэлгийн амьдралаас бүрэн татгалзахад хүнд туслах ёстой байдаг.”

Бэлгийн дүр хүсэлдээ хөтлөгдөн байгаа хүн иогийг зөв хэрэгжүүлнэ гэдэг боломжгүй хэрэг. Ийм учраас *брахмачарияг* энэ талын амьдралын мэдлэггүй байх үеэс буюу бүр хүүхэд ахуй цагаас нь сурган хүмүүжүүлдэг. Хүүхдүүдийг таван нас хүрэх үед нь *гуру-кулу* буюу номын багшийн гэр лүү явуулдаг бөгөөд багш нь эдгээр хөвгүүдийг *брахмачария* болох чанга хатуу сахилга дэглэмд сургаж хүмүүжүүлдэг. Энэхүү суурь, үндэсгүйгээр *бхакти*, *дхьяна*, *гьяна* ч бай, аль ч иогод хөгжил дэвшил гаргаж чадахгүй. Гэр бүлтэй хүний амьдралын журам дүрмийг даган зөвхөн өөрийн эхнэртэй бэлгийн харьцаатай (мөн тодорхой хязгаарлалт, журмын дагуу) байдаг хүмүүсийг мөн *брахмачария* гэж нэрлэдэг. Ийнхүү тодорхой тэвчлийг туулан байгаа гэр бүлтэй-*брахмачарияг бхактийн* номлолд хүлээн зөвшөөрдөг байхад *гьяна* болон *дхьяна* иогийн сургууль, номлолд хүлээн зөвшөөрдөггүй. Тэд ямар ч зохицуулалтгүйгээр бүрэн огоорохыг шаарддаг. Бурханы албанд зүтгэн байгаа хүн илүү дээд жаргал цэнгэлийг амтлан байх тул *бхакти* иогийг хэрэгжүүлэх явцад бэлгийн дүр хүсэл аяндаа үгүй болдог. *Бхакти-йога* нь ийм л хүчирхэг учраас *бхактийн* номлолд гэр бүлтэй *брахмачарияд* хянан захирагдсан бэлгийн амьдралыг зөвшөөрдөг. Бхагавад Гитагийн (2.59)-д өгүүлэхдээ:

*вишья винивартанте нирахарасья дехинах
раса-варжам расо `ни асья парам дриштва нивартате*

Бусад иогчид өөрсдийгөө мэдрэхүйн таашаал ханамж эдлэх үйлээс хүчээр хойш татан холдуулдаг байхад илүү дээд цэнгэл жаргалыг амталж мэдсэн Бурханы *бхактууд* нь түүнээс өөрсдөө аяндаа холдон ангижирдаг. Чин бишрэлтэнгүүдээс өөр хэн ч энэхүү илүү дээд амтыг үл мэднэ.

Вигата-бхих. Кришнаг бүрэн ухамсарлаагүй хүн айдас хүйдсээс ангид байж чаддаггүй. Бурхантай холбогдсон мөнхийн харьцаагаа мартсанаас болж ой санамж нь гажуудсан болзолт сүнснүүд нь айдас хүйдэст байнга нэрвэгдэж байдаг. Бхагаватамын (11.2.37)-д өгүүлснээр: *бхаям двитиябхивешатах сьяд ишад апетасья випарьяйо `смритах*- Кришнагийн ухамсар бол айдас хүйдэсгүй байхын цорын ганц үндэс суурь. Иймээс Кришнагийн ухамсарт оршин байгаа хүн л иогийг төгс төгөлдөр байдлаар хэрэгжүүлэх боломжтой. Тэр өөрийн дотооддоо залрах Бурханыг харах дээдийн дээд зорилгодоо хэдийнээ хүрсэн байдаг тул бүх иогчдоос хамгийн шилдэг нь. Энэ бүгд нь иогийн системийн зарчмууд бөгөөд олон нийтэд түгэн тархсан иогийн нийгэмлэг, сургуулиуд гэгдэх байгууллагуудад заах зүйлүүдээс эрс ялгаатай.

ШҮЛЭГ 15

*юнжанн эвам садатманам йоги нията-манасах
шантим нирвана-парамам мат-самстхам адхигаччхати*

юнжанн- сургуулилснаар, *эвам*- дээр дурьдсан шиг, *сада*- байнгад, *атманах*- бие махбодь, ухаан болон сүнс, *йоги*- ид шидэт трансценденталист, *нията-манасах*- зохицуулагдсан ухаантай, *шантим*- амар амгалан, *нирвана-парамам*- материаллаг оршнолын эцэс төгсгөл, *мат-самстхам*- бурханлаг тэнгэрийг (Бурханы орон), *адхигаччхати*- хүрдэг.

Ид шидэт-трансценденталист нь өөрийн бие махбодь, үйл, ухаанаа хянан захирахын тулд ийм байдлаар байнгад сургуулилснаар ухаанаа бүрэн эзэмдэн захирч

чаддаг учраас өөрийн материаллаг оршнолыг төгсгөл болгон Бурханы оронд (Кришнагийн залран байх орон) хүрч очдог.

ТАЙЛБАР: Энд иогийн дээдийн дээд зорилгыг тодорхой тайлбарлаж байна. Иог нь хүнийг материаллаг баялаг, тав тухтай нөхцөлд хүрэхэд биш харин ч эсрэгээр өөрийн материаллаг оршихуйг бүрмөсөн төгсгөл болгон орших чадвартай болоход зориулагдсан. Өөрийн эрүүл мэндийг сайжруулах болоод материаллаг төгс төгөлдөрт хүрэхийг эрмэлзэгч нь Бхагавад Гитад заасны дагуу бол иогч биш. Материаллаг оршихуйг бүрмөсөн орхино гэдэг нь “хий хоосонд” орж очихыг хэлдэггүй. Бурханы бүтээлийн хаана ч хий хоосон гэж байдаггүй учир энэ бол зөвхөн худал зүйл. Харин түүний оронд, материаллаг оршихуйг төгсгөл болгон орхисноор иогч Бурханы залран байх орон бурханлаг тэнгэрт хүрч очих чадвартай болдог. Энэхүү орныг Бхагавад Гитад, тэнд нар ч, сар ч, цахилгаан гэрэл ч огтхон ч хэрэггүй байдаг хэмээн тодорхой өгүүлсэн байдаг. Бурханлаг ертөнц дэх бүх гаригууд нь материаллаг тэнгэрийн нар лугаа өөрөө өөрөөсөө гэрэлтэн байдаг аж. Бурханы эзэмшил нь хаа сайгүй байх боловч бурханлаг тэнгэр болоод тэнд байх гаригуудыг *парам дхама* буюу дээдийн дээд орон гэж нэрлэдэг.

Шри Кришнагийн тухай төгс төгөлдөр мэдлэгийг хүртсэн, хамгийн дээд түвшинд орших иогч жинхэнэ амар амгаланг олж чаддаг бөгөөд энд Бурхан Өөрөө тайлбарласанчлан, (*мат-читтах, мат-парах, мат-стханам*) эцэстээ тэрээр Голока Вриндавана гэж нэрлэгддэг Түүний дээдийн дээд орон, Кришналокад хүрдэг ажээ. Брахма-самхитагийн (5.37)-д өгүүлснээр, *голока эва нивасти акхилатма-бхутах*. Бурхан Өөрийн орон Голокад мөнхөд залран байхын зэрэгцээ Өөрийн дээд, бурханлаг эрчмийнхээ хүчээр бүхэнд нэвчих Брахман болон амьд оршнол бүрийн зүрхнээ залрах Параматма хэлбэрээр нэгэн зэрэг илэрч тодорч байдаг. Шри Кришна болон Түүний бүрэн хувилгаан дүр Вишнуг жинхэнэ дүр төрхөөр нь, зөв ойлгож чадаагүй л бол бурханлаг тэнгэр (Вайкунтха) буюу Бурханы мөнхийн орон (Голока Вриндавана)-д хэн ч хүрч очиж чадахгүй. Иймээс Кришнагийн ухамсрын үйлэнд зүтгэн байгаа хүний ухаан нь Кришнагийн үйлийн тухай бодолд гүнээ автсан байдаг учир тэрээр төгс төгөлдөр иогч юм (*са вай манах кришна-надаравиндаяйох*). Ведэд (Шветашватара Упанишад, 3.8): *там эва видитвати мрить ум эти* буюу “Зөвхөн Бурханы Дээд Бодьгал, Кришнаг ойлгосноор л төрөлт үхлийн хүрднээс ангижирч болно” хэмээн өгүүлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, иогийн төгс төгөлдөр нь гэнэн хүмүүсийг хууран мэхлэх ид шидийн гэмээр элдэв арга заль болон гимнастикийн үзүүлбэрт биш харин материаллаг оршихуйгаас ангижрахад л оршдог.

ШҮЛЭГ 16

*натй-аштанас ту його `сти на чайкантам анашнатах
на чати свапна-шиласья жаграто найва чаржуна*

на- үгүй, *ати-* хэт их, *ашнатах-* иддэг хүний, *ту-* гэвч, *йогах-* Бүхний Дээдтэй холбоо, *асти-* байдаг, *на-* үгүй, *ча-* мөн, *экантам-* хэт, *анашнатах-* хоолноос хойш сууснаар, *на-* үгүй, *ча-* мөн, *ати-* хэт их, *свапна-шиласья-* унтдаг хүний, *жагратах-* эсвэл шөнө удаан сэрүүн байдаг хүн, *на-* үгүй, *эва-* хэзээ ч, *ча-* болон, *аржуна-* Аржуна минь.

Ай Аржуна минь ээ, Хэт их эсвэл хэт бага иддэг, мөн хэт их эсвэл хангалттай биш унтдаг хүн иогч болох боломжгүй юм.

ТАЙЛБАР: Энд иогчдод хоол, нойрны дэглэмээ зөв зохицуулж байх ёстойг зөвлөж байна. Бие махбодь болон сүнсээ хамтад нь тогтоон барьж байх шаардлагатай хэмжээнээс илүү идэхийг хэт их идэх гэдэг. Хангалттай хэмжээний үр тариа, ногоо, жимс болон сүү байгаа учир хүмүүсийн хувьд амьтны мах хоол хүнсэндээ хэрэглэх шаардлагагүй юм. Бхагавад Гитад зааснаар бол иймэрхүү энгийн хүнс нь цэвэр ариуны гунад хамаарагддаг. Харин амьтны мах нь харанхуй мунхгийн гунад орших хүмүүст л зориулагдсан. Иймээс амьтны мах идэж,

согтууруулах ундаа ууж, тамхи татаж, эхлээд Кришнад өргөөгүй хоолыг хэрэглэж байгаа хүн нь ариун бус зүйл хэрэглэж байгаа тул кармын нүгэлт үр дагавраас болж зовж шаналах болдог. *Бхунжате те тв агхам папа е пачанти атма-каранат.* Мэдрэхүйн таашаал ханамж эдлэх үүднээс идэж байгаа болон Бурханд өргөлгүйгээр өөртөө зориулан хоол хүнс бэлтгэж байгаа хүн зөвхөн нүгэл л идэж байна гэсэн үг. Нүгэл болон, өөрт нь тохирох хэмжээнээс илүү ихийг идэж байгаа хүн иогийг бүрэн төгс, жинхэнэ байдлаар хэрэгжүүлж чадахгүй. Кришнад өргөсөн зоогийн үлдэгдлийг хүртэх нь хамгийн сайн юм. Кришнагийн ухамсарт оршин байгаа хүн, эхлээд Кришнад өргөөгүй л бол юу ч байсан иддэггүй. Иймээс зөвхөн Кришнаг ухамсарласан хүн л иогийн төгс төгөлдөрт хүрч чадна. Түүнчлэн хоол унднаас зохиомлоор татгалзан, өөрийн санаа зоргоор мацаг барьж байгаа хүн иогийн зам мөрөөр замнаж чадахгүй. Кришнаг ухамсарласан хүн зөвхөн сударт заасны дагуу мацаг барьдаг. Тэр заасан хэмжээнээс илүү удаан хугацаагаар ч мацаг барьдаггүй, мөн шаардлагатай хэмжээнээс илүү ихээр ч иддэггүй учраас иогийн зам мөрөөр замнан хэрэгжүүлэх чадвартай. Шаардлагатай хэмжээнээс илүү их иддэг хүн унтаж байх үедээ илүү их зүүдэлдэг учир мөн шаардлагатай хэмжээнээс илүү их хугацаагаар унтдаг. Хүн хоногт зургаан цаг унтахад хангалттай. Хоногийн хориндөрвөн цагт энэ хэмжээнээс илүү хугацаагаар унтаж байгаа хүн харанхуй мунхагийн гунын нөлөөлөлд автсан байдаг нь эргэлзээгүй хэрэг. Харанхуй мунхагийн гунад орших хүн залхуу хойрго бөгөөд их унтах дуртай байдаг. Ийм хүн иогийн зам мөрөөр замнах нь боломжгүй юм.

ШҮЛЭГ 17

*юктахара-вихарасья юкта-чештасья кармасу
юкта-свапнавабодхасья його бхавати духкха-ха*

юкта- журамласан, *ахара-* хоол, *вихарасья-* амралт, *юкта-* журамласан, *чештасья-* амьдралыг залгуулахын төлөө ажиллаж байгаа хүний, *кармасу-* оноогдсон үүргээ биелүүлэх үед, *юкта-* журамласан, *свапна-авабодхасья-* нойр болон сэрүүн байдал, *йогах-* иогийн хэрэгжүүлэлт, *бхавати-* болдог, *духкха-ха-* зовлон зүдгүүрийг хөнгөлдөг.

Хоол унд, нойр, ажил, амралтаа зөв тохируулж чадаж байгаа хүн иогийг хэрэгжүүлснээр өөрийн бүхий л материаллаг зовлон зүдгүүрийг хөнгөлж чадна.

ТАЙЛБАР: Бие махбодийн хэрэгцээ болох эр эмийн харьцаа, биеэ хамгаалах, унтах, идэхээ хэтрүүлэх явдал нь иогийн зам мөрт ахиц дэвшил гаргахад саад тотгор учруулдаг. Зөвхөн ариуссан зоог буюу *прасадамыг* байнга хүртэж дадаж заншсанаар хоол ундны асуудал зохицуулагдана. Бхагавад Гитагийн (9.26)-д өгүүлснээр, Шри Кришнад ногоо, цэцэг, жимс, үр тариа, сүү... зэргийг өргөж болно. Иймээс Кришнагийн ухамсарт оршин байгаа хүн хүмүүст зориулагдаагүй болоод цэвэр ариуны ангилалд үл хамаарагдах зүйлсийг хоол хүнсэндээ хэрэглэхгүй байхад аяндаа өөрөө сурч дадаж заншдаг. Унтахын хувьд гэвэл Кришнагийн ухамсарт орших хүн Бурханд үйлчлэн зүтгэх өөрийн үүргээ биелүүлэхийн хүслэн байнгад болж байдаг учир тэр хэтрүүлэн унтаж өнгөрүүлсэн хугацааг асар их хохирол хэмээн үзэж байдаг. *Авьяртха-калатвам:* Кришнагийн чин бишрэлтэнгийн хувьд Кришнад үйлчлэн зүтгэх үйлнээс гадуур өнгөрөн алдагдаж байгаа түүний амьдралын минут бүр нь тэсвэрлэхийн аргагүй байдаг. Иймээс тэр унтах хугацаагаа хамгийн бага хэмжээнд байлгадаг. Энэ тал дээр, Кришнад үйлчлэн зүтгэх үйлэнд өөрийгөө байнгад зориулж байсан Шрила Рупа Госвами үлгэр дууриал болох бөгөөд тэрээр хоногт хоёроос илүүгүй цаг унтдаг байсан ба заримдаа бүр ийм хугацаагаар ч унтдаггүй байв. Мөн Тхакура Харидасад өдөр бүр Бурханы ариун гэгээн нэр алдрыг эрхин дээрээ гурван зуун мянган удаа давтан хэлэхээс нааш *прасадам* хүртэх болон хоромхон зуур ч дугхийх бодол төрдөггүй байв. Ажил үйлийн хувьд гэвэл Кришнаг ухамсарласан хүн нь Түүний таалалд үл нийцэх юуг ч хийддэггүй тул түүний үйл

ажиллагаа нь үргэлжид зохицуулагдсан, цэгц журамтай байхаас гадна мэдрэхүйн таашаал ханамж эдлэхтэй ямар ч холбоогүй байдаг. Түүнд мэдрэхүйн таашаал ханамж эдлэх талын хүсэл сонирхол огтхон ч төрдөггүй учир түүний хувьд материаллаг шинж чанартай зүйлээр оролдох хий дэмий хоосон цаг гардаггүй. Түүний ажил үйл, үг яриа, унтах, сэрүүн байх болон бие махбодийн бусад бүхий л үйл ажиллагаа нь зохицуулагдсан байх учир түүний хувьд материаллаг зовлон шаналал гэж байдаггүй.

ШҮЛЭГ 18

*яда виниятам читтам атманй эваватиштхате
нисприхах сарва-камебхьо юкта итй учьяте тада*

яда- хэрвээ, *виниятам-* онцгой эзэмдэн захирдаг, *читтам-* ухааныг болон түүний үйлийг, *атмани-* трансценденталь түвшинд, *эва-* гарцаагүй, *аватиштхате-* автдаг, *нисприхах-* хүслээс ангид, *сарва-* бүхий л төрлийн, *камебхьях-* материаллаг мэдрэхүйн таашаал ханамжаас, *юктах-* иогт батжин бэхжсэн, *ити-* ийм байдлаар, *учьяте-* гэж хэлдэг, *тада-* тэр цагт.

Иогч нь иогийг хэрэгжүүлснээр өөрийн ухааны үйл ажиллагааг удирдан жолоодож, материаллаг хүслээс ангид трансценденталь түвшинд дээшлэн хүрч очвоос түүнийг иогд бүрнээ батжин бэхжиж гэж ярьдаг.

ТАЙЛБАР: Иогч хүний үйлүүд нь жирийн хүмүүсийн үйлүүдээс, бэлгийн дур хүсэл хамгийн нэг дүгээрт тавигддаг материаллаг хүслүүдээсээ салж ангижирсан байдгаараа ялгаатай. Төгс төгөлдөр иогч нь өөрийн ухааныг цаашид ямар ч материаллаг хүсэл эрмэлзэлд өдөөгдөн үймрэхгүй болтол нь тийм сайн эзэмдэн захирсан байдаг. Шримад Бхагаватамын (9.418-20)-д батлан өгүүлсэнчлэн, Кришнагийн ухамсарт оршин байгаа хүн л энэхүү төгс төгөлдрийн түвшинд өөрөө аяндаа хүрдэг:

*са вай манах кришина-падаравиндайор
вачамси вайкунтха-гунануварнани
карау харер мандира-маржанадишу
шрутим чакарачьюта-сат-катходае*

*мукунда-лингалая-даршане дришау
тад-бхритья-гатра-спарше `нга-сангамам
гхранам ча тат-пада-сарожса-саурабхе
шримат туласья расанам тад-арпите*

*падау харех кшетра-паданусарпане
широ хришикеша-падабхивандане
камам ча дасье на ту кама-камьяя
ятхоттама-шлока-жанашрая ратих*

“Амбариша хаан эхлээд ухаанаа Шри Кришнагийн бадамлянхуа өлмийд чиглүүлэн дараа нь үг яриагаа Бурханы трансценденталь мөн чанарыг тодорхойлоход, гараа Бурханы сүмийг угааж цэвэрлэхэд, чихээ Бурханы үйл болоод зугаа наадмын талаар сонсоход, нүдээ Бурханы трансценденталь дүр хэлбэрийг ажиглан бясалгахад, биеэ чин бишрэлтэнгийн биетэй шүргэлцэхэд, үнэрлэх мэдрэхүйн эрхтэнээ Бурханд өргөсөн бадамлянхуа цэцгийг үнэрлэхэд, хэлээ Бурханы бадамлянхуа өлмийд өргөсөн *туласийн* навчийг амтлахад, хөлөө Бурханы сүм болоод ариун мөргөлийн газраар явахад, тэргүүнээ Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөхөд, хүслээ Бурханаас даалгасан үүргийг биелүүлэхэд зориулсан. Энэ бүх

трансценденталь үйлүүдийг Бурханы жинхэнэ чин бишрэлтэнгээс өөр хэн ч зохих ёсоор нь хийж гүйцэтгэж чадахгүй.”

Энэхүү трансценденталь түвшин нь бодьгал бусыг баримтлагчдын хувьд төсөөлж дүрслэхийн аргагүй байдаг бол дээр өгүүлсэн Махаража Амбаришагийн үйлээс үзэхэд Кришнагийн ухамсарт орших чин бишрэлтэнгүүдийн хувьд бодитой бөгөөд хүрэхэд хялбар байдаг юм. Ухаанаа Бурханы бадамлянхуа өлмийн тухай бодолд байнгад үл автуулах хүн эдгээр трансценденталь үйлүүдийг бодитойгоор үйлдэн хэрэгжүүлж чадахгүй. Иймд чин бишрэл дүүрэн бялхах албанд зүтгэхэд бүх мэдрэхүйгээ хамруулан оролцуулдаг бөгөөд ийм үйлийг *арчана* гэж нэрлэдэг. Мэдрэхүй болон ухаан нь байнгад идэвхтэй үйл хөдлөл хийж байхыг шаарддаг; үйлээс зүгээр л татгалзан тэднийг үгүйсгэх нь ямар ч боломжгүй хэрэг. Иймээс нийт хүмүүс, ялангуяа огоорохуйн амьдралын хэвшилд үл амьдрагч хүмүүсийн хувьд ухаан болоод мэдрэхүйгээ дээр өгүүлсэн байдлаар Бурханы трансценденталь албаны үйлэнд зүтгэхэд татан оролцуулах нь Бхагавад Гитад *юкта* гэж нэрлэдэг трансценденталь түвшинд хүрэх төгс төгөлдөр арга зам болдог.

ШҮЛЭГ 19

*ятха дипо нивата-стхо ненгате сопама смрита
йогина ята-читтасья юнжато йогам атманах*

ятха- яаж, *дипах*- дэн, *ниватастхах*- салхигүй газарт, *на*- үгүй, *ингате*- анивалздаг, *са*- энэ, *упама*- зүйрлэл, *смрита*- ажиглагддаг, *йогинах*- иогчийн, *ята-читтасья*- ухаанаа эзэмдэн захирсан, *юнжатах*- үргэлж автдаг, *йогам*- бясалгалд, *атманах*-трансцендентын тухай.

Салхигүй орчинд дэнгийн гэрэл анивалздаггүйн адил, ухаанаа эзэмдэн захирсан трансценденталист дотоод харцаа өөрийн жинхэнэ “Би”-д чиглүүлэн хандуулснаар бясалгалд тасралтгүйгээр умбадаг.

ТАЙЛБАР: Үргэлжид трансценденталь түвшинд орших, Кришнаг үнэхээрийн ухамсарласан бөгөөд өөрийн бишрэн шүтэх Бурханы тухай тасралтгүй хийгээд ямар ч саад тогторт ажралгүйгээр бясалгах хүн салхигүй орчинд байх дэнгийн дөл мэт тогтвортой байдаг.

ШҮЛЭГ 20-23

*ятропарамате читтам нируддхам йога-севая
ятра чайватманатманам пашьянн атмани тушьяти*

*сукхам атьянтикам ят тад буддхи- грахьям атиндриям
ветти ятра на чайваям стхитаи чалати таттватах*

*ям лабдхва чапарам лабхам маньяте надхикам татах
ясмин стхито на духкхена гурунапи вичалияте
там видьяд духкха-самйога-вийогам йога-самгьитам*

ятра- ийм байдалд, *упарамате*- орхидог (трансценденталь аз жаргалыг мэдэрсэн учраас), *читтам*- ухааны үйлийг, *нируддхам*- материас холдон хөндийрсөн, *йога-севая*- иогийг хэрэгжүүлснээр, *ятра*- энэ, *ча*- мөн, *эва*- гарцаагүй, *атмана*- цэвэр ариун ухаанаар, *атманам*- сүнс, *пашьян*- байр сууриа таньж мэдсэнээр, *атмани*- сүнсэнд, *тушьяти*- ханамжтай болно, *сукхам*- аз жаргал, *атьянтикам*- дээдийн дээд, *ят*- тэр, *тат*- энэ, *буддхи*- оюун ухаанаар, *грахьям*- боломжтой, *атиндриям*- трансценденталь, *ветти*- таньж мэддэг, *ятра*- түүнд, *на*- хэзээ ч үгүй, *ча*- мөн, *эва*- гарцаагүй, *аям*- тэр, *стхитах*- автдаг,

чалати- хөдөлдөг, *таттва*тах- үнэнээр, *ям*- энэ, *лабдхва*- хүрсэнээр, *ча*- мөн, *апарам*-ямар нэгэн өөр, *лабхам*- ашиг хонжоо, *маньяте*- ажигладаг, *на*- хэзээ ч үгүй, *адхикам*- илүү, *татах*- үүнээс, *ясмин*- энэнд, *стхитах*- автан байх, *на*- хэзээ ч үгүй, *духкхена*- зовлонгоор, *гуруна-апи*- маш хүнд хэцүү ч, *вичалияте*- цочирддог, *там*- үүнийг, *видьят*- чи мэдэх хэрэгтэй, *духкха-самйога*- материтай шүргэлцсэнээс үүсэх зовлон шаналал, *вийога*м- эцэс төгсгөл, *йога-самгьитам*- иог дахь транс гэж нэрлэгддэг.

Транс буюу самадхи гэж нэрлэгддэг төгс төгөлдөр түвшинд хүрсэн хүний ухаан нь материаллаг үйлээс бүрмөсөн салан холддог. Энэхүү төгс төгөлдөр байдал нь хүн өөрийн жинхэнэ “Би”-г цэвэр ариун ухаанаар харах болон өөрийн “Би”-ээс баяр хөөр, цэнгэл жаргалыг олох чадвараар тодорхойлогддог. Энэхүү баяр хөөр дүүрэн төлөв байдалд хүн трансценденталь мэдрэхүйгээрээ хэмжээ хязгааргүй трансценденталь аз жаргалыг эдэлдэг. Ийнхүү бат итгэлийг олсноор хүн үнэнээс хэзээ ч хазайн гаждаггүй бөгөөд энэ шатанд хүрснээр хүн үүнээс илүү ач тустай зүйл байдаггүй гэдгийг ойлгодог. Ийм байр сууринд хүрсэн хүн хэзээ ч, хамгийн их хүндрэл бэрхшээлтэй тулгарсан байсан ч цочирдолд ордоггүй. Үнэндээ энэ бол материтай хутгалдан зууралдсанаар үүсэн бий болсон бүхий л зовлонгоос жинхэнэ ангижирсан явдал юм.

ТАЙЛБАР: Иогийн зам мөрөөр замнаж байгаа хүн материаллаг үзэл бодлоосоо аажим аажмаар салан холддог. Энэ бол иогийн зарчмын хамгийн гол онцлог шинж юм. Үүний дараагаар хүн транс (*самадхи*)-д буюу өөрийн “Би”-г Бүхний Дээдтэй адилтган үзэж алдаа хийлгүйгээр трансценденталь ухаан хийгээд трансценденталь оюун ухаанаараа Параматмаг ойлгож ухаарах түвшинд хүрдэг. Иогийн зам мөр нь их бага ямар нэгэн хэмжээгээр Патанжалийн системийн зарчмууд дээр үндэслэгдсэн байдаг. Зарим эх сурвалж бус болох хүмүүс, бие даасан сүнс нь Параматматай адил юм хэмээн тайлбарлахыг оролдож байхад монистууд, үүнийг л бүрэн таньж мэдэх нь ангижрал юм гэж бодож, итгэж байдаг. Үүгээрээ тэдний аль аль нь Патанжалийн иогийн системийн жинхэнэ зарчмыг ойлгоогүй гэдгээ харуулдаг. Патанжалийн системд трансценденталь жаргал цэнгэлд хүрдэгийг хүлээн зөвшөөрдөг байхад, монистууд нь үүний улмаас хүмүүс тэдний нэг болохын онолд эргэлзэх болно гэж эмээснээс түүнийг хүлээн зөвшөөрдөггүй. Мэдлэг болон мэдэгч хоёрын хоорондын ялгааг монистууд хүлээн зөвшөөрдөггүй ч энэ шүлэгт трансценденталь мэдрэхүйгээр мэдрэх трансценденталь жаргал цэнгэл байдаг гэж тайлбарлаж байна. Үүнийг иогийн системийн алдарт төлөөлөгч болох Патанжали Муни мөн баталсан билээ. Энэхүү аугаа их мэргэн өөрийн “*Йога сутра*”-ын (3.34)-д тайлбарлахдаа: *пурушартха-шуньянам гунанам пратипрасавах кайвальям сварупа-пратиштха ва чити-шактир ити* гэсэн байдаг.

Энэхүү *чити-шакти*, дотоод эрчим нь трансценденталь. *Пурушартха* нь материаллаг бишрэл шүтлэг, эдийн засгийн хөгжил цэцэглэлт, мэдрэхүйн таашаал ханамж, төгсгөлд нь Бүхний Дээдтэй нэгдэн нэг болох эрмэлзэлд хамааралтай үг юм. Энэхүү “Бүхний Дээдтэй нэгдэн нэг болох”-ыг монистууд *кайвальям* гэж нэрлэдэг. Харин Патанжалийнхаар бол энэхүү *кайвальям* нь дотоод буюу трансценденталь эрчим бөгөөд түүний тусламжтайгаар амьд оршнол өөрийн жинхэнэ байр суурийг ухаарч ойлгодог. Шри Чайтанья энэхүү үйл явцыг *чето-дарпана-маржанам* буюу ухааны толийг бузраас ариусгах гэж нэрлэсэн байдаг. Энэхүү “ариусгал” нь чухамдаа жинхэнэ ангижрал буюу *бхава-маха-давагни-нирвапанам* юм. *Нирваны* онол нь мөн л урьдчилсан бэлтгэл мэдлэг бөгөөд энэхүү зарчимтай нийцэж тохирдог. Бхагаватамын (2.10.6)-д үүнийг *сварупена вьявастхитих* гэж нэрлэсэн байдаг. Бхагавад Гитагийн энэ шүлэгт ч энэ байр суурийг мөн бататгаж байна.

*Нирвана*д хүрсний дараа буюу материаллаг оршихуйгаа төгсгөл болгосноор амьд оршнол нь бурханлаг үйл үйлдэх буюу Бурханы чин бишрэл дүүрэн бялхах албанд зүтгэх, Кришнагийн ухамсрын түвшинд хүрдэг. Бхагаватамд өгүүлсэнчлэн, *сварупена вьявастхитих* буюу эндээс л “амьд оршнолын жинхэнэ амьдрал” эхэлдэг. *Майа* буюу хий хуурмаг нь бурханлаг амьдралын материаллаг бузраар хучигдсан нөхцөл байдал юм. Энэхүү материаллаг

бузраас ангижрана гэдэг бол амьд оршнолын анхдагч, мөнхийн байр суурийг устган үгүй хийнэ гэсэн үг биш. Патанжали үүнтэй мөн санал нэг байсан тул *кайвальям сварупа-пратиштва ва чити-шактир ити* гэж хэлсэн байдаг. Энэхүү *чити-шакти* буюу трансценденталь жаргал цэнгэл бол жинхэнэ амьдрал. Веданта судрын (1.1.12)-д энэ тухай *ананда-майо `бхьясат* гэж батлан өгүүлсэн байдаг. Энэхүү жам ёсны трансценденталь жаргал цэнгэл нь иогчийн дээдийн дээд зорилго байдаг бөгөөд энэхүү зорилгод Бурханы чин бишрэл дүүрэн бялхах албанд зүтгэснээр буюу *бхакти-йогын* тусламжтайгаар тун хялбар хүрч болно. *Бхакти-йогын* талаар Бхагавад Гитагийн долоо дугаар бүлэгт маш тодорхой өгүүлнэ.

Энэ бүлэгт тодорхойлон өгүүлж байгаачлан, иогийн системд *самадхийн* хоёр хэлбэр байдаг. Тэдгээрийг *сампрагьята-самадхи* болон *асампрагьята-самадхи* гэж нэрлэдэг. Трансценденталь байр сууринд философийн эрэл хайгуулын арга замаар хүрэхийг *сампрагьята-самадхи* гэж нэрлэдэг. Харин *асампрагьята-самадхи* түвшинд хүрсэн хүн нь мэдрэхүйн аз жаргалын ямар ч хэлбэрт трансценденталь байр суурьтай байдаг учир материаллаг таашаал ханамжтай ямар ч холбоогүй болдог. Иогч энэхүү трансценденталь байр сууринд нэг л автсан бол түүнээс хэзээ ч доошилж унадаггүй. Зөвхөн энэ түвшинд дээшлэн хүрч чадсан иогчийн хичээл чармайлт л амжилттай болж иогийн зам мөрөөр замнахын зорилгодоо хүрэх болно. Эдүгээ цагийн иог гэж нэрлэгдэх зүйлд мэдрэхүйн янз бүрийн таашаал ханамж эдлэх явдал зөвшөөрөгдсөн байдаг учир тэр өөрөө өөртэйгөө зөрчилдөж байдаг. Бэлгийн таашаал эдлэн, мансууруулах бодис хэрэглэж байгаа иогч бол энэ бүлэгт өгүүлж буй иогийн системийн зам мөрөөр замнаж буй иогчтой харьцуулахад элэг доог, тоглоом тохуу юм. Тэр бүү хэл *сиддхи* буюу ид шидтэй болохын хойноос чармайн байгаа иогч ч мөн төгс төгөлдөр бус гэж нэрлэгддэг. Иогийн зам мөрөөр замнан хэрэгжүүлэх явцдаа хажуугийн дагалдах илрэлүүдэд татагдан тэмүүлэх иогч нь энэ шүлэгт өгүүлсэнчлэн, төгс төгөлдөр түвшинд хүрч чадахгүй. Иймээс биеийн тамирын эсвэл *сиддхийн* үзүүлбэрийн төлөө иогоор хичээллэж байна хэмээн цагаа хий дэмий үрж буй хүмүүс нь иогийн жинхэнэ зорилгоос хазайн гажуудсан байна гэдгээ ойлгох хэрэгтэй.

Иогийн энэ цаг үе дэх хамгийн шилдэг сайн бөгөөд хялбар арга нь Кришнагийн ухамсар бөгөөд энэ арга замд хандсан хэн бүхэн урам хугарч итгэл алдрахгүй. Кришнаг ухамсарласан хүн нь өөрийн үйл хэрэгтээ маш их аз жаргалтай байдаг учир өөр ямар ч аз жаргалын хойноос тэмүүлдэггүй. Энэ бялангач цаг үед *хатха-йога, дхьяна-йога* эсвэл *гьяна-йогийн* зам мөрөөр замнахад маш их саад тотгор, хүндрэл бэрхшээлүүд учирдаг бол *карма-йога* болон *бхакти-йогийн* хувьд ийм асуудал тулгардаггүй.

Хүн материаллаг бие махбодид оршин байгаа цагт идэх, унтах, аюулаас хамгаалах болон өсөн үржих зэрэг бие махбодийн хэрэгцээ, шаардлагатай тулгарах хэрэг гарна. Харин цэвэр *бхакти-йогын* буюу Кришнагийн ухамсарт бие махбодийн хэрэгцээгээ хангаж байгаа хүний хувьд үүнийг өөрийн мэдрэхүүдээ таашаал ханамж эдлүүлэх байдлаар хийж үйлддэггүй. Тэрээр, бүтэл муутай ажил хэргээс хамгийн их ашиг хонжоо олох гэж ярьдагтай адил амьдралаа тэтгэж байх үндсэн шаардлагатай зүйлээр л хязгаарлагдгийн зэрэгцээ Кришнагийн ухамсарт трансценденталь жаргал цэнгэлээр цэнгэж байдаг. Тэрээр өөрийн үүргийг Кришнагийн ухамсарт, *бхакти-йогад* биелүүлэхээр эрс шийдвэртэйгээр чармайн зүтгэж байдаг бөгөөд түүнийг осол, өвчин, гачаал зовлон, тэр бүү хэл ойр дотныхных нь үхэл зэрэг санамсаргүй явдлууд ч зовоон түгшээдэггүй. Ямар ч гай тотгор түүнийг өөрийн үүргээ биелүүлэх явцад хэзээ ч саад тотгор болдоггүй. Бхагавад Гитагийн (2.14)-д өгүүлсэнчлэн: *агамапайино `нитьяс тамс титикшасва бхарата*. Тэр энэхүү урьдаас хүсэн хүлээгээгүй нөхцөл байдлууд нь ирж, одож байдаг түр зуурын бөгөөд түүний үүрэгт огтхон ч нөлөөлөхгүй гэж мэдэх учир энэ бүхнийг тэсвэрлэж байдаг. Ийм байдлаар л тэр иогийн дээдийн дээд төгс төгөлдөрт хүрдэг.

ШҮЛЭГ 24

са нишчаена йоктавьо його `нирвинна-четаса

*санкалпа-прабхаван камамс тьяктва сарван ашешатах
манасайвендриа-грамам виниямья самантатах*

сах- энэ, нишчаена- итгэлтэй шийдвэр төгс, йоктавьях- хэрэгжүүлэгдэх хэрэгтэй, йогах- иогийн систем, анирвинна-четаса- гажилтгүйгээр, санкалпа- ухаан бодлын цэцэрхийлэл, прабхаван- төрөгдсөн, каман- материаллаг хүсэл, тьяктва- орхисноор, сарван- бүх, ашешатах- бүрэн, манаса- ухаанаар, эва- гарцаагүй, индриа-грамам- мэдрэхүйн цогц, виниямья- зохицуулснаар, самантатах- бүх талаас нь.

Иогийн зам мөрөөр замнаж байгаа хүн итгэлтэй бөгөөд шийдвэр төгс байх хэрэгтэй, зам мөрөөсөө хазайн гажиж болохгүй. Ухаан бодлын цэцэрхийллээс төрөх материаллаг хүслүүдээ ямар ч ялгаварлалгүйгээр бүгдийг нь хаяж, орхих хэрэгтэй. Ингэж байж л мэдрэхүйнүүдээ бүхий л талаас нь ухаанаараа хянаж захирч чадна.

ТАЙЛБАР: Иогийн зам мөрөөр замнаж байгаа хүн энэ зам мөрөөсөө хазайн гажилгүй, бүрэн шийдвэр төгс бөгөөд тэсвэр тэвчээртэй байх ёстой. Тэрээр эцсийн амжилтандаа итгэлтэй байж энэ зам мөрийг тэвчээртэйгээр даган, хүссэн зорилгодоо даруйхан хүрэхгүй байгаад цөхөрч болохгүй. Эх сурвалжуудыг хэлбэрэлт гуйвалтгүй даган мөрдөж байгаа хүн амжилтанд хүрэх нь зайлшгүй. *Бхакти-йогатай* холбогдуулан Рупа Госвами хэлэхдээ:

*утсахан нишчаяд дхайрьят тат-тат-карма-правартанат
санга-тьягат сато-вриттех садхбир бхактих прасидхьяти*

“Хэрвээ хэн нэгэн хүн *бхакти-йогын* зам мөрийг урам зориг дүүрэн, тэсвэр тэвчээр, шийдвэр төгс даган, өөрт оноогдсон үүргээ чин бишрэлтэн нарын хүрээлэлд биелүүлж, үйлээ гагцхүү цэвэр ариунд үйлдэх аваас амжилтанд хүрэх нь тодорхой.” (Упадешамрита, 3)

Шийдвэр төгс байхын хувьд гэвэл, өндгөө далайн давалгаанд урсган алдсан бор шувууны үлгэр жишээг дагах хэрэгтэй. Тэр бор шувууны далайн эрэг дээр гаргасан өндгийг далайн давалгаа хаман авч урсган оджээ. Тэр шувуу маш ихээр гуниглан гашуудаж, өндгийг нь буцаан өгөхийг далайгаас гуйжээ. Далай түүний гуйлтыг огтхон ч анхаарч үзээгүй учраас бор шувуу далайн усыг хоослон шавхахаар шийдэж жижигхэн хошуугаараа усыг утгаж эхлэхэд эргэн тойронд нь байгсад түүний энэ үл биелэх, тэнэг шийдвэрийг шоолон инээлджээ. Энэ тухай мэдээ маш түргэн тархаж, Вишну Бурханы хүлэг аврага том шувуу, Гаруда хүртэл сонсжээ. Тэрээр өөрийн бяцхан дүүгээ өрөвдөн түүн рүү нисэн иржээ. Тэр энэ бяцхан шувууны шийдвэр төгс байдлыг хараад машид ихээр бахадсан тул туслахаар амлажээ. Гаруда далайд өндгийг нь гаргаж өгөхийг шаардаж, эс биелүүлвээс бор шувууны оронд түүнийг ховх сорон хоослоно хэмээн занан сүрдүүлжээ. Далай маш ихээр айж мэгдэн өндгийг тэр дор нь буцаан өгсөн. Ийнхүү Гаруда шувууны өршөөл нигүүлслээр бяцхан бор шувуу аз жаргалаа дахин олж авжээ.

Үүний нэгэн адил, иогийг хэрэгжүүлэх, ялангуяа Кришнагийн ухамсарт *бхакти-йогыг* хэрэгжүүлэх нь маш хүнд бэрх мэт санагдаж болох ч түүний зарчмуудыг шийдвэртэйгээр даган мөрдөж байгаа хүнд Бурхан туслан өршөөл нигүүлслээ хайрлах нь эргэлзээгүй юм. Учир нь гэвэл, өөрөө өөртөө тусалж байгаа хүнд Бурхан тусалдаг.

ШҮЛЭГ 25

*шанайх шанайр упарамед буддхья дхрити-грихитая
атма-самстхам манах критва на кинчид апи чинтает*

шанайх-аажмаар, шанайх- алхам алхмаар, упарамет- хойш татах ёстой, буддхья- оюун ухаанаар, дхрити-грихитая- итгэл үнэмшил дээр үндэслэн, атма-самстхам- трансцендентэд

чиглэдэг, *манах*- ухаан, *критва*- хийснээр, *на*- үгүй, *кинчит*- өөр ямар нэгэн зүйл, *апи*- тэрч бүү хэл, *чинтает*- бодох ёстой.

Итгэл үнэмшил дүүрэн байж оюун ухааныхаа дэмжлэгтэйгээр хүн аажмаар, алхам алхмаар трансын байдалд автан умбах ёстой. Ингэснээр ухаанаа гагцхүү өөртөө төвлөрүүлэх ёстой бөгөөд өөр юуны ч тухай бодох ёсгүй.

ТАЙЛБАР: Жинхэнэ итгэл үнэмшил болон оюун ухааны дэмжлэгтэйгээр хүн мэдрэхүйн үйл ажиллагаагаа аажим аажмаар орхин түүнээс холдон салж болдог. Үүнийг *прагьяхара* гэж нэрлэдэг. Ухаанаа мэдрэхүйн үйл ажиллагаанаас салгаж холдуулан итгэл үнэмшил, бясалгалын замаар эзэмдэн захирах аваас тэр *самадхи* (транс)-д автан орж умбах ёстой. Тэгсэн цагт хүн материаллаг амьдралын үзэл бодолд дахин унах аливаа аюул нүүрлэхгүй болно. Өөрөөр хэлбэл, материаллаг бие махбодид оршин байгаа цагтаа хүн материтай хутгалдан байдаг боловч мэдрэхүйн таашаал ханамж эдлэх тухай бодох ёсгүй. Дээд Сүнсэнд цэнгэл, жаргал эдлүүлэхээс өөр ямар ч цэнгэл жаргалын тухай бодох ёсгүй. Кришнагийн ухамсрын зам мөрд шууд орон замнаснаар энэ түвшинд төвөггүй хүрч болно.

ШҮЛЭГ 26

*ято ято нишчалати манаши чанчалам астхирам
татас тато ниямьяятад атмани эва вашам нает*

ятах ятах- хаашаа ч, *нишчалати*- маш их өдөөдөгддөг, *манах*- ухаан, *чанчалам*- хөнгөн хийсвэр, *астхирам*- тууштай биш, *татах- татах*- тэндээс, *ниямья*- зохицуулсанаар, *этан*- үүнийг, *атмани*- өөртөө, *эва*- гарцаагүй, *вашам*- ноёрхол, *нает*- доор авчрах хэрэгтэй.

Ухаан хувирамтгай, тууштай биш мөн чанартай байдгийн улмаас хаашаа ч хамаагүй хэсүүчлэн явчих тул түүнийг тухай бүрд нь эргүүлэн авчирч өөрийн “Би” буюу сүнсний хяналт захиргаанд оруулах хэрэгтэй.

ТАЙЛБАР: Ухаан нь мөн чанарын хувьд хувирамтгай бөгөөд тууштай бус байдаг. Гэхдээ өөрийгөө бүрэн нээж, танин мэдсэн иогч нь ухаанаа эзэмдэн захирч, залдаг байх ёстой. Ухаан нь түүнийг биш. Өөрийн ухааныг (тэгснээрээ мэдрэхүйгээ) эзэмдэн захирч чадаж байгаа хүнийг *свами* буюу *госвами*, харин өөрийн ухааны эрхшээл захиргаанд байгаа хүнийг *го-даса* буюу мэдрэхүйн боол гэж нэрлэдэг. *Госвами* хүн жинхэнэ мэдрэхүйн баяр цэнгэл гэж юу болохыг мэднэ. Энэ бол мэдрэхүйн дээдийн дээд эзэн захирагч Кришнагийн буюу Хришикешагийн албанд мэдрэхүйнүүдээ хамруулж оролцуулан зүтгэж байх трансценденталь түвшин дэх мэдрэхүйн баяр цэнгэл билээ. Кришнад ариуссан мэдрэхүйгээр зүтгэн байхыг Кришнагийн ухамсар гэж нэрлэдэг. Чухамхүү энэ нь л мэдрэхүйгээ эзэмдэн захирах арга зам, үйл явц мөн болохын зэрэгцээ иогийн дээдийн дээд төгс төгөлдөр болно.

ШҮЛЭГ 27

*прашанта-манасам хи энам йогинам сукхам уттамам
упайти шанта-ражасам брахма-бхутам акалмасам*

прашанта- Кришнагийн бадамлянхуа өлмийд чиглэсэн, тайван амгалан, *манасам*- түүний ухаан, *хи*- үнэхээр, *энам*- энэ, *йогинам*- иогч, *сукхам*- аз жаргал, *уттамам*- дээдийн дээд, *упайти*- хүрдэг, *шанта-ражасам*- өөрийн хүсэл тачаалыг тайтгаруулдаг, *брахма-бхутам*- Үнэмлэхүйтэй адилтгаснаар ангижрал, *акалмасам*- бүхий л өнгөрсөн нүгэлт үр дагавруудаас ангижирдаг.

Ухаан нь Надад төвлөрөн байгаа иогчид нь трансценденталь цэнгэл жаргалын дээдийн дээд түвшинд баттай хүрдэг. Тэрээр хүсэл тачаалын гунын нөлөөлөл, хүрээний чанадад орших бөгөөд өөрийгөө Бүхний Дээдтэй чанарын хувьд адил болохыг таньж мэдэх тул өнгөрсөн үйлүүдийнхээ бүх үр дагавраас салан ангижирдаг.

ТАЙЛБАР: Хүн материаллаг бузраас ангижран Бурханы трансценденталь албанд зүтгэх үйлэнд өөрийгөө зориулах түвшинг *брахма-бхута* гэж нэрлэдэг. *Мад-бхактим лабхате парам* (Бг.18.54). Ухаанаа Бурханы бадамлянхуа өлмийд төвлөрүүлээгүй байсан цагт Үнэмлэхүйн буюу Брахманы түвшинд хүрж чадахгүй. *Са вай манах кришина-падаравиндайох*. Бурханы трансценденталь хайр дүүрэн бялхах албанд үргэлжид зүтгэж байх буюу Кришнагийн ухамсарт оршин байна гэдэг нь хүсэл тачаалын гунын нөлөөллөөс болон бүхий л материаллаг бузраас үнэхээрийн ангид байна гэсэн үг.

ШҮЛЭГ 28

*юнжанн эвам садатманам йоги вигата-калмашах
сукхена брахма-самспаршам атьянтам сукхам ашнуге*

юнжан- иогд зүтгэн байгаа, *эвам*- ийм байдлаар, *сада*- үргэлж, *атманам*- сүнс, *йоги*- Дээд Сүнстэй холбоотой байх тэр, *вигата*- ангижирдаг, *калмашах*- бүхий л материаллаг бузраас, *сукхена*- трансценденталь аз жаргалд, *брахма-самспаршам*- үргэлж Бүхний Дээдтэй холбоонд, *атьянтам*- дээдийн дээд, *сукхам*- аз жаргал, *ашнуге*- хүрдэг.

Иогийн үйл явцдаа тасралтгүйгээр автан умбах, өөрийгөө эзэмдэн захирсан иогч нь ийм байдлаар бүхий л материаллаг бузраас ангижрах бөгөөд Бурханы трансценденталь хайрын алба дахь төгс төгөлдөр аз жаргалын дээдийн дээд түвшинд хүрдэг.

ТАЙЛБАР: Өөрийгөө бүрэн нээж, танин мэднэ гэдэг нь Бурхантай холбогдсон өөрийн жинхэнэ байр суурийг таньж мэднэ гэсэн үг. Бие даасан сүнс нь Бүхний Дээдийн өчүүхэн жижиг хэсэг бөгөөд тэрээр Бурханы трансценденталь албанд үйлчлэн зүтгэх байр суурьтай байдаг. Бүхний Дээдтэй холбогдсон энэхүү трансценденталь хэлхээ холбоог *брахма-самспарша* гэж нэрлэдэг.

ШҮЛЭГ 29

*сарва-бхута-стхам атманам сарва-бхутани чатмани
икшате йога юктатма сарватра сама-даршанах*

сарва-бхута-стхам- бүхий л оршнолд залрах, *атманам*- Дээд Сүнс, *сарва*- бүх, *бхутани*- амьд оршнол, *ча*- мөн, *атмани*- өөртөө, *икшате*- хардаг, *йога-юкта-атма*- Кришнагийн ухамсарт бат холбогдсон тэр, *сарватра*- хаа сайгүй, *сама-даршанах*- адилаар хардаг.

Жинхэнэ иогч нь Намайг бүхий л оршнол дотор залран байгааг, мөн оршнол бүр Миний дотор оршин байдгийг харж байдаг. Өөрийгөө бүрэн нээж, таньж мэдсэн сүнс нь Бурханы Дээд Бодьгал, Намайг хаа сайгүй залран байгааг харж байдаг билээ.

ТАЙЛБАР: Кришнаг ухамсарласан иогч нь Дээдийн Дээд, Кришнаг бүгдийн зүрхэнд Параматма дүрээр залран байгааг харж байдаг тул төгс төгөлдөр хараатай юм. *Ишвараксарва-бхутанам хрид-деше ржуна тиштхати*. Бурхан Өөрийн Параматма дүрээр нохойны зүрхэнд ч, мөн *брахманы* зүрхэнд ч залран байдаг. Төгс төгөлдөрт хүрсэн иогч нь Бурхан нохойны

зүрхэнд эсвэл *брахманы* зүрхэнд залран байсан ч материтай огтхон ч шүргэлцэн хүрэлцдэггүй бөгөөд мөнхийн трансценденталь гэдгийг мэддэг. Энэ бол Бурханы дээдийн дээд үл хутгалдах шинж чанар юм. Бие даасан сүнс нь мөн бие даасан зүрхэнд оршдог. Гэхдээ зөвхөн тухайн тэр зүрхэнд л оршин байхаас бүгдэд биш. Үүнд л бие даасан сүнс болон Дээд Сүнс, Параматма хоёрын ялгаа оршдог. Иогийн жинхэнэ зам мөрөөр ороогүй хүн ингэж тод томруунаар харж чадахгүй. Кришнаг ухамсарласан хүн Бурханыг хаа сайгүй, бишрэн шүтэгчийн ч зүрхэнд, мөн эс бишрэн шүтэгчийн ч зүрхэнд залран байгааг харж байдаг билээ. *Смритид* энэ тухай дараах байдлаар батлан өгүүлсэн байдаг: *атататвач ча матритвач атма хи парамо харих*. Бурхан бүх амьд оршнолын эх булаг болох учраас Тэрээр эх хүний адил тэдэнд бүгдэд нь санаа тавьж байдаг. Эх хүн өөрийн үр хүүхдүүдэд адил хандаж байдагтай адил дээдийн дээд Эцэг (дээдийн дээд Эх) мөн тэгж ханддаг. Ийм учраас Параматма нь бүх амьд оршнолуудад нэгэн адил залран байдаг бөлгөө.

Нөгөө талаас, амьд оршнол бүр нь Кришнад буюу бүр тодруулбал Түүний эрчимд оршин байдаг. Бурхан, бурханлаг (буюу дээд), материаллаг (буюу доод) гэсэн үндсэн хоёр эрчимтэй байдаг гэдгийг долоо дугаар бүлэгт тайлбарлах болно. Амьд оршнол нь хэдийгээр дээд эрчмийн хэсэг мөн болох ч доод эрчмийн эрхшээлд орж болзолдож нөхцөлдсөн байдалд ордог. Гэхдээ амьд оршнол нь аль ч тохиолдолд байсан Бурханы эрчимд оршин байдаг. Амьд оршнол нь иймээс дээрхийн аль нэгэн байдлаар Түүний дотор оршин байдаг.

Төгс төгөлдөрт хүрсэн иогч, амьд оршнолууд нь өөрсдийн үйлийн үр дагавраас хамааран янз бүрийн байр суурь эзлэн байгаа хэдий ч, ямар ч нөхцөл байдалд байсан тэд бүгд л Бурханы албат, үйлчлэгчид гэдгийг харж байдаг учраас тэрээр тэднийг буюу бүх амьд оршнолуудыг нэг л ижил байдлаар хардаг. Материаллаг эрчимд оршин байх амьд оршнол нь материаллаг мэдрэхүйдээ зүтгэн байдаг бол бурханлаг эрчимд оршносоор тэрээр Бүхний Дээд Бурханд шууд үйлчлэн зүтгэж байдаг. Энэ хоёр тохиолдлын алинд нь ч байсан амьд оршнол нь Бурханы албат, үйлчлэгч мөн бөлгөө. Амьд оршнолуудыг ийнхүү адил байдлаар харах ийм харааг Кришнагийн ухамсарт байх хүн л төгс төгөлдөр хэмжээгээр агуулдаг.

ШҮЛЭГ 30

*йо мам пашьяти сарватра сарвам ча майи пашьяти
тасьяхам на пранашьями са ча ме пранашьяти*

яx- тэр, *мам-* Намайг, *пашьяти-* хардаг, *сарватра-* хаа сайгүй, *сарвам-* бүгд, *ча-* болон, *майи-* Миний дотор, *пашьяти-* хардаг, *тасья-* түүний хувьд, *ахам-* Би, *на-* үгүй, *пранашьями-* алдагдсан, *сах-* тэр, *ча-* мөн, *ме-* Миний хувьд, *на-* үгүй, *пранашьяти-* алдагдсан.

Намайг хаа сайгүй харж байгаа болон оршин байгаа бүхнийг Миний дотор харж байгаа хүн Надаас хэзээ ч холдон одохгүй, мөн Би түүнийг хэзээ ч орхихгүй.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсарт оршин байгаа хүн Кришнаг хаа сайгүй харж байгаа нь эргэлзээгүй хэрэг бөгөөд түүний зэрэгцээ бүхнийг Кришнагийн дотор оршин байхыг харж байдаг. Ийм хүн материаллаг байгалийн янз бүрийн хэлбэрүүдийг бүгд салангид тусдаа илрэл тодролууд мэтээр харж байгаа юм шиг санагдаж болох ч эргэн тойрны бүх зүйлс нь дан ганц Кришнагийн эрчмийн илрэл гэдгийг мэдэх тул тэр ямар ч тохиолдолд Кришнаг ухаарч байдаг. Кришнагүйгээр юу ч оршиж чадахгүй бөгөөд Кришна бол бүх зүйлийн эзэн – энэ бол Кришнагийн ухамсрын үндсэн зарчим. Кришнагийн ухамсар-энэ бол Кришнаг хайрлах хайраа хөгжүүлэх явдал мөн бөгөөд энэ түвшин нь материаллаг ангижрахууд ч трансценденталь байдаг. Энэ түвшин нь өөрийгөө бүрэн нээж танин мэдэхээс ч дээш, түүний чанадад байх бөгөөд тэнд хүрсэн чин бишрэлтэнгийн хувьд Кришна түүний бүх зүйл болж, тэр Түүнийг хайрлах хайраар бялхан байдаг бөгөөд энэ утгаараа тэд нэгдмэл болдог. Тэгснээр Кришна

болон Түүний чин бишрэлтэн хоёрын хооронд ойр дотно харьцаа бий болно. Энэ түвшинд хүрсэн ч чин бишрэлтэн нь бие даасан байдлаа алддаггүй бөгөөд Бурханы Дээд Бодьгал түүний хараанаас дахин хэзээ ч алдардаггүй. Кришнад уусан нэгдэх нь бурханлаг устал сүйрэл юм. Чин бишрэлтэн нь өөрийгөө ийм аюул эрсдэлд учруулдаггүй. Брахма-самхитагийн (5.38)-д өгүүлэхдээ:

*преманжана-ччурита-бхакти-вилочанена
сантах садайва хридаешу вилокаянти
ям шьямасундарам ачинтья-гуна-сварупам
говиндам ади-пурушам там ахам бажами*

“Би хайрын бальзамаар нүд нь чийгшсэн чин бишрэлтэнгийн үргэлж тольдон харж байдаг анхдагч Бурхан, Говиндад бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөм үү. Тэрээр чин бишрэлтэнгийнхээ зүрхэнд Шьямасундара байдлаар залран байх Түүний мөнхийн дүрийг тольдон хармуй.”

Энэ түвшинд хүрсэн чин бишрэлтэн нь Бурханыг хараанаасаа хэзээ ч алддаггүйн адил Шри Кришна чин бишрэлтэнгийнхээ хараанаас хэзээ ч холдон оддоггүй. Бурханыг өөрийн зүрхэндээ залрах Параматма дүрээр нь харж байгаа иогчийн хувьд мөн адил ийм байдаг. Ийм иогч нь цэвэр чин бишрэлтэн болон дэвшин дээшлэх бөгөөд өөрийн дотооддоо залрах Бурханыг харалгүйгээр хоромхон зуур ч байж чаддаггүй.

ШҮЛЭГ 31

*сарва-бхута-стхитам йо мам бхажатй экатвам астхитах
сарватха вартамано `ни са йоги майи вартате*

сарва-бхута-стхитам- бүгдийн зүрхэнд залардаг, *ях-* тэр, *мам-* Надад, *бхажати-* чин бишрэл дүүрэн бялхах албанд зүтгэдэг, *экатвам-* нэгдэлд, *аштхитах-* оршдог, *сарватха-* бүх талаар, *вартаманаш-* оршдог, *апи-* ч, *сах-* тэр, *йоги-* трансценденталист, *майи-* Миний дотор, *вартате-* үлддэг.

Би болон бүх амьд оршнолуудын дотоодод залрах Параматма нь нэг юм гэдгийг мэдэх иогч Надад бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн зүтгэж байдаг бөгөөд ямар ч нөхцөлд, үргэлж Миний дотоодод байдаг болно.

ТАЙЛБАР: Дээд Сүнс, Параматмаг бясалган байгаа иогч нь Кришнагийн бүрэн хувилгаан дүр болох бадамлянхуа цэцэг, шийдэм, галт хүрд, лавай зэргийг барьсан дөрвөн мутар бүхий Вишнуг өөрийн дотооддоо харж байдаг. Ийм иогч нь, Вишну бол Кришнагаас ялгаатай биш гэдгийг тодорхой мэдэж байх ёстой. Кришна Дээд Сүнс буюу Параматма дүрээрээ бүгдийн зүрхэнд залран байдаг. Иймээс тоо томшгүй олон амьд оршнолуудын зүрхнээ залран байх тоо томшгүй олон Параматмуудын хооронд ялгаа байдаггүй. Мөн Кришнагийн трансценденталь хайраар дүүрэн бялхах албанд байнгад зүтгэн байгаа, Кришнаг ухамсарласан хүн болон Параматмад төвлөрөн Түүнийг бясалган байгаа төгс төгөлдөр иогчийн хооронд ялгаа байдаггүй. Кришнагийн ухамсарт оршин байгаа иогч нь хэдийгээр материаллаг оршихуйд оршин янз бүрийн үйл үйлдэн байх боловч үргэлж Кришнад автан умбаж байдаг. Шрила Рупа Госвами энэ тухай Бхакти-расамрита-синдху-гийн (1.2.187)-д: *никхилешу авастхасу живанмукта са учьяте* гэж батлан өгүүлсэн байдаг. Үйл хэргээ Кришнагийн ухамсарт байнгад явуулж байх Бурханы чин бишрэлтэн нь өөрөө аяндаа ангижралд хүрдэг. Энэ тухай Нарада-панчаратра-д дараахь байдлаар батлан өгүүлсэн байдаг:

дик-каладй-анаваччинне кришне чето видхая ча

тан-майо бхавати киширам живо брахмани йожает

“Цаг хугацаа, орон зайнаас чанадад оршихын зэрэгцээ бүхэнд нэвчин залрах Кришнагийн трансценденталь дүрд анхаарлаа төвлөрүүлснээр хүн Кришнагийн тухай бодолд бүрэн автах бөгөөд тэгснээр Түүнтэй трансценденталь түвшинд харьцах аз жаргалант байдалд хүрнэ.”

Кришнагийн ухамсар бол иогийн зам мөр дэх трансын хамгийн дээд түвшин. Кришна Параматма дүрээр бүхний зүрхэнд залран байдаг гэсэн энэхүү ойлголт л иогчийг бүхий л төгс төгөлдөр бус байдлаас нь ангижруулдаг. Бурханы энэхүү ойлгож хүртэхийн аргагүй аугаа их хүч чадлыг Ведэд (Гопала-тапни Упанишад, 1.21): *эко `пи сан бахудха йо `вабхати-* буюу “Бурхан хэдийгээр цор ганцаар боловч Тэрээр тоо томшгүй олон зүрхэнд заларснаар олон болдог.” гэж батлан өгүүлсэн байдаг. Мөн *смрити-шастирт* өгүүлэхдээ:

*эка эва паро вишнух сарва-вьяти на самшаях
айшварьяд рупам экам ча сурья-ват бахудхяте*

“Вишну бол ганц, гэхдээ Тэр бүхэнд нэвчин хаа сайгүй залран байдаг. Тэр хэдийгээр үл хуваагдах нэгэн дүртэй ч Өөрийн төсөөлөхийн аргагүй хүч чадлаараа хаа сайгүй залран байдаг. Яг л нар адил, Тэр олон газар нэгэн зэрэг илэрдэг.”

ШҮЛЭГ 32

*атмаупамьена сарватра самам пашьяти йо `ржуна
сукхам ва яди ва духкхам са йоги парамо матах*

атма- өөртэйгөө, *аупамьена-* харьцуулснаар, *сарватра-* хаа сайгүй, *самам-* адил, ялгаагүй, *пашьяти-* хардаг, *ях-* тэр, *аржуна-* Аржуна минь, *сукхам-* аз жаргал, *ва-* эсвэл, *яди-* хэрвээ, *ва-* эсвэл, *духкхам-* зовлон шаналал, *сах-* иймэрхүү, *йоги-* иогч, *парамах-* төгс төгөлдөр, *матах-* тооцогддог.

Ай Аржуна минь ээ, Амьд оршнолуудыг өөрийн "Би"-гэй харьцуулснаар аз жаргалтай ч бай, зовлон гунигтай ч бай тэд бүгд адил юм гэдгийг олж харсан хүн л төгс төгөлдөр иогч юм.

ТАЙЛБАР: Кришнаг ухамсарласан хэн бүхэн төгс төгөлдөр иогч юм. Тэр өөрийн хувийн туршлагын үндсэн дээр бусдын жаргал болоод зовлонг ойлгож ухаардаг. Амьд оршнолын зовлонгийн шалтгаан нь тэр Бурхантай холбогдсон харьцаа холбоогоо мартсанд л байдаг. Харин тэд баяр хөөр, аз жаргалтай байдгийн учир шалтгаан нь Кришна бол хүний бүхий л үйлийн дээдийн дээд таашаан болгоогч, мөн Тэр бүх газар дэлхий, од гаригуудын эзэн бөгөөд бүх амьд оршнолуудын үнэнч найз нөхөр нь гэдгийг танин мэдсэнд оршдог. Амьд оршнол нь Кришнаатай холбогдсон холбоо харьцаагаа мартаж умартсанаас л материаллаг мөн чанарын гунуудын эрхшээлд эрсдэн унаж нөхцөлдөж болзолдсон байдалд орж материаллаг гурвалсан зовлонгийн нөлөөлөлд нэрвэгддэг гэдгийг тэр мөн мэддэг билээ. Кришнагийн ухамсарт орших хүн аз жаргалтай байдаг учраас Кришнагийн тухай мэдлэгийг хаа сайгүй түгээн дэлгэрүүлэхийг хичээж байдаг. Төгс төгөлдөр иогч нь Кришнаг ухамсарлах нь ямар чухал болохыг бусдад ойлгуулж итгүүлэхийг чармайн хичээж байдаг учир ертөнцийн хамгийн их ачтан бөгөөд Бурханы хамгийн хайртай албат үйлчлэгч нь юм. *На ча тасман манушьешу кашчин ме прия-криттамах* (Бг, 18.69). Өөрөөр хэлбэл Бурханы чин бишрэлтэн нь бүх амьд оршнолуудын сайн сайхны төлөө үргэлж санаа тавьж байдаг учраас тэр чухамдаа бүгдийн нь жинхэнэ найз нөхөр юм. Тэр зөвхөн өөрийн төгс төгөлдөрийн төлөө биш, мөн бусад бүгдийн төгс төгөлдөрийн төлөө ч хичээн чармайж байдаг учраас хамгийн шилдэг иогч билээ. Тэр бусдад үл атаархана. Бурханы цэвэр чин бишрэлтэн нь энэ байдлаараа зөвхөн өөрийн төгс

төгөлдрийн төлөө хичээн чармайх иогчоос ялгаатай байдаг. Төгс төгөлдөр байдлаар бясалгахын тулд эзэнгүй, аглаг зэлүүд газарт зорин очсон иогч нь, хүн бүрийг Кришнагийн ухамсрын зам мөрд хандуулахыг бүхий л чадлаараа хичээн чармайж байгаа Кришнагийн цэвэр чин бишрэлтэн адил тийм төгс төгөлдөр биш юм.

ШҮЛЭГ 33

аржуна увача

йо`ям йогас твая проктах самьена мадхусудана

этакьяхам на пашьями чанчалатват стхитим стхирам

аржунах увача- Аржуна айлтгасан нь, *ях аям-* энэ систем, *йогах-* ид шид, *твая-* Танаар, *проктах-* тодорхойлсон, *самьена-* шөрөнхийдөө, *мадху-судана-* Мадху демоныг хөнөөн дарагч минь, *этакья-* эдгээрээс, *ахам-* би, *на-* үгүй, *пашьями-* харж байна, *чанчалатват-* тэр тайван бус учраас, *стхитим-* байр суурь, *стхирам-* тогтвортой.

Аржуна айлтгасан нь: Ай Мадхусудана минь ээ, ухаан тайван бус, мөн тууштай бус байдаг учраас Таны надад товчхон айлдаж буй иогийн энэ систем нь миний хувьд хэрэгжүүлэхийн аргагүй юм.

ТАЙЛБАР: Аржуна нь, Шри Кришнагийн айлдаж буй *шучау деше* гэж эхлэн *йоги парамах* гэсэн үгээр дуусаж байгаа иогийн энэ зам мөрийг дагаж мөрдөх чадваргүй гэдгээ мэдэрч байгаа тул түүнээс татгалзаж байна. Энэхүү Калийн цаг үед жирийн хүмүүсийн хувьд гэр орноо орхин аглаг зэлүүд газарт, ууланд эсвэл ойд очин иогоор хичээллэн хэрэгжүүлэх нь боломжгүй юм. Энэ цаг үе нь богинохон зуур үргэлжлэх амьдралын төлөөний улайран тэмцэх тэмцлээр тодорхойлогддог. Хүмүүс өөрийгөө бүрэн нээж, танин мэдэх явдалд хандах нухацтай сонирхолгүй байдаг. Үүний тулд хамгийн хялбар арга замыг ч сонгон замнахыг хүсэхгүй байгаа тэдэнд ухаанаа материаллаг үйлээс бүрэн холдуулан хөндийрүүлж, оршин байх газар орноо зөв сонгон, зөв зохистой байрлалаар суух зэрэг хатуу чанга дэглэм, журам бүхий амьдралын хэв маягийг өөртөө агуулах иогийн хүнд хэцүү системийн талаар ярихын ч хэрэггүй билээ. Аржуна хэдийгээр олон гайхамшигт сайн шинж чанаруудыг агуулж байсан хэдий ч бодит байдлыг зөвөөр ойлгож харж байгаа хүний хувьд тэрээр энэхүү иогийн системийг даган хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж байна. Тэр хааны гэр бүлийн гишүүн бөгөөд өөрийн олон олон сайн шинж чанаруудын улмаас өндөр дээд байр суурийг эзэлж байсан. Аржуна мөн аугаа баатар дайчин эр байсны зэрэгцээ түүнд урт удаан амьдрал заясан байлаа. Гэхдээ хамгийн гол нь тэрээр Бурханы Дээд Бодьгал, Кришнагийн хамгийн дотнын итгэлт сайн нөхөр нь байлаа. Таван мянган жилийн өмнө Аржуна, өнөөгийн биднийг бодоход хавьгүй илүү сайн нөхцөл боломжтой байсан ч энэхүү иогийн зам мөрөөр замнахаас татгалзаж байв. Бид түүхийн ямар ч эх сурвалжид Аржунаг хэзээ нэгэн цагт иогийн энэхүү төрлийн зам мөрийг даган хэрэгжүүлж байсан гэсэн баримт баталгааг олохгүй. Иймээс иогийн энэ системийг хэрэгжүүлэх явдал Кали *югад* ерөнхийдөө боломжгүй юм гэдгийг бодитойгоор харах хэрэгтэй. Энэ нь магадгүй маш цөөхөн, ховор хүмүүсийн хувьд боломжтой байж болох ч нийт олны хувьд бүтэшгүй, боломжгүй хэрэг. Таван мянган жилийн өмнө ийм байсан зүйл өнөөдөр хэрхэн боломжтой байх билээ дээ? Энэхүү иогийн системийг иогийн нийгэмлэг буюу сургууль гэж нэрийдэх байгууллагуудад дуурайн хийж байгаа хүмүүст энэ нь бахархалтай, урамтай сайхан байх мэт боловч үнэн хэрэгтээ тэд цагаа хий дэмий хоосон өнгөрүүлж байгаа хэрэг. Эдгээр хүмүүс нь иогийн жинхэнэ зорилготой харьцуулан үзвэл харанхуй мунхагт оршиж байдаг.

ШҮЛЭГ 34

*чанчалам хи манах кришна праматхи балавад дридхам
тасьяхам ниграхам манье вайор ива су-душкарам*

чанчалам- хөнгөн хийсвэр, хи- тодорхой, манах- ухаан, кришна- Кришна минь, праматхи- тайван бус, бала-ват- хүчтэй, дридхам- зөрүүд, тасья- түүний, ахам- би, ниграхам- ялан дийлснээр, манье- би бодож байна, вайох- салхийг, ива- яаж, су-душкарам- хүнд.

Учир нь ухаан тайван бус, догшин, зөрүүд бөгөөд маш хүчирхэг. Ай Кришна минь ээ, түүнийг эзэмдэн захирна гэдэг миний бодлоор бол салхийг хянан удирдахаас ч хэцүү бэрх юм.

ТАЙЛБАР: Ухаан нь хэдийгээр оюун ухаанд захирагдсан байр суурьтай байдаг ч заримдаа түүнийг дийлж чадахуйц хүчтэй бөгөөд зөрүүд болдог. Өдөр тутмын амьдралын олон тооны саад бэрхшээл, зөрчилдөөнтэй байдлуудтай тулгаран тэмцэлдэж байдаг хүний хувьд ухаанаа эзэмдэн захирна гэдэг мэдээж хэрэг маш хэцүү хэрэг. Найз нөхөр болон дайсан этгээддээ зохиомол байдлаар адил тэгш хандаж болох ч энэ нь догшин салхи, шуургыг номхруулахаас ч хэцүү учир эцсийн эцэст материаллаг хүмүүсийн хэнд нь ч үүнийг ийнхүү цаашид хэвээр хадгалан үргэлжлүүлэх хүч чадал байдаггүй. Ведийн судруудад (Катха Упанишад, 1.3.3-4) өгүүлэхдээ:

*атманам ратхинам виддхи шарирам ратхам эва ча
буддхим ту саратхим виддхи манах праграхам эва ча*

*индрияни хаян ахур вишаямс тешу го-чаран
атмендрия-mano-юктам бхоктетй ахур манишинах*

“Бие даан орших сүнс нь материаллаг бие махбодийн тэргэн дотор сууж яваа аялагч бөгөөд оюун ухаан нь тэрэгний хөтөч. Жолоо нь ухаан, морьд нь мэдрэхүйнүүд. Сүнс нь ийм маягаар ухаан болон мэдрэхүйн хамтаар сайн, муу үр дагавраа амсаж эдлэн нэг бол таашаал ханамж эдэлж эсвэл зовон шаналж байдаг. Аугаа их сэтгэгчид ингэж тодорхойлсон байдаг.”

Чухамдаа бол оюун ухаан нь ухаанаа удирдан залж байх ёстой байдаг ч аюултай халдварт өвчин эмийн анагаах үйлчлэлд тэр бүр дарагддаггүйн адил, ухаан нь хүчирхэг болоод зөрүүд учраас оюун ухаанд үргэлж захирагдан залагдаад байдаггүй. Ухаан нь ийм хүчтэй байдаг учраас түүнийг иогийн аргаар л эзэмдэн захирах хэрэгтэй юм. Гэхдээ, Аржунын нэгэн адил материаллаг үүрэг хүлээсэн хүний хувьд иогийн энэ зам мөрөөр замнан хэрэгжүүлэх нь аргагүй учир орчин цагийн хүмүүсийн хувьд бүр ч ярилтгүй хэрэг. Энэ шүлэгт хэрэглэгдэж байгаа, салхийг хянан захирч номхруулж болдоггүйн адил гэсэн зүйрлэл нь маш оновчтой юм. Салхийг барьж авна гэдэг огтын боломжгүй хэрэг. Догшин ширүүн ухааныг эзэмдэн захирч номхруулна гэдэг бол бүр түүнээс ч хэцүү. Шри Чайтаньягийн сургаж зөвлөсөнчлөн, ангижралд хүргэх Харе Кришна махамантраг ямар ч алдас хийлгүйгээр, хүлцэнгүй байдалтайгаар давтан хэлэх явдал бол ухааныг эзэмдэн захирах хамгийн хялбар арга юм. Энэ арга нь: *са вай манах кришна-надаравиндайох* буюу “Хүн өөрийн ухааныг Кришнад бүрэн автуулан зүтгүүлэх хэрэгтэй.” гэж заадаг. Тэгсэн цагт түүнийг өөр ямар ч зүйл өдөөж чадахгүй.

ШҮЛЭГ 35

*шри бхагаван увача
асамшьям маха-бахо мано дурниграхам чалам
абхьясена ту каунтея вайрагьена ча грихьяте*

шири бхагаван увача- Бурханы дээд Бодьгал айлдсан, *асамшаях*- эргэлзээгүй, *маха-бахо*- хүчит гарт минь, *манах*- ухаан, *дургиграхам*- ялан дийлэх нь хүнд, *чалам*- тайван бус, *абхьясена*- дадлагаар, *ту*- гэвч, *каунтея*- Кунтийн хүү минь, *вайрагьяна*- огоорохуйгаар, *ча*- мөн, *грихьяте*- ингэж эзэмдэн захирагдаж болно.

Бурханы Дээд Бодьгал Шри Кришна айлдсан нь: Ай Кунтийн хүчит гарт хүү минь ээ, тайван бус ухааныг залж жолоодох нь маш хүнд гэдэг нь эргэлзээгүй хэрэг. Гэхдээ зохих дасгал сургуулилт болон огоорохуйн тусламжтайгаар түүнийг эзэмдэн захирах боломжтой.

ТАЙЛБАР: Бурханы Дээд Бодьгал, зөрүүд ухааныг эзэмдэн захирна гэдэг хэцүү хэмээн Аржунагийн хэлснийг зөвшөөрч байна. Гэхдээ, Тэр түүний зэрэгцээ зохих сургуулилт болоод огоорохуйн тусламжтайгаар ухааныг эзэмдэн захирах боломжтой гэж айлдаж байна. Ямар дасгал сургуулилтын тухай айлдана вэ? Одоогийн энэ цаг үед хэн ч ариун дагшин газар очиж суун ухаанаа Параматмад төвлөрүүлэн, мэдрэхүй хийгээд ухаанаа эзэмдэн, гэр бүл бололгүй цэвэр ариун байдлаа хадгалан, аглаг зэлүүд газар ганцаар байх гэх зэргийн хатуу чанга журам, дэглэмийг нарийн чанд сахин баримталж чадахгүй юм. Харин Кришнагийн ухамсарын зам мөрөөр замнан байгаа хүн Бурханы чин бишрэлийн албаны есөн төрлийн үйлэнд зүтгэн байдаг. Чин бишрэл дүүрэн бялхах үйлүүдийн хамгийн эхний бөгөөд хамгийн чухал нь Кришнагийн тухай сонсох үйл юм. Энэ бол ухааныг бүхий л муу нөлөөллөөс ариусгах маш хүчтэй, трансценденталь арга юм. Кришнагийн тухай хэдийчинээн их сонсоно төдийчинээн их гэгээрэх бөгөөд ухаанаа Кришнагаас холдуулан самууруулах бүхнээс салан ангижирдаг. Бурханд зориулаагүй үйлээс ухаанаа холдуулан хөндийрүүлснээр хүн *вайрагья*г өөртөө амархан хөгжүүлж болдог. *Вайрагья* гэдэг нь “материас огоорох болон ухаанаа бурханлаг үйлэнд автуулах” гэсэн утгатай. Бодьгал бус дээр үндэслэгдсэн бурханлаг огоорохуйд хүрэх нь ухаанаа Кришнагийн үйлэнд дурлан татагдуулж, автуулахаас ч илүү төвөгтэй. Кришнагийн тухай сонссоноор хүн Бүхний Дээд Бурханд аяндаа татагдах учир ийнхүү сонсох нь илүү бодитой, ач тустай. Ийнхүү дурлан татагдахыг *парешанубхути* буюу бурханлаг цэнгэл жаргал эдлэх гэж нэрлэдэг. Энэ нь өлсгөлөн хүн хоолыг үмхэх бүрдээ мэдэрдэг мэдрэхүйн ханамж таашаал эдлэхтэй адил төстэй байдаг. Хүн идэх тусам өлсгөлөн байдал нь улам намжин, цадаж ханан хүч чадал орж байгаага мэдэрдэг. Үүний төстэй байдлаар, чин бишрэлийн албанд зүтгэж байгаа хүн ухаан нь материаллаг зүйлүүдээс холдон хөндийрөхийн хирээр трансценденталь жаргал цэнгэл улам ихээр эдэлж байдаг. Энэ нь зөв зүйтэй эмчилгээ болон цагаан хоолны зохистой дэглэмээр өвчнөөсөө салан эдгэрч буй мэт. Иймээс Шри Кришнагийн трансценденталь үйлүүдийн талаар сонсох нь галзуурч солирсон ухааныг анагаах зөв зүйтэй эмчилгээ болох бөгөөд Кришнад өргөсөн зоог нь зовж шаналж буй өвчтөнд хамгийн зохимжтой хоол болдог юм. Кришнагийн ухамсарын үйл нь ийм л анагаах увидастай.

ШҮЛЭГ 36

асамьятатмана його душпрана ити ме матих
вашьятмана ту ятата шакьо `ваптум упаятах

асамьята- жолоогүй, *атмана*- ухаанаар, *йогах*- өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүй, *душпранах*- хүрэхэд хүнд бэрх, *ити*- ингэж, *ме*- Миний, *матих*- бодол, таалал, *вашья*- эзэмдэн захирагдсан, *атмана*- ухаанаар, *ту*- харин, *ятата*- хичээн чармайснаар, *шакьях*- үнэн хэрэгтэй, *аваптум*- хүрэхэд, *упаятах*- зохистой арга хэрэгслээр.

Ухаанаа бүрэн эзэмдэн захирч, жолоодож чадахгүй байгаа хүний хувьд өөрийгөө бүрэн нээж, танин мэднэ гэдэг маш хүнд. Харин өөрийн ухаанаа эзэмдэн захирч, зөв

зохистой зам мөрөөр хичээнгүйлэн замнаж яваа хүн амжилтанд хүрэх нь зайлшгүй билээ. Миний таалал ийм байдаг.

ТАЙЛБАР: Бурханы Дээд Бодьгал энд, ухаанаа материаллаг үйлээс салган холдуулахын тулд зөв зохистой арга хэмжээ авахгүй байгаа хүн өөрийгөө бүрэн нээж, танин мэдэх зам мөрдөө амжилт гаргах нь маш хүнд хэцүү байх болно гэж тайлбарлаж байна. Иогоор хичээллэхийг оролдохын зэрэгцээ материаллаг зугаа цэнгэлд дурлан татагдах нь галаа асааж байгаа хирнээ дээрээс нь ус асгахтай адил ямар ч горьдлого найдваргүй юм. Өөрөөр хэлбэл иог нь ухаанаа эзэмдэн захирахтай холбогдоогүй л бол түүгээр хичээллэж байна хэмээн цагаа дэмий хоосон үрэх хэрэггүй. Иогийн иймэрхүү үзүүлбэрүүд нь гаднаас нь өнгөцхөн буюу материаллаг талаас нь харахад ашиг тустай мэт санагдаж болох ч бурханлаг танин мэдэхүйн талаас бол ямар ч тус нэмэргүй, дэмий хоосон эд. Иймээс ухааныг Бурханы трансценденталь хайрын албанд бишрэн зүтгэх үйлэнд тасралтгүй татан оролцуулж байж л эзэмдэн захирах хэрэгтэй. Кришнагийн ухамсрын үйлэнд зүтгээгүй цагт ухааныг цаг үргэлжид эзэмдэн захирах нь боломжгүй хэрэг юм. Кришнаг ухамсарласан хүний хувьд, иогийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнд ямар нэгэн онцгой хүчин чармайлт гаргалгүйгээр хялбархан хүрдэг. Харин тэгэхэд иогийн зам мөрөөр замнаж байгаа хүн Кришнаг ухамсарлаагүй л бол амжилтанд хүрч чадахгүй.

ШҮЛЭГ 37

аржуна увача

аятих шраддхайопето йогач чалита-манасах

апрапья його-самсиддхим кам гатим кришна гаччхати

аржунах увача- Аржуна айлтгасан, *аятих-* амжилттай бус трансценденталист, *шраддхая-* итгэл бишрэлтэйгээр, *унетах-* зүтгэдэг, *йогат-* ид шидэт холбоогоор, *чалита-* гажсан, *манасах-* ийм ухаантай байх тэр, *апрапья-* хүрэлгүйгээр, *його-самсиддхим-* ид шидийн дээдийн дээд төгс төгөлдөр, *кам-* тэр, *гатим-* тодорхойлолт, *кришна-* Кришна минь, *гаччхати-* хүрдэг.

Аржуна айлтгасан нь: Ай Кришна минь ээ, өөрийгөө бүрэн нээж, танин мэдэх замд эхлээд итгэлтэйгээр орсон ч дараа нь материаллаг таашаал ханамж эдлэхэд дур булаагдсанаас болоод энэхүү зам мөрөө орхисноор ид шидийн төгс төгөлдөрт хүрч чадаагүй, урагш муутайхан трансценденталистын хувьд чухам юу тохиолдох вэ?

ТАЙЛБАР: Өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн зам мөрийн талаар Бхагавад Гитад тодорхой өгүүлдэг. Өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн үндсэн зарчим нь амьд оршнол бол материаллаг бие махбодь биш, харин түүнээс ялгаатай бөгөөд түүний аз жаргал нь мөнхийн амьдрал, мөнхийн жаргал цэнгэл, мөнхийн мэдлэгт буюу өөрөөр хэлбэл бие махбодь болон ухааны чанадад, трансценденталь түвшинд оршдог гэдгээ таньж мэдэх явдал юм. Хүмүүс өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйд янз бүрийн, тухайлбал мэдлэгээ хөгжүүлэх замаар, найман шатлалт иогийн эсвэл *бхакти-йогын* зам мөрөөр замнан хүрэхийг эрмэлздэг. Эдгээрийн аль ч зам мөрөөр замнасан байсан хүн бүр өөрийн буюу амьд оршнолын жинхэнэ байр суурь, Бурхантай холбогдсон холбоо харьцаа болон мартаж умартсан холбоо харьцаагаа дахин сэргээх хийгээд Кришнагийн ухамсрын төгс төгөлдрийн дээд түвшинд хүргэх үйлийг таньж мэдэх хэрэгтэй. Дээр дурьдсан гурван зам мөрийн алинаар нь ч замнасан эрт орой хэзээ нэгэн цагт дээдийн дээд зорилгодоо хүрэх нь зайлшгүй. Бурхан энэ тухай хоёр дугаар бүлэгт айлдсанчлан, трансценденталь зам мөрөөр замнан өчүүхэн төдий ч оролдлого, чармайлт гаргах нь ангижралд хүрэх асар их итгэл найдварыг төрүүлдэг. *Бхакти-його* нь Бурханыг таньж мэдэхэд хүргэх хамгийн шулуун зам учраас дээрх гурван арга замуудаас энэ цаг үед хамгийн

тохиромжтой нь юм. Баталгаатай байдлыг давхар хангах үүднээс Аржуна Шри Кришнаг урьд нь түүнд айлдсанаа батлан, дахин айлдахыг гуйж байна. Хэн нэгэн нь мэдлэгээ хөгжүүлэхийн эсвэл найман шатлалт иогийн зам мөрөөр замнахыг үнэн голоосоо эрмэлзэн тэмүүлж байж болох ч өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн эдгээр арга замуудыг дагах нь одоогийн энэ цаг үеийн (Кали юга) нийт хүмүүсийн хувьд ерөнхийдөө маш хүндрэлтэй байх тул хэдийгээр байнгын хүчин чармайлт гарган хичээх боловч олон янзын учир шалтгаанаас болж бүтэмжгүй болох аюул тулгардаг. Тэдгээрээс хамгийн гол нь тэд энэ үйл явц, зам мөртөө хангалттай хэмжээгээр нухацтай хандахгүй байх явдал юм. Трансценденталь зам мөрийг даган замнана гэдэг бол хий хуурмагийн эрчимд их бага ямар нэгэн хэмжээгээр дайн зарлана гэсэн үг. Иймээс хий хуурмагийн эрчим нь өөрийн савраас мултран зугатахыг завдагч бүрийг янз бүрийн дур булаам зүйлээр татан унагаахыг оролддог. Материаллаг байгалийн гунуудын нөлөөлөлд орж мансуурсан болзолт сүнс нь трансценденталь зам мөрөөр замнаж байв ч дахин түүнд уруу татагдаж болох юм. Ийнхүү трансценденталь зам мөрөөс хазайн гажихыг *йогач чалита-манасах* гэж нэрлэдэг бөгөөд өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн замаас ингэж хазайн гажихын үр дагавар юу болохыг Аржуна мэдэхийг хүсэж байна.

ШҮЛЭГ 38

*каччин нобхая-вибхрашташ чхиннабхрам ива нашьяти
апратиитхо маха-бахо вимудхо брахманах патхи*

каччит- эсвэл, *на-* үгүй, *убхая-* хоёрын, *вибхрашташ-* гажсан, *чхинна-* сэмэрсэн, *абхрам-* үүл, *ива-* яаж, *нашьяти-* үгүй болдог, *апратиитхах-* ямар нэгэн байргүйгээр, *маха-бахо-* хүчит гарт Кришна минь, *вимудхах-* төөрөлдсөн, *брахманах-* трансценденталь, *патхи-* зам мөр дээр.

Ай хүчит мутарт Кришна минь ээ, трансценденталь зам мөрөөсөө гажин холдсон ийм хүмүүсийн хүрсэн бурханлаг болоод материаллаг амжилт нь сэмэрсэн үүл юунд ч торж тогтолгүйгээр сарнин алга болдгийн адил үгүй болох уу?

ТАЙЛБАР: Хөгжил дэвшлийн хоёр төрөл байдаг. Материалистууд нь трансценденталь байдлыг үл сонирхох тул эдийн засгаа цэцэглэн хөгжүүлж материаллаг хөгжил дэвшилд хүрэх эсвэл зохих хэрэгслийн тусламжтайгаар дээд гаригуудад хүрч очихыг л ихэд сонирхцгооно. Трансценденталь зам мөрөөр замнахыг хүсвэл бүхий л материаллаг үйлээ орхин материаллаг аз жаргал гэгчийн бүхий л хэлбэрээс татгалзан холдох хэрэгтэй. Трансценденталь зам мөрөөр замнаж буй тухайн хүний эрмэлзэл тэмүүлэл нь бүтэмжгүй болбол тэрээр материаллаг талдаа ч мөн бурханлаг талдаа ч аль алинд нь хохирол амсаж байгаа мэт харагдаж болох юм. Өөрөөр хэлбэл, тэрээр материаллаг аз жаргалыг амсаж эдлэхгүйн зэрэгцээ бурханлаг төгс төгөлдөрт ч хүрэхгүй болж байгаа мэт. Зүйрлүүлж хэлбэл, тэр сэмрэн урагдаж сарних үүл адил ямар ч авралгүй мэт. Заримдаа тэнгэрт байгаа бага үүлнээс жижигхэн хэсэг нь илүү том үүлтэй нийлэхээр салан тасарсан ч нийлж амжаагүй байхдаа салхинд хөөгдөж туугдан тэнгэрийн уудамд сарнин алга болдог. *Брахманах патхи-* бол бурханлаг танин мэдэхүйн зам мөр бөгөөд энэ зам мөрөөр замнах хүн өөрийгөө Бхагаван, Параматма болон Брахман хэлбэрээр илрэх Бүхний Дээд Бурханы салшгүй өчүүхэн жижиг хэсэг, бурханлаг оршнол гэдгээ таньж мэддэг. Шри Кришна бол Үнэмлэхүй Үнэний төгс төгөлдөр, дээдийн дээд төлөв бөгөөд энэхүү Бүхний Дээд Бурханд өөрийгөө даатгасан хэн бүхнийг төгс төгөлдөр трансценденталист гэж үздэг. Амьдралын энэхүү зорилгод Брахманыг болоод Параматмыг таньж мэдэх зам мөрөөр замнан хүрэхийн тулд олон олон дахин төрөх шаардлагатай (*бахунам жанманам анте*). Харин тэгэхэд, Кришнагийн ухамсар, *бхакти-йога* нь энэ зорилгод хүрэх хамгийн шууд зам болох учир трансценденталь танин мэдэхүйн дээдийн дээд, шилдэг арга зам юм.

ШҮЛЭГ 39

*этан ме сакшьям кришна чхеттум архасй ашешатах
тват-аньях самшьясясья чхетта на хи унападьяте*

этан- энэ бол, *ме-* миний, *самшьям-* эргэлзээ, *кришна-* Кришна минь, *чхеттум-* хөөн зайлуулахаар, *архаси-* Таныг гуйж байна, *ашешатах-* бүрэн, *тват-* Танаар, *аньях-* өөр нэг, *самшьяся-* эргэлзээний, *асья-* энэ, *чхетта-* бут цохигч тэр, *на-* хэзээ ч үгүй, *хи-* тодорхой, *унападьяте-* ологдох ёстой.

Үүнд л миний эргэлзээ байгаа юм. Ай Кришна минь ээ, энэ эргэлзээ тээнэгэлзээг бүрэн зайлуулж өгөхийг Танаас гуйж байна. Танаас өөр хэн ч энэхүү эргэлзээг тайлан, арилгаж чадахгүй билээ.

ТАЙЛБАР: Кришна өнгөрсөн, одоо болон ирээдүй цагийн талаархи бүрэн төгс төгөлдөр мэдлэгийг агуулж байдаг. Бхагавад Гитагийн эхэнд Бурхан: бүх амьд оршнолууд нь өнгөрсөн цаг үед бие даан оршиж байсан, тэд одоо ч мөн тийн оршиж байгаа бөгөөд ирээдүйд ч, тэр бүү хэл материаллаг хүлээснээс ангижирсаны дараагаар ч мөн бие даасан байдлаа хадгалан байх болно гэж айлдсан билээ. Бурхан, бие даан орших амьд оршнолын ирээдүйн тухай асуудлыг ийнхүү тайлбарлаж өгсөн билээ. Харин одоо Аржуна, өөрийнхөө зорилгод хүрч чадаагүй трансценденталистыг ямархуу ирээдүй, хувь заяа хүлээж байдаг тухай асууж байна. Кришнаатай хэн ч эн зэрэгцэхгүй, Түүнийг хэн ч даван гарч илүү байж чадахгүй, мөн материаллаг байгалийн эрхшээлд орших гүн ухаантангууд болон мэргэд гэгдэгчид ч Түүнтэй эн зэрэгцэхгүй нь тодорхой. Иймээс өнгөрсөн, одоо болон ирээдүйн тухай бүрэн төгс мэдэх Шри Кришнагийн айлдвар нь ямар ч эргэлзээ тээнэгэлзээтэй асуудлын эцсийн шийдвэрлэх бөгөөд төгс хариулт болно. Гэвч Түүнийг Өөрийг нь хэн ч таньж мэддэггүй. Зөвхөн Кришна болон Кришнаг ухамсарласан чин бишрэлтэн л юмсын жинхэнэ байр суурийг мэддэг.

ШҮЛЭГ 40

*шири бхагаван увача
партха найвеха намутра винашас тасья видьяте
на хи кальяна-крит кашчид дургатим тата гаччхати*

шири бхагаван увача- Бурханы Дээд Бодьгал айлдсан нь, *партха-* Притхын хүү минь, *на эва-* хэзээ ч ийм байдаггүй, *иха-* энэ материаллаг ертөнцөд, *на-* хэзээ ч үгүй, *амутра-* дараагийн амьдралд, *винашас-* устал сүйрэл, *тасья-* түүний, *видьяте-* оршдог, *на-* хэзээ ч үгүй, *хи-* тодорхой, *кальяна-крит-* аз жаргал авчрах үйлийн хойноос явах тэр, *кашчит-* хэн нэгэн, *дургатим-* доройтолд, *тата-* Миний найз, *гаччхати-* явдаг.

Бурханы Дээд Бодьгал айлдсан нь: Ай Притхын хүү минь ээ, буянлаг сайн үйлийн хойноос явах трансценденталист нь материаллаг болоод бурханлаг ертөнцийн аль алинд нь сөнөл сүйрлийг үздэггүй. Ай найз минь ээ, сайныг үйлдэж буй хэн бүхэн мууд хэзээ ч ялагддаггүй билээ.

ТАЙЛБАР: Шримад Бхагаватамын (1.5.17)-д Шри Нарада Муни Вьясадевад дараах сургаалыг хайрладаг:

*тъяктва сва-дхармам чаранамбужам харер
бхажанн апакво `тха патет тато яди
ятра ква вабхадрам абхуд амушья ким
ко вартха апто `бхажатам сва-дхарматах*

“Бүхий л материаллаг эрмэлзэл, тэмүүлээсээ татгалзан орхиж , Бурханы Дээд Бодьгалаас аврал өмгөөлөл эрэн Түүнд өөрийгөө бүрнээ даатгаж байгаа хүнд ямар ч гарз хохирол учрахгүйн зэрэгцээ уналт доройтолд үл орно. Харин тэгэхэд чин бишрэлтэн бус хүн нь өөрт оноогдсон бүхий л үүргээ бүрэн биелүүлэхэд бүхнээ зориулан байвч юу ч хождоггүй.”

Материаллаг зорилгод хүрэхэд тус дэм болох, уламжлалаас үүдэлтэй хийгээд судруудад заасан олон үйлүүд байдаг ч трансценденталист нь Кришнагийн ухамсраа хөгжүүлэхийн тулд буюу бурханлаг хөгжил дэвшилд хүрэхийн тулд бүхий л материаллаг үйлээсээ татгалзан, орхих ёстой. Кришнагийн ухамсрын зам мөрөөр замнан оргилд нь хүртэл явснаар л дээдийн дээд төгс төгөлдөрт хүрдэг үү? харин энэхүү төгс төгөлдөр түвшинд хүрээгүй хүн яах вэ? гэдэг асуудал эндээс зүй ёсоор урган гарна. Хэрвээ тэр төгс төгөлдрийн энэ түвшинд хүрч чадахгүй бол материаллаг болоод бурханлаг аль аль талдаа гарз хохирол амсах болж байх шиг. Бурханлаг зам мөрөөр замнахын тулд өөрт оноогдсон материаллаг үүргүүдээ орхисон ч, мөн өөрийн трансценденталь үйлээ зүй ёсоор нь биелүүлэлгүй бурханлаг зам мөрөөсөө хазайн гарсан болохоор, өөрт оноогдсон үүргээ биелүүлээгүйн үр дагавраас болж хүн зовж шаналах ёстой байдаг гэж сударт өгүүлсэн байдгийн дагуу түүний үр дагаврыг амсаж эдлэхээр болж байх шиг. Тэгвэл Бхагаватамд, амжилтанд буюу дээдийн дээд зорилгодоо бүрэн хүрээгүй трансценденталистын хувьд санаа зовох огтхон ч хэрэггүй гэж батлан өгүүлсэн байдаг. Өөрт оноогдсон үүргээ бүрэн төгс гүйцэтгэн биелүүлээгүйн кармын үр дагаврыг эдлэх байсан ч тэрээр юуг ч алдахгүй. Учир нь, аз жаргалыг хайрлагч Кришнагийн ухамсар хэзээ ч мартагдан алга болдоггүй бөгөөд энэ зам мөрт орсон байсан хүн дараагийн амьдралдаа доод язгуурын гэр бүлд төрсөн байсан ч энэ ухамсараа хадгалан, цаашид үргэлжлүүлэн хөгжүүлэх болно. Нөгөө талаас өөрт оноогдсон үүргээ нарийн чанд, нягт нямбай биелүүлсэн байсан ч Кришнагийн ухамсрыг хөгжүүлээгүй л бол тэрээр аз жаргал авчрах үр дүнд заавал хүрэх албагүй.

Үүнийг дараах байдлаар ойлгож болно. Хүмүүсийг дотор нь зохицуулах зарчмуудыг даган баримталдаггүй болон баримталдаг гэсэн хоёр бүлэгт хуваадаг. Өөрийн бурханлаг ангижралын тухай эсвэл дараагийн амьдралд нь юу хүлээж байгаа тухай юу ч үл мэдэн зөвхөн амьтан адгуус лугаа мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн хойноос тэмүүлэгчид нь зохицуулах зарчмуудыг үл баримтлагч хэсэгт хамрагддаг. Судруудад заасан зарчмууд болон үүрэг, журмуудыг баримтлагчид нь нөгөө хэсэгт хамаарагддаг. Эхний хэсэгт хамаарагдах хүмүүс нь боловсролтой ч бай, боловсролгүй ч бай, соёлтой ч бай, соёлгүй ч бай, хүч чадалтай ч бай, сул дорой ч бай ялгаагүй үргэлж амьтан адгуусны байлтай гэмээр дур хүслээр дүүрэн байдаг. Идэх, унтах, биеэ хамгаалах болон бэлгийн дур хүслээ хангах зэргээр амьтан адгуусны гэмээр таашаал ханамж эдэлж, аяглаж байдаг тэдний үйл нь бурханлаг хөгжилд ямар ч тус нэмэр авчирдаггүй тул тэд зовлон шаналалаар дүүрэн материаллаг оршихуйд үргэлжлэн байх болно. Харин тэгэхэд, сударт заасны дагуу амьдралаа зохицуулан явуулж байгаа хүмүүс хөгжил дэвшилд хүрэх нь ямар ч эргэлзээгүй бөгөөд аажим аажмаар Кришнагийн ухамсарт дээшлэн хүрэх болно.

Аз жаргалд хүргэх ач тустай зам мөрөөр замнаж байгаа хүмүүсийг дотор нь дараах гурван бүлэгт хувааж болно: (1) сударт заасан заавар, журам, зарчмуудыг баримтлагчид, ийнхүү тэдгээрийг даган баримталснаар тэд материаллаг сайн сайхныг эдэлдэг. (2) материаллаг оршихуйгаас бүрмөсөн ангижрахыг эрэлхийлэгчид. (3) Кришнагийн ухамсарт оршин байгаа чин бишрэлтэнгүүд. Материаллаг аз жаргал, сайн сайханд хүрэхийн тулд сударт заасан заавар, журам, зарчмуудыг баримтлах хүмүүсийг дотор нь мөн: а) өөрсдийн ажил үйлийн үр дүнд тэмүүлэгчид болон б) мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн төлөөх үр дагаврыг үл хүсэгчид гэсэн хоёр хэсэгт хувааж болно. Мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн төлөө өөрийн ажил, үйлийн үр шимд тэмүүлэн байгаа хүмүүс амьдралын илүү дээд шатанд, тэр бүү хэл дээд гаригуудад дээшлэн хүрч болох ч материаллаг оршихуйгаас ангижирч чадахгүй тул тэд жинхэнэ аз жаргалд хүргэх замаар замнаагүй нь илэрхий юм. Зөвхөн ангижралд хүргэх үйл нь л аз жаргалд хүргэх үйл юм. Өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн дээдийн дээд зорилгыг

агуулаагүй буюу амьдралын тухай материаллаг бие махбодийн үзэл бодлоос ангижруулахад үл хүргэх аливаа үйл аз жаргалд хүргэх үйл биш юм. Кришнагийн ухамсар дахь үйл нь л жинхэнэ аз жаргалд хүргэх үйл үнэхээрийн мөн бөгөөд Кришнагийн ухамсрын зам мөрт хөгжил дэвшил гаргахын төлөөнөө сайн дураараа бие махбодийн бүхий л материаллаг тааламжтай бус байдлыг өөртөө эдэлж буй хүнийг дээдийн дээд огоорохуйд оршин байгаа төгс төгөлдөр трансценденталист гэж нэрлэж болно. Найман шатлалт иог нь эцэстээ Кришнагийн ухамсарт бодитойгоор хүрэхэд чиглэгдсэн байдаг тул мөн л аз жаргалд хүргэх бөгөөд энэ зам мөртөө өөрийн бүх хүчийг үл дайчлах хэн бүхэнд уналтанд өртөх аюул учирдаг.

ШҮЛЭГ 41

*прапья пунья-критам локан ушитва шаиватих самах
шучинам шриматам гехе йога-бхрашито `бхижасяте*

прапья- хүрсэний дараа, *пунья-критам-* зөв шудрага үйл үйлдсэн тэр, *локан-* гаригууд, *ушитва-* амьдарсаны дараагаар, *шаиватих-* олон, *самах-* жилүүд, *шучинам-* зөв шудрагуудын, *шири-матам-* баян язгууртнуудын, *гехе-* гэр бүлд, *йога-бхраштах-* өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн зам мөрөөсөө гажсан тэр, *абхижасяте-* төрөгддөг.

Дээдийн дээд зорилгодоо хүрч чадаагүй иогч нь зөв шудрага амьд оршнолуудын амьдарч, орших гаригууд дээр олон олон жилийн туршид таашаал ханамж эдлэсний дараагаар зөв шударга, зарчимч гэр бүл буюу эсвэл баян язгууртан айлд төрдөг.

ТАЙЛБАР: Дээдийн дээд буюу эцсийн зорилгодоо хүрч чадаагүй иогчдыг, өчүүхэн бага хөгжил дэвшилд хүрсний дараагаар эсвэл удаан хугацааны туршид иогийн зам мөрөөр замнасны эцэст уналтанд өртсөн гэсэн хоёр хэсэгт хуваадаг. Богино хугацааны дараагаар уналтанд өртсөн иогч нь зөв шудрага амьд оршнолуудын очдог гаригуудад хүрдэг ба түүнийг тэнд урт удаан хугацаагаар амьдарсны эцэст шудрага, ёс зарчимч *брахмана-вайшнавын* эсвэл баян язгууртан худалдаачдын гэр бүлд төрүүлэхээр газар дэлхий рүү буцаан илгээдэг.

Иогийн жинхэнэ зорилго нь Кришнагийн ухамсрын дээдийн дээд төгс төгөлдөрт хүрэх явдал байдаг. Энэ талаар энэ бүлгийн төгсгөлийн шүлэгт тайлбарлах болно. Гэхдээ энэ зорилгодоо хүртэл тууштай байж чадалгүй, материаллаг зүйлд дур булаагдан уналт доройтолд орж буй хүнд өөрийн бүх материаллаг дур хүслээ бүрэн хангах зөвшөөрлийг Бурхан өршөөн соёрхдог. Мөн үүний дараагаар шудрага, ёс зарчимч эсвэл баян язгууртан хүний гэр бүлд төрж чинээлэг амьдралаар амьдрах боломж олгодог. Ийм гэр бүлд төрсөн хэн бүхэн энэхүү нөхцөл боломжоо ашиглан Кришнагийн ухамсрын төгс төгөлдөр түвшинд дээшлэн хүрэхийг хичээх хэрэгтэй.

ШҮЛЭГ 42

*атха ва йогинам эва куле бхавати дхиматам
этад дхи дурлабхатарам локе жанма яд идришам*

атха ва- эсвэл, *йогинам-* номч трансценденталист, *эва-* гарцаагүй, *куле-* гэр бүлд, *бхавати-* төрдөг, *дхи матам-* аугаа цэцэн мэргэн байдлыг агуулах тэднээс, *эват-* үүнийг, *хи-* үнэхээр, *дурла-бхатарам-* маш ховор, *локе-* энэ дэлхийд, *жанма-* төрөлт, *ят-* энэ, *идришам-* үүн шиг.

Эсвэл, иогийн зам мөрөөр удаан хугацааны туршид замнасны дараа бүтэлгүйтсэн тохиолдолд тэрээр аугаа их цэцэн мэргэн трансценденталистын гэр бүлд хүүхэд нь болон төрнө. Энэ дэлхийд ийм төрөлтийг олно гэдэг үнэхээр ховор.

ТАЙЛБАР: Бүхий л аугаа их цэцэн мэргэн ухааныг агуулах иогчийн буюу трансценденталистын гэр бүлд хүүхэд нь болж төрснөөр амьдралынхаа бүр эхнээс бурханлаг хөгжлийн зам мөрөөр удирдагдан замнах боломж нөхцөлтэй болж байгааг энэ шүлэгт тод томруунаар дээдлэн өгүүлж байна. Энэ нь ялангуяа *ачарья* болон *госвамиин* гэр бүлд онцгой хамааралтай. Ийм гэр бүлийн гишүүд нь уламжлал болон хүмүүжлийн ачаар гүн гүнзгий мэдлэг хийгээд бишрэл шүтлэгтэй болдог тул тэд номын багш болох чадвартай болдог. Энэтхэгт ийм *ачарья* гэр бүлүүд олон байдаг ч одоо тэд хүмүүжил болон сургалт суларсаны улмаас мухардалд орж урьд байсан шигээ байж чадахаа больсон. Гэсэн ч, Бурханы өршөөлөөр үеэс үед трансценденталистуудыг өсгөн хүмүүжүүлж байдаг ийм гэр бүлүүд мөн байсаар байна. Ийм гэр бүлд төрнө гэдэг мэдээж үнэхээрийн аугаа их зол завшаантай хэрэг. Миний номын багш Ом Вишнупада Шри Шримад Бхактисиддханта Сарасвати Госвами Махаража болон энэхүү мөрүүдийг бичигч өчүүхэн надад Бурханы өршөөлөөр ийм гэр бүлд төрөх боломж тохиосон бөгөөд бид хоёулаа амьдралынхаа бүр эхнээс л Бурханы чин бишрэлийн албанд зүтгэх үйлэнд сургагдан хүмүүжигдсэн билээ. Хожим нь, бид трансценденталь зарчмын системийн эрхээр бие биетэйгээ учран золгосон юм.

ШҮЛЭГ 43

*татра там буддхи-самьогам лабхате паурва-дехикам
ятате ча тато бхуях самсиддхау куру-нандана*

татра- тэнд, *там*- үүнийг, *буддхи-самьогам*- ийм ухамсарыг дахин сэргэлт, *лабхате*- хүрдэг, *паурва-дехикам*- урьдын бие махбодийн, *ятате*- тэр чармайдаг, *ча*- мөн, *татах*- дараа нь, *бхуях*- дахин, *самсиддхау*- төгс төгөлдөрийн төлөө, *куру-нандана*- Куругийн хүү минь.

Ай Кунтийн хүү минь ээ, ийм гэр бүлд төрснөөр тэр өөрийн өнгөрсөн амьдралын бурханлаг ухамсрыг дахин сэргээдэг бөгөөд бүрэн төгс амжилтанд хүрэхийн тулд цаашид хөгжил дэвшил гаргахаар зүтгэдэг болно.

ТАЙЛБАР: Хоёр амьдралын дараагаар эрхэм дээд *брахманы* гэр бүлд төрсөн Бхаратын хаан нь зохих сайн гэр бүлд төрснөөрөө түрүүчийн амьдралын трансценденталь ухамсараа хэрхэн яаж сэргээдэг талын жишээ болно. Бхаратын хаан нь бүх дэлхийн эзэн хаан байсан бөгөөд түүний хаанчилж байсан энэ цаг үеэс эхлэн манай гариг нь сахиулсан тэнгэрүүдийн дунд *Бхарата-варша* гэж нэрлэгдэх болсон. Түүнээс өмнө *Илаврита-варша* гэж нэрлэгддэг байсан. Эзэн хаан бага залуу настай байхдаа бурханлаг төгс төгөлдөрт хүрэхийн тулд эзэн хааны үйл хэргээсээ татгалзан орхисон боловч бүрэн төгс амжилтанд хүрч чадаагүй. Хожим нь тэрээр жинхэнэ *брахманы* гэр бүлд төрсөн бөгөөд хэнтэй ч ярьдаггүй, байнгад олноос хөндий тусдаа байдаг байсан учраас Жада Бхарата гэж нэршсэн байв. Гэвч хожим Рахугана хаан түүнийг аугаа их трансценденталист мөн болохыг таньсан. Түүний амьдралын жишээнээс трансценденталь хичээл зүтгэл буюу өөрөөр хэлбэл иогын зам мөрөөр замнасан замнал нь хэзээ ч алдагдан үгүй болдоггүй гэдэг нь харагддаг билээ. Бурханы өршөөлөөр трансценденталист нь Кришнагийн ухамсрын бүрэн төгс төгөлдөрт хүрэх боломжийг дахин дахин авдаг байна.

ШҮЛЭГ 44

*пурвабхьясена тенайва хрияте хй аваши `ни сах
жигьясур апи йогасья шабда-брахмативартате*

пурва- урьдын, *абхьясена-* дадлагаар, *тена-* түүгээр, *эва-* зайлшгүй, *хрияте-* татагддаг, *хи-* заавал, *аваших-* аяндаа, *апи-* мөн, *сах-* тэр, *жигьясух-* мэдлэгт шунан дурлах, *апи-* ч, *йогасья-* иогийн тухай, *шабда-брахма-* судруудад заасан зан үйлийн зарчмууд, *ативартате-* даван гардаг.

Иогийн зарчмуудыг дагаж мөрдөхөөр хичээн чармайхгүй байсан ч түүрүүчийн амьдралын бурханлаг ухамсрын хүчээр жам ёсоороо аяндаа өөрөө тэдгээрт татагддаг. Ийнхүү мэдлэгт шунан дурлах трансценденталист нь сударт заасан байдаг зан үйлийн ёс зарчмуудаас дээш оршдог.

ТАЙЛБАР: Өндөр түвшинд хүрсэн иогч нь сударт заасан байдаг зан үйл, ёслолуудад нэг их татагддаггүй. Гэхдээ тэр иогийн дээдийн дээд төгс төгөлдөр, Кришнагийн бүрэн ухамсарт хүргэх иогийн зарчмуудад аяндаа татагддаг. Өндөр түвшинд хүрсэн трансценденталист нь ведийн зан үйлүүдийг яагаад үл сонирхдог талаар Шримад Бхагаватамын (3.33.7)-д дараах байдлаар өгүүлсэн байдаг:

*ахо бата шва-пачо `то гариян
яж-жихвагре вартате нама тубхьям
тепус тапас те жухувух саснур арья
брахманучар нама гринанти е те*

“Ай Бурхан минь ээ, Таны ариун нэр алдрыг давтан хэлэх хүн нохойгоор хооллогчийн гэр бүлд төрсөн байсан ч бурханлаг амьдралын маш өндөр түвшинд хүрсэн байдаг. Тэрээр огоорохуйн болон өргөл тахилгын бүх хэлбэрийг хэдийнээ хийж гүйцэтгэн, бүхий л ариун дагшин гол мөрнүүдэд угаал үйлдэж, бүх судруудыг үзэж судласан гэдэг нь эргэлзээгүй хэрэг.”

Үүний нэг яруу тод жишээ бол Шри Чайтанья Өөрийн хамгийн гарамгай сод шавь нарын нэг гэж нэрлэсэн Харидаса Тхакура юм. Хэдийгээр тэр мусульман шашинтны гэр бүлээс гаралтай байсан ч Бурханы ариун нэр алдрыг өдөр бүр, гурван зуун мянган удаа Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе/ Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе Харе гэж давтан хэлэх ам өчгөө нарийн чанд сахьдаг байсан учир Шри Чайтанья түүнийг *намачарья* хэмээн өргөмжилсөн билээ. Бурханы ариун гэгээн нэр алдрыг байнгад давтан хэлж байгаа түүний энэ бодит байдлаас үзэхэд, тэр өөрийн өнгөрсөн амьдралууддаа *шабда-брахма* буюу Ведийн бүхий л зан үйлийг хэдийнээ хийж гүйцэтгэсэн гэдэг нь илэрхий. Учир нь, зөвхөн ариуссан хүн л Кришнагийн ухамсрын зарчмуудад хандахын зэрэгцээ Бурханы ариун гэгээн нэр алдрыг давтан хэлж эхэлдэг.

ШҮЛЭГ 45

*пратнат ятаманас ту йоги самишуддха-килбишах
анека-жанма-самсиддхас тато яти парам гатим*

пратнат- нарийн чанд биелүүлснээр, *ятаманах-* чармайснаар, *ту-* болон, *йоги-* ийм трансценденталист, *самишуддха-* угаагдсан, *килбишах-* түүний нүглүүд, *анека-* олон олон, *жанма-* төрлийн дараа, *самсиддхас-* төгс төгөлдөрт хүрсэнээр, *татах-* дараа нь, *яти-* хүрдэг, *парам-* дээдийн дээд, *гатим-* зорилго.

Цаашдаа улам их хөгжил дэвшилд хүрэхийг үнэнээсээ чармайх хийгээд бүхий л бузраасаа ариуссан байх иогч нь олон олон амьдралын туршид иогийн зам мөрөөр идэвхитэй, тууштай замнасны эцэст дээдийн дээд зорилгодоо хүрдэг.

ТАЙЛБАР: Онцгой шудрага шулуун, ёс зарчимч, язгууртны эсвэл ариун гэгээн гэр бүлд төрсөн хүн цаг хугацааны явцад, түүнд иогийн зам мөрөөр замнахад таатай нөхцөл бололцоо байна гэдгээ ухаардаг. Иймээс тэр өөрийн бүрэн дуусгаж амжаагүй үүрэг даалгавраа гүйцээн биелүүлэхээр шийдвэр төгс эхлэн улмаар бүхий л материаллаг бузраасаа ариусдаг. Бүхий л бузраас бүрэн ариусаж ангижирсан цагт л тэр дээдийн дээд төгс төгөлдөр- Кришнагийн ухамсарт хүрдэг. Кришнагийн ухамсар бол бүх бузраас ангид байдаг төгс төгөлдөр түвшин юм. Энэ тухай Бхагавад Гитагийн (7.28)-д батлан өгүүлсэн байдаг:

*ешам тв анта-гатам папам жананам пунья-карманам
те двандва-моха-нирмукта бхажанте мам дридха-вратах*

“Олон олон амьдралын туршид зөв шудрага үйл үйлдэн байсны эцэст, бүхий л бузраас бүрэн ариуссан хийгээд хий хуурмагийн хоёрдмол байдлаас бүрэн ангижирсан цагт л хүн Бурханы трансценденталь хайраар дүүрэн бялхах алба үйлэнд зүтгэж эхэлдэг.”

ШҮЛЭГ 46

*тапасвибхо `дхико йоги гьянибхо `ни мато `дхиках
кармибхьяш чадхико йоги тасмад йоги бхаваржуна*

тапасвибхухах- тэвчил наманчлал үйлдэгч, *адхиках*- илүү, *йоги*- иогч, *гьянибхьях*- цэцэн мэргэнээс, *ани*- мөн, *матах*- тооцогддог, *адхиках*- илүү, *кармибхьях*- үр дагавар дагуулах үйл үйлдэгчээс, *ча*- мөн, *адхиках*- илүү, *йоги*- иогч, *тасмат*- иймээс, *йоги*- трансценденталист, *бхава*- бол, *аржуна*- Аржуна минь.

Иогч нь кармын үйл үйлдэгчээс ч, эмпирик-гүн ухаанчаас ч, тэвчил наманчлал үйлдэгчээс ч илүү дээгүүр. Иймээс, ай Аржуна минь ээ, ямар ч нөхцөл байдалд байсан иогч бай.

ТАЙЛБАР: Хэрвээ бид иогийн тухай ярьж байгаа бол дээдийн дээд Үнэмлэхүй Үнэнтэй өөрсдийн ухамсрыг холбох тухай ярьж байна гэсэн үг. Хүмүүсийн хандаж, дагаж мөрдөж буй арга замаас хамааран иог нь янз бүрээр нэрлэгддэг. Холбогдох үйл явц нь кармын үйлээс зонхилон бүрдэж байвал *карма-йога*, гүн ухааны эрэлхийллийн дүгнэлтэд тулгуурлаж байвал *гьяна-йога*, харин Бүхний Дээд Бурханыг хайрлан чин бишрэлээр зүтгэх харьцаан дээр үндэслэж байвал *бхакти-йога* гэж нэрлэгддэг. *Бхакти-йога* буюу Кришнагийн ухамсар нь иогийн бүхий л арга зам, төрлийн дээдийн дээд төгс төгөлдөр нь болж байдаг. Энэ тухай дараагийн шүлэгт тайлбарлах болно. Бурхан энэ шүлэгт иогийн давуутай байдлын талаар тайлбарлаж байгаа ч энэхүү иог нь *бхакти-йогоос* илүү сайн гэж айлдахгүй байна. *Бхакти-йога* нь төгс төгөлдөр бурханлаг мэдлэг учраас түүнээс илүү, давуутай зүйл гэж үгүй. Өөрийгөө таньж мэдэлгүйгээр тэвчил, огоорол үйлдэх нь бүрэн төгс бус байдгийн адил Бүхний Дээдэд чин бишрэлээр зүтгэлгүйгээр гүн ухааны мэдлэг агуулан байх нь мөн л төгс төгөлдөр бус. Мөн Кришнагийн ухамсаргүй үр дагавар дагуулах үйл үйлдэх нь цагаа хий дэмий үрсэн хэрэг. Энэ шүлэгт иогийн арга замыг онцгойлон дурьдаж байгаа бөгөөд дээрх учир, үндэслэлүүдээс үзэхэд иогийн дээдийн дээд шат, түвшин бол *бхакти-йога* юм. Энэ тухай мөн дараагийн шүлэгт илүү тодорхой тайлбарлах болно.

ШҮЛЭГ 47

*йогинам апи сарвешам мад-гатенантар-атмана
шраддхаван бхажате йо мам са ме юктатамо матах*

йогинам- иогчдоос, *апи*- мөн, *сарвешам*- бүхий л төрлийн, *мат-гатена*- Надад оршсоноор, үргэлж Миний тухай бодсоноор, *антах-атмана*- дотоодод, *ираддхаван*- бүрэн итгэл бишрэлтэйгээр, *бхажате*- трансценденталь хайр дүүрэн бялхах албанд зүтгэдэг, *яx*- тэр, *мам*- Надад (Бүхний Дээд Бурханд), *сах*- тэр, *ме*-Надаар, *юкта-тамах*- хамгийн аугаа тогч, *матах*- гэж тооцогддог.

Бүх иогчдоос, хэлбэрэлт гуйвалтгүй итгэл бишрэл дүүрэн байж, үргэлж Надад оршиж, Миний тухай бодолд байнгад автан умбаж, Надад трансценденталь хайр дүүрэн зүтгэж, Надтай хамгийн дотно, бат бэх холбогдсон тэр л хамгийн дээд нь байдаг. Миний бодол таалал ийм байна.

ТАЙЛБАР: *Бхажате* гэдэг үг энд онцгой утга санааг агуулж байна. *Бхажате* гэдэг үгийн үндэс нь *бхаж* буюу зүтгэх буюу алба өргөх гэсэн санааг илэрхийлэх үйл үг юм. “Хүндэтгэх” гэдэг үгийг *бхаж-тай* адил утгаар хэрэглэж болохгүй. Хүндэтгэл үзүүлнэ гэдэг бол бахдан сайшаах буюу зохих ёсны анхаарал тавихыг хэлдэг. Хайр болон итгэлтэйгээр бишрэн зүтгэх нь зөвхөн Бурханы Дээд Бодьгалд л зориулагддаг. Хэн нэгэн эрхэм хүн эсвэл сахиулсан тэнгэрт хүндэтгэл үзүүлэхээс зайлсхийж болох бөгөөд ингэснээр тэр эелдэг бус л гэгдэж магадгүй. Харин Бүхний Дээд Бурханд зүтгэх үйлнээс зайлсхийж болохгүй. Тэгэх аваас хүн өөрийгөө мөхөл сүйрэлд гүн оруулах болно. Амьд оршнол бүр нь Бурханы Дээд Бодьгалын салшгүй, өчүүхэн жижиг хэсэг болох тул тэрээр өөрийн мөн чанарын хувьд Бүхний Дээдэд зүтгэн үйлчлэх үүрэг, зориулттай байдаг. Хэрвээ тэр үүнийг эс биелүүлэх аваас уналт доройтолд орох болно. Бхагаватамын (11.5.3)-д энэ тухай дараах байдлаар батлан өгүүлсэн байдаг:

*я эшам нурушам сакшад
атма-прабхавам ишварам
на бхажантй аважананти
стханад бхраиштах патантй адхах*

“Бүх амьд оршнолуудын эх булаг болсон анхдагч Бурханы өмнө хүлээсэн үүргээ үл хайхран Түүнд үл үйлчлэн зүтгэх хэн бүхэн өөрийн жинхэнэ байр сууринаасаа унах нь эргэлзээгүй.”

Мөн энэ шүлэгт ч *бхажанти* гэдэг үг мөн л хэрэглэгдэж байна. Энэ үг зөвхөн Бүхний Дээд Бурханд хамааралтайгаар хэрэглэгддэг байхад хүндэтгэх гэдэг үгийг сахиулсан тэнгэрт эсвэл өөр бусад жирийн амьд оршнолуудад зориулан хэрэглэж болно. Шримад Бхагаватамын энэ шүлэгт хэрэглэгдэх *аважананти* гэдэг үг нь мөн Бхагавад Гитад ч тохиолддог: *аважананти мам мудхах* буюу “Зөвхөн тэнэг мунхаг болоод үл бүтэх этгээдүүд л Бурханы Дээд Бодьгал, Шри Кришнаг элэглэн шоолдог.” Иймэрхүү мунхагууд нь Шри Кришнад үйлчлэн зүтгэх хүсэлгүй байж Бхагавад Гитад тайлбар бичих гэж ихэмсэг дүр эсгэдэг. Ийм учраас тэд *бхажанти* болон хүндэтгэх гэсэн хоёр үгийг зөв зүйтэйгээр ялгаж салган ойлгох чадваргүй байдаг. Иогийн бүх төрлүүдийн оргил нь *бхакти-йога* байдаг. Бусад бүх иогууд нь *бхакти-йогын бхакти* түвшинд хүрэх арга хэрэгсэл болохоос цаашгүй юм. Иогийн бусад төрлүүд нь *бхакти-йогад* буюу зорилгодоо хүрэх арга замын алхам, үе шатуудаас өөрцгүй болох учир иог нь чухамдаа *бхакти-йога* юм. Эхлэл болох *карма-йога* болон оргил болох *бхакти-йогын* хооронд өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн урт зам байдаг. Хүн энэхүү зам мөрийг үйлийнхээ үр дагавраас татгалзах *карма-йогоор* эхэлдэг. *Карма-йогыг* мэдлэг хийгээд огоорохуйгаар баяжуулан нэмэгдүүлснээр хүрэх түвшинг *гьяна-йога* гэж нэрлэдэг. Харин *гьяна-йогаг* бие махбодийн янз бүрийн дасгал сургуулилтаар өргөжүүлэн Параматмаг бясалгах бясалгал болгон хөгжүүлж, ухаанаа Түүнд төвлөрүүлэх аваас энэ түвшинг *аштанга-йога* гэж нэрлэдэг. *Аштанга-йогоос* илүү дээш гаран Бурханы Дээд Бодьгал, Кришнад шууд хандах түвшинг иогийн хамгийн дээд түвшин *бхакти-йога* гэж нэрлэдэг. Чухамдаа *бхакти-йога нь* эцсийн буюу дээдийн дээд зорилго мөн боловч түүнийг нарийн судалж үзэхийн тулд эдгээр бусад иогийг мөн ойлгож мэдэх хэрэгтэй. Үргэлж ахиц дэвшил гарган урагш тэмүүлэх иогч нь

иймээс мөнхийн аз жаргалын жинхэнэ зам мөрөөр замнаж байгаа хэрэг юм. Харин цаашид ахиц, хөгжил дэвшил үл гарган иогийн ямар нэгэн түвшинд зогсон үлдэх иогчийг тухайн түвшинд нь харгалзуулан *карма-йогч, гьяна-йогч, дхьяна-йогч, ража-йогч, хатха-йогч...* гэх зэргээр нэрлэдэг. *Бхакти-йогын* түвшинд хүрсэн хүнийг бусад *йогуудыг* хэдийнээ ардаа орхисон гэж үзэж, ойлгох хэрэгтэй. Гималайн нуруу бол дэлхийн хамгийн өндөр уул, түүний ноён оргил буюу хамгийн өндөр цэг нь Эверест байдагтай адил Кришнаг ухамсарлана гэдэг бол иймээс иогийн хамгийн дээд түвшин болой.

Маш их зол завшаан тохиосон хүн л *бхакти-йогын* зам мөрд орон түүгээр замнаж, ведийн судруудад өгүүлснээр хамгийн дээд түвшин болох Кришнагийн ухамсарт хүрдэг. Төгс төгөлдөр иогч нь өөрийн анхаарлыг Шьямасундара гэж нэрлэгдэх Кришнад төвлөрүүлдэг. Түүний дур булаам биеийн өнгө нь аадар борооны үүл мэт, Түүний бадамлянхуа адил царай нь нар мэт гэрэлтэй, Түүний өмсгөл нь гялалзан солонгорох үнэт эдлэлийн гоёлтой, Түүний бие нь цэцгэн гирляндаар (зүүлт) чимэглэгдсэн байдаг. *Брахмажьоти* гэж нэрлэгдэх Түүний гялбам туяа нь зүг бүртээ цацран байдаг. Тэрээр Рама, Нрисимха, Враха болон Бурханы Дээд Бодьгал, Кришна зэрэг олон янзын дүрүүдээр илэрч тодордог. Мөн Тэрээр Яшода эхийн хүү нь болж, хүний дүр хэлбэрээр ч морилон бууж ирдэг ба Кришна, Говинда болон Васудева гэж нэрлэгддэг. Тэр бол төгс төгөлдөр хүүхэд, төгс төгөлдөр эр нөхөр, төгс төгөлдөр найз, төгс төгөлдөр сургаал айлдагч буюу номын багш бөгөөд Өөртөө бүхий л баялаг болоод бүхий л трансценденталь мөн чанаруудыг агуулж байдаг. Бурханы энэ бүх шинж чанарыг бүрнээ ухамсарласан хүнийг дээдийн дээд иогч гэж нэрлэдэг.

Ведийн бүхий л судруудад батлан өгүүлсэнчлэн, иогийн дээдийн дээд төгс төгөлдөр энэхүү түвшинд зөвхөн *бхакти-йогын* замаар л хүрч болно:

*ясья деве пара бхактир ятха деве татха гурау
тасьяйти катхита хй артха пракашанте махатманах*

“Бурханд болон номын багшдаа ямар ч болзол нөхцөлгүйгээр бүрэн итгэх тийм аугаа сүнснүүдэд л ведийн мэдлэгийн бүхий л утга учир аяндаа өөрөө бүрнээ тайлагдан нээгдэнэ.”

Бхактир асья бхажанам тад ихамутропадхи-найрасье-намушмин манах-калпанам, этад эва найшкармьям. “*Бхакти* гэдэг нь энэ болоод дараагийн амьдралдаа материаллаг ашиг хонжоо олох хүсэл эрмэлзлээс ангид тусдаа байх, Бурханд зориулсан чин бишрэл дүүрэн бялхах алба гэсэн үг. Хүн иймэрхүү дур сонирхлоос ангид байж ухаанаа Бүхний Дээдэд бүрэн автуулах ёстой. Энэ бол *найшкармья-гийн* утга санаа юм.” (Гопала-тапани Упанишад, 1.15)

Эдгээр нь иогийн системийн төгс төгөлдрийн дээдийн дээд түвшин *бхакти* буюу Кришнагийн ухамсарт хүргэх зарим нэгэн арга хэрэгслүүд болох юм.

*Шримад Бхаөгавад Гитагийн “Дхьяна-йога”
нэртэй зургаа дугаар бүлэгт
Бхактиведантын өгсөн тайлбар
ийнхүү өндөрлөлөө.*

ДОЛОО ДУГААР БҮЛЭГ

Үнэмлэхүйн мэдлэг

ШҮЛЭГ 1

май асакта-манах партха йогам юнжан мад-ашраях

асамшаям самаграм мам ятха гьясьяси тач чхрину

шри бхагаван увача- *Бурханы Дээд Бодьгал айлдсан нь*, майи- *Надад*, асакта-манах- *төвлөрсөн ухаантай*, партха- *Притхын хүү минь*, йогам- *өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүй*, юнжан- *хэрэгжүүлснээр*, мат-ашраях- *Миний тухай ухамсарт (Кришнагийн ухамсарт)*, асамшаям- *эргэлзээгүйгээр*, самаграм- *бүрэн*, мам- *Намайг*, ятха- *яаж*, гьясьяси- *чи таньж мэдэх болно*, тат- *энэ тухай*, шрину- *сонс*.

Бурханы Дээд Бодьгал айлдсан нь: Ай Притхын хүү минь ээ, иогийн зам мөрөөр замнан, ухаанаа Надад төвлөрүүлэн, Намайг бүрнээ ухаарснаар Намайг аливаа эргэлзээ тээнэгэлзээнээс ангид бүрнээ хэрхэн таньж мэдэж болохыг одоо сонс.

ТАЙЛБАР: Бхагавад Гитагийн долоо дугаар бүлэгт Кришнагийн ухамсрын мөн чанарыг бүрэн төгс тодорхойлон өгүүлнэ. Кришна бүхий л гайхамшигт байдлуудыг бүрэн төгс төгөлдөрөөр агуулсан байдаг бөгөөд энд, Тэрээр энэхүү гайхамшигт байдлуудаа хэрхэн дэлгэрүүлж байдаг талаар өгүүлнэ. Долоо дугаар бүлгийн бас нэг сэдэв нь Кришнад татагдан ойртож байгаа зол завшаантай хүмүүсийн дөрвөн төрөл болон Түүнд хэзээ ч үл хандах, зол заяа муутай хүмүүсийн дөрвөн төрлийн тухай юм.

Бхагавад Гитагийн эхний зургаан бүлэгт, амьд оршнол нь иогийн янз бүрийн арга замаар өөрийгөө бүрэн нээж танин мэдэх түвшинд хүрч болдог материаллаг бус, бурханлаг сүнс мөн гэдэг талаар өгүүлсэн. Зургаа дугаар бүлгийн төгсгөлд, ухаанаа Кришнад байнгад төвлөрүүлэх явдал буюу өөрөөр хэлбэл Кришнагийн ухамсар нь иогийн бүхий л арга замуудын дээдийн дээд хэлбэр гэж чухалчлан заасан билээ. Хүн ухаанаа зөвхөн Кришнад хандуулж төвлөрүүлэхээс өөр бусад ямар ч арга замаар Үнэмлэхүй Үнэнийг бүрэн төгс таньж мэдэж чадахгүй. Бодьгал бус *брахмачюти* эсвэл бүхэнд нэвчин залрах Параматмын тухай мэдлэг нь Үнэмлэхүй Үнэний мэдлэгийн зөвхөн нэгээхэн хэсэг учир бүрэн төгс бус юм. Төгс төгөлдөр хийгээд жинхэнэ мэдлэгийг Кришна л агуулах бөгөөд Кришнагийн ухамсарыг өөртөө хөгжүүлэн байх хэн бүхэнд бүгд нээгдэх болно. Кришна бүрнээ ухамсарласан хүн л Кришна бол аливаа эргэлзээ тээнэгэлзээнээс ангид байх дээдийн дээд мэдлэг юм гэдгийг ойлгоно. Иогийн янз бүрийн хэлбэрүүд нь Кришнагийн ухамсарт хүргэх зам мөр дээрх нэг ёсны үе шатууд юм. Харин Кришнагийн ухамсарт шууд хандан байгаа хүн *брахмачюти* болон Параматмын талаарх бүрэн төгс мэдлэгийг аяндаа эзэмшин хүртэх болно. Кришнагийн ухамсрын иогийн зам мөрөөр замнаж байгаа хүн бүгдийг, тухайлбал: Үнэмлэхүй Үнэн, амьд оршнол, материаллаг байгаль болоод түүний илрэл тодролуудыг, тэдгээрт хамаарагдах бүх зүйлсийнх нь хамт бүрэн төгс таньж мэднэ.

Ийм учраас зургаа дугаар бүлгийн сүүлчийн шүлэгт өгүүлсэн иогийн зам мөрөөр замнах хэрэгтэй. Зөвхөн Бурханы чин бишрэлийн албанд зүтгэснээр л Бүхний Дээд Бурхан, Кришнад ухаанаа төвлөрүүлэх боломжтой болно. Бурханы чин бишрэлийн алба есөн төрлийн үйлээс бүрддэг ба тэдгээрийн хамгийн эхнийх нь бөгөөд хамгийн чухал нь *шраванам* юм. Ийм учраас Бурхан Аржунад хандан: *тач чхрину*- "Намайг сонс." гэж айлдаж байна. Кришнагаас аугаа жинхэнэ эх сурвалж гэж хэн ч байж чадахгүй тул Түүнийг сонсоно гэдэг амьд оршнолын хувьд Кришнагийн ухамсрын төгс төгөлдөрт хүрэх маш чухал ховор боломж олдож байгаа хэрэг. Иймээс Кришнагаас Өөрөөс нь, эсвэл Түүний цэвэр чин бишрэлтэнгээс л мэдлэгийг хүртэх хэрэгтэй. Харин ямар ч тохиолдолд, өөрийн академийн боловсролоор бардамнах итгэл бишрэлгүйчүүд болон чин бишрэлтэн бусчуудыг сонсох хэрэггүй.

Шримад Бхагаватамын нэг дүгээр дууллын хоёр дугаар бүлэгт, Үнэмлэхүй Үнэн, Бурханы Дээд Бодьгал Кришнаг таньж мэдэх энэхүү арга замыг дараах байдлаар тодорхойлсон байдаг:

*шринватам сва-катхах кришнах пунья-шравана-киртанах
хридй антах-стхо хй абхадрани видхуноти сукхрит сатам.*

*нашта-праешв абхадрешу нитьям бхагавата-севая
бхагаватй уттама-шлоке бхактир бхавати найштхики.*

*тада ражас-тамо-бхавах кама-лобхадаяш ча е
чета этайр анавиддхам стхитам саттве прасидати.*

эвам прасанна-манасо бхагавад-бхакти-йогатах

бхагават-таттва-вигьянам мукта-сангасья жаяте.

*бхидьяте хридая-грантхиш чхидьянте сарва-самшаях
кшиянте часья кармани дришта эватманишваре*

“Ведийн судруудаас Кришнагийн тухай яриа хүүрнэлүүдийг, эсвэл Кришнагийн айлдварыг шууд Бхагавад Гитагаас сонсох нь чин бишрэлийн ариун үйл юм. Чин бишрэлтэн нь байнгад Кришнагийн тухай сонсох аваас амьд оршнол бүрийн зүрхэнд залрах Шри Кришна Өөрийгөө түүнд дээдийн дээд, сайныг ерөөгч найз нөхөр байдлаар нээн, түүнийг дотроос нь ариусгадаг. Чин бишрэлтэн нь ийнхүү жам ёсны байдлаар өөрийн дотооддоо үүрэглэн байх трансценденталь мэдлэгээ сэрээж хөгжүүлж байдаг. Кришнагийн тухай Бхагаватамаас болон чин бишрэлтэнгүүдээс хэдийчинээн их сонсоно, Бурханы чин бишрэл бишрэлийн албанд төдийчинээн гүн батжина. Чин бишрэлээр зүтгэх үйлээ хөгжүүлснээр хүн хүсэл тачаалын болоод харанхуй мунхгийн гунуудын эрхшээл, нөлөөллөөс ангижрах бөгөөд материаллаг шунал болоод хомхойрол нь буурна. Энэхүү бузраас ариуссанаар трансценденталист нь цэвэр ариуны гунын түвшинд бэхжиж, чин бишрэлийн албанд зүтгэхийн баяр хөөрийг амтлан эдэлж, Бурханы тухай эрдэм ухааныг төгс төгөлдөр ойлгох болно. Ийнхүү *бхакти-йога* нь материаллаг дурлан татагдахуйн хатуу чанга зангилааг тас цавчин хаяж, чин бишрэлтэнг Дээдийн Дээд Үнэмлэхүй Үнэн, Бурханы Бодьгалыг ойлгох *асамшайам самаграм* түвшинд шууд хүрэх чадвартай болгодог. (Шримад Бхагаватам, 1.2.17-21).

Иймээс Кришнагийн тухай эрдэм ухааныг зөвхөн Кришнагаас эсвэл Кришнаг ухамсарласан Түүний чин бишрэлтэнгээс сонссоноор л ойлгож болно.

ШҮЛЭГ 2

гьянам те `хам са-вигьянам идам вакшьямй ашешатах

яж гьятва неха бхуйо `ньяж гьятавьям авашишьяте

гьянам- *онолын мэдлэг*, те- *чамд*, ахам- *Би*, са- *хамт*, вигьянам- *практик мэдлэг*, идам- *энэ*,

вакшьями- *тайлбарлах болно*, ашешатах- *бүрэн*, ят- *түүнийг*, гьятва- *таньж мэдсэнээр*, на-

үгүй, иха- *энэ ертөнцөд*, бхуях- *цаашид*, аньят- *ямар нэгэн зүйл илүү*, гьятавьям- *таньж*

мэдэх, авашишьяте- *үлддэг*.

Харин Би одоо чамд энэхүү онолын ба практик мэдлэгийг бүхэлд нь тайлбарлая. Үүнийг ойлгож хүртсэнээр чамд таньж мэдээгүй зүйл гэж огт үгүй болно.

ТАЙЛБАР: Бүрэн төгс мэдлэг нь материаллаг ертөнц болон түүний цаад ард талд нь байх бурханлаг мөн чанар болон тэдгээр хоёрын эх үүсвэрийн тухай мэдлэгийг агуулж байдаг. Бүрэн төгс төгөлдөр мэдлэг гэдэг нь иймээс трансценденталь мэдлэгийг хэлдэг. Аржуна бол Бурханы дотнын найз нөхөр хийгээд итгэлт чин бишрэлтэн учир Тэр түүнд дээр дурьдсан мэдлэгийн системийг тайлбарлаж өгөхийг хүсэж байна. Зөвхөн Бурханаас Өөрөөс нь эхлэл авсан багш шавийн барилдлагааны хэлхээнд хамаарах чин бишрэлтэн л бүрэн төгс мэдлэгийг хүртэж чадна гэдгийг дөрөв дүгээр бүлгийн эхэнд Бурхан тайлбарласан бөгөөд одоо энд тэр тухай дахин давтан, баталгаажуулж байна. Иймээс хүн, иогийн бүхий л арга замуудын бясалгах цорын ганц объект болох хийгээд бүх учир шалтгааны учир шалтгаан байх бүх мэдлэгийн тэр л эх булагт хүрэхээр оюунлаг байх хэрэгтэй. Бүх учир шалтгааны учир шалтгааныг таньж мэдсэн хүн л мэдэж болох бүхнийг мэдэх бөгөөд таньж мэдээгүй зүйл гэж түүний хувьд үгүй болдог. Ведэд (Мундака-упанишад, 1.3)-т үүнийг баталгаажуулан, *касмин ну бхагаво вижнате сарвам идам вигьятам бхаватити* гэж өгүүлсэн байдаг.

ШҮЛЭГ 3

манушьянам сахасрешу кашчид ятати сиддхае

ятатам апи сиддханам кашчин мам ветти таттватах

манушьянам- хүмүүсийн, сахасрешу- олон мянган, кашчид- нэг, ятати- чармайдаг, сиддхае-
төгс төгөлдөрт хүрэхээр, ятатам- ингээж чармайж байгаа хүмүүсээс, апи- үнэхээр,
сиддханам- төгс төгөлдөрт хүрэгсдээс, кашчит- нэг, мам- Намайг, ветти- таньж мэддэг,
таттватах- үнэн байдалд,

Олон мянган хүмүүсийн дотроос магадгүй нэг нь л төгс төгөлдөрт хүрэхийг чармайж байдаг. Төгс төгөлдөрт хүрэгсдээс дөнгөж нэг нь л Намайг жинхэнэ үнэнээр нь арай чарай таньж мэддэг.

ТАЙЛБАР: Хүмүүс янз бүр байдаг бөгөөд олон олон мянган хүмүүсээс магадгүй нэг нь л сүнс гэж хэн болох, бие махбодь гэж юу болох, мөн Үнэмлэхүй Үнэн гэж хэн болохыг ойлгохыг оролдох хэмжээгээр л бурханлаг танин мэдэхүйг сонирхож байдаг. Ерөнхийдөө хүмүүсийн ихэнх нь зөвхөн идэх, унтах, амиа хамгаалах болон өсөж үржих гэсэн адгуусны гэмээр дур сонирхлоо хангахын хойноос л хөөцөлдөж байдаг бөгөөд бараг хэн нь ч трансценденталь мэдлэгийн талаар сонирхдоггүй. Гитагийн эхний зургаан бүлэг нь трансценденталь мэдлэгийг буюу сүнс болон Дээд Сүнсний мөн чанарыг хийгээд мөн *гьяна-йога*, *дхьяна-йога* болон сүнсээ бие махбодиос ялгаж салгах арга замаар өөрийгөө танин мэдэхийг сонирхогчдод зориулагдсан. Гэхдээ Кришнаг зөвхөн Кришнаг ухамсарласан хүн л таньж мэдэж чадах болно. Бодьгал бус Брахманыг таньж мэдэх нь Кришнаг ойлгохоос амар хялбар байдаг учир бусад трансценденталистууд нь түүнд л хүрсэн байж болох. Кришна бол Дээдийн Дээд Бодьгал мөн болохын зэрэгцээ Брахман хийгээд Параматмаг таньж мэдэх түвшингээс чанадад оршдог. *Йогчид* болон *гьяначдын* Кришнаг ойлгох гэсэн оролдлого чармайлт нь бүрнээ төөрөгдөл, самууралд ордог. Хэдийгээр бодьгал бусыг баримтлагч философичдоос хамгийн аугаа нь болох Шрипада Шанкарачарья нь Гитад өгсөн тайлбартаа Кришнаг Бурханы Дээд Бодьгал гэдгийг хүлээн зөвшөөрсөн байдаг ч түүнийг дагалдагчид нь Кришнаг ийм байдлаар хүлээн зөвшөөрдөггүй. Энэ нь бодьгал бус Брахманыг таньж мэдэх трансценденталь түвшинд хүрсэн хүн ч Кришнагийн жинхэнэ мөн чанарыг ойлгоно гэдэг маш хүнд бэрх байдаг гэдгийг илтгэж байна.

Кришна бол Бурханы Дээд Бодьгал, бүх учир шалтгааны учир шалтгаан, анхдагч Бурхан, Говинда. *Ишварах парамах кришнах сач-чид-ананда-виграхах анадир адир говиндах сарва-карана-каранам*. Чин бишрэлтэн бус хүмүүсийн хувьд Кришнаг ойлгох нь маш хүнд бэрх. Тэд чин бишрэл дүүрэн бялхах албаны зам мөр, *бхакти-йога* нь маш хялбархан гэгцгээх боловч өөрсдөө энэ зам мөрийг даган замнах чадваргүй байдаг. Чин бишрэлийн зам мөр нь эдгээр хүмүүсийн батлан байгаа шиг үнэхээр тийм амар хялбар юм бол тэд өөрсдөө яагаад хүнд бэрх зам мөрөөр замнаж байдаг юм бэ? Үнэндээ *бхакти-йога* зам мөр нь амар хялбар биш. *Бхактийн* талаар ямар ч мэдлэггүй хүмүүсийн дагаж мөрдөх *бхакти-йога* гэгдэх зүйл нь амархан байж болох боловч, чин бишрэл дүүрэн бялхах албаны дүрэм журам, заавруудыг жинхэнэ ёсоор нь баримтлан мөрдөхдөө тулмагц л эдгээр цэцэрхэгчид нь энэ зам мөрийг орхицгоодог. Шрила Рупа Госвами Бхакти-расамрита-синдхугийн (1.2.101)-д бичихдээ:

*шрути-смрити-пуранади- панчаратра-видхим вина
айкантики харер бхактир утпатаййва калпате*

“Упанишад, Пурана болон Нарада-панчаратра зэрэг Ведийн жинхэнэ эх сурвалж болох судруудад заасны дагуу Бурханд чин бишрэлээр зүтгээгүй л бол тэр нь нийгмийг хий дэмий тайван бус байдалд оруулдаг.”

Бодьгал бус Брахманыг бүрэн таньж мэдсэн имперсоналистууд эсвэл Параматмаг бүрэн таньж мэдэх түвшинд хүрсэн иогчдын хувьд Бурханы Дээд Бодьгал Кришнаг Яшода эхийн хүү юмуу эсвэл Аржунагийн байлдааны тэрэгний хөтөч байдлаар ойлгож хүлээн авах нь боломжгүй хэрэг юм. Зарим үед аугаа сахиулсан тэнгэрүүд ч хүртэл төөрөлдөн Кришнаг ойлгодоггүй (*мухьянти ят сураях*). Үүнтэй холбогдуулан Бурхан айлдахдаа: *мам ту веда на кашчана*- “Намайг жинхэнэ байдлаар нь хэн ч ойлгодоггүй.” гэжээ. Мөн Түүнийг үнэхээр танин мэдэгчийн тухай: *са махатма су-дурлабхах*- “Ийм аугаа сүнс маш ховор.” хэмээн айлдсан. Бурханы чин бишрэлийн албанд зүтгээгүй цагт хүн аугаа их эрдэмтэн ч бай, эсвэл философич ч бай ялгаагүй Кришнаг жинхэнэ дүр төрхөөр нь (*таттватах*) ойлгож ухаарч чадахгүй. Кришна чин бишрэлтэнгүүддээ элэгсэг дотно, ивээнгүй ханддаг учраас зөвхөн Түүний цэвэр чин бишрэлтэнгүүд л бүх учир шалтгааны учир шалтгаан болох Кришнагийн ойлгож ухаарахын аргагүй трансценденталь шинж чанарууд -Түүний төгс хүчин, Түүний гайхамшигт байдлуудын талаар, Түүний баялгийн тухай, Түүний алдар цууны, Түүний хүч чадлын, Түүний гоо үзэсгэлэн төгөлдөрийн, Түүний мэдлэгийн тухай болон Түүний огоорохуйн тухай- тодорхой хэмжээгээр л ойлгож чадна. Энэ бол Брахманыг танин мэдэхүйн дээдийн дээд төлөв бөгөөд гагцхүү чин бишрэлтэнгүүд л Түүнийг жинхэнэ дүр төрхөөр нь таньж мэдэж чадна. Тийм учраас:

*атах шри-кришна-намади на бхавед грахьям индрияйх
севонмукхе хи жихвадау сваям эва спхуратй адах*

“Бүдүүн баараг мэдрэхүйнхээ тусламжтайгаар хэн ч Кришнаг жинхэнэ байгаагаар нь ойлгож ухаарах аргагүй. Харин Тэр, Өөрт нь трансценденталь хайраар дүүрэн зүтгэж байгаа чин бишрэлтэнгүүдээ таашаан байдаг учраас тэдэнд Өөрийгөө нээдэг.” (Бхакти-расамрита-синдху, 1.2.234) гэжээ.

ШҮЛЭГ 4

*бхумир апо `нало ваюх кхам мано буддхир эва ча
аханкара итьям ме бхина пракритир аштадха*

бхумих- газар, алах- ус, аналах- гал, ваюх- хий, кхам- огторгуй, манах- ухаан, буддхих- оюун ухаан, эва- гарцаагүй, ча- болон, аханкарах- хуурамч эго, ити- ийм байдлаар, иям- энэ бүхэн, ме- Миний, бхинна- салангид тусдаа, пракритих- эрчмүүд, аштадха- найман.

Шороо, ус, гал, хий, огторгуй, ухаан, оюун ухаан болон хуурамч эго- эдгээр найман махбодь нь нийтдээ Миний салангид тусдаа байх материаллаг эрчмүүдийг бүрдүүлдэг.

ТАЙЛБАР: Бурханы тухай эрдэм ухаан нь Бурханы жинхэнэ байр суурь болоод Түүний янз бүрийн эрчмүүдийн тухай мэдлэгийг агуулдаг. Материаллаг байгалийг *пракрити* гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл, энэ нь Бурханы Өөрийнх нь янз бүрийн *пуруша-аватар* дүрүүдээрээ илрүүлж тодруулдаг эрчим юм. Энэ тухай Сатвата-тантрад өгүүлэхдээ:

*вишнос ту трини рупани пурушакхьяни атхо видух
экам ту махатах сраштри двитиям тв анда-самстхитам
тритиям сарва-бхута-стхам тани гьятва вимучьяте*

“Материаллаг бүтээлийг илрүүлэн тодруулахын тулд Шри Кришнагийн бүрэн хувилгаан дүр нь Вишнугийн гурван хэлбэр, дүрд хувилдаг. Нэг дүгээр дүр Маха Вишну нь *махат-таттва* гэж нэрлэгдэх материаллаг эрчмийг бүхэлд нь бүтээн бий болгодог, хоёр дахь буюу Гарбодакашайи Вишну нь орчлон бүрт олон төрөл зүйлийг бий болгохын тулд бүхий л орчлонгуудад нэвчин ордог. Гурав дахь буюу Кширодакашайи Вишну нь Параматма хэлбэрээр орчлон даяар бүхэнд нэвчин орж хаа сайгүй тэр ч бүү хэл атом бүрт ч заларч байдаг. Энэ гурван Вишнуг таньж мэдсэн хэн бүхэн материаллаг боолчлолын хүлээснээс ангижирч чадна.”

Материаллаг ертөнц нь Бурханы эрчмүүдийн нэгнийх нь түр зуурын илрэл юм. Материаллаг ертөнцөд болж буй бүхий л үйл ажиллагааг Шри Кришнагийн энэхүү гурван Вишну- дүр залж удирдаж байдаг. Эдгээр *пуруша-гуудыг* хувилгаан дүрүүд гэж нэрлэдэг. Бурханы (Кришнагийн) тухай эрдэм ухааны мэдлэггүй хүмүүс нь ерөнхийдөө, энэхүү материаллаг ертөнц нь амьд оршнолын таашаал ханамж эдлэхийн төлөө л зориулагдан бүтээгдсэн хийгээд амьд оршнол нь өөрөө *пуруша* буюу материаллаг эрчмийн удирдан залагч, түүний учир шалтгаан, мөн түүнийгч таашаагч хэмээн боддог. Бхагавад Гитагийн дагуу бол ийм бурхангүйн үзэл бодол нь буруу юм. Энэ шүлэгт, Кришна бол материаллаг илрэлийн анхдагч буюу эх шалтгаан нь гэдгийг батлан өгүүлж байна. Шримад Бхагаватамд ч мөн энэ тухай батлан өгүүлдэг. Материаллаг илрэл тодролын бүрэлдэхүүн хэсгүүд нь Бурханы салангид тусдаа эрчмүүд байдаг. Тэр бүү хэл, имперсоналистуудын дээдийн дээд зорилго болсон *брахмахьоти* нь бурханлаг тэнгэрт дэлгэрэн байгаа бурханлаг эрчим билээ. Вайкунтха-гийн гаригууд дээрх шиг тийм бурханлаг олон янз байдал *брахмахьотид* байдаггүй ч бодьгал бусыг баримтлагчид нь энэхүү *брахмахьотиг* дээдийн дээд мөнхийн зорилго болгож байдаг. Параматма ч Кширодакашайи Вишнугийн түр зуурын, бүхэнд нэвчих төлөв учраас мөн дээдийн дээд зорилго биш юм. Параматма нь бурханлаг ертөнцөд мөнхөд оршигч илрэл тодрол биш. Ийм учраас Бурханы Дээд Бодьгал, Кришна бол үнэхээрийн Үнэмлэхүй Үнэн мөн болой. Тэр бол бүрэн төгс төгөлдөр Бодьгал, бүх эрчмүүдийн эх үүсвэр болох бөгөөд Тэрээр янз бүрийн салангид тусдаа гадаад болон мөн дотоод эрчмүүдийг агуулж байдаг.

Дээр өгүүлсэнчлэн, материаллаг эрчимд найман гол элемент (махбодь) байдаг. Эдгээрийн эхний тав буюу шороо, ус, гал, хий болон огторгуйг гол буюу бүдүүн махбодиуд гэж нэрлэдэг. Эдгээр бүдүүн махбодиудад мөн мэдрэхүйн таван объектууд болох материаллаг дуу авианы, материаллаг хүртэхүйн, материаллаг хэлбэрийн, материаллаг амтны болон материаллаг үнэрийн илрэл тодролууд агуулагдаж байдаг. Материаллаг шинжлэх ухаан нь энэ арван ойлголтыг л авч үзэхээс биш түүнээс цааш гардаггүй. Бусад гурвын нь буюу ухаан, оюун ухаан болон хуурамч эго-г материалистууд анхаардаггүй. Ухаан бодлын түвшний янз бүрийн үйл явцыг судлах философичид нь дээд учир шалтгаан Кришнаг таньж мэддэггүй учир мөн л төгс төгөлдөр бус юм. Материаллаг оршихуйн үндсэн зарчмыг бүрдүүлэгч болох, “Би бол” болон “Энэ бол минийх” гэсэн ойлголттой холбогдсон хуурамч эго нь материаллаг үйл ажиллагааг гүйцэтгэдэг мэдрэхүйн арван эрхтнийг өөртөө агуулж байдаг. Оюун ухаан нь *махат-таттвад* буюу материаллаг бүтээлийн цогцод мөн хамаарагддаг. Иймээс материаллаг ертөнцийн хориндөрвөн элементүүд нь Бурханы салангид тусдаа орших найман эрчмээс илрэн гардаг байна. Бурхангүй үзэлт *санкхья*-философийн судлагдахуун болсон эдгээр хориндөрвөн элементүүд нь язгуур гарлын хувьд Кришнагийн эрчмийн бүтээгдхүүн бөгөөд Түүнээс салангид тусдаа оршдог. Гэсэн ч мэдлэгээр хомс дутмаг *санкхья*-философичид нь бүх учир шалтгааны учир шалтгаан нь Кришна гэдгийг мэддэггүй. Бхагавад Гитад, энд тодорхойлсноор, *санкхья*-философичдын маргалдааны сэдэв нь зөвхөн, Кришнагийн гадаад эрчмийн илрэл тодролууд болж байдаг байна.

ШҮЛЭГ 5

*апареям итас тв аньям пракритим виддхи ме парам
жива-бхутам маха-бахо яедам дхарьяте жагат*

апара- доод, *иям-* энэ, *итах-* үүний зэрэгцээ, *ту-* гэвч, *аньям-* өөр нэг, *пракритим-* эрчим, *виддхи-* ойлгохыг оролд, *ме-* Миний, *парам-* илүү дээд, *жива-бхутам-* амьд оршнолуудыг багтаах, *маха-бахо-* хүчит гарт минь, *яя-* тэднээр, *идам-* энэ, *дхарьяте-* ашиглагддаг, *жагат-* материаллаг ертөнц.

Эдгээр доод эрчмүүдийн зэрэгцээ, ай хүчит гарт Аржуна минь ээ, материаллаг, доод байгалийн баялгийг ашиглах боломж олгогдсон амьд оршнолуудыг өөртөө багтаах мөн өөр нэг Миний дээд эрчим оршин байдаг.

ТАЙЛБАР: Амьд оршнол нь Бүхний Дээдийн дээд байгальд буюу дээд эрчимд хамаарагддаг гэж энд тодорхой хэлж байна. Доод эрчим нь шороо, ус, гал, хий, огторгуй, ухаан, оюун ухаан болон хуурамч эго зэрэг махбодиудаас бүрдэх матери юм. Материаллаг байгалийн бүдүүн (шороо гэх мэт) болон нарийн (ухаан гэх мэт) гэсэн хоёр хэлбэр нь хоёулаа доод эрчмийн бүтээгдэхүүн байдаг. Эдгээр доод эрчмүүдийг янз бүрийн зорилгоор ашиглаж байдаг амьд оршнолууд нь Бүхний Дээд Бурханы дээд эрчимд хамаарагддаг бөгөөд энэ эрчмийн ач тусаар л материаллаг ертөнцийн бүхий л үйл ажиллагаа явагдаж байдаг. Сансар огторгуйн илрэл тодролуудыг дээд эрчим буюу амьд оршнолууд үйл, хөдлөлд оруулахгүй л бол тэд өөрсдөө ийнхүү идэвхтэй байх чадваргүй билээ. Эрчмүүд нь эх үүсвэртээ үргэлж удирдагдаж, залагдаж байдаг учраас амьд оршнолууд нь Бурханд захирагдаж байдаг бөгөөд тэд бүрэн хамааралгүйгээр оршдоггүй. Оюунлаг бус хүмүүсийн бодож байдаг шигээр, тэд яагаад ч Бурхантай адил хүчирхэг байдаггүй билээ. Амьд оршнол болон Бурханы хоорондын ялгааг Шримад Бхагаватамын (10.87.30)-д дараах байдлаар тодорхойлон өгүүлсэн байдаг:

*апаримита дхрувас тану-бхрито яди сарва-гатас
тархи на шасьятети ниямо дхрува нетаратха
ажани ча ян-маям тад авимучья ниятри бхавет
самам анужанатам яд аматам мата-душтатая*

“Ай мөнхөд оршигч Дээдийн Дээд минь ээ, Материаллаг бие махбодид төрсөн амьд оршнолууд нь Тан лугаа үл өөрчлөгдөж хувирдаг хийгээд бүхэнд нэвчин ордог байсансан бол тэд Танд захирагдахгүй байсан билээ. Харин амьд оршнолууд нь Таны Бодьгалын эрчмийн өчүүхэн жижиг хэсэг гэдгээ хүлээн зөвшөөрөх аваас энэ нь шууд, тэд Таны дээдийн дээд захиргаанд захирагдаж байдаг гэсэн үг болно. Иймээс амьд оршнолууд нь нь жинхэнэ ангижралд хүрэхийн тулд Танд өөрсдийгөө даатгах ёстой бөгөөд ийнхүү даатгагчааснаар л тэд аз жаргалтай болно. Зөвхөн энэхүү жинхэнэ байр сууриндаа л тэд эзэн байж чадах билээ. Бурхан болон амьд оршнолууд нь бүхий л талаараа адил байдаг гэх монизмын онолыг төлөөлөх хомс мэдлэг бүхий хүмүүс нь үнэн хэрэгтээ буруу болоод ариун бус үзэл бодлын золиос болж байдаг.”

Бүхний Дээд Бурхан Кришна цорын ганц эзэн захирагч бөгөөд бүх амьд оршнолууд Түүнд захирагддаг. Эдгээр амьд оршнолууд нь шинж чанарын хувьд Бүхний Дээдтэй ижил түвшинд орших учраас тэд Түүний дээд эрчим байх боловч эрх, хүч чадлын хувьд Бурхантай хэзээ ч эн зэрэгцэхгүй. Дээд эрчим (амьд оршнол) нь бүдүүн болоод нарийн хэлбэртэй байх доод эрчмийг ашиглаж, мөлжин байх явцдаа өөрийн жинхэнэ бурханлаг ухаан болоод жинхэнэ бурханлаг оюун ухаанаа мартдаг. Ийнхүү мартаж амьд оршнолд үзүүлэх материйн үйлчлэл, нөлөөллөөс үүдэлтэй. Гэхдээ амьд оршнол нь хий хуурмагийн, материаллаг эрчмийн нөлөөллөөс чөлөөлөгдөн салсанаараа *мукти* буюу ангижрал гэж нэрлэгдэх түвшинд хүрдэг. Материаллаг хий хуурмагийн нөлөөлөлд орших хуурамч эго нь “Би бол матери, материаллаг зүйлс, баялаг нь минийх, надад харьяалагддаг.” хэмээн бодож байдаг. Харин амьд оршнол нь бүхий л материаллаг төсөөлөл болоод Бурхантай бүх талаар адил, ижил байдаг гэсэн ойлголтоосоо ангижирсанаар л өөрийн жинхэнэ байр суурийг таньж мэддэг. Иймээс, Гитагийн номлол, сургаалаас, амьд оршнол нь Бурханы олон янзын эрчмийн зөвхөн нэг нь л бөгөөд энэхүү эрчим нь материаллаг бузраас ариуссанаар Кришнаг бүрэн ухамсарлах буюу төгс төгөлдөр ангижралд хүрнэ гэсэн дүгнэлт хийж болно.

ШҮЛЭГ 6

*этад-йонини бхутани сарванитй упадхарая
ахам критснасья жагатах прабхавах пралаяс татха*

элат- энэ хоёр мөн чанарууд, *йонини-* бхутани- бүтээгдсэн бүхэн, *сарвани-* бүгд, *ити-* ийм байдлаар, *упадхарая-* мэдэж ав, *ахам-* Би, *критснасья-* бүхнийг өөртөө агуулах, *жагатах-* ертөнцийн, *прабхавах-* илрэл тодролын эх булаг, *пралаях-* устал сүйрэл, *татха-* мөн тэрчлэн.

Бүтээгдсэн бүх оршнолууд нь энэ хоёр мөн чанараас эхлэлээ авдаг. Энэ ертөнц дэх материаллаг болоод бурханлаг бүхний эхлэл болоод төгсгөл нь чухамхүү Би юм гэдгийг мэдэж ав.

ТАЙЛБАР: Энэ ертөнцөд оршин байх бүхэн нь матери болоод бурханлаг эрчим хоёрын бүтээгдэхүүн билээ. Бурханлаг эрчим нь бүтээлийн үндэс суурь нь байдаг бөгөөд материйг бурханлаг эрчим бүтээдэг. Матери нь өөрийн хөгжлийн тодорхой түвшинд бурханлаг эрчмийг бий болгодог гэдэг нь буруу юм. Харин ч эсрэгээр буюу зөвхөн бурханлаг эрчмийн үндсэн дээр л энэхүү материаллаг ертөнц нь оршин тогтнож байдаг. Бурханлаг эрчим материт оршин байгаагийн ачаар л бидний материаллаг бие махбодь хөгжиж байдаг. Энэхүү дээд эрчим, бурханлаг сүнс оршин байдаг учраас л нялх нярай хүүхэд аажим аажмаар өсөн торниж балчир, өсвөр насыг туулан улмаар насанд хүрч том хүн болдог. Үүний нэгэн адил, Дээд Сүнс, Вишну залран байх учраас аврага том орчлонгийн нийт сансар огторгуйн илрэлүүд нь тодрон байдаг. Энэхүү аврага том орчлонг илрүүлэн тодруулахаар хоорондоо холбогдон байх бурханлаг байгаль хийгээд матери нь гарал язгуурын хувьд Бурханы эрчмүүд мөн тул Бурхан бол бүх зүйлсийн анхдагч, эх учир шалтгаан байдаг. Бурханы өчүүхэн жижиг, салшгүй хэсэг болох амьд оршнол нь тэнгэр баганадсан өндөр том барилгын эсвэл нэгэн том үйлдвэрийн ч юм уу эсвэл нэгэн том хотын учир

шалтгаан байж болох боловч хэзээ ч аугаа том орчлонгийн учир шалтгаан байж чадахгүй. Энэхүү аугаа том орчлонгийн учир шалтгаан нь аугаа сүнс буюу Дээд Сүнс юм. Харин Дээдийн Дээд, Кришна нь аугаа том болоод жижиг бүхий л сүнснүүдийн анхдагч учир шалтгаан. Ийм учраас Тэр бүх учир шалтгаануудын эх учир шалтгаан. Энэ тухай Катха-упанишадын (2.2.13)-д: *нитьо нитьянам четанаш четананам* гэж батлан өгүүлсэн байдаг.

ШҮЛЭГ 7

*маттах паратарам наньят кинчид асти дхананжая
майи сарвам идам протам сутре мани-гана ива*

маттах- Надаас чанадад, *пара-тарам*- илүү дээд, *на*- үгүй, *аньят кинчит*- өөр ямар нэгэн, *асти*- байдаг, *дхананжая*- баялгийг эзлэгч минь, *майи*- Миний дотор, *сарвам*- оршин байгаа бүхэн, *идам*- бидний харж байгаа, *протам*- хэлхэгдсэн, *сутре*- утсанд, *мани-ганах*- сувд, *ива*- шиг.

Ай баялгыг байлдан эзлэгч минь ээ, Надаас дээш үнэн гэж үгүй билээ. Бүх зүйлс нь утсанд хэлхсэн сувд адил Надад тулгуурлан оршиж байдаг.

ТАЙЛБАР: Дээдийн дээд Үнэмлэхүй Үнэн нь бодьгал уу, бодьгал бус уу гэдэг талаар эртнээс л маргалдаж ирсэн. Бхагавад Гитагийн хувьд Үнэмлэхүй Үнэн бол Бурханы Бодьгал Шри Кришна бөгөөд энэ талаар хуудас бүрт л баталж нотолсон байдаг. Ялангуяа энэ шүлэгт Үнэмлэхүй Үнэн бол бодьгал гэдгийг онцлон тэмдэглэж байна. Бурханы Бодьгал нь Дээдийн Дээд Үнэмлэхүй Үнэн гэдгийг мөн Брахма-самхитад: *ишварах парамах кришнах сач-чид-ананда-виграхах* буюу “Дээдийн Дээд Үнэмлэхүй Үнэн, Бурханы Бодьгал нь Шри Кришна юм. Тэр бол анхдагч Эзэн, бүх баяр баясгалангийн эх булаг, Говинда бөгөөд төгс төгөлдөр жаргал цэнгэл хийгээд төгс төгөлдөр мэдлэгийн мөнхийн дүр” гэж батлан өгүүлсэн байдаг. Эдгээр жинхэнэ эх сурвалж судрууд нь Үнэмлэхүй Үнэн бол Дээдийн Дээд Бодьгал, бүх учир шалтгааны эх учир шалтгаан мөн гэдэг тал дээр ямар ч эргэлзээ төрүүлдэггүй. Харин бодьгал бусыг баримтлагчид нь Шветашватара-упанишадын (3.10)-д өгүүлэх дараах шүлэгт тулгуурлан эсрэг байр суурийг илэрхийлдэг: *тато яд уттараатарам тад арупам анамаям я этад видур амритас те бхаванти атхетаре духкхам эвалиянти* “Материаллаг ертөнцөд орчлонгийн анхдагч амьд оршнол болох Брахма нь сахиулсан тэнгэрүүд, хүмүүс болон доод амьтдын дундаас хамгийн дээд гэж тооцогддог. Гэсэн ч Брахмагаас дээш, чанадад материаллаг хэлбэр дүрүүдийг үл агуулах болон бүхий л материаллаг бузраас ангид байх Трансцендент оршдог. Түүнийг таньж мэдэж чадсан хэн бүхэн мөн трансценденталист. Харин Трансцендентыг таньж мэдэж чадаагүй хэн бүхэн материаллаг ертөнцийн зовлон зүдгүүрийг амсаж эдлэн, туулах ёстой болж байдаг.”

Бодьгал бусыг баримтлагч философичид нь юуны өмнө *арулам* гэдэг үгийг онцолдог. Гэхдээ энэ үг нь бодьгал бус зүйлд хамаарагддаггүй. Энэ үг нь Үнэмлэхүй Үнэн бол материаллаг бус харин дээр, Брахма-самхитагаас иш татсан шүлгийн баталж байгаачлан, мөнхийн, жаргал цэнгэл, мэдлэгээр дүүрэн бялхаж байх трансценденталь дүртэйг зааж байдаг. Энэ тухай мөн Шветашватара-упанишадын (3.8-9) шүлгүүд баталдаг:

*ведахам этам пурушам махантам
адитья-варнам тамасах парастат
там эва видитвати мритьюм эти
наньях пантха видьяте `яная*

*ясмат парам напарам асти кинчид
ясман нанийо но жьяйо `сти кинчит
врикша ива стабдхо диви тиштхатй экас
тенедам пурнам пурушена сарвам*

“Харанхуй мунхгийн бүхий л материаллаг ойлголт, төсөөллүүдэд трансценденталь орших Бурханы Дээд Бодьгалыг би таньж мэддэг билээ. Зөвхөн Түүнийг таньж мэдсэн хүн л төрөлт-үхлийн хүлээсийг ялан дийлж чадна. Дээдийн Дээд Бодьгалыг таньж мэдэхгүйгээр ангижралд хүрэх өөр арга зам байдаггүй.

Бурхан бүхний дээр залрах учраас Түүнээс дээш орших үнэн гэж байдаггүй. Тэр бол хамгийн өчүүхэн жижгээс ч жижиг, хамгийн аугаа томоос ч том. Түүнийг ургаа модтой зүйрлэж болох бөгөөд Тэрээр трансценденталь тэнгэрийг гийгүүлэн байдаг. Мод өөрийн үндсээ тархаан сунгаж байдгийн адил Тэр Өөрийн олон янзын эрчмүүдээ дэлгэрүүлж байдаг.”

Энэ шүлгүүдээс үзэхэд, Дээдийн Дээд Үнэмлэхүй Үнэн нь Өөрийн олон янзын материаллаг болон бурханлаг эрчмүүдээрээ бүхэнд нэвчин ордог Бурханы Дээд Бодьгал мөн болох нь тодорхой байна.

ШҮЛЭГ 8

*расо `хам апсу каунтея прабхасми шаши-сурьяйох
пранавах сарва-ведешу шабдах кхе паурушам нришу*

расах- амт, *ахам*- Би, *апсу-усанд*, *каунтея*- Кунтийн хүү минь, *прабха*- гэрэл, *асми*- Би бол, *шаши-сурьяйох*- сарны болон нарны, *пранавах*- а-у-м гурван үсэг, *сарва*- бүхэнд, *ведешу*- Ведэд, *шабдах*- дуу авиа, *кхе-огторгуйд*, *паурушам*- чадвар, *нришу*- хүнд.

Ай Кунтийн хүү минь ээ, Би бол усны амт, Би бол нар болоод сарны гэрэл, Ведийн мантрад байдаг ом-үе, Би бол огторгуй дахь дуу, хүний авъяас чадвар билээ.

ТАЙЛБАР: Бурхан Өөрийн олон янзын материаллаг болон бурханлаг эрчмүүдээрээ бүхэнд хэрхэн нэвчин түгж байдаг тухай энэ шүлэгт тайлбарлаж байна. Бүхний Дээд Бурханыг эхлээд Түүний янз бүрийн эрчмүүдээр нь ухаарч байж л дараа нь бодьгал бус төлөвт байх Түүнийг таньж мэдэж болно. Нарны тэнгэр нь бодьгал байдаг хийгээд түүнийг бүхэнд нэвчин тархах эрчим нарны туяагаар нь хэрхэн яаж ойлгож мэддэгийн адил Өөрийн мөнхийн орондоо залран байх Бурханыг, Түүнийг бүхэнд нэвчиж, хаа сайгүй түгэн тархах эрчмүүдээр нь л ойлгож ухаарч болно.

Амт бол усны үндсэн шинж чанар юм. Усны цэвэр амт нь давсны амттай холилдсон байдаг учраас далайн усыг уухыг хэн ч дурладаггүй билээ. Хүнд цэвэр ус уух сонирхол төрдөг нь түүний амтны цэвэр ариунаас шалтгаалдаг бөгөөд энэхүү цэвэр амт нь Бурханы эрчмүүдийн нэг байдаг. Имперсоналистууд нь Бурханыг усанд оршин байхыг түүний амтаар л ойлгож мэддэг бол, персоналистууд нь мөн үүний зэрэгцээ, хүний цангааг нь тайлахын тулд ийнхүү амтат усыг хүртээн, өршөөл соёрхлоо хайрлан байдаг нь Бурханыг магтан дуулдаг. Бүхний Дээдийг тэд ингэж л өөр өөрсдийнхөөрөө ойлгож ухаардаг. Чухамдаа бодит байдалд, персонализм болоод имперсонализмын онолуудын хооронд маргаан сэргэлдөөн байддаггүй. Бурханыг таньж мэдсэн хэн бүхэн бодьгал бус болоод бодьгал төлөв байдлууд нь бүгдэд нэгэн зэрэг оршин байх бөгөөд тэдгээрийн хооронд зөрчилдөөн байдаггүй гэдгийг мэднэ. Иймээс л Шри Чайтаны Өөрийн *ачинтья-бхеда*- болон *абхеда-таттва* буюу нэгэн зэрэг, ижил болоод ялгаатай байх гэсэн эрхэм дээд сургаалаа номлосон билээ.

Нар болоод сарны гэрэл нь Бурханы бодьгал бус туяа, *брахмажьоти*-гоос гаралтай учир мөн л Бурханы эрчим билээ. Ведийн дуулал бүрийн эхлэл болдог *пранава* буюу трансценденталь дуу авиа *омкара* нь Бүхний Дээд Бурханд хандаж байгаа хандлагын хэлбэр, дуудлага юм. Имперсоналистууд нь Бүхний Дээд Бурхан, Кришнаг Түүний тоо томшгүй олон алдар нэрээр нь дуудан хандахаасаа их айж эмээдэг тул тэд трансценденталь дуу авиа *омкара*г дуудахыг эрхэмд үздэг. Гэхдээ тэд *омкара* нь Кришнагийн дуу авиан төлөөлөл гэдгийг мэддэггүй. Кришнагийн ухамсарын нөлөөлөх хүрээ хязгаар нь хаа сайгүй үргэлжлэх тул Кришнагийн ухамсрыг ойлгож ухаарсан хэн бүхэн адислагдсан байдаг байхад Кришнаг таньж мэдэхгүй хэн бүхэн хий хуурмагт автаж байдаг. Иймээс Кришнагийн тухай мэдлэгийг хүртэнэ гэдэг нь ангижралд хүрнэ гэсэн үг бөгөөд харин Кришнагийн талаар үл мэдэн мунхаг байна гэдэг нь боолчлогдон байхын учир шалтгаан болдог.

ШҮЛЭГ 9

*пуньо гандхах притхивьям ча тежаш часми вибхаваसाу
живанам сарва-бхутешу тапаш часми тапасвишу*

пунья- анхдагч, *гандхах*- үнэр, *притхивьям*- газар дахь, *ча*- мөн, *тежах*- халуун, *ча*- мөн, *асми*- Би бол, *вибхаваसाу*- галд, *живанам*- амьдрал, *сарва*- бүхэнд, *бхутешу*- амьд оршнол, *тапах*- тэвчил, *ча*- мөн, *асми*- Би бол, *тапасвишу*- тэвчил үйлдэгчдийн.

Би бол газар шорооны жинхэнэ үнэр, Би бол галын илч дулаан, Би бол амьд бүхний амьдрал нь, мөн Би бол тэвчил үйлдэгчдийн тэвчил нь байдаг.

ТАЙЛБАР: *Пунья* гэдэг үг нь гэмтэж муудаагүй, жинхэнэ байдлаараа байгаа зүйлийг заадаг. Материаллаг ертөнц дэх бүх зүйлс тодорхой үнэртэй байдаг. Жишээлбэл: цэцгийн үнэр, газрын үнэр, усны үнэр, галын үнэр, агаарын үнэр гэх мэт. Ямар ч хольцоогүй бөгөөд бүхэнд нэвчих анхдагч анхилуун үнэр бол Кришна. Үүнтэй нэгэн адил, бүх зүйлд өөрийн гэсэн тодорхой, анхдагч жинхэнэ амт байдаг бөгөөд химийн янз бүрийн бодисуудтай хольсноор энэ амтыг өөрчилж болно. Бүх зүйлс өөрийн анхдагч хэлбэр, байдалдаа тодорхой үнэр, анхилуун байдал, амтыг агуулж байдаг.

*Вибхава*су гэдэг үг нь гал гэсэн утгатай. Галгүйгээр үйлдвэрүүд ч ажиллахгүй, бид ч хоол ундаа бэлтгэх боломжгүй болох бөгөөд энэхүү гал бол Кришна. Мөн түүнчлэн галын илч халуун ч Кришна байдаг. Ведийн анагаах ухаанаар бол ходоодны халуун дулааны хэмжээ бага байх нь хоолны боловсролт, шингэц муудахын учир шалтгаан болдог. Иймээс хоол боловсрох, шингэх явцад ч гал шаардлагатай байдаг. Кришнагийн ухамсарт л бид бүхэн шороо, ус, гал, хий болон химийн бүх бодисууд хийгээд материаллаг элементүүд Кришнагаас үүсэл гаралтай гэдгийг таньж мэддэг. Хүний амьдралын үргэлжлэх хугацаа ч Кришнагаас хамааралтай. Иймээс Кришнагийн өршөөлөөр л хүн амьдралаа уртасгаж эсвэл богиносгож чадах юм. Ингэхлээр Кришнагийн ухамсар нь оршихуйн бүхий л хүрээ салбарт үйлчлэл нөлөөллөө үзүүлдэг байна.

ШҮЛЭГ 10

*бижам мам сарва-бхутанам виддхи партха санатанам
буддхир буддхиматам асми тежас тежасвинам ахам*

бижам- үр, *мам*- Намайг, *сарва-бхутанам*- бүх амьд оршнолуудын, *виддхи*- ойлгохыг оролд, *партха*- Притхын хүү минь, *санатанам*- анхдагч, мөнх, *буддхих*- оюун ухаан, *буддхиматам*- ухаалаг хүмүүсийн, *асми*- Би бол, *тежах*- сүр хүч, *тежасвинам*- сүр хүчтэнгүүдийн, *ахам*- Би бол.

Ай Притхын хүү минь ээ, Би бол оршин байгаа бүхний анхдагч үр хөврөл, оюунлаг хүмүүсийн оюун ухаан нь, сүр хүчтэнгүүдийн сүр хүч нь гэдгийг мэдэж ав.

ТАЙЛБАР: *Бижам* гэдэг үг нь “үр” гэсэн утгатай бөгөөд Кришна бол оршин байгаа бүхний үр нь юм. Хөдлөх болоод үл хөдлөх янз бүрийн амьд оршнолууд байдаг. Шувууд, амьтад, хүмүүс болон бусад өөр олон янзын амьд оршнолууд нь хөдлөх, харин мод, ургамал зэрэг нь нэг дороо байнга байх учир үл хөдлөх амьд оршнолд хамаарагддаг. Амьд оршнол бүр нь амьдралын 8400 000 хэлбэрийн нэгэнд л хамаарагдах бөгөөд тэдний зарим нь

хөдөлдөг байхад бусад нь үл хөдлөнө. Гэхдээ аль нь ч байсан, тэдний амьдралын үр нь Кришна юм. Ведийн судруудад, Брахман буюу Дээдийн Дээд Үнэмлэхүй Үнэн нь бүх зүйл үүсэн гарах Тэр л юм гэж өгүүлсэн байдаг. Кришна бол Парабрахман буюу Дээдийн Дээд Брахман. Брахман нь бодьгал бус бол Парабрахман бол бодьгал. Бодьгал төлөв нь бодьгал бус Брахманыг өөртөө агуулдаг гэж Бхагавад Гитад тайлбарласан байдаг. Ийм учраас Кришна оршин байгаа бүхний анхдагч эх булаг буюу өөр үгээр хэлбэл үндэс нь болж байдаг. Модыг бүхэлд нь тэтгэж байдаг үндэс лугаа бүх оршнолын язгуур үндэс болох Кришна материаллаг илрэл тодролд байгаа бүхий л зүйлийг тэтгэж байдаг. Энэ тухай мөн Ведийн сударт (Катха-упанишад, 2.2.13) батлан өгүүлсэн байдаг:

*нитьянам четанаш четананам
эко бахунам йо видадхати каман*

“Тэр бол бүх мөнх оршигчдоос дээдийн дээд мөнх оршигч, Тэр бол бүх амьд оршнолуудаас дээдийн дээд амьд оршнол, Тэр ганцаараа бүхний амьдралыг тэтгэж байдаг. Оюун ухаан үгүй бол хүн юу ч хийх чадваргүй байхсан билээ. Харин энд Кришна, Тэрээр бүхий л оюун ухааны үндэс нь гэж мөн айлдаж байна. Оюунлаг бус байгаа цагт хүн Бурханы Дээд Бодьгал, Кришнаг ойлгож ухаарч чадахгүй.”

ШҮЛЭГ 11

*балам балаватам чахам кама-рага-виваржитам
дхармавируддхо бхутешу камо`сми бхаратаршабха*

балам- хүч, бала-ватам- хүчтэнгүүдийн, ча- болон, ахам- Би бол, кама- хүсэл тачаал, рага- болон дурлан татагдахуй, виваржитам- ангид, дхарма-авируддха- шашны зарчмуудын эсрэг биш, бхутешу- бүхий л орнолд, камах- бэлгийн харьцаа, асми- Би бол, бхарата-ришабха- Бхаратын тэргүүн минь.

Би бол хүсэл тачаал болоод шавдалт шаардалтаас ангид байх хүчтэнгүүдийн хүч чадал нь. Би бол шашин номын зарчмуудтай үл зөрчилдөх бэлгийн харьцаа билээ. Ай Бхаратын тэргүүн минь ээ (Аржуна).

ТАЙЛБАР: Хүчтэй хүмүүсийн хүч чадлыг бусдыг дайран довтлоход биш, харин хүчин мөхөс сул доройчуудыг хамгаалахад ашиглах ёстой. Бэлгийн харьцааны тухайд гэвэл, зөвхөн шашин номын хууль, зарчмууд (дхарма)-ын дагуу хүүхэд төрүүлэхийн тулд бэлгийн харьцаанд орох ёстой болохоос өөр бусад зорилгоор биш. Тэгсэн цагт эцэг эхчүүд нь өөрсдийн хүүхдүүдээ Кришнаг ухамсарлан хүмүүжүүлэх хариуцлага хүлээдэг.

ШҮЛЭГ 12

*е чайва саттвика бхава ражасас тамасаш ча е
матта евети тан виддхи на тв ахам тешу те майи*

е- бүгд, ча- болон, эва- гарцаагүй, саттвиках- цэвэр ариунд, бхавах- оршнолын төлөвүүд, ражасх- хүсэл тачаалын гунад, тамасх- харанхуй мунхгийн гунад, ча- мөн, е- бүгд, маттах- Надаар, эва- гарцаагүй, ити- энэ хэлбэр байдлаар, тан- тэднийг, виддхи- ойлгохыг оролд, на- үгүй, ту- гэвч, ахам- Би, тешу- тэдэнд, те- тэд, майи- Миний дотор.

Оршихуйн бүхий л түвшин- цэвэр ариуны ч бай, хүсэл тачаалын ч бай, эсвэл харанхуй мунхгийн ч бай ялгаагүй, Миний эрчмийн л нэг илрэл тодрол бөлгөө. Тодорхой утгаараа бол Би бүх зүйл, гэхдээ Би үл хамааралтай байдаг. Би материаллаг байгалийн гунуудын нөлөөлөл доор оршдоггүй, харин ч эсрэгээр, тэд Миний дотор оршиж байдаг.

ТАЙЛБАР: Ертөнц дэх бүхий л материаллаг үйл хөдлөлүүд нь материаллаг байгалийн гурван гунын нөлөөн доор явагдаж, үйлдэгдэж байдаг. Хэдийгээр материаллаг байгалийн эдгээр гунууд нь Бүхний Дээд Бурхан Кришнагаас гарал үүсэлтэй ч Тэрээр тэдгээрийн нөлөөнд үл ордог. Жишээлбэл, хэн нэгэн иргэн төрийн хуулиудын дагуу шийтгэгддэг байхад, хууль тогтоогч эзэн хаан нь эдгээр хуулиудад захирагддаггүй. Үүний нэгэн адил, материаллаг байгалийн цэвэр ариуны, хүсэл тачаалын болон харанхуй мунхгийн гунууд нь Бүхний Дээд Бурхан, Кришнагаас гаралтай боловч Бурхан Кришна энэхүү материаллаг байгальтай үл хавьтан шүргэнэ. Иймээс Тэр бол *ниргеуна*. Энэ үг нь эдгээр гурван гуна нь хэдийгээр Бурхан Кришнагаас гаралтай боловч Түүнд нөлөөлж огтхон ч чаддаггүй гэсэн утгыг агуулдаг. Энэ бол Бурханы Дээд Бодьгал, Бхагаваны онцгой шинж чанаруудын нэг болой.

ШҮЛЭГ 13

*трибхир гунамаяйр бхавайр эбхих сарвам идам жагат
мохитам набхижанати мам эбхьях парам авьяям*

трибхир- гурав, гунамаяйх- гунуудаас тогтон байгаа, бхавайх- оршнолын төлөвүүдээр, эбхих- энэ бүх, сарвам- нийт, идам- энэ, жагат- орчлон, мохитам- мэхлэгдсэн, на абхижанати- мэддэггүй, мам- Намайг, эбхьях- үүний тухай, парам- Бүхний Дээд, авьяям-цаглашгүй.

Гурван гунад (цэвэр ариун, хүсэл тачаал, харанхуй мунхгийн) хууртаж мэхлэгдсэн бүхий л ертөнц Намайг эдгээр гунуудын чанадад залардаг хийгээд цаглашгүй гэдгийг үл мэднэ.

ТАЙЛБАР: Бүхий л ертөнц материаллаг байгалийн гурван гунын нөлөөнд мансуурч байдаг. Эдгээр гунуудын нөлөөллөөр төөрлөдөг самуурсан хэн бүхэн материаллаг байгалийн чанадад Бүхний Дээд Бурхан, Кришна залран байдаг гэдгийг үл ойлгоно.

Материаллаг байгалийн нөлөөн доор орших амьд оршнол бүр нь окуны болоод биеийн хүчний тодорхой үйлүүд үйлдэхэд нийцэж зохицсон байх бие махбодийн ямар нэгэн хэлбэрийг авдаг. Материаллаг байгалийн гурван гунуудын үзүүлэх нөлөөллийн дагуу хүмүүс дөрвөн ангилалд хуваагддаг. Дан цэвэр ариуны гунад орших хүмүүсийг *брахмана*, цэвэр хүсэл тачаалын гунад орших хүмүүсийг *кшатрия* гэж нэрлэдэг. Харин хүсэл тачаалын болоод харанхуй мунхгийн гунуудын холимог нөлөөнд оршигчдыг *вайшья*, бүхэлдээ харанхуй мунхгийн гунад живэгсдийг *шудра* гэж нэрлэдэг. Эдгээр дөрвөн ангиллын хүмүүсийн доор адгуусан амьтад болоод тэдгээрийн амьдралаар амьдрах хүмүүс оршдог. Хүн энэхүү амьдралдаа *брахмана*, *кшатрия*, *вайшья* эсвэл өөр хэн нэгэн хэмээн нэрлэгдэж болох боловч аль нь ч байсан энэ нь түр зуурын бие махбодид хамаарагдах учир удаан үргэлжлэхгүй. Хэдийгээр амьдрал түр зуурын байдаг хийгээд дараагийн амьдралдаа хэн болохоо мэддэггүй ч хий хуурмагийн эрчмийн нөлөөн доор орсон бид өөрсдийгөө бие махбодийн үзэл бодлын үүднээс авч үзэн, улмаар бид америкчууд, энэтхэгчүүд, оросууд эсвэл *брахман*, хинду шашинтан, мусульман шашинтан гэх мэтээр бодож байдаг. Бид материаллаг байгалийн гунуудтай зууралдан орооцолдсоноор тэдгээрийн цаана байх Бурханы Дээд Бодьгалыг мартахад хүрдэг. Иймээс Бурхан Кришна, байгалийн гунуудын нөлөөлөлд автаж төөрөлдсөн хүмүүс материаллаг халхавчийн цаана Бурханы Дээд Бодьгал заларч байдаг гэдгийг ойлгодоггүй гэж айлдаж байна.

Амьд оршнолуудын янз бүрийн, тухайлбал хүн, сахиулсан тэнгэр, амьтан гэх мэтийн төрөл хэлбэрүүд байх бөгөөд тэд бүгдээрээ материаллаг байгалийн гунуудын нөлөөлөл, эрхшээлд орших ба бүгд л Бурханы трансценденталь Бодьгалыг мартсан байдаг. Хүсэл тачаалын болоод харанхуй мунхгийн гунад, тэр бүү хэл цэвэр ариуны гунад оршигчид ч Үнэмлэхүй Үнэний бодьгал бус Брахманы төлвийн тухай мэдлэгээс цааш гарч чаддаггүй. Бүхий л гоо сайхан, бүхий л баялаг, бүхий л мэдлэг, бүхий л хүч чадал, бүхий л алдар цуу болон бүхий л огоорлыг агуулан байх Бүхний Дээд Бурханы бодьгал төлвийн өмнө тэд бүгд төөрөлдөн самуурч будилцгаах болно. Цэвэр ариуны гунад байгаа хүн ч Бурхан Кришнаг ойлгож чаддаггүй юм бол хүсэл тачаалын болон харанхуй мунхагийн гунуудад оршигчдын хувьд ямар горьдлого найдвар байх билээ дээ? Кришнагийн ухамсар нь материаллаг байгалийн энэхүү гунуудад трансценденталь бөгөөд Кришнагийн ухамсарт бүрнээ автан байх хүн л ангижралын түвшинд үнэхээрийн хүрсэн байдаг.

ШҮЛЭГ 14

*дайви хй зша гуна-майи мама майа дуратьяя
мам эва е прападьянте маям этам таранти те*

дайви- трансценденталь, *хи*- тодорхой, *зша*- энэ, *гуна-майи*-материаллаг байгалийн гурван гунуудаас тогтсоноор, *мама*- Миний, *майа*- эрчим, *дуратьяя*- ялан дийлэхэд маш хүнд бэрх, *мам*- Надад, *эва*- гарцаагүй, *е*- тэд, *прападьянте*- өөрийгөө даатгах, *маям этам*- энэхүү хий хуурмаг эрчим, *таранти*- ялан дийлэх, *те*- тэд.

Материаллаг байгалийн гурван гунуудаас бүрдэх Миний энэхүү бурханлаг эрчим нь гэтлэн туулахад маш хэцүү. Гэхдээ Надад өөрийгөө бүрэн даатгагч хэн бүхэн түүний нөлөөллөөс хялбархан гарч чадна.

ТАЙЛБАР: Бурханы Дээд Бодьгал нь тоо томшгүй олон янзын эрчмүүдийг агуулж байдаг бөгөөд тэд бүгдээрээ бурханы шинжтэй. Амьд оршнолууд нь Түүний эрчмийн нэг хэсэг мөн учраас тэднийг мөн бурханлаг гэж нэрлэж болох боловч материаллаг эрчимтэй шүргэлцсэнээс болж тэдний анхдагч, жинхэнэ илүү дээд хүч чадал нь бүрхэгдэн суларсан байдаг. Материаллаг эрчмийн бүрхүүл доор ийнхүү орсон хэн бүхэн түүний нөлөөллөөс зайлан гарах боломжгүй болдог. Урьд өмнө тайлбарлаж байсанчлан, материаллаг болон бурханлаг мөн чанарууд нь Бурханы Дээд Бодьгалын цацраг байдлаар мөнхөд байдаг билээ. Амьд оршнол нь Бурханы мөнхийн, дээд мөн чанарт харьяалагддаг ч доод мөн чанар болох материд бузарлагдсан байдаг учраас тэдний хий хуурмаг байдал мөнхийн байдаг. Болзолт сүнсүүдийг иймээс *нитья-баддха* буюу буюу мөнхийн болзолт гэж нэрлэдэг. Материаллаг түүхийн чухам аль цаг үед тэд энэхүү болзолт байдалд унан орсоньг хэн ч мөшгөн тодорхойлж чадахгүй. Иймээс, материаллаг байгаль нь хэдийгээр доод эрчим мөн ч тэдний хувьд материаллаг байгалиас салан ангижрах нь маш хүнд бэрх. Учир нь материаллаг эрчмийг амьд оршнолын хувьд ялан дийлэхийн аргагүй дээдийн дээд Таалал захиран залж байдаг билээ. Доод, материаллаг байгаль нь Бурхантай холбогдсон байдаг ба Түүний тааллаар үйл хөдлөлөө хийж байдаг учир энд түүнийг бурханы шинжтэй мөн чанар гэж нэрлэж байна. Материаллаг байгаль нь доод ангилалд хамаарагддаг хэдий ч Бурханы тааллаар чиглүүлэгдэн байгаа тэрээр материаллаг сансар огторгуйг бүтээж бий болгон мөн устган үгүй болгонгоо жинхэнэ гайхамшгийг үйлдэн байдаг. Энэ талаар Ведэд дараах байдлаар батлан өгүүлсэн байдаг: *маям ту пракритим видьян майинам ту махешварам*- “*Майа* бол хий хуурмаг, өөрөөр хэлбэл түр зуурын байдаг, гэсэн ч түүний цаад ард талд нь дээдийн дээд илбэчин, дээдийн дээд Эзэн Захирагч, Махешвара болох Бурханы Бодьгал залран байдаг (Шветашватара-упанишад, 4.10).

Гуна гэдэг үг нь уяа, хүлээс гэсэн өөр нэгэн утгыг илэрхийлдэг бөгөөд болзолт сүнс нь байнгад хий хуурмагийн уяанд бат бэхээр хүлэгдсэн байдгийг заадаг. Гар, хөл нь хүлээтэй байгаа хүн өөрийгөө суллаж чадахгүй. Түүнд бусдын дэмжлэг тусалцаа хэрэгтэй. Гэхдээ өөрөө мөн адил хүлээтэй байх хүн түүнд тусалж чадахгүй. Иймээс аврагч нь уягдаж хүлэгдсэн байдлаас ангид байх ёстой. Үүнтэй нэгэн адил, гагцхүү Шри Кришна эсвэл Түүний жинхэнэ элч төлөөлөгч, номын багш л болзолт сүнснийг чөлөөлж чадна. Ийм эрхэм дээд тусламжгүйгээр хэн ч материаллаг байгалийн олзлогдлоос суллагдан ангижирч чадахгүй. Чин бишрэлийн алба, Кришнагийн ухамсар л хүнийг ийн ангижрахад туслана. Кришна хий хуурмагийн эрчмийн эзэн захирагч мөн учир Тэр л энэхүү гэтлэн давшгүй эрчимд болзолт сүнснийг суллах зарлигийг буулгаж чадна. Бурхан, Түүнд өөрийгөө

даатган байх сүнсэнд учир шалтгаангүй өршөөнгүй хандсанаас хийгээд амьд оршнол нь уг гарал, үүслийн хувьд Түүний хайртай хүү нь мөн болох тул Өөрийн эцэг ёсны хайраасаа үүдэн түүнийг ийнхүү чөлөөлөхийг зарлиг болгодог. Иймээс Бурханы бадамлянхуа өлмийд өөрийгөө даатгах нь хүчирхэг материаллаг мөн чанарын гинж тушаанаас ангижрах цорын ганц арга зам юм.

Мөн *мам эва* гэдэг үг нь чухал ач холбогдолтой. *Мам* гэдэг нь “гагцхүү зөвхөн Кришнад (Вишну)”, харин Брахма болон Шивад биш гэсэн утгатай. Хэдийгээр Брахма болон Шива нь маш өндөр дээд, Вишнутаг барга адил түвшний байр суурийг эзэлцгээх боловч *ража-гуна* (хүсэл тачаал) –ыг болон *тамо-гуна* (харанхуй мунхаг)-ийг залан захирагчид болох тэдний хувьд болзолт сүнсийг *майа-гийн* хүчирхийллээс чөлөөлөх боломжгүй байдаг. Өөрөөр хэлбэл, Брахма, Шива хоёр нь мөн л *майа-гийн* нөлөөн дор байдаг. Гагцхүү Вишну л *майаг* захирч байдаг. Иймээс зөвхөн Тэр л болзолт сүнсийг чөлөөлж чадна. Энэ тухай Ведэд (Шветашватара-упанишад, 3.8)-д: *там эва видитва*- буюу зөвхөн Кришнаг ойлгож ухаарсанаар л ангижралд хүрнэ хэмээн батлан өгүүлсэн байдаг. Зөвхөн Вишнугийн өршөөл нигүүлслээр л ангижралыг олдог гэдгийг Шива хүртэл батлан: *мукти-прадата сарвешам вишнур эва на самшаях* “Вишну бүхэнд ангижралыг хайрлан хүртээдэг нь ямар ч эргэлзээгүй юм.” гэж хэлсэн байдаг.

ШҮЛЭГ 15

на мам душкритино мудхах прападьянте нарадхамах майаяпахрита-гьяна асурам бхавам ашритах

на- үгүй, *мам*- Надад, *душкритинах*- бурхангүй хүмүүс, *мудхах*-тэнэг мангуу, *прападьянте*- өөрийгөө даатгах, *нарадхамах*- хүн төрөлхтний адаг шаар, *майая*- хий хуурмагийн эрчмээр, *апахрита*- хулгайд алдсан, *гьянах*- тэдний мэдлэг *асурам*- демонлог, *бхавам*- мөн чанар, *ашритах*- авснаар.

Мэдлэгээ хий хуурмагийн хулгайд алдсан, демонуудын бурхангүй үзэл бүхий мөн чанартай, хүмүүсийн адаг шаар болсон мангуу тэнэгүүд л Надад өөрсдийгөө үл даатгадаг.

ТАЙЛБАР: Бхагавад Гитад, Бурханы Дээд Бодьгал Кришнагийн бадамлянхуа өлмийд өөрийгөө даатгаснаар л материаллаг байгалийн хахир хатуу чанга хуулиудыг гэтлэн туулж чадна гэж өгүүлдэг. Тэгвэл яагаад энэ бүх, гүн гүнзгий мэдлэгтэй философичид, эрдэмтэд, бизнес эрхлэгчид, улс төрчид болон хүн төрөлхтөний удирдагчид нь бүхнээс хүчирхэг Бурханы Бодьгал Шри Кришнагийн бадам лянхуа өлмийд өөрсдийгөө даатгахгүй байгаа юм бэ? гэсэн асуулт зүй ёсоор гарч ирнэ. Хүн төрөлхтөний удирдагчид нь материаллаг байгалийн хуулиудаас ангижрахын (*мукти*) тулд олон олон жилийн өмнөөс, олон үеийн туршид төрөл бүрийн төлөвлөгөөнүүдийг цөхрөлтгүйгээр зохион, янз бүрийн арга замуудыг хайн эрэлхийлж байгаа билээ. Хэрвээ Бурханы Дээд Бодьгалын бадамлянхуа өлмийд зүгээр л өөрийгөө даатгаснаар энэхүү ангижралд хүрч болох юм бол оюунлаг бөгөөд цөхрөлтгүй шаргуу ажиллах эдгээр удирдагчид энэхүү амар хялбар арга замаар яагаад замнахгүй байгаа юм бэ?

Гита энэ асуултанд маш нээлттэй хариулж байна. Нийгмийн жинхэнэ оюунлаг удирдагчид болох Брахма, Шива, Капила, Кумарууд, Ману, Вьяса, Девала, Асита, Жанака, Прахлада, Бали болон мөн хожмын үеийн Мадхвачарья, Рамануджачарья, Шри Чайтанья болон жинхэнэ философичид, улс төрчид, соён гэгээрүүлэгчид, эрдэмтэн мэргэд, болон өөр бусад нь бүхнээс хүчирхэг жинхэнэ эх сурвалж Дээдийн Дээд Бодьгалд өөрсдийгөө даатган Түүний бадамлянхуа өлмийд өмөг түшиг, аврал ивээл эрдэг билээ. Харин философич, эрдэмтэн мэргэд, соён гэгээрүүлэгч, улс төрчид зэрэг нэр алдрыг жинхэнэ ёсоор нь хүртэх эрх, гавьяагүй, зөвхөн материаллаг ашиг хонжоо олохын тулд ийм дүр эсгэх хүмүүс Бүхний Дээд Бурханы зам мөр буюу төлөвлөгөөг хүлээн зөвшөөрдөггүй. Бурханы тухай юу ч үл мэдэх тэд зөвхөн материаллаг төлөвлөгөөнүүдээ боловсруулан байх бөгөөд материаллаг оршихуйн асуудлуудыг шийдэх гэсэн тэдний эдгээр бүтэцгүй оролдлогууд нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж хурцатгадаг. Материаллаг эрчим (байгаль)-ийн аугаа их хүчийг бурхангүй үзэлтнүүдийн (атеистуудын) хувийн хүсэл сонирхлыг агуулах төлөвлөгөөнүүд сөрөн зогсож чадахгүй учраас тэдний “төлөвлөлтийн” гэж нэрлэгдэх байгууллагын сэдэл санаархал нь ямар ч үр дүнгүй болдог.

Энэхүү атейст төлөвлөгөө боловсруулагчдыг энд *душкритинах* буюу “бурхангүй хүмүүс” гэж нэрлэж байна. *Крити* гэдэг үг нь “урамшуулбал зохих ажил гүйцэтгэгч эсвэл гавьяат үйлстэн” гэсэн утгатай. Сайн, муу аль нь ч бай ямар нэгэн үлэмж том төлөвлөгөө, санаа сэдлийг хэрэгжүүлэхэд ихээхэн оюун ухаан зарах шаардлагатай нь мэдээж хэрэг тул атейст төлөвлөгөө боловсруулагчид нь заримдаа маш оюунлаг байдаг учир тэд мөн магтаал сайшаал хүрэх гавъяатай. Гэхдээ эдгээр атейст төлөвлөгөө боловсруулагчид нь оюун ухаанаа буруугаар буюу Бүхний Дээд Бурханы тааллын эсрэгээр ашиглаж байгаа учраас тэднийг *душкрити* гэж нэрлэж байгаа нь тэдний оюун ухаан болоод хүчин чармайлт нь буруу зүгт чиглэгджээ гэдгийг зааж байна.

Материаллаг эрчим нь бүхэлдээ Бүхний Дээд Бурханы соёрхол, тааллын дагуу үйл хөдлөлөө хийж байдаг гэдгийг Гитад тодорхой өгүүлдэг. Энэ нь тэр үл хамаарах байдалтай биш гэсэн үг юм. Түүний үйл ажиллагаа, ямар нэгэн зүйлийн сүүдэр нь зөвхөн түүнээс хамааран түүний хөдөлгөөний дагуу л хөдөлж байдагтай адил явагддаг. Гэсэн хэдий ч материаллаг байгаль нь маш хүчирхэг бөгөөд атейст нь өөрийн бурхангүй мөн чанараасаа болж Бүхний Дээд Бурханы төлөвлөгөөг мэдэх боломжгүй байдаг шигээ түүнийг үйлчлэлээ хэрхэн үзүүлж байдгийг үл мэднэ. Тэрээр хий хуурмагийн болоод хүсэл тачаал, харанхуй мунхгийн гунуудын нөлөөнд автан байх учраас Хираньякашипу болон Равана хоёрын (хэдийгээр тэр хоёр материаллаг үүднээс үзэхэд хоёул эрдэмтэн мэргэд, философичид, улс төрчид, гэгээрүүлэгчид байсан ч) төлөвлөгөө, санаа сэдлүүд нь хумхийн тоос болтлоо сүүрдгийн адилаар түүний бүх төлөвлөгөө нь нуран унана. *Душкрити* буюу Бурханд үл итгэгч иймэрхүү хүмүүсийн дөрвөн хэлбэр байдаг ба энэ талаар доор өгүүлнэ.

(1) *Мудха* нь хүнд хүчир ажилд хамаг тэнхээгээрээ зүтгэх ажлын мал мэт онцгой тэнэг мунхаг хүмүүс юм. Ийм хүмүүс нь ажил хөдөлмөрийнхөө үр шимийг Бүхний Дээдтэй хуваалцахын оронд зөвхөн өөрсдийн хувийн таашаал

ханамжинд л зориулахыг хүсдэг. Илжиг бол ачаа зөөгч амьтдын нийтлэг хэв шинжийг агуулсан амьтан юм. Эзэн нь энэхүү дуулгавартай амьтныг хүнд ажилд зүтгүүлж байдаг. Хэний төлөө ингэж өдөр шөнөгүй хүнд ажилд нухлагдан зүтгэж байгаагаа чухамдаа илжиг өөрөө ч үл мэднэ. Атга чимх өвс ходоодондоо хийн, эзэндээ цохиулж жанчуулахаас эмээн байж хэсэгхэн зуур унтаж амрах болон эсрэг хүйстэндээ цөөнгүй удаа өшиглүүлэн байж өөрийн бэлгийн дур хүслээ хангаж чадсанаар л энэ амьтан ханамж таашаал эдэлж байдаг. Илжиг заримдаа утга уянгын болоод гүн ухааны агуулгатай дуу дуулахыг оролдох боловч түүний энэхүү орилоон хашгираан нь орчин тойрны амар амгалан байдлыг алдагдуулах л үйл болж байдаг. Хэний төлөө ажиллах ёстойгоо үл мэдэх, үр дагавар дагуулах ажил хөдөлмөртэй зууралдах тэнэг мулгуу хүний байр байдал ийм л байдаг. Тэр карма буюу үйл нь ягъя буюу өргөл тахилгад зориулагдсан байдаг гэдгийг мэддэггүй.

Өөрөө өөртөө оногдуулан бий болгосон үүргийн хүнд ачаанаасаа салахын тулд өдөр шөнөгүй хүчир ажилд зүтгэж байгаа тэд, амьд оршнолын үхэшгүй мөнхийн талаар сонсох цагаар хомс, завгүй байна хэмээн олонтоо ярьж байдаг. Мудхачууд хэдийгээр өөрсдийн хөдөлмөрийн үр шимийн зөвхөн маш өчүүхэн бага хэсгээр л таашаал ханамж эдэлж байдаг ч тэдний хувьд материаллаг цаг зуурын ашиг хонжоо нь амьдралын нь учир утга, дээдийн дээд зорилго болж байдаг. Заримдаа тэд материаллаг ашиг хонжоо олохын тулд өдөр шөнөгүй нойргүй зүтгэхийн зэрэгцээ хоол боловсруулах эрхтний өвчлөл болон хоолны шингэлт нь муудсанаас болж зовж шаналж байсан ч бараг юм идэхгүй. Хуурмаг эзний ашиг тусын тулд өдөр шөнөгүй хүнд хүчир ажилд нухлагдан зүтгэж байгаадаа тэд хэт автчихсан байдаг. Өөрсдийн жинхэнэ Эзэнийг таньж мэддэггүй эдгээр мунхаг хүмүүс эд баялгийг шүтэн түүний муу нөлөөнд автан, зөвхөн түүний төлөө зүтгэсээр үнэт цагаа хий дэмий алдаж үрэгдүүлж байдаг. Харамсалтай нь тэд бүх эздийн Эзэн болсон Бүхний Дээд Эзэнд өөрсдийгөө хэзээ ч даатгадаггүйн зэрэгцээ Түүний талаар жинхэнэ эх булгуудаас сонсохын тулд цаг зав ч гаргадаггүй. Ялгадас идэх гахай нь чихэрлэг, тослог зүйлээр хийсэн амттаны төлөө санаа үл тавьдагтай адил хүнд ажилд нухлагдан зүтгэх эдгээр мунхаг хүмүүс нь материаллаг ертөнцийг хөдөлгөн байх мөнхийн амьдралын хүчний тухай сонсох цаг зав гаргахгүй мөртөө мэдрэхүйн таашаал ханамж өгөгч энэ гял цал материаллаг ертөнцийн тухай өгүүлэхийг эцэж цуцалтгүйгээр чих тавин чагнацгаана.

(2) *Душкритинууд* буюу бурхангүй үзэлт хүмүүсийн хоёр дугаар бүлгийг *нарадхама* буюу хүмүүсийн адаг шаар бологсод гэж нэрлэдэг. *Нара*- хүн, *адхама* нь “хамгийн доод, адаг шаар” гэсэн утгатай. 8 сая 400 мянган амьдралын хэлбэрүүдээс 400 мянга нь хүний амьдралын хэлбэр байдаг бөгөөд үүний дотор олон тооны, ихэнх нь соёл иргэншилгүй доод хэлбэрүүд байдаг. Нийгмийн, улс төрийн болоод шашин номын амьдралдаа зохицуулах зарчмуудыг дагаж баримталдаг хүмүүс нь соёл иргэншил бүхий хүмүүст тооцогддог. Нийгмийн болоод улс төрийн хувьд хөгжсөн боловч шашин номын зарчмуудыг үл даган баримтлах хүмүүс нь мөн *нарадхамачуудад* хамаарагддаг. Шашин номын зарчмуудын утга учир, зориулалт нь Бүхний Дээд Үнэн хийгээд Түүнтэй холбогдох хүний харьцааг таньж мэдэхэд чиглэгдсэн байдаг учраас Бурхангүй шашин нь жинхэнэ шашин биш юм. Бүхний Дээд Бурхан Бхагавад Гитад, Түүнээс дээш орших жинхэнэ эх сурвалж гэж байдаггүй, Тэр л Дээдийн Дээд Үнэн гэж тов тодорхой айлдсан билээ. Хүмүүний амьдралын соёл иргэншил бүхий хэлбэр нь Дээдийн Дээд Үнэн, хамгаас хүчирхэг Бурханы Бодьгал Шри Кришнатай холбогдсон мөнхийн холбоо, харьцаагаа умартаж мартсан хүний ухамсарыг сэргээхэд зориулагдсан байдаг. Гэвч энэхүү боломжийг алдах хэн бүхэн *нарадхамачуудад* хамаарагдана. Бид бүхэн ариун гэгээн судруудаас мэдэхчлэн, эхийн хэвлийд онцгой хүнд хэцүү, таатай бус нөхцөл байдалд байгаа хүүхэд чөлөөлж ангируулж өгөхийг Бурханаас гуйн, төрж мэндлэнгүүтээ л зөвхөн Түүнийг бишрэн шүтэж байхаа амлаж байдаг. Хүнд хэцүү нөхцөл байдалд орсон аливаа амьд оршнолын Бурханд залбирч мөргөх нь Бурхантай холбогдсон түүний мөнхийн харьцаанаас үүдэн гарах жам ёсны зөн совин, үйл юм. Гэвч, хүүхэд хий хуурмагийн нөлөөлөлд ордог учир чөлөөлөгдмөгц төрөлтийн үеийн хүнд хэцүү байдлыг ч, мөн өөрийг нь Чөлөөлөгчийг ч мартдаг.

Хүүхдийн төлөө хариуцлага хүлээгчдийн үүрэг нь хүүхдийн дотоодод үүрэглэн, нойрмоглож байгаа бурханлаг ухамсарыг сэргээх явдал байдаг. Шашин номын зарчмуудын заавар болох Ману-смитид *варнашрама* системийн хүрээнд бурханлаг ухамсарыг сэргээхэд зориулагдсан ариусгах арван зан үйлийг заасан байдаг. Гэвч өнөөгийн цаг үед энэ дэлхийн хаана ч эдгээр зан үйлүүдийг зохих ёс журам, дүрмийн дагуу нарийн чанд биелүүлдэггүй учир хүн амын 99.9 хувь нь *нарадхама* юм.

Бүх хүн ам нь нийтдээ *нарадхама* болсон цагт тэдний хөгжил дэвшил гэж нэрлэх зүйл нь материаллаг мөн чанарын аугаа хүчирхэг эрчмээр юунд ч хэрэгцээгүй, чухал биш зүйл болон алдагддаг. Гитад заасны дагуу эрдэм мэдлэгтэй хүн гэж гүн гүнзгий мэдлэг бүхий *брахмана*, нохой, үнээ, заан болон нохойгоор хооллогч энэ бүгдийг нэг ижил нүдээр хардаг хүнийг хэлдэг. Энэ бол жинхэнэ чин бишрэлтэнгийн хараа билээ. Бурханлаг номын багшийн дүрээр заларсан Бурханы хувилгаан Шри Нитьянанда Прабху нь жинхэнэ *нарадхамачуудын* нийтлэг хэв шинжит дүр болох Жагай, Мадхай хоёрыг ангижралд хүргэснээр жинхэнэ чин бишрэлтэн нь өөрийн өршөөл нигүүлслээ хүний адаг шаар бологчдод хэрхэн хайрлан хүртээдгийг харуулсан билээ. Иймд, Бурханы Бодьгалын тааллаар шийтгэгдсэн байсан ч *нарадхама* нь өөрийн бурханлаг ухамсараа зөвхөн чин бишрэлтэнгийн өршөөл нигүүлслээр л дахин сэргээж болдог.

Чин бишрэлтэнгүүдийн зам мөр болох *бхагавад-дхармаг* номлоос Шри Чайтанья Махапрабху нь Бурханы Бодьгалын илгээлтийг хүлцэнгүй, бишрэлтэйгээр сонсохыг хүмүүст зөвлөсөн. Энэ илгээлтийн охь, дээж нь Бхагавад Гита юм. Хамгийн адгийн хүмүүс ч хүлцэнгүй, бишрэлтэйгээр сонссоноор л аврагдан, ангижралд хүрч болох байтал харамсалтай нь тэд Бүхний Дээд Бурханы таалалд нийцүүлэн өөрсдийгөө даатгахыг ярих нь бүү хэл энэхүү илгээлтийг ч зөвхөн зүгээр сонсохоос ч татгалзан нүүр буруулж байдаг. *Нарадхама* буюу хүмүүсийн адаг нь хүний хамгийн эхний үүргийг биелүүлэхээс ч ийнхүү бүрмөсөн татгалздаг байна.

(3) *Душкритиудын* дараагийн бүлгийг *маяпахрита-гьянах* буюу хий хуурмагийн материаллаг эрчмийн нөлөөлөл, үйлчлэлээр гүн их мэдлэг боловсролын нь үнэ цэнэ нь алдагдан үгүй болсон хүмүүс гэж нэрлэдэг. Тэд ихэнхидээ, нэртэй философичид, яруу найрагчид, уран зохиолчид, эрдэмтэд гэх зэргээр өндөр боловсролтой хүмүүс байдагч хий хуурмагийн эрчим тэднийг буруу тийш нь төөрөлдүүлэх учир тэд Бүхний Дээд Бурханы тааллын эсрэг байдаг.

Одоогийн энэ цаг үед маш олон, тэр бүү хэл Бхагавад Гитаг судлагчдын дунд ч *маяпахрита-гьяначууд* байдаг. Гитад маш энгийн болоод ойлгомжтой үгүүдээр, Шри Кришна бол Бурханы Дээд Бодьгал гэдгийг тайлбарласан байдаг. Түүнтэй эн зэрэгцэх болоод Түүнийг даван гарах хэн ч байдаггүй. Түүнийг бүх хүмүүсийн

анхдагч эцэг-Брахмын эцэг гэдэг. Тийм ээ, Кришнаг зөвхөн Брахмын эцэг төдийгүй мөн амьдралын бүхий л хэлбэрүүдийн анхдагч эцэг гэж нэрлэдэг. Тэр бол бодьгал бус Брахманы болоод бүхий л амьд оршнол бүрт залрах Параматма буюу Өөрийн хэсэгчилсэн бүрэн хувилгаан дүр болох Дээд Сүнсний эх булаг билээ. Тэр бол бүх зүйлийн анхдагч эх булаг бөгөөд Түүний бадамлянхуа өлмийд өөрийгөө даатгах нь хүн бүхэнд хамгийн эрхэм гэж зөвлөдөг. Энэ бүх тодорхой баталгаа нотолгоо байсаар байгал *маяпахрита-гьяначууд* нь Бүхний Дээд Бурханы Бодьгалыг басамжлан, Түүнийг зүгээр л нэг эгэл жирийн хүн мэтээр үздэг. Хүний амьдралын адислагдсан хэлбэр дүр нь Бүхний Дээдийн мөнхийн трансценденталь дүртэй төстэй хэлбэрээр бүтээгдсэн гэдгийг тэд мэддэггүй.

Парампарын системд огтын хамааралгүй байдаг *маяпахрита-гьяначуудын* Бхагавад Гитад өгсөн бүхий л тайлбарууд нь бурханлаг танин мэдэхүйн зам мөрт зөвхөн саад тотгор л болно. Эдгээр самуурч төөрөлдсөн тайлбарлагчид нь Шри Кришнагийн бадамлянхуа өлмийд өөрсдийгөө даатгадаггүйн зэрэгцээ бусдыг ч энэ зарчмыг даган мөрдөхөд сургадаггүй.

(4) *Душкритичуудын* сүүлчийн, үлдсэн хэсгийг *асурам бхавам ашритах* буюу демоны зарчмуудыг даган баримтлагчид гэж нэрлэдэг. Эдгээр хүмүүс нь илт атейстууд юм. Тэдний зарим нь Бүхний Дээд Бурхан хэзээ ч энэхүү материаллаг ертөнцөд морилон бууж ирж чадахгүй хэмээн батлахыг оролдох боловч энэ нь яагаад боломжгүй байдаг талаар ямар нэгэн үндэслэлтэй шалтгаан хэлэх чадваргүй байдаг. Мөн нөгөө нэг хэсэг нь Гитад тайлбарласны эсрэгээр буюу Тэрээр бодьгал бус төлөвт захирагдан түүний мэдэлд байдаг гэцгээнэ. Атейстууд нь Бурханы Дээд Бодьгалд атаархаж, жөтөөрхөж байдаг учраас өөрсдийн ухаандаа дүрслэн бодож зохиосон олон хуурамч хувилгаадыг өргөмжлөн зарлаж байдаг. Бурханы Бодьгалыг гутаан доромжлохыг амьдралынхаа үндсэн зарчим болгосон иймэрхүү хүмүүст Шри Кришнагийн бадамлянхуа өлмийд өөрсдийгөө даатгах хувь тавилан заяахгүй

Өмнөд Энэтхэгийн Шри Ямуначарья Албандару: “Ай Бурхан минь ээ, Та Өөрийн жирийн бус шинж чанарууд болон гайхамшигт үйлүүдээрээ цуутай байдаг ч атейст зарчмуудыг даган мөрдөгч хүмүүс Таныг таньж мэдэж чаддаггүй билээ. Цэвэр ариуны гуна дахь бүхий л ариун гэгээн судруудад Таны Бодьгалыг тодорхойлон өгүүлсэн байдаг болон бурханлаг эрдэм ухааны гүн гүнзгий мэдлэгтэй хийгээд бурханлаг шинжийг агуулсан бүхий л аугаа мэргэд Таныг алдаршуулан магтдаг. Харин тэгэхэд бурхангүй үзэлтэнгүүдийн хувьд бол Та таньж мэдэхийн аргагүй байдаг билээ.” гэж хэлсэн байдаг.

Ийнхүү, энэ шүлэгт өгүүлэн байх онцгой тэнэг мунхгууд, хүмүүсийн адаг шаар бологсод, Бурханы хуурмаг эрчимд төөрөлдөн буруу замаар орсон цэцэрхэгчид болон илт атейстууд нь бүхий л ариун гэгээн судрууд хийгээд жинхэнэ эх сурвалжууд зөвлөн байдаг ч, дээр өгүүлсэнчлэн, Бурханы Бодьгалын бадамлянхуа өлмийд өөрсдийгөө хэзээ ч үл даатгадаг.

ШҮЛЭГ 16

*чатур-видха бхажанте мам жанах сукритино`ржуна
арто жигьясур артхартхи гьяни ча бхаратаршабха*

чатур-видхах- дөрвөн төрөл, *бхажанте-* алба барьдаг, *мам-* Надад, *жанах-* хүмүүс, *сукритинах-* зөв шудрага байх тэд, *аржуна-* Аржуна минь, *артах-* зовж шаналагч, *жигьясух-* мэдлэгт шунагч, *артха-артхи-* материаллаг ашиг хонжоо хүсэж шунагч, *гьяни-* юмсыг байгаа байдлаар нь таньж мэдэгч, *ча-* мөн, *бхарата-ршабха-* Бхаратын удмынхны шилдэг минь.

Ай Бхаратынхны шилдэг нь минь ээ (Аржуна), зовлон гамшигт нэрвэгдэгсэд, эд баялгийн хойноос хөөцөлдөгсөд, сониуч зантангууд болон Үнэмлэхүйн тухай мэдлэгийн хойноос эрэл хайгуул хийгсэд гэсэн дөрвөн төрлийн зөв шудрага хүмүүс Надад чин бишрэлээр зүтгэж эхэлдэг.

ТАЙЛБАР: Энэ шүлэгт дурьдагдаж буй хүмүүс нь бурхангүй үзэлт хүмүүсийг бодвол тэс өөр буюу сударт заасан зохицуулах зарчмуудыг дагаж мөрдөж байдаг. Ийм хүмүүс судруудад заасан байдаг зөвшөөрсөн болон хориглож цээрлэсэн дүрэм журмууд, мөн ёс суртахууны болоод нийгмийн хуулиудыг дагаж мөрддөг ба их бага ямар нэгэн хэмжээгээр Бүхний Дээд Бурханд өөрсдийгөө даатгаж байдаг учраас тэднийг *сукритинах* гэж нэрлэдэг. Тэднийг дотор нь, зарим үед зовлон бэрхшээлтэй тулгарагсад, мөнгө хөрөнгө хэрэгтэй хүмүүс, зарим үед асуулт тавин сониурхагчид болон мөн зарим үед Үнэмлэхүй Үнэний талаар эрэл хайгуул хийгсэд гэсэн дөрвөн хэсэгт хуваадаг. Эдгээр хүмүүс нь Бүхний Дээд Бурханд янз бүрийн нөхцөл байдлын доор бишрэн зүтгэхээр Түүнд ханддаг. Тэд өөрсдийн чин бишрэлийн зүтгэлийн хариуд тодорхой нэгэн хүсэлтээ гүйцэлдүүлэхийг хүсэж байдаг тул цэвэр чин бишрэлтэнгүүд биш юм. Цэвэр чин бишрэл дүүрэн бялхах алба нь хувийн сонирхол эрмэлзэл болон материаллаг ашиг хонжооны хүслээс ангид байдаг. Бхакти-расамрита-синдхугийн (1.1.11)-д цэвэр чин бишрэл дүүрэн бялхах албыг дараахь байдлаар тодорхойлсон байдаг:

*аньябхилашита-шуньям жнана-кармади-анаэритам
анукульена кришнану- шиланам бхактир уттама*

“Үр дагавар дагуулах үйл хийгээд философийн цэцэрхийллээр материаллаг ашиг хонжоо олох хүсэл эрмэлзлээс ангид байж, Бүхний Дээд Бурхан Шри Кришнагийн трансценденталь хайраар бялхан байх албанд эерэг, чин бишрэл дүүрэн хандлагатайгаар зүтгэх хэрэгтэй. Үүнийг л цэвэр чин бишрэлийн алба зүтгэл гэж нэрлэдэг.”

Эдгээр дөрвөн төрлийн хүмүүс нь чин бишрэлийн албанд зүтгэхээр Бүхний Дээд Бурханд хандсанаар болон цэвэр чин бишрэлтэнтэй харилцах бүрэн ариуссанаар л цэвэр чин бишрэлтэн болно. Бурхангүй үзэлт хүмүүсийн хувьд, тэд нар амиа бодсон эмх замбараагүй хийгээд бурханлаг зорилгогүйгээр амьдарч байдаг учраас чин бишрэлийн алба зүтгэлд хандах нь маш хэцүү хүнд байдаг. Хэдийгээр тийм боловч, тэдний зарим нь цэвэр чин бишрэлтэнтэй тохиолдлоор учирсанаар мөн цэвэр чин бишрэлтэн болж болдог.

Ашиг хонжоо олохын тулд үр дагавар дагуулах үйлэнд автан байх хүн материаллаг зовлон бэрхшээлтэй тулгарсан үедээ Бурханд хандахдаа цэвэр чин бишрэлтэнтэй учирч, харьцах боломжийг олдог бөгөөд улмаар өөрөө чин бишрэлтэн болдог. Ямар нэгэн учир шалтгааны улмаас ханамжтай бус байгаа хүн заримдаа мөн цэвэр чин бишрэлтэнд хандан Бурханы тухай асууж лавлаж эхэлдэг. Мөн түүний нэгэн адил зарим үед, хуурай философичид нь өөрсдийн нь цэцэрхийлэл мухардалд орон, цөхрөл гайхашралаа бармагц Бурханы тухай мэдэх хүсэл төрдөг бөгөөд улмаар Бурханд чин бишрэлээр зүтгэхээр Түүнд хандсанаар бодьгал бус Брахманы болоод бүхэнд нэвчих Параматмын тухай мэдлэгээс дээш халин гарч Бүхний Дээд Бурханы эсвэл Түүний цэвэр чин бишрэлтэнгийн өршөөл нигүүлслээр Бурханы Бодьгалын үзэл бодол, ойлгоцод хүрдэг. Дүгнэж хэлэхэд, зовж зүдрэгсэд, сониуч зан гаргагсад, танин мэдэхүйн хойноос эрэл хайгуул хийгсэд болон мөнгө хөрөнгө хэрэгтэй байгаа хүмүүс нь материаллаг баялаг нь бурханлаг хөгжил дэвшилтэй ямар ч холбоо, хамааралгүй гэдгийг бүрэн ойлгож мэдэн бүхий л материаллаг хүслээсээ ангижирсан цагт л цэвэр чин бишрэлтэн болдог. Бурханы трансценденталь албанд зүтгэн байгаа чин бишрэлтэн нь цэвэр ариуны энэхүү түвшинд хүрээгүй цагт үр дагавар дагуулах үйл, материаллаг мэдлэгийн хойноос тэмүүлэх болон бусад зүйлд татагдсан хэвээр байдаг. Ийм учраас цэвэр чин бишрэлийн алба зүтгэлийн түвшинд хүрэхийн өмнө хүн энэхүү материаллаг учир шалтгаануудыг ардаа орхин тэдгээрээс салсан байх ёстой.

ШҮЛЭГ 17

*тешам гьяни нитья-юкта эка-бхактир вишишьяте
прийо хи гьянино тьяртхам ахам са ча мама приях*

тешам- тэднээс, *гьяни*- бүрэн төгс мэдлэгтэй тэр, *нитья-юкта*- үргэлж зүтгэдэг, *эка*- гойд, *бхакти*- чин бишрэлийн албанд, *вишишьяте*- бол онцгой, *приях*- маш эрхэм, *хи*- тодорхой, *гьянина*- мэдлэгт тулгуурласан түүнд, *атьартхам*- маш, *ахам*- Би бол, *сах*- тэр, *ча*- мөн, *мама*- Надад, *приях*- эрхэм.

Тэднээс, бүрэн төгс мэдлэгт тулгуурласан хийгээд Надад цэвэр чин бишрэлээр байнгад зүтгэж байгаа нь л хамгийн шилдэг сайн нь. Учир нь Би түүнд маш эрхэм, мөн тэр Надад эрхэм байдаг бөлгөө.

ТАЙЛБАР: Зовж зүдрэгчид, сониуч зан гаргагчид, хөрөнгө чинээ муутайчууд болон дээдийн дээд мэдлэгийн хойноос эрэл хайгуул хийгчид нь материаллаг хүслээр бузардах явдлаас бүрэн ангижран салсан цагт бүгд цэвэр чин бишрэлтэн болж чадна. Тэдний дундаас, Үнэмлэхүй Үнэний тухай мэдлэгийг эзэмшиж хүртсэн хийгээд бүхий л материаллаг хүслээс ангид байх хүн л жинхэнэ цэвэр чин бишрэлтэн болдог. Эдгээр дөрвөн янзын хүмүүсээс, Бурханы айлдсанчлан, төгс төгөлдөр мэдлэгийг агуулахын зэрэгцээ чин бишрэлийн албанд зүтгэн байгаа чин бишрэлтэн л хамгийн шилдэг нь байдаг. Эрдэм мэдлэгийг судласнаар хүн түүний жинхэнэ “Би” нь бие махбодиос ялгаатай юм гэдгийг таньж мэддэг бөгөөд цаашид улам бүр лавшруулан ахиц дэвшил гаргаснаар тэр бодьгал бус Брахманы болоод Параматмын тухай мэдлэгт хүрдэг. Бүрэн ариуссанаар хүн өөрийн нь жинхэнэ байр суурь бол Бурханы мөнхийн албат зарц мөн гэдгийг таньж мэддэг. Сониуч зантангууд, зовж зүдрэгсэд, материаллаг ашиг хонжооны хойноос тэмүүлэгчид болон мэдлэг агуулсан хүмүүс нь цэвэр чин бишрэлтэнтэй холбоо харьцаа тогтоосноор бүгд цэвэр чин бишрэлтэн болж болно. Гэхдээ, эхлэлийн үе шатандаа л Бүхний Дээд Бурханы тухай мэдлэгийг бүрэн эзэмшиж хүртэхийн зэрэгцээ Түүнд чин бишрэлээр зүтгэж байгаа хүн л Бурханд онцгой эрхэм байдаг. Бурханы Дээд Бодьгалын трансценденталь байдлын тухай цэвэр ариун мэдлэг бүхий хэн бүхэн чин бишрэлээр зүтгэх явцад материаллаг бузарт өртөхөөс найдвартай хамгаалагдсан байдаг.

ШҮЛЭГ 18

*ударак сарва эвайте гьяни тв атмайва ме матам
астхитах са хи юктатма мам эвануттамам гатим*

ударак- ховор, *сарва*- бүгд, *эва*- гарцаагүй, *эте*- энэ, *гьяни*- мэдэгт тулгуурлах тэр, *ту*- харин, *атма эва*- Над шиг, *ме*- Миний, *матам*- бодол таалал, *астхитах*- автдаг, *сах*- тэр, *хи*- тодорхой, *юкта-атма*- чин бишрэл дүүрэн бялхах албанд зүтгэдэг, *мам*- Миний дотор, *эва*- гарцаагүй, *ануттамам*- дээдийн дээд, *гатим*- зорилго.

Энэ бүх чин бишрэлтэнгүүд нь ховор сүнсүүд байдаг гэдэг нь ямар ч эргэлзээгүй юм. Гэхдээ, Миний тухай мэдлэгт тулгуурлах тэр л Надад Би Өөрөө мэт эрхэм бөлгөө. Тэрээр Миний трансценденталь албанд зүтгэн, дээдийн дээд хийгээд хамгийн төгс төгөлдөр зорилго болох Надад хүрч ирэх нь гарцаагүй.

ТАЙЛБАР: Бүрэн төгс бус мэдлэг бүхий чин бишрэлтэнгүүд нь Бурханд эрхэм биш байдаг гэж ойлгож болохгүй. Ямар нэг учир шалтгааны улмаас Бурханд хандаж байгаа хэн бүхнийг *махатма* буюу аугаа их сүнс гэж нэрлэдэг тул Тэр энд, тэд бүгдээрээ ховор ариун сүнсүүд юм гэж айлдаж байна. Өөрийн чин бишрэлийн зүтгэлийн хариуд тодорхой нэгэн ач тус хүртэхийг хүсэж байгаа чин бишрэлтэнг Бурхан хүлээн зөвшөөрдөг. Учир нь тэд ийм байдлаар харилцан бие биедээ дотносож байдаг. Тэд Түүнээс ямар нэгэн материаллаг ач тусыг гуйхаар дотносдог бөгөөд хүссэн зүйлээ хүртмэгц ханамжтай болж Бурханд талархах нь мөн тэд чин бишрэлийн зүтгэлдээ ахиц дэвшил гаргаж байгаагийн шинж. Гэхдээ төгс төгөлдөр мэдлэгт тулгуурлах чин бишрэлтэн нь Бүхний Дээд Бурханд хайр, чин бишрэлээр үйлчлэн зүтгэх цорын ганц зорилготой байдаг тул тэр Бурханд онцгой эрхэм байдаг. Ийм чин бишрэлтэн нь Бүхний Дээд Бурхантай холбоо харьцаатай байлгүйгээр эсвэл Түүнд үйлчлэн зүтгэлгүйгээр агшин зуурч байж чаддаггүй. Мөн үүний нэгэн адил Бүхний Дээд Бурхан Өөрийн чин бишрэлтэндээ маш эрхэм дотноор хандан түүнээс хэзээ ч салан холддоггүй.

Шримад Бхагаватамын (9.4)-д Бурхан:

*садхаво хридаям махьям садхунам хридаям тв ахам
мад-аньят те на жананти нахам тебхьо манаг апи*

“Миний чин бишрэлтэнгүүд үргэлж Миний зүрхэнд, мөн Би чин бишрэлтэнгүүдийнхээ зүрхэнд үргэлж байдаг. Чин бишрэлтэн Надаас өөр юуг ч мэдэхгүй бөгөөд Би ч чин бишрэлтэнгээ мартаж чаддаггүй. Би Өөрийн цэвэр чин бишрэлтэнгүүдтэйгээ маш дотнын харьцаатай байдаг. Төгс төгөлдөр мэдлэг хүртсэн цэвэр чин бишрэлтэнгүүд нь бурханлаг мөн чанараас хэзээ ч салан холддоггүй учир тэд Надад маш эрхэм байдаг” хэмээн айлдсан байдаг.

ШҮЛЭГ 19

*бахунам жанманам анте гьянаван мам прападьяте
васудевах сарвам ити са махатма су-дурлабхах*

бахунам- олон олон, *жанманам*- давтагдсан төрөлт болон үхэл, *анте*- дараа, *гьянаван*- бүрэн дүүрэн мэдлэг агуулах хүн, *мам*- Надад, *прападьяте*- өөрийгөө даатгадаг, *васудевах*- Бурханы Дээд Бодьгал, *сарвам*- бүгд, *ити*- ийм байдлаар, *сах*- энэ, *махатма*- аугаа сүнс, *су-дурлабхах*- олоход маш ховор.

Олон олон төрөлт үхлийн дараагаар төгс төгөлдөр мэдлэгийг үнэхээрийн хүрсэн хүн, Намайг шалтгаан бүгдийн шалтгаан гэдгийг танин мэдээд Надад өөрийгөө даатгадаг болой. Ийм аугаа сүнс нь туйлын ховор бөлгөө.

ТАЙЛБАР: Амьд оршнол нь олон амьдралын дараагаар чин бишрэлийн зүтгэл буюу бурханлаг зан үйл үйлдэх түвшинд хүрмэгц цэвэр ариун трансценденталь мэдлэгийг хүртэн бурханлаг танин мэдэхүйн дээдийн дээд зорилго бол Бурханы Дээд Бодьгал мөн гэдгийг таньж мэддэг. Материаллаг зүйлд татагдахаас салж ангижихыг оролдон байх бурханлаг танин мэдэхүйн зам мөрийн эхэн үедээ хүн бодьгал бусын үзэл бодолд маш хялбархан автах хандлагатай байдаг ч цаашид илүү дээд түвшинд дээшлэн хүрснээр бурханлаг амьдралд, Бурханд чин бишрэлээр зүтгэх олон янзын үйл дүүрэн байдаг гэдгийг ойлгодог. Үүнийг таньж мэдсэнээр Бурханы Дээд Бодьгалд татагдан Түүнд өөрийгөө даатгадаг. Энэ түвшинд хүрсэн хүн л Шри Кришнагийн өршөөл нигүүлсэл нь бүхний учир утга, Тэр бол бүх учир шалтгааны учир шалтгаан хийгээд материаллаг илрэл тодролууд нь бүх талаараа Түүнээс хамааралтай байдаг гэдгийг ойлгодог. Тэр мөн, материаллаг ертөнц нь бурханлаг олон талт байдлын гажуудсан тусгал бөгөөд эндхийн бүх зүйлс Бүхний Дээд Бурхан, Шри Кришнаатай холбоо шүтэлцээтэй байдаг гэдгийг таньж мэддэг. Ингэснээр тэр, бүхнийг Шри Кришна, Васудеватай холбон харах болдог. Васудеваг ийнхүү харах болсноор тэр дээдийн дээд зорилгодоо буюу Дээдийн Дээд Бурхан, Шри Кришнад өөрийгөө бүрнээ даатгах түвшинд түргэн хүрдэг. Ийнхүү өөрийгөө даатгагч аугаа сүнс маш ховор байдаг.

Бхагавад Гитагийн энэ шүлгийг Шветашватара-упанишадын (3.14-15)-д маш гайхамшигтайгаар тайлбарласан байдаг:

*сахасра-ширша пурушах сахасракшах сахасра-пат
са бхумим вишвато вритва атй-атиштхад дашангулам
пуруша зведам сарвам яд бхутам яч ча бхавьям
утамритатвасьешано яад анненатирохати*

“Бурхан Вишну нь мянга мянган тэргүүн, мянга мянган мэлмий, мянга мянган өлмийтэй билээ. Өөрийгөө бүхий л орчлон даяар нэвчин түгээхэд Тэрээр түүний хүрээ хязгаараас чанагш арван хурууны өргөнтэй илүү гардаг. Тэр, *вираг-пуруша* бүхий л орчлонгийн учир утга билээ. Тэр бол үхэшгүй мөнхрөлийн Эзэн. Тэр бол хоол тэжээлээр амьдрагч бүхнийг захирч байдаг.”

Чандхогья-упанишадын (5.1.15)-д хэлсэнчлэн: *на ваи вачо на чакшумши на шротрани на манамсити ачакшате прана ити эвачакшате прано хй эваштани сарвани бхаванти*—Амьд оршнол бүрийн бие махбодь дахь жинхэнэ хөдөлгөгч хүчин зүйл нь ярих, харах, сонсох эсвэл бодох чадвар биш харин бүх үйлийн төв нь болох амьдралын хүч байдаг. Үүний нэгэн адил, Шри Кришна, Бурхан Васудева бүгдийн жинхэнэ хөдөлгөгч хүч нь байдаг. Бидний бие махбодь нь ярих, харах, сонсох, бодох гэх мэтээр янз бүрийн чадвартай байдаг ч тэдгээр нь Бүхний Дээд Бурхантай холбогдоогүй л бол ямар ч утга учир, үнэ цэнэгүй юм. Васудева нь бүхэнд нэвчин хаа сайгүй залран байхын зэрэгцээ Өөрөө бүх зүйлс байдаг учир төгс төгөлдөр мэдлэгийг хүртсэн чин бишрэлтэн Түүнд өөрийгөө даатгадаг. (Мөн Бхагавад Гитагийн 7.17 болон 11.40-г үз.)

ШҮЛЭГ 20

*камайс тайс тайр хрита-гьянах
прападьянте `нья-деватах
там там ниямам астхая
пракритья ниятах свая*

камайх- хүслээр, *тайх-тайх*- янз бүрийн, *хрита*- хулгайлуулсан, *гьянах*- мэдлэгийг, *прападьянте*- өөрийгөө даатгах, *анья*- бусад, *деватах*- сахиулсан тэнгэрүүдэд, *там-там*- дагуу, *ния мам*- зохицуулалт, *астхая*- дагаж мөрдсөнөөр, *пракритья*- мөн чанарт, *ниятах*- хянагдмал, *свая*- тэдний өөрсдийн.

Материаллаг хүсэлд оюун ухаанаа хулгайлуулагсад нь сахиулсан тэнгэрүүдэд өөрсдийгөө даатган өөр өөрсдийн мөн чанарт харгалзсан бишрэл хүндэтгэлийн тодорхой дүрэм журмуудыг даган баримтлаж байдаг.

ТАЙЛБАР: Бүхий л материаллаг бузраасаа ангижрагсад нь Бүхний Дээд Бурханд өөрсдийгөө даатган, Түүний чин бишрэлийн албанд зүтгэж байдаг. Амьд оршнолууд нь бүхий л материаллаг бузраасаа бүрэн ангижран салаагүй л бол мөн чанарын хувьд чин бишрэлтэнгүүд биш юм. Гэхдээ материаллаг хүсэл агуулан байгаа хэдий ч Бүхний Дээд Бурханаас өмөг түшиг, аврал эрэгчид нь гадаад мөн чанарт төдийлөн татагдахаа больдог. Учир нь тэд зөв зорилгодоо ойртож байгаа учир бүхий л материаллаг шунал тачаалаасаа мөдхөн ангижирдаг. Шримад Бхагаватамд, материаллаг хүсэл үл агуулах цэвэр чин бишрэлтэн ч бай, материаллаг хүслээр дүүрэн байдаг хүн ч бай эсвэл бүхий л материаллаг бузраасаа ангижран салахыг хүсэж байгаа хүн ч бай ялгаагүй, ямар ч нөхцөл байдалд байсан Васудевад өөрийгөө даатган Түүнд бишрэл хүндэтгэлээ илэрхийлж байхыг зөвлөсөн байдаг.

Бхагаватамын (2.310)-д өгүүлсэнчлэн:

*акамах сарва-камо ва мокша-кама удара-дхих
тиверена бхакти-йогена яжета пурушам парам*

Бурханлаг ойлгоцоо умартсан оюунлаг бус хүмүүс нь материаллаг хүслээ түргэн хангахын тулд сахиулсан тэнгэрүүдээс өмөг түшиг эрдэг. Иймэрхүү хүмүүс нь материаллаг байгалийн доод (харанхуй мунхгийн болон хүсэл тачаалын) гунуудад оршдог учраас янз бүрийн сахиулсан тэнгэрүүдэд бишрэл хүндэтгэлээ илэрхийлдэг. Иймээс тэд ерөнхийдөө Бурханы Дээд Бодьгалд ханддаггүй. Сахиулсан тэнгэрүүдэд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх ёс журмуудыг даган баримталснаар тэдний хүсэл биелэгддэг. Түр зуурын байх эдгээр хүслүүддээ хөтлөгдөн байх, сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэгчид нь дээдийн дээд зорилгодоо хэрхэн хүрдгийг мэддэггүй байхад чин бишрэлтэнгүүд нь зөв замаар замнаж байдаг. Ведийн судруудад тодорхой нэгэн хүсэл, зорилгод хүрэхийн тулд тодорхой нэгэн саиулсан тэнгэрт бишрэл хүндэтгэлээ илэрхийлж байхыг (жишээлбэл, өвчтэй хүнд нарыг бишрэн шүтэхийг) зөвлөсөн байдаг учир Бурханы чин бишрэлтэн бус хүмүүс нь тодорхой зорилгод хүрэхийн тулд сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэх нь Бүхний Дээд Бурханыг бишрэн шүтэхээс илүү дээр хэмээн бодож байдаг. Харин цэвэр бишрэлтэн нь Бүхний Дээд Бурхан, Шри Кришна бол хэн бүхний Эзэн гэдгийг мэддэг билээ. Чайтанья Чаритамритагийн (Ади, 5.142)-д өгүүлсэнчлэн: *экале ишвара кришна ара саба бхрита*-"Зөвхөн, Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна л Эзэн, бусад нь бүгд албатууд бөлгөө." Ийм учраас цэвэр чин бишрэлтэн нь өөрийн материаллаг хэрэгцээ, шаардлагаа хангуулахын тулд сахиулсан тэнгэрүүдэд хэзээ ч ханддаггүй. Тэр өөрийгөө Бүхний Дээд Бурханд даатган, Түүний өөрт нь хайрлаж хүртээсэн бүхэнд хангалуун байдаг.

ШҮЛЭГ 21

*йо йо ям ям танум бхактах шраддхаярчитум иччхати
тасья тасьячалам шраддхам там зва вивадхамй ахам*

ях ях- хэн боловч, ям ям- ямар боловч, *танум*- сахиулсан тэнгэрийн дүр, *бхактах*- чин бишрэлтэн, *шраддхая*- итгэ бишрэлтэй, *арчитум*- бишрэн шүтэх, *иччхати*- хүсдэг, *тасья тасья*- түүнд, *ачалам*- бат бэх, *шраддхам*- итгэл бишрэл, *там*- түүнийг, *зва*- заавал, *видадхами*- өгдөг, *ахам*- Би.

Би Дээд Сүнс хэлбэрээр бүгдийн зүрхэнд залран байдаг бөгөөд хэн нэгэн нь аль нэгэн сахиулсан тэнгэрт бишрэл хүндэтгэлээ илэрхийлэхийг хүсмэгц Би түүний энэхүү сахиулсан тэнгэрт итгэх итгэлийг нь бэхжүүлэн батжуулдаг бөгөөд тэгснээр тэр өөрийгөө түүнд даатгаж чаддаг бөлгөө.

ТАЙЛБАР: Бурхан амьд оршнол бүрд үл хамаарсан байдлыг хайрласан байдаг. Иймээс хүн материаллаг таашаал ханамж эдлэхийг хүсэх хийгээд энэхүү хүсэл эрмэлзлээ хангах боломжийг материаллаг сахиулсан тэнгэрүүдээс үнэхээрийн хүсэж байхыг амьд оршнол бүрийн зүрхнээ Дээд Сүнс төлөв, хэлбэрээр залран байх Бүхний Дээд Бурхан мэддэг бөгөөд түүнд эдгээр хүслээ хангах боломжийг олгодог. Бүх амьд оршнолуудын дээдийн дээд Эцэг болохын хувьд Бурхан түүний үл хамаарах байдалд үл оролцдог бөгөөд харин ч түүнийг өөрийн материаллаг хүслээ ханган биелүүлэхэд шаардлагатай бүхий л боломжийг өгдөг. Тэгвэл эндээс, бүхнээс хүчирхэг Бурхан амьд оршнолуудад материаллаг таашаал ханамж эдлэх боломжийг яагаад өгөн тэднийг хий хуурмагийн эрчмийн урхинд орон унахыг зөвшөөрдөг юм вэ? гэсэн асуулт гарч болох юм. Үүнд дараах хариулыг өгч болно. Хэрвээ Бурхан Дээд Сүнс хэлбэрээр амьд оршнолд ийм боломжийг өгдөггүй байсансан бол бидний үл хамаарах байдал гэдэг нь ямарч утгагүй байсан билээ. Иймээс Тэр амьд оршнол бүрт өөрийн дуртай үйлээ үйлдэх бүрэн эрх чөлөөтэй буюу үл хамаарсан байдлыг хүртээсэн байдаг ч, Бхагавад Гитад Өөрийн дээдийн дээд сургаал: "Бусад бүхий л үйлээ орхиод Надад өөрийгөө бүрнээ даатга." гэж айлдсан байдаг. Тэгсэн цагт л хүн жинхэнэ аз жаргалтай болно.

Хүмүүс ч, мөн сахиулсан тэнгэрүүд ч тэр бүгд Бурханы Дээд Бодьгалын тааллаас хамаарч, Түүнд захирагдаж байдаг. Иймээс, сахиулсан тэнгэрүүд нь дээдийн дээд Тааллын зөвшөөрөлгүйгээр хэнд ч адислал хүртээж үл чаддагийн адил аливаа хүн өөрийн дан ганц хувийн хүсэл сонирхлын улмаас үүдэн тэдэнд бишрэл хүндэтгэлээ илэрхийлж чаддаггүй. Ийм учраас л, өвсний толгой хүртэл Бурханы Дээд Бодьгалын таалалгүйгээр хөдөлдөггүй гэж ярьцгаадаг. Материаллаг ертөнцөд зовлон төрхшээлтэй учирсан хүмүүсийг сахиулсан тэнгэрүүдэд хандахыг Ведийн судруудад ерөнхийдөө зөвлөсөн байдаг. Тодорхой нэгэн хүсэл, зорилгод хүрэхийн тулд тодорхой нэгэн сахиулсан тэнгэрт бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх хэрэгтэй. Жишээлбэл, өвчтэй хүн нарны сахиулсан тэнгэрт, нэр цуутай эрдэм боловсролтой болохыг хүсэх хүн эрдэм мэдлэгийн охин тэнгэр Сарасватид, харин гоо сайхан эхнэртэй болохыг хүсэх хүн Шивагийн гэргий Ума охин тэнгэрт бишрэл хүндэтгэлээ илэрхийлэхийг зөвлөсөн байдаг. Янз бүрийн сахиулсан тэнгэрүүдэд бишрэл хүндэтгэлээ хэрхэн илэрхийлэхтэй холбогдсон ийм зөвлөмжүүд

Ведийн судруудад байдаг. Аль нэгэн амьд оршнол материаллаг тодорхой нэгэн таашаал ханамж эдлэхийг хүсэж байвал Бурхан түүнийг зохих сахиулсан тэнгэрт хандахыг зоригжуулан энэхүү адислалыг хүртэхүйцээр хүслийг нь улам бүр хүчтэй өдөөж өгдөг ба ингэснээр тэр уг адислалыг хүртэн өөрийн хүссэндээ хүрдэг. Амьд оршнолын тодорхой нэгэн сахиулсан тэнгэрт үзүүлж буй бишрэл дүүрэн хандлагын ямар ч хэлбэрийг мөн л Бурхан өдөөж өгдөг болохоос, тухайн сахиулсан тэнгэр биш. Сахиулсан тэнгэрүүд нь амьд оршнолын зүрхэнд иймэрхүү мэдрэмж, хандлагыг өдөөх чадваргүй байдаг тул зохих сахиулсан тэнгэрүүдэд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх түлхэцийг хүнд чухамдаа, амьд оршнол бүрийн зүрхнээ Дээд Сүнс хэлбэрээр залран байх Бүхний Дээд Бурхан, Кришна өгдөг юм. Үнэн хэрэгтээ сахиулсан тэнгэрүүд нь Бүхний Дээд Бурханы орчлонгийн дүрийн биеийн янз бүрийн хэсгүүд байдаг учраас тэд Түүнээс хамааралгүй байдаггүй. Үүнтэй холбогдуулан Ведийн судруудад дараах шүлгийг өгүүлсэн байдаг: “Бурханы Дээд Бодьгал нь Дээд Сүнс хэлбэрээр мөн сахиулсан тэнгэрийн ч зүрхэнд залран байдаг учраас Тэр, амьд оршнолын хүслийг биелүүлэхийн тулд сахиулсан тэнгэрүүдээр халамж, санаа тавиулдаг. Сахиулсан тэнгэр ч тэр, амьд оршнол ч тэр ялгаагүй дээдийн дээд Тааллаас хамааралтай байдаг. Тэд хамааралгүй биш юм.”

ШҮЛЭГ 22

*са тая шраддхая юктас тасьярадханам ихате
лабхате ча татах каман маяйва вихитан хи тан*

сах- тэр, тая- -тай, шраддхая- итгэл бишрэл, юктах- биелүүлдэг, тасья- энэ сахиулсан тэнгэрийн, арадханам- бишрэн шүтэхийн тулд, ихате- чармайдаг, лабхате- хүрдэг, ча- болон, татах- үүнээс, каман- түүний хүсэл, майа- Надаар, зва- ганцаар, вихитан- санаа тавигддаг, хи- тодорхой, тан- түүнийг.

Ийм итгэл бишрэлээр дүүрэн байх хүн тодорхой нэгэн сахиулсан тэнгэрт бишрэл хүндэтгэлээ илэрхийлэхийг чармайх бөгөөд түүний хүслүүд нь ч биеллээ олдог. Гэвч үнэн хэрэгтээ тэдний хүртэн буй эдгээр адислалуудыг гагцхүү Би л хайрладаг билээ.

ТАЙЛБАР: Бүхний Дээд Бурханы соёрхолгүйгээр сахиулсан тэнгэрүүд нь өөрсдийн бишрэн шүтэгчдэд ямар ч адислал хүртээж чаддаггүй. Бүх зүйл Бүхний Дээд Бурханы соёрхолд байдаг гэдгийг амьд оршнолууд мартсан байж болох ч сахиулсан тэнгэрүүд нь үүнийг үргэлж санаж мэдэж байдаг. Иймд сахиулсан тэнгэрүүдэд бишрэл хүндэтгэл үзүүлэх болон хүссэн үр дүндээ хүрэх явдал нь Бурханы Дээд Бодгалын тааллаас хамаарахаас биш сахиулсан тэнгэрүүдээс бол үгүй байна. Оюунлаг бус хүмүүс нь энэ тухай мэддэггүй учир зөвхөн материаллаг зорилгод хүрэхийн тулд ямар ч бодлогогүйгээр сахиулсан тэнгэрүүдэд хандаж байдаг. Харин цэвэр чин бишрэлтэн нь түүнд ямар нэгэн зүйл хэрэгтэй болох аваас зөвхөн Бүхний Дээд Бурханаас л залбиран гуйдаг. Гэхдээ материаллаг ашиг хонжооны үүднээс гуйна гэдэг нь цэвэр чин бишрэлтэнгийн шинж тэмдэг биш. Ерөнхийдөө амьд оршнол нь өөрийн шунал тачаалаа хангахын төлөө галзуурсан мэт тэмүүлж байдаг учраас сахиулсан тэнгэрүүдэд хандаж билээ. Тэр болшгүй, хориотой зүйлийг хүсэх бөгөөд Бурхан Өөрөө түүний хүсэлтийг биелүүлээгүй тохиолдолд тэр ийнхүү ханддаг. Чайтанья-чаритамритад, Бүхний Дээд Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлж байдгийн зэрэгцээ материаллаг таашаал ханамж эдлэхийн хойноос эрмэлзэх хүн нь нийцэшгүй хүслүүдийг агуулж байдаг гэж өгүүлсэн байдаг. Бүхний Дээд Бурханд чин бишрэлээр зүтгэх үйл нь бүрнээ бурханлаг, харин сахиулсан тэнгэрүүдэд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх үйл нь материаллаг байдаг тул Бүхний Дээд Бурханд зүтгэх чин бишрэлийн алба болон сахиулсан тэнгэрүүдэд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх явдал хоёр нь огтын өөр зүйлс учраас хоёр өөр түвшинд байдаг.

Бурханы зүг буцаж очихыг эрмэлзэн тэмүүлж байгаа амьд оршнолын хувьд материаллаг хүсэл саад тотгор болж байдаг. Иймээс л, Бүхний Дээд Бурханы чин бишрэлийн албанд зүтгэхээс материаллаг ертөнцийн сахиулсан тэнгэрүүдэд бишрэл хүндэтгэл үзүүлэхийг илүүд үзэгч, оюунлаг бус хүмүүсийн хүсэн мөрөөдөх материаллаг ашиг хонжоо, эрх дархыг цэвэр чин бишрэлтэнд хүртээдэггүй.

ШҮЛЭГ 23

*антават ту пхалам тешам тад бхавати алпа-медхасам
деван дева-яжо янти мад-бхакта янти мам али*

анта-ват- цаг зуурын, ту- харин, пхалам- үр дүн, тешам- тэдний, тат- энэ, бхавати- болдог, алпа-медхасам- оюунлаг бусчууд, деван- сахиулсан тэнгэрүүдэд, дева-яжах- сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэгчид, янти- явдаг, мат- Миний, бхактах- чин бишрэлтэнгүүд, янти- явдаг, мам- Над руу, али- мөн.

Тийм ч оюунлаг бус хүмүүс нь сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэж байдаг ба тэдний бишрэл шүтлэгийн үр дүн нь хязгаарлагдмал бөгөөд түр зуурын байдаг. Сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэгч нь сахиулсан тэнгэрийн гаригуудад хүрч очдог бол Миний чин бишрэлтэнгүүд нь эцэстээ Миний дээдийн дээд оронд хүрч ирдэг.

ТАЙЛБАР: Бхагавад Гитагийн зарим тайлбарлагчид нь сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтсэнээр Бүхний Дээд Бурханы залрах оронд хүрч болно гэж батлахыг оролддогч, сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэгчид нь эдгээр сахиулсан тэнгэрүүдийн оршин байх янз бүрийн гаригуудад л хүрч очдог гэж энэ шүлэгт ямар ч салаа утгагүйгээр тов тодорхой өгүүлж байна. Жишээлбэл, нарны сахиулсан тэнгэрийг бишрэн шүтэгч нь наран дээр, сарны сахиулсан тэнгэрийг бишрэн шүтэгч нь саран дээр хүрч очдог. Хэн нэгэн нь Индра зэрэг сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэхийг хүсвэл тэрээр тэр сахиулсан тэнгэрийн гаригт хүрэх болно. Ямар ч сахиулсан тэнгэрийг биширч шүтсэн ялгаагүй, Бурханы Дээд Бодьгалд хүрдэг гэж бодох нь буруу юм. Чин бишрэлтэнгүүд нь Бурханы Дээд Бодгалын

дээдийн дээд гаригт шууд хүрдэг байхад сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэгчид нь зөвхөн тэдний гаригууд дээр л хүрч очих буюу материаллаг ертөнцөд үлддэг гэдгийг энд тодорхой хэлж байгаа учир дээрх баталгаа няцаагдаж байна.

Сахиулсан тэнгэрүүд нь Бүхний Дээд Бурханы биеийн хэсгүүд мөн болох учраас тэдэнд бишрэл хүндэтгэлээ илэрхийлснээр, шууд Бүхний Дээд Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлснээр хүрч болох зорилгод хүрэх ёстой биш үү гэсэн эргэлзээ тээнэгэлзээ энд гарч ирж болох юм. Гэхдээ, энэ учир байдал нь сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэгчид нь тийм ч оюунлаг бус гэдгийг харуулж байна. Учир нь тэд, биеийн чухам аль хэсгийг хоол тэжээлээр хангах ёстой вэ? гэдгийг мэдэхгүй байна. Тэдний зарим нь бие махбодийн аль ч хэсгээр хоол тэжээл авч болно хэмээн батлан хэлэхээр оролдох тийм мунхаг тэнэг байдаг. Иймэрхүү бодол санааг эрүүл гэж хэлэхийн аргагүй. Бидний хэн нь чихээрээ эсвэл нүдээрээ хооллох чадвартай билээ дээ? Ийм хүмүүс сахиулсан тэнгэрүүд нь Бурханы орчлонгийн биеийн хэсгүүд гэдгийг мэддэггүй бөгөөд мунхагийн улмаас сахиулсан тэнгэр бүр тусдаа Бурхан бөгөөд Бүхний Дээд Бурханы өрсөлдөгчид гэж боддог.

Зөвхөн сахиулсан тэнгэрүүд ч төдийгүй эгэл жирийн амьд оршнолууд хүртэл Бүхний Дээд Бурханы хэсгүүд байдаг. Шримад Бхагаватамд, *брахманууд* нь Бүхний Дээд Бурханы тэргүүн, *кшатриянууд* нь Түүний мутрууд, *вайшьягууд* нь Түүний ходоод, *шудрагууд* нь Түүний хөлнүүд болж байдаг ба тэд бүгд өөр өөр үүргүүдийг гүйцэтгэдэг гэж өгүүлсэн байдаг. Сахиулсан тэнгэрүүд хийгээд тэр өөрөө Бүхний Дээд Бурханы хэсэг мөн гэдгээ ойлгож ухаарсан цагт л хүн ямар байр суурь эзэлж байгаагаасаа үл хамааран төгс төгөлдөр мэдлэгийг хүртдэг. Харин үүнийг ойлгоогүй хүн сахиулсан тэнгэрүүдийн гаригуудад хүрдэг байхад чин бишрэлтэнгүүд нь огтын өөр, дээдийн дээд зорилгодоо хүрдэг.

Материаллаг ертөнц дэх гаригууд, сахиулсан тэнгэрүүд болон тэднийг бишрэн шүтэгчид нь бүгд л мөнх бус учир сахиулсан тэнгэрүүдийн өршөөл адислалаар хүртэж байгаа үр дүн нь мөн л цаг зуурын байдаг. Иймд, сахиулсан тэнгэрүүдэд бишрэл хүндэтгэлээ илэрхийлснээр хүртэж буй бүх зүйлс түр зуурын учир зөвхөн оюунлаг бус хүмүүс л тэднийг бишрэн шүтдэг гэж энэ шүлэгт тодорхой өгүүлж байна. Бүхний Дээд Бурхан Кришнагийн ухамсарт чин бишрэл дүүрэн бялхах албанд зүтгэж байгаа цэвэр чин бишрэлтэн нь мөнхийн, аз жаргал болон мэдлэгээр дүүрэн бялхах оршихуйд хүрдэг учир түүний хүрсэн амжилт нь сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэгчдийнхээс ялгаатай. Бүхний Дээд Бурхан бол цаглашгүй, Түүний ээл ивээл нь хязгааргүй, Түүний өршөөл нигүүлсэл нь хэмжээлшгүй. Тиймээс Бүхний Дээд Бурханы Өөрийн чин бишрэлтэнгүүддээ хүртээн байдаг өршөөл нигүүлсэл нь мөн хэмжээлшгүй юм.

ШҮЛЭГ 24

*авьяктам вяктим апаннам маньянте мам абуддхаях
парам бхавам ажананто мамавьяям ануттамам*

авьяктам- үл илэрч тодордог, *вяктим*- бодьгал, *апаннам*- хүрдэг, *маньянте*- бодох, *мам*- намайг, *абуддхаях*- ухаалаг бус хүмүүс, *парам*- дээдийн дээд, *бхавам*- оршнол, *ажанантах*- таньж мэдэлгүйгээр, *мама*- Миний, *авьяям*- цаг зуурын бус, *ануттамам*- хамгийн гайхамшигтай.

Намайг бүрэн төгс таньж мэдэхгүй, оюунлаг бус хүмүүс нь Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна Намайг урьд өмнө нь бодьгал бус байснаа одоо л энэхүү бодьгал дүрийг авч байгаа хэмээн үздэг. Мэдлэг хомс байдлаасаа болж тэд Миний мөнхийн бөгөөд үнэмлэхүй дээдийн дээд мөн чанарыг таньж мэддэггүй.

ТАЙЛБАР: Сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэгчдийг оюунлаг бус, холын бодолгүй хүмүүс гэж нэрлэдэг бөгөөд имперсоналистуудыг ч мөн тэдэнтэй адил гэдэг тухай энд өгүүлж байна. Шри Кришна энд Аржунад Өөрийн бодьгал дүрээрээ сургаал айлдаж байхад имперсоналистууд нь өөрсдийн мунхаг байдлын улмаас Бүхний Дээд Бурхан нь эцсийн дүндээ хэлбэр, дүргүй байдаг хэмээцгээдэг. Үүнтэй холбогдуулан Раманужачарьягийн *парампарад* хамаарагдах, Бурханы аугаа чин бишрэлтэн Ямуначарья маш гайхалтай оновчтой хоёр шүлгийг бичсэн байдаг:

*твям шила-рупа-чаритаих парама-пракриштаих
саттвена саттвикатая прабалаиш ча шастраих
пракхьята-даива-парамартха-видам матаиш ча
наивасура-пракритаиях прабхаванти боддхум*

“Ай Бурхан минь ээ, Вьясадева болон Нарада шиг чин бишрэлтэнгүүд нь, Та бол Бурханы Дээд Бодьгал гэдгийг мэддэг билээ. Ведийн янз бүрийн судруудыг судласнаар хүн Таны шинж чанарууд, Таны дүрийг болон Таны үйлүүдийг ойлгон Таныг Бурханы Дээд Бодьгал гэдгийг таньж мэдэж болдог. Гэхдээ, хүсэл тачаалын болон харанхуй мунхагийн гунуудад оршигчид, демонууд болон чин бишрэлтэн бусчууд нь Таныг ойлгож чадахгүй билээ. Тэд Таныг таньж мэдэх чадваргүй байдаг. Веданта, Упанишадууд болон Ведийн бусад судруудын талаар хэлэлцэж маргалдахдаа хичнээн сайн мэдлэгтэй, туршлагатай байсан ч гэсэн тэдний хувьд Бурханы Бодьгалыг танин мэдэх нь боломжгүй хэрэг юм.” (Стотра-ратна, 12)

Зөвхөн Ведантаг судласнаар Бурханы Бодьгалыг ойлгож чадахгүй юм гэж Брахма-самхитад өгүүлсэн байдаг. Зөвхөн Бүхний Дээд Бурханы өршөөл нигүүлслээр л Бүхний Дээдийн Бодьгалыг таньж мэдэж болдог. Ийм учраас л энэ шүлэгт, зөвхөн сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэгчид төдийгүй мөн жинхэнэ Кришнагийн ухамсрын өчүүхэн төдий ч шинж тэмдэг, үл мөрийг үл агуулан Ведантаг судлах хийгээд Ведийн судруудын талаар цэцэрхийлцгээх чин бишрэлтэн бусчууд ч оюунлаг бус юм гэж өгүүлж байна. Мөн тэдний хувьд ч Бурханы бодьгал шингэлж ойлгож ухаарах нь боломжгүй хэрэг байдаг. Үнэмлэхүй Үнэн нь бодьгал бус юм гэсэн үзэл бодол бүхий хүмүүсийг *абуддхаях* (оюун ухаангүй) гэж нэрлэдэг. Учир нь тэд Үнэмлэхүй Үнэний дээдийн дээд төлөвийн талаар юу ч үл мэднэ. Шримад Бхагаватамд өгүүлсэнчлэн, Бүхний Дээдийг танин мэдэх үйл явц нь бодьгал бус Брахманыг таньж мэдэхээр эхлэн дараа нь бүхний зүрхэнд залрах Дээд Сүнсний түвшинд дээшлэн хүрдэг ч, Үнэмлэхүй Үнэний

дээдийн дээд төлөв нь Бурханы Бодьгал байдаг. Өнөө цаг үеийн имперсоналистууд нь, Кришна бол Бурханы Дээд Бодьгал мөн гэж тодорхой хэлсэн өөрсдийн өмнөх үеийн аугаа төлөөлөгч болох Шанкарачарьягийн үгийг ч даган мөрдөхөө больсон тийм л ухвар мөчид болтлоо буюу оюун ухааны хувьд бүр доройтжээ. Имперсоналистууд нь Дээдийн Дээд Үнэнийг үл ойлгох учраас Кришна нь бол зүгээр л Деваки болон Васудевагийн хүү буюу хан хүү эсвэл нэгэн хүчирхэг амьд оршнол гэж бодоцгоодог. Иймэрхүү хандлагыг Бхагавад Гитагийн (9.11)-д мөн буруушаан: *аваджананти мам мудха манушим танум ашритам*- “Зөвхөн тэнэг мангуунууд л Намайг эгэл жирийн хүн гэж үздэг.” хэмээн айлдсан байдаг.

Иймд, Бурханы чин бишрэлийн албанд үл зүтгэх болон Кришнагийн ухамсрыг өөртөө хөгжүүлэхгүйгээр хэн ч Кришнаг танин мэдэж чадахгүй юм гэдэг нь бодит зүйл. Үүнийг батлан Бхагавад Гитагийн (10.14.29)-д:

*атхапи те дева падамбужа-двая
прасада-лешанугрихита зва хи
жанати таттвам бхагаван махимно
на чанья эко `пи чирам вичинван*

“Ай Бурхан минь ээ, Таны бадамлянхуа өлмийн өршөөл ивээлээс тань өчүүхэн багыг ч гэсэн хүртсэн хүн л Таны Бодьгалын аугааг ойлгож ухаарч чадах билээ. Харин Бурханы Дээд Бодьгалыг ойлгож ухаарах гэж цэцэрхэн байгаа хүн олон жилийн туршид Ведийг судалсан байсан ч Танд хүрч чадахгүй.” гэж өгүүлсэн байдаг.

Бурханы Дээд Бодьгал, Кришнаг, Түүний дүрийг, Түүний шинж чанарыг болон Түүний нэр алдрыг зөвхөн ухаан бодлын цэцэрхийлэл эсвэл Ведийн судруудыг хэлэлцсэнээр ойлгож ухаарах боломжгүй. Бурханд хүрэхийн тулд Түүний хайр чин бишрэл дүүрэн албанд л зүтгэх хэрэгтэй. Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе/Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе Харе махамантраг даван хэлэхээр эхэлдэг Кришнагийн ухамсрын үйлэнд бүрнээ автан зүтгэж байгаа хүн л Бурханы Дээд Бодьгалыг ойлгож чадах болно. Атейст-имперсоналистууд нь Кришна бол материаллаг бие махбодтой хийгээд Түүний бүхий л үйл, дүр болон бусад бүхэн нь бүгд *майа* гэж үздэг. Ийм имперсоналистуудыг майвадистууд гэж нэрлэдэг. Тэд жинхэнэ үнэнийг таньж мэддэггүй.

Энэ бүлгийн хорь дугаар шүлэгт: *камайс тайс тайр хрита-жнанах прападьянте `нья-деватах*- “Шуналт хүсэлдээ хөтлөгдөн, харалган бологсод нь янз бүрийн сахиулсан тэнгэрүүдэд өөрсдийгөө даатгаж байдаг.” гэж өгүүлсэн билээ. Бурханы Дээд Бодьгалын хажуугаар, өөр өөрсдийн гаригуудтай байх олон тооны сахиулсан тэнгэрүүд оршдог. Бурханд ч Өөрийн нь гариг байдаг билээ. Үүнтэй холбогдуулан хорингурав дугаар шүлэгт өгүүлсэнчлэн: *дееан дева-яджо янти мад-бхакти янти мам апи* буюу сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэгчид нь сахиулсан тэнгэрүүдийн гаригуудад, харин Шри Кришнагийн чин бишрэлтэнгүүд нь Кришналока гаригт хүрч очдог. Ийнхүү хоёрдмол бус, салаа утгагүй баталгаа нотолгоо байсаар байтал тэнэг мангуу имперсоналистууд нь Бурхан нь хэлбэр дүргүй байдаг, энэ бүх хэлбэр дүрүүд нь бүгд хийсвэр санаа гэсэн үзэлдээ бат зогсож байдаг. Гитаг судласнаар, сахиулсан тэнгэрүүд болон тэдгээрийн гаригууд нь бүгд л бодьгал бус гэсэн дүгнэлтэнд хүрч байна гэж үү? Сахиулсан тэнгэрүүд ч мөн Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна ч бодьгал бус биш гэдэг нь тодорхой. Тэд бүгдээрээ л бодьгалууд, Шри Кришна бол Бурханы Дээд Бодьгал бөгөөд сахиулсан тэнгэрүүд өөрсдийн гэсэн гаригуудыг эзэмшин байдагтай адил мөн Түүнд Өөрийнх нь гариг байдаг.

Иймээс, жинхэнэ үнэн нь хэлбэр дүргүй бөгөөд аливаа дүр нь хийсвэрлэл хэмээн монистуудын батлахыг оролдох нь буруу юм. Энд, тэр бол хийсвэр зүйл биш гэж тодорхой хэлж байна. Бхагавад Гитагаас үзэхэд, Бүхний Дээд Бурханы болоод сахиулсан тэнгэрүүдийн хэлбэр дүрүүд нь нэгэн зэрэг оршин байдаг бөгөөд Шри Кришна *сач-чид-ананда*, мөнхийн, баяр цэнгэл болон мэдлэгээр дүүрэн бялхаж байдаг гэдэг нь тодорхой. Энэ тухай мөн Ведэд, Дээдийн Дээд Үнэмлэхүй Үнэн нь цэнгэл жаргалын баяр хөөрөөр дүүрэн мөн чанартай (*ананда-майо `бхйасат*) бөгөөд Тэрээр бүхий л сайн шинж чанаруудыг хэмжээ хязгааргүйгээр агуулан байдаг гэж батлан өгүүлдэг. Бурхан мөн Гитад айлдсанчлан, Тэр хэдийгээр *ажа* (төрдөггүй) боловч Өөрийн бодьгал дүрээр илэрч тодордог. Энэ бүгд нь Бхагавад Гитад тодорхойлон өгүүлсэн байх үнэн бөгөөд тэдгээрийг бид яг тэр байдлаар нь ойлгож хүртэх ёстой. Бурханы Дээд Бодьгал нь бодьгал бус байх аргагүй, иймээс монист-имперсоналистуудын төлөөлөн байх хийсвэр байдлын онол нь Гитагийн дагуу бол буруу. Иймээс Дээдийн Дээд Үнэмлэхүй Үнэн, Шри Кришнаг хэлбэр дүртэй болоод бодьгал гэдэгт ямар ч эргэлзээ байхгүй.

ШҮЛЭГ 25

*нахам паракашах сарвасья йога-мая-самаверитах
мудхо `ям набхижанати лока мам ахам авьяям*

на- үгүй, *ахам*- Би, *пракашах*- харагддаг, *сарвасья*- бүгдэд, *йога-майа*- дотоод хүчээрээ, *самаверитах*- хучигддаг, *мудхах*- тэнэгүүд, *аям*- энэ, *на*- үгүй, *абхижанати*- ойлгож чадахгүй, *локах*- хүмүүс, *мам*- Намайг, *ахам*- төрдөггүй, *авьяям*- цаглашгүй.

Би Өөрийгөө тэнэг мунхаг болон оюунлаг бус хүмүүст хэзээ ч үл нээдэг. Тэднээс Би Өөрийгөө дотоод эрчмийнхээ хүчээр халхлах учир тэд Намайг төрдөггүй хийгээд алдаа эндэгдэл үл гаргадаг гэдгийг үл мэдмүй.

ТАЙЛБАР: Кришна одоо хүн бүрт Өөрийгөө нээдэггүй мөртөө, Тэр энэ газар дэлхий дээр морилон байх үедээ яагаад хүн бүрт харагдаж байсан юм бэ? гэсэн асуулт тавьж магадгүй. Үнэн хэрэгтээ, тэр үед Кришна Өөрийгөө хүн бүгдэд нээгээгүй билээ. Кришнаг энд залран байхад, Тэр бол Бурханы Дээд Бодьгал гэдгийг ойлгож ухаарсан зөвхөн цөөн хэдхэн хүмүүс л байв. Куругийн удмынхны чуулган дээр Шишупала Кришнаг хуралдааныг удирдах тэргүүлэгчээр сонгохын эсрэг санал хэлэхэд Бхишма Кришнагийн талд орон, Түүнийг Бүхний Дээд Бурхан мөн гэж зарласан. Мөн Пандавынхан болоод өөр бусад зарим нэгэн нь л Түүнийг Бүхний Дээд мөн болохыг мэддэг байснаас, бүгдээрээ биш. Чин бишрэлтэн бусчууд болон эгэл жирийн хүмүүст Тэр Өөрийгөө нээгээгүй. Иймээс л

Кришна Бхагавад Гитад, чин бишрэлтэнгүүдээс бусад хүмүүс нь Түүнийг өөрсөдтэйгээ адил нэгэн гэж үздэг хэмээн айлдсан билээ. Тэр зөвхөн чин бишрэлтэнгүүддээ л Өөрийгөө бүхий л баяр баясгалангийн сан хөмрөг байдлаар нээдэг бол, бусад бүх хүмүүс, оюунлаг бус чин бишрэлтэн бусчуудаас Өөрийгөө дотоод эрчмээрээ халхалдаг.

Шримад Бхагаватамын (1.8.19)-д Кунти хатан мөргөл залбиралдаа, Бурхан *йога-майагийн* гивлүүр халхавчаар Өөрийгөө далдалсан байдаг учраас эгэл жирийн хүмүүс Түүнийг ойлгох аргагүй гэж хэлсэн байдаг. Энэхүү *йога-майагийн* гивлүүр, хаалтын тухай мөн Ишопанишадын (15)-д чин бишрэлтэн Бурханд мөргөн залбирахдаа ийн өгүүлсэн байдаг:

*хиранмаена патрена сатьясьяпихитам мукхам
тат твам пушанн апаврину сатья-дхармаяа дриштае*

“Ай Бурхан минь ээ Та бол бүхий л орчлонг тогтоон барьж ивээн тэтгэж байдаг бөгөөд Танд чин бишрэлээр зүтгэх алба нь шашин номын дээдийн дээд зарчим билээ. Иймээс, Таныг, намайг мөн ивээлдээ авахыг гуйж, мөргөн залбиръя. Таны трансценденталь дүр *йога-майагаар* далдлагдсан байдаг. *Брахмажьоти* бол Таны дотоод эрчмийн хаалт хөшиг. Намайг өршөөн соёрхож, Таны *сач-чид-ананда-виграха*, Таны цэнгэл жаргал мэдлэгээр дүүрэн бялхах мөнхийн дүрийг халхлан, үл харуулах энэхүү нүд гялбам туяагаа холдуулан хайрлаач.” Цэнгэл жаргал хийгээд мэдлэгийн трансценденталь дүрдээ Бурханы Дээд Бодьгал Өөрийн дотоод эрчмийн хөшиг *брахмажьоти-гоор* биднээс халхлагдан байдаг учир оюунлаг бус имперсоналистууд Бүхний Дээдийг харж үл чадна.

Шримад Бхагаватамын (10.14.7)-д *Брахма* Шри Кришнад хандан дараах мөргөл залбирлыг өргөн байдаг: “Ай Бурханы Дээд Бодьгал минь ээ, ай Дээд Сүнс минь ээ, ай бүх ид шидийн хүчийн Эзэн минь ээ, энэ ертөнц дэх Таны хүч чадал болон Таны зугаа наадмуудыг хэмжиж хэн чадах билээ дээ. Таны дотоод эрчим байнгад өргөжин тэлж, дэлгэрч байдаг учраас Таныг хэн ч ойлгож ухаарч чаддаггүй. Аугаа их эрдэмтэд нь материаллаг ертөнцийн атомын бүтэц зохион байгуулалт болон гаригуудыг судлахыг оролдож чаддаг байлаа ч, өмнө нь Та залран байсан ч тэд Таны хүч чадал болон эрчмийг хэмжих чадваргүй билээ.” Бурханы Дээд Бодьгал Шри Кришна зөвхөн төрдөггүй төдийгүй мөн *авьяа* буюу цаглашгүй. Түүний мөнхийн дүр нь цэнгэл жаргал хийгээд мэдлэг бөгөөд Түүний бүхий л эрчим нь шавхагдан барагдашгүй билээ.

ШҮЛЭГ 26

*ведахам саматитани вартманани чаржуна
бхавишьяни ча бхутани мам ту веда на кашчана*

веда- мэддэг, *ахам*- Би, *саматитани*- өнгөрсөнийг, *вартаманани*- одоог, *ча*- болон, *аржуна*- Аржуна минь, *бхавишьяни*- ирээдүйд бүрэн, *ча*- мөн, *бхутани*- бүхий л амьд оршнолууд, *мам*- Намайг, *ту*- харин, *веда*- мэддэг, *на*- үгүй, *кашчана*- бүгд.

Ай Аржуна минь ээ, Бурханы Дээд Бодьгал мөн болохын хувьд Би, өнгөрсөн үед юу болж байсан, одоо цагт юу болж байгаа болон ирээдүйд юу болох талаар бүгдийг нь мэддэг. Мөн Би бүх амьд оршнолуудыг мэддэг байхад Намайг таньж мэдэх хэн ч байдаггүй.

ТАЙЛБАР: Энд бодьгал болон бодьгал бус байдлын тухай асуудлыг тодорхой тайлбарлаж байна. Хэрвээ Бурханы Дээд Бодьгал, Шри Кришнагийн дүр нь бодьгал бусыг баримтлагчдын үздэг шиг *майа*, материаллаг байсансан бол Тэрээр амьд оршнолуудын нэгэн адил Өөрийн биеэ солин өнгөрсөн амьдралдаа болсон бүхнээ мартаж байхсан билээ. Материаллаг бие махбодид төрсөн хэн бүхэн өнгөрсөн амьдралдаа болж тохиолдсон бүхнээ эргэн санадаггүйн зэрэгцээ одоогийн энэ амьдралын нь үр дагавар буюу ирээдүйнхээ амьдралын талаар урьдчилан хэлж чадахгүй билээ. Иймээс тэр өнгөрсөн амьдралын үеэ ч, одоо цаг үеэ ч мөн ирээдүйн талаараа ч мэддэггүй. Материаллаг бузраасаа ангижраагүй байсан цагт хүн өнгөрсөн, одоо болон ирээдүйгээ мэдэж чадахгүй.

Шри Кришна энэ шүлэгт, Тэр эгэл жирийн хүнийг бодоход өнгөрсөн үедээ юу болсныг, одоо юу болж байгааг мөн ирээдүйд юу болохыг бүгдийг нь мэддэг гэж тодорхой айлдаж байна. Шри Кришна сая сая жилийн өмнө нарны сахиулсан тэнгэр Вивасванад сургаал айлдсанаа эргэн санаж байдгийг бид дөрөв дүгээр бүлэгт үзсэн билээ. Кришна бүгдийн зүрхнээ Дээд Сүнс хэлбэрээр залран байдаг учир Тэр бүх амьд оршнолуудыг таньж мэддэг. Хэдийгээр Кришна Бурханы Дээд Бодьгал дүрээрээ илрэн тодордог болон амьд оршнол бүрийн зүрхнээ Дээд Сүнс хэлбэрээр залран байдаг ч оюунлаг бус хүмүүс нь бодьгал бус *Брахманы* түвшинд хүрсэн байсан ч Түүнийг Бүхний Дээд Бурхан гэдгийг таньж мэдэж чаддаггүй.

Шри Кришнагийн трансценденталь бие нь мөнхийн гэдэг нь эргэлзээгүй. Кришна нь нар мэт бөгөөд харин *майа* нь үүлтэй зүйрлэхүйц. Материаллаг ертөнцөд бид бүхэн нар, үүл, янз бүрийн одод болон гаригуудыг харж байдаг. Зарим үед үүл тодорхой хугацааны туршид тэнгэрийг бүхэлд нь бүрхдэг. Ийнхүү бүрхэгдмэл байдал нь зөвхөн бидний хязгаарлагдмал хараатай л холбоотой. Үнэн хэрэгтээ, үүл нь нар, сар болон оддыг хэзээ ч бүрхэн далдалж чадахгүй. Үүний нэгэн адил *майа* нь Бүхний Дээд Бурханыг бүрхэн хучиж чаддаггүй. Харин Тэр Өөрийн дотоод эрчмийн хүчээр л оюунлаг бус хүмүүсийн хараанаас зайлсхийж байгаа хэрэг. Энэ бүлгийн гурав дугаар шүлэгт өгүүлсэнчлэн, сая сая хүмүүсээс зөвхөн цөөн хэд нь л хүний амьдралын төгс төгөлдөрт хүрэхээр тэмүүлдэг бөгөөд төгс төгөлдөрт хүрсэн мянга мянган ийм хүмүүсээс дөнгөж нэг нь л арай чарай Шри Кришнаг жинхэнэ үнэн дүр төрхөөр нь ойлгож болох юм. Бодьгал бус *Брахманыг* эсвэл бүгдийн зүрхнээ залрах *Параматмаг* төгс төгөлдөр таньж мэдэх түвшинд хүрсэн байлаа ч Кришнагийн ухамсрыг өөртөө хөгжүүлээгүй л бол Бурханы Дээд Бодьгал, Шри Кришнад хэн ч хүрч чадахгүй.

ШҮЛЭГ 27

*иччха-деваша самуттхена двандва-мохена бхарата
сарва-бхутани саммохам сарге янти парантапа*

иччха- шунал тачаал, двеша- болон үзэн ядалт, самуттхена- үүсэн гарсан, двандва- хоёрдмол байдал, мохена- хий хуурмагаар, бхарата- Бхаратын үр удам минь, сарва- бүгд, бхутани- амьд оршнол, саммохам- хууран мэхлэлд, сарге- төрдөг, янти- явах, парантапа- дайснаа дарагч минь.

Ай Бхаратын үр удам, ай дайснаа дарагч минь ээ, бүхий л амьд оршнолууд нь төөрөгдөл дунд төрдөг бөгөөд шунал тачаал болон үзэн ядалтаас үүдэн гарах хоёрдмол байдалд төөрч будилмуй.

ТАЙЛБАР: Амьд оршнолын жинхэнэ жам ёсны байр суурь нь цэвэр ариун мэдлэг болох Бүхний Дээд Бурханд захирагдан байх байдал юм. Энэхүү цэвэр ариун мэдлэгээс хууртагдан салж холдсон хүн хий хуурмагийн эрчмийн эрхшээл ноёрхолд орох бөгөөд Бурханы Дээд Бодьгалыг таньж мэдэх чадваргүй болдог. Хий хуурмагийн эрчим нь шунал тачаал болон үзэн ядалтын хоёрдмол байдлын хэлбэрээр илэрч тодордог. Шунал тачаал болон үзэн ядалт нь хүнийг Кришнаатай нэгдмэл нэг болохыг хүсэх эсвэл Түүнийг Бурханы Дээд Бодьгал хэмээн атаархан жетөөрхөхөд хөтлөн хүргэдэг. Шунал тачаал болон үзэн ядалтанд үл хууртан мэхлэгдэх цэвэр ариун чин бишрэлтэнгүүд нь Шри Кришнаг Өөрийн дотоод эрчмийн хүчээр илэрч тодордог гэдгийг мэддэг байхад энэхүү хоёрдмол байдал болоод өөрсдийн харанхуй мунхагт төөрөлдөн хууртагсад нь Бурханы Дээд Бодьгал нь материаллаг эрчмээс бүтээгдсэн гэж бодож итгэж байдаг. Энэ нь тэдний зол завшаан муутайнх. Ийнхүү төөрөлдөж харалган болсон хүмүүс нь хүндэтгэл доромжлол, жаргал зовлон, эхнэр нөхөр, сайн муу, баяр хөөр өвчин шаналал гэх мэтийн хоёрдмол байдалд амьдарч байдаг бөгөөд: "Энэ бол миний эхнэр, энэ бол миний гэр орон, би энэ байшингийн эзэн нь, би энэ эмэгтэйн нөхөр нь" гэх мэтээр бодож байдаг. Энэ бүхэн нь хий хуурмагаас үүсэн бий болсон хоёрдмол байдал бөгөөд энэхүү хоёрдмол байдалд хууртан мэхлэгдсэн хүмүүс нь бүрнээ харалган болдог учраас Бурханы Дээд Бодьгалыг таньж мэдэж чаддаггүй.

ШҮЛЭГ 28

*ешам тв анта-гатам папам жананам пунья-карманам
те двандва-моха-нирмукта бхажанте мам дридха-вратах*

ешам- түүний, ту- харин, анта-гатам- бүрэн устсан, папам- нүгэл, жананам- хүний, пунья- зөв шудрага, карманам- түүний өмнөх үйлүүд, те- тэд, двандва- хоёрдмол байдлын, моха- заль мэх, нирмуктах- ангид, бхажанте- чин бишрэл дүүрэн бялхах албанд зүтгэх, мам- Надад, дхридха-вратах- шийдвэртэйгээр.

Өнгөрсөн болоод одоогийн амьдралдаа зөв шудрага үйл үйлдсэн хийгээд бүхий л нүгэл нь устан үгүй болсон хүмүүс нь хий хуурмагийн хоёрдмол байдлын эрхшээл нөлөөнөөс ангижрах бөгөөд Миний албанд шийдвэр төгс зүтгэн байдаг.

ТАЙЛБАР: Энэ шүлэгт, хэн трансценденталь түвшинд дээшлэн хүрч болох талаар тайлбарлаж байна. Нүгэлтэй, атейст, тэнэг мунхаг болон залилан мэхлэгч хүмүүсийн хувьд шунал тачаал хийгээд үзэн ядалтын хоёрдмол байдлыг гэтлэн туулна гэдэг маш хүнд бэрх байдаг. Өөрсдийн амьдралдаа шашин номын зохицуулах зарчмуудыг баримталж мөрдөн, ариун шудрага үйл үйлдэх хийгээд бүхий л нүгэлт үр дагавруудаа даван туулсан зөвхөн тийм хүмүүс л чин бишрэлийн зүтгэлийн албанд ханддаг бөгөөд аажим аажмаар Бурханы Дээд Бодьгалын тухай цэвэр ариун мэдлэгийн түвшинд дээшлэн хүрдэг. Тэгсэн цагт тэд аажим аажмаар Бурханы Дээд Бодьгалын тухай бясалган трансын байдалд бүрэн автан, умбаж эхэлдэг. Бурханлаг түвшинд ингэж л хүрдэг. Аугаа чин бишрэлтэнгүүдийн хүрээлэлд багтан орсноор мэхлэгдэн хууртагдахаас салан ангижирч чадах тул цэвэр чин бишрэлтэнгүүдийн хүрээлэлд орж Кришнагийн ухамсарт оршин байх хүн л ийм түвшинд дээшлэн хүрэх боломжтой.

Шримад Бхагаватамын (5.5.2)-д өгүүлсэнчлэн, ангижралд хүрэхийг үнэхээрийн хүсэж байгаа хүн чин бишрэлтэнгүүдэд үйлчлэн зүтгэх хэрэгтэй (*махат-севам дварам ахур вимуктех*). Харин, материалист хүмүүстэй харьцагсад нь оршихуйн хамгийн түнэр харанхуй хэсэгт хүргэдэг зам мөрөөр явж байдаг (*тамо-дварам йошитам санги-сангам*). Бурханы чин бишрэлтэнгүүд нь болзолт сүнснүүдийг хий хуурмагаас чөлөөлөхийн тулд л дэлхий дахинаар аялан явж байдаг. Хүн өөрийн жинхэнэ байр суурь буюу Бүхний Дээд Бурханд захирагдаж байдаг гэдгээ мартаж нь Бурханы хуулиудыг хамгийн ноцтойгоор зөрчиж байгаа хэрэг гэдгийг имперсоналистууд мэддэггүй. Хүн өөрийн жинхэнэ байр сууриа дахин эзлээгүй цагт Бурханы Дээд Бодьгалыг ойлгох болон Түүний трансценденталь хайрын албанд шийдвэр төгс бүрнээ зүтгэх нь боломжгүй байдаг.

ШҮЛЭГ 29

*жара-марана-мокшая мам ашритья ятанги е
те брахма тад видух критснам адхьятмам карма чакхилам*

жара- хөгшрөл, марана- үхлээс, мокшая- ангижрах зориулалтаар, мам- Надад, ашритья- аврал өмгөөлөл эрснээр, ятанги- чармайх, е- тэд бүгд, те- ийм хүмүүс, брахма- Брахман, тат- үнэхээр түүнийг, видух- тэд мэддэг, критснам- бүгдийг, адхьятмам- трансценденталь, карма- үйлүүд, ча- мөн, акхилам- бүрэн.

Хөгшрөлт болон үхлээс чөлөөлөгдөж, ангижралд хүрэхийг эрмэлзэх оюунлаг хүмүүс нь Миний чин бишрэлийн албан дор өмөг түшиг олмуй. Тэд трансценденталь үйлүүдийн талаарх бүрэн төгс мэдлэгийг агуулах учир жинхэнэ Брахман мөн болой.

ТАЙЛБАР: Төрөлт, үхэл, хөгшрөлт болон өвчлөл нь бидний материаллаг бие махбодид л нөлөө үзүүлэхээс биш бурханлаг биед бол үгүй. Бурханлаг биеийн хувьд гэвэл төрөлт, үхэл, хөгшрөлт болон өвчлөлт гэж байдаггүй. Иймээс бурханлаг биетэй болж Бурханы Дээд Бодьгалын бараа бологсдын хүрээлэлд багтсан хийгээд мөнхийн чин бишрэл дүүрэн бялхах албанд зүтгэн байгаа хэн бүхэн төгс төгөлдөр ангижралд хүрсэн байдаг. *Ахам брахмаси*: "Би бол бурханлаг мөн чанартай". Энэ нь амьд оршнол нь өөрийгөө бурханлаг сүнс-Брахман гэж ойлгох ёстой гэсэн утгатай юм. Ийнхүү өөрийгөө Брахман гэж танин мэдэх нь өмнөх шүлэгт тайлбарласанчлан, чин бишрэлийн үйлд мөн давхар агуулагдаж байдаг. Цэвэр чин бишрэлтэнгүүд нь материаллаг оршихуйд трансценденталь байх Брахманы түвшинд оршин байдаг бөгөөд трансценденталь үйлүүдийн талаар бүрэн төгс мэдлэгийг агуулж байдаг.

Бурханы трансценденталь албанд хандсанаар өөрийн хүссэнд хүрэх дөрвөн төрлийн цэвэр бус чин бишрэлтэнгүүд нь Кришнаг бүрэн ухамсарлах аваас Бурханы өршөөлөөр тэд Түүний бурханлаг хүрээлэлд орон цэнгэл жаргал, баяр хөөртэй болох боломжтой болно. Харин сахиулсан тэнгэрүүдийг бишрэн шүтэгчид нь Бурханы дээдийн дээд гаригт хэзээ ч үл хүрнэ. Ухвар мөчид, оюунлаг бус хүмүүсээс арай илүү дээр, зөвхөн Брахманыг таньж мэдэх хүмүүс ч Кришнагийн дээдийн дээд гариг, Голока Вриндаванад хүрч үл чадна. Зөвхөн, Кришнагийн ухамсарт үйл хэргээ явуулагсад нь (*мам ашритья*) Кришнагийн гаригт хүрэхийг үнэнхүү хичээн чармайж байдаг учраас тэднийг Брахман гэж нэрлэх нь үнэхээрийн зохистой билээ. Ийм хүмүүс нь Кришнад эргэлздэггүй учраас тэд үнэхээрийн Брахман бөлгөө.

Материаллаг хүлээснээс ангижрахын тулд Бурханы *арча*-дүрд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн эсвэл Бурханы тухай бясалган байгаа хүмүүс нь Бурханы өршөөлөөр Брахманы учир утга, *адхибхута* болон бусад зүйлүүдийг ойлгож ухаарах болно. Бурхан энэ талаар дараагийн бүлэгт тайлбарлана.

ШҮЛЭГ 30

*садхибхута*дхидайвам мам садхиягьям ча е видух
праяна-кале `пи ча мам те видур юкта-четасах

са-адхибхута- материаллаг илрэл тодролын ноёлох зарчим, *адхидайвам*- бүхий л сахиулсан тэнгэрүүдийг захирсанаар, *мам*- Намайг, *са-адхиягьям*- болон бүхий л тахилга өргөлүүдийг захирсанаар, *ча*- мөн, *е*- тэд, *видух*- таньж мэдэх, *праяна*- үхлийн, *кале*- цагт, *али*- ч, *ча*- болон, *мам*- Намайг, *те*- тэд, *видух*- таньж мэдэх, *юкта-четасах*- өөрсдийн ухаанаа Надад чиглүүлдэг.

Ухамсраа Надад бүрнээ чиглүүлсэн хийгээд өргөл тахилгуудын бүхий л үйл явц, сахиулсан тэнгэрүүд болон материаллаг илрэл тодролыг эзэгнэн захирдаг ноёлох зарчим бол Бүхний Дээд Бурхан, Би мөн юм гэдгийг таньж мэдэгчид нь Бурханы Дээд Бодьгал, Намайг үхэх цаг мөчдөө ч бүрэн төгс ойлгож, таньж мэдэж болно.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсарт үйл хэргээ явуулах хүн нь Бурханы Дээд Бодьгалыг бүрэн төгс ойлгож ухаарахад хүргэх зам мөрөөс хэзээ ч гажин хазайдаггүй. Кришнагийн ухамсрыг агуулах чин бишрэлтэнгүүдийн бурханлаг хүрээлэлд л Бүхний Дээд Бурхан бол бүхий л материаллаг илрэл тодролуудыг, тэр бүү хэл сахиулсан тэнгэрүүдийг ч эзэгнэн захирах зарчим гэдгийг ойлгож сурна. Энэхүү трансценденталь харилцаа, хүрээлэлд орсноор тэр Бурханд аажмаар улам бүр итгэлтэй болох бөгөөд ийм хүн Кришнаг ухамсарласнаар Түүнийг хэзээ ч, тэр бүү хэл үхэх цаг үедээ ч мартахгүй болдог. Ингэснээр тэр бие махбодио орхимогц Бүхний Дээд Бурханы залран байх гариг Голока Вриндаванад дээшлэн хүрдэг.

Долоо дугаар бүлэгт, Кришнаг хэрхэн бүрэн ухамсарлаж болохыг онцгойлон тайлбарлаж байна. Кришнаг ухамсарласан хүнтэй учран, түүнтэй холбоо хэлхээ тогтоон харьцсанаар л Кришнагийн ухамсар эхэлдэг. Ийм харьцаа нь бурханлаг байдаг бөгөөд хүнийг Кришнаатай шууд холбодог. Тэгсэн цагт Түүний өршөөл нигүүлслээр Тэр бол Бурханы Дээд Бодьгал гэдгийг таньж мэддэг. Үүний зэрэгцээ, амьд оршнолын жинхэнэ байр суурь ямар байдаг хийгээд амьд оршнол нь Кришнаг хэрхэн мартсан хийгээд түүнийхээ улмаас материаллаг үйлийн торонд яаж орооцолддог болохыг үнэнээр нь ойлгож мэдэх болно. Амьд оршнол нь зөв харьцаа холбоонд Кришнагийн ухамсрыг аажим аажмаар хөгжүүлэх аваас тэр зөвхөн Кришнаг мартсанаас л болж материаллаг байгалийн хуулиудын эрхшээл, нөлөөнд орж унасан гэдгээ ойлгох болно. Тэр мөн, хүний амьдралын хэлбэр нь Кришнагийн ухамсрыг өөртөө дахин сэргээх боломжийг түүнд өгдөг болон Бүхний Дээд Бурханы учир шалтгаангүй өршөөл нигүүлслийг хүртэхийн тулд энэхүү амьдралаа бүрэн дүүрэн ашиглах ёстой гэдгээ ойлгоно.

Энэ бүлэгт, зовлон шаналал тохиолдогсод, сониуч зантангууд болон материаллаг эд баялгийн хэрэгцээтэй хүмүүс, Брахманыг танин мэдэх, Параматмаг танин мэдэх, төрөлт, үхэл болон өвчлөлөөс ангижрах болон Бүхний Дээдэд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх тухай зэрэг олон төрлийн сэдвүүдийг авч үзлээ. Кришнагийн ухамсрын хөгжил дэвшилд үнэхээрийн хүрсэн хэн бүхэн энэхүү олон янзын арга зам, үйлүүдийг сонирхож санаа тавьдаггүй. Тэр зүгээр л Кришнагийн ухамсарын үйлэнд шууд зүтгэж байдаг ба тэгснээрээ Шри Кришнагийн мөнхийн албат зарц гэсэн өөрийн жинхэнэ байр сууринаа хүрдэг. Энэ түвшинд хүрснээр тэр Бурханы тухай сонсох болон Түүнийг алдаршуулан магтах цэвэр чин бишрэлийн албандаа баяр хөөрийг амсаж эдэлж байдаг. Ингэснээр тэр өөрийнх нь бүхий л хүсэл биелэгдэнэ гэдэгт бат итгэлтэй болдог. Энэхүү хэлбэрэлт гуйвалтгүй итгэл бишрэлийг *дридха-врата* гэж нэрлэдэг бөгөөд энэ нь трансценденталь хайрын алба, *бхакти-йогын* эхлэл болдог билээ. Бүхий л судруудад ийнхүү өгүүлсэн байдаг. Мөн Бхагавад Гитагийн долоо дугаар бүлэг нь энэхүү итгэл бишрэлийн гол цөм ба шинж чанарыг тодорхойлон өгүүлж байна.

Шримад Бхагавад Гитагийн "Үнэмлэхүйн мэдлэг" нэртэй долоо дугаар бүлэгт Бхактиведантын өгсөн тайлбар ийнхүү өндөрлөлөө.

